

# Хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн талаарх чанарын судалгаа

Судалгааны тайлан

Бүтээгдэхүүн 3



## АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар .....	6
ХУРААНГУЙ .....	8
ТАНИЛЦУУЛГА .....	11
Судалгааны зорилго, зорилтууд .....	11
Судалгааны хүрээ .....	11
Судалгааны арга зүй .....	12
Судалгаанд оролцогчдын ерөнхий шинж .....	13
Судалгааны хязгаарлагдмал тал .....	15
Тайлангийн бүтэц .....	16
<b>1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭСРЭГ ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ .....</b>	<b>16</b>
<b>1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ГБХ-д өртөж буй байдал .....</b>	<b>16</b>
1.1.1 Харааны бэрхшээлтэй хүн .....	21
1.1.2 Сонсголын бэрхшээлтэй хүн .....	26
1.1.3 Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүн .....	30
1.1.4 Оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй хүн .....	34
1.1.5 Бусад төрлийн бэрхшээлтэй хүн .....	39
1.1.6 ХБХ-ий асран хамгаалагчдын нөхцөл байдал .....	43
<b>1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ГБХ-д өртөхөд нөлөөлж буй хүчин зүйлс .....</b>	<b>45</b>
1.2.1. Хувь хүний хүчин зүйлс .....	47
1.2.2. Гэр бүлийн хүчин зүйлс .....	52
1.2.3. Олон нийтийн хүчин зүйлс .....	56
1.2.4. Тогтолцооны хүчин зүйлс .....	59
<b>1.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ГБХ-ийн талаарх ойлголт, тусламж дэмжлэг эрэлхийлэх зан үйл 64</b>	<b>64</b>
1.3.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ГБХ-ийн талаарх ойлголт, мэдлэг .....	64
1.3.2. ГБХ-д өртсөн ХБХ-ий тусламж, дэмжлэг эрэлхийлэх зан үйл .....	71
<b>2. МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТОГТОЛЦОО БА ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХ .....</b>	<b>79</b>
2.1    ГБХ-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа .....	84
2.2    ГБХ-ийн хохирогч хамгааллын асуудал, шаардлагатай дэмжлэг туслалцаа .....	86
2.3    ГБХ-ийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа .....	94
2.4    ГБХ-тэй тэмцэх чиглэлээр талуудын хамтын ажиллагаа .....	100
<b>3    ДҮГНЭЛТ .....</b>	<b>103</b>

4	САНАЛ, ЗӨВЛӨМЖ .....	111
	Хавсралт 1. ХБХ-ий ГБХ-ийн талаар ойлголт, үйлдэл тус бүрээр.....	116
	Хавсралт 2. ГБХ-тэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдох журмуудад орсон ХБХ-тэй холбоотой зохицуулалт тусгагдсан байдал .....	121

## Дүрс, Хүснэгтийн жагсаалт

Дүрс 1. Судалгаанд оролцсон ХБХ-ий боловсролын түвшин, бэрхшээлийн төрлөөр, хувь (n=150) .....	14
Дүрс 2. Дор хаяж нэг удаа ГБХ-ийн хэлбэрт өртсөн ХБХ-ий хувь, ХБ-ийн төрлөөр.....	17
Дүрс 3. ХБХ-ий ГБХ-д өртсөн байдал, хүчирхийллийн давхардлаар .....	18
Дүрс 4. ХБХ-ий өртсөн ГБХ-ийн аюулын түвшин, %.....	19
Дүрс 5. Харааны бэрхшээлтэй хүмүүсийн өртсөн ГБХ-ийн эрсдлийн түвшин.....	21
Дүрс 6. ГБХ-ийн 5 төрлийн илрэх хэлбэрүүдээс дор хаяж нэг хэлбэрт өртсөн харааны бэрхшээлтэй хүмүүсийн хувь, (n=27).....	21
Дүрс 7. ГБХ-д өртсөн харааны бэрхшээлтэй хүмүүсийн сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн байдал, % .....	23
Дүрс 8. ГБХ-д өртсөн харааны бэрхшээлтэй хүмүүсийн хянах зан үйлийн хүчирхийлэлд өртсөн байдал, % .....	23
Дүрс 9. ГБХ-д өртсөн харааны бэрхшээлтэй хүмүүсийн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байдал, % .....	24
Дүрс 10. ГБХ-д өртсөн харааны бэрхшээлтэй хүмүүсийн эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн байдал, % .....	25
Дүрс 11. ГБХ-д өртсөн харааны бэрхшээлтэй хүмүүсийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдал, %.....	25
Дүрс 12. Сонголын бэрхшээлтэй хүмүүсийн өртсөн ГБХ-ийн эрсдлийн түвшин .....	26
Дүрс 13. ГБХ-ийн 5 төрлийн илрэх хэлбэрүүдээс дор хаяж нэг хэлбэрт өртсөн сонголын бэрхшээлтэй хүмүүсийн хувь, (n=25).....	26
Дүрс 14. ГБХ-д өртсөн сонголын бэрхшээлтэй хүмүүсийн сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн байдал, % .....	27
Дүрс 15. ГБХ-д өртсөн сонголын бэрхшээлтэй хүмүүсийн хянах зан үйлийн хүчирхийлэлд өртсөн байдал, % .....	27
Дүрс 16. ГБХ-д өртсөн сонголын бэрхшээлтэй хүмүүсийн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байдал, % .....	28
Дүрс 17. ГБХ-д өртсөн сонголын бэрхшээлтэй хүмүүсийн эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн байдал, % .....	29
Дүрс 18. ГБХ-д өртсөн сонголын бэрхшээлтэй хүмүүсийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдал, % .....	29
Дүрс 19. Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн өртсөн ГБХ-ийн эрсдэлийн түвшин .....	30
Дүрс 20. ГБХ-ийн 5 төрлийн илрэх хэлбэрүүдээс дор хаяж нэг хэлбэрт өртсөн тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн хувь, (n=35).....	30
Дүрс 21. ГБХ-д өртсөн тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн байдал, % .....	30
Дүрс 22. ГБХ-д өртсөн тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн хянах зан үйлийн хүчирхийлэлд өртсөн байдал, % .....	31

Дүрс 23. ГБХ-д өртсөн бие махбодын бэрхшээлтэй хүмүүсийн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байдал, %.....	32
Дүрс 24. ГБХ-д өртсөн тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн байдал, %.....	32
Дүрс 25. ГБХ-д өртсөн тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдал, %.....	33
Дүрс 26. Оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн өртсөн ГБХ-ийн эрсдэлийн түвшин.....	34
Дүрс 27. ГБХ-ийн 5 төрлийн илрэх хэлбэрүүдээс дор хаяж нэг хэлбэрт өртсөн оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн хувь, (n=34).....	34
Дүрс 28. ГБХ-д өртсөн оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн байдал, %.....	35
Дүрс 29. ГБХ-д өртсөн оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн хянах зан үйлийн хүчирхийлэлд өртсөн байдал, %.....	36
Дүрс 30. ГБХ-д өртсөн оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байдал, %.....	36
Дүрс 31. ГБХ-д өртсөн оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн байдал, %.....	37
Дүрс 32. ГБХ-д өртсөн оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдал, %.....	38
Дүрс 33. Бусад хэлбэрийн бэрхшээлтэй иргэдийн өртсөн ГБХ-ийн эрсдэлийн түвшин.....	39
Дүрс 34. ГБХ-ийн 5 төрлийн илрэх хэлбэрүүдээс дор хаяж нэг хэлбэрт өртсөн бусад төрлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувь, (n=29).....	39
Дүрс 35. ГБХ-д өртсөн бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүсийн сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн байдал, %.....	40
Дүрс 36. ГБХ-д өртсөн бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүсийн хянах зан үйлийн хүчирхийлэлд өртсөн байдал, %.....	40
Дүрс 37. ГБХ-д өртсөн бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүсийн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байдал, %.....	41
Дүрс 38. ГБХ-д өртсөн бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүсийн эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн байдал, %.....	42
Дүрс 39. ГБХ-д өртсөн бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүсийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдал, %.....	42
Дүрс 40. Эмзэг байдлыг тодорхойлох загвар.....	45
Дүрс 41. Ядуурлын тойрог, түүний үр дагавар ГБХ-д нөлөөлөх байдал.....	62
Дүрс 42. ГБХ-ийн талаар ойлголт мэдээлэлтэй ХБХ-ий хувь, бэрхшээлийн төрлөөр, %.....	65
Дүрс 43. Харааны бэрхшээлтэй хүмүүсийн ГБХ-ийн хэлбэрүүдийн талаар ойлголт, % (n=27).....	67
Дүрс 44. Сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн ГБХ-ийн хэлбэрүүдийн талаар ойлголт, % (n=25).....	67
Дүрс 45. Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн ГБХ-ийн хэлбэрүүдийн талаар ойлголт, % (n=35)..	69
Дүрс 46. Оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн ГБХ-ийн хэлбэрүүдийн талаар ойлголт, % (n=34).....	70
Дүрс 47. Бусад төрлийн бэрхшээлтэй хүмүүсийн ГБХ-ийн хэлбэрүүдийн талаар ойлголт, % (n=29).....	70
Дүрс 48. ГБХ-д өртвөл хамгийн эхэнд хандах тал, (n=150).....	72
Дүрс 49. ГБХ-д өртвөл хамгийн эхэнд хандах тал, харааны бэрхшээлтэй хүн, давхардсан тоогоор (n=27).....	73

Дүрс 50. ГБХ-ийн талаар мэдээлэхдээ харааны бэрхшээлтэй хүмүүсийн ашиглах боломжтой харилцааны хэрэгсэл, хувь.....	74
Дүрс 51. ГБХ-д өртвөл хамгийн эхэнд хандах тал, сонсголын бэрхшээлтэй хүмүүс, хувь (n=25) .....	74
Дүрс 52. ГБХ-ийн талаар мэдээлэхдээ сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн ашиглах боломжтой харилцааны хэрэгсэл, хувь.....	75
Дүрс 53. ГБХ-д өртвөл хамгийн эхэнд хандах тал, сонсголын бэрхшээлтэй иргэд, хувь (n=25).....	75
Дүрс 54. ГБХ-ийн талаар мэдээлэхдээ тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн ашиглах боломжтой харилцааны хэрэгсэл, хувь.....	76
Дүрс 55. ГБХ-д өртвөл хамгийн эхэнд хандах тал, оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүн, хувь (n=34) .....	76
Дүрс 56. ГБХ-ийн талаар мэдээлэхдээ тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн ашиглах боломжтой харилцааны хэрэгсэл, хувь.....	77
Дүрс 57. ГБХ-д өртвөл хамгийн эхэнд хандах тал, бусад төрлийн бэрхшээлтэй хүн, хувь (n=29) .....	77
Дүрс 58. ГБХ-ийн талаар мэдээлэхдээ тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн ашиглах боломжтой харилцааны хэрэгсэл, хувь.....	78
Дүрс 59. ГБХ-тэй тэмцэж буй одоогийн тогтолцоо.....	80
Дүрс 60. Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны тоон мэдээлэл .....	91
Дүрс 61. Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн үйлчлүүлэгчийн тоо болон байрласан хоног .....	91
Хүснэгт 1. ГБХ-д нөлөөлж буй хүчин зүйлс.....	8
Хүснэгт 2. Мэдээлэл цуглуулсан, боловсруулсан арга .....	12
Хүснэгт 3. Судалгаанд оролцогчид ба түүврийн хэмжээ.....	13
Хүснэгт 4. Түүврийн төлөвлөгөө, гүйцэтгэл .....	13
Хүснэгт 5. Судалгаанд оролцсон ХБХ-ий хүйс, насны харьцаа, бэрхшээлийн төрлөөр, (N=150).....	14
Хүснэгт 6. ГБХ-д өртсөн ХБХ-ий хүйс, насны харьцаа, бэрхшээлийн төрлөөр, (n=111).....	17
Хүснэгт 7. ГБХ үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлс, түвшнээр .....	46
Хүснэгт 8. ГБХ-д өртсөн ХБХ-ий нас, хүйсийн харьцаа, бэрхшээлийн төрлөөр, (N=111).....	47
Хүснэгт 9. Нийт ГБХ-д өртсөн ХБХ-ий гэрлэлтийн байдал (n=111) .....	48
Хүснэгт 10. Судалгаанд оролцсон ХБХ-ийн насны харьцаа, бэрхшээлийн төрлөөр .....	53
Хүснэгт 11. ХБХ-тэй өрхийн гол эх үүсвэрүүд.....	53
Хүснэгт 12. Монгол Улсын хүн амын ядуурлын түвшний судалгаа, ядуурлын хүрээ, хувиар .....	61
Хүснэгт 13. ХБХ-ий ГБХ-ийн талаар ойлголт, мэдлэг (n=150).....	64
Хүснэгт 14. ГБХ-д өртсөн ХБХ-ий цагдаагийн дуудлага мэдээлэл өгсөн байдал .....	71
Хүснэгт 15. ГБХ-д өртсөн үедээ хандах талууд, ГБХ-ийн талаар ойлголттой эсэхээр (n=150) .....	72
Хүснэгт 16. Үндэсний хэмжээд үйл ажиллагаа явуулж буй түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн тоо, 2020 оны 10 сарын байдлаар .....	89
Хүснэгт 17. Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн тоон мэдээллээс хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчдийн тоон мэдээлэл.....	91
Хүснэгт 18. ГБХ-ийн хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг ТББ-ын мэдээлэл .....	92

## Товчилсон үгийн тайлбар

АБХ	Азийн хөгжлийн банк
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ГХУСАЗЗАА	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба
ЗГ	Засгийн газар
ИНБ	Хүний нийгмийн байгууллага
МТИҮХ	Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо
МХҮХ	Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз
МОНЭС	Монголын эмэгтэйчүүдийн сан
МХЭҮТ	Монголын хүүхдийн эрхийн үндэсний төв
МХЭССХ	Монголын хүүхдийн эрхийн сургалт, судалгааны хүрээлэн
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан
НЦҮТ	Нэг цэгийн үйлчилгээний төв
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
НЦГ	Нийслэлийн Цагдаагийн газар
ОУБ	Олон улсын байгууллага
СБД	Сүхбаатар дүүрэг
ТББ	Төрийн бус байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ФБЯ	Фокус бүлгийн ярилцлага
ХБИБҮХ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүн
ХБХХЕГ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
ХБХЭТК	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц
ХБХЭТХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
ХБЯ	Хагас бүтэцлэгдсэн ярилцлага
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХҮЕГ	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮХ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

## МЭДЭГДЭЛ

IRIM судалгааны хүрээлэн нь Хууль зүй дотоод хэргийн яам (ХЗДХЯ), Азийн хөгжлийн банк (АХБ) хамтран хэрэгжүүлж буй “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн талаарх чанарын судалгаа”-г 2020 оны 07 сараас 11 сарын хугацаанд гүйцэтгэлээ. Уг тайлангийн үр дүн, дүн шинжилгээ, дүгнэлт нь зөвхөн судалгааны багийн байр суурийг илэрхийлэх бөгөөд ХЗДХЯ, АХБ болон бусад оролцогч талуудын байр суурийг илэрхийлэхгүй болно.

## СУДАЛГААНЫ БАГ

Гүнсэнчоймболын Амаржаргал	Багийн ахлагч, IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх
Цэдэнгийн Оюунбаатар	Зөвлөх, IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх
Гэлэнхүүгийн Түмэннаст	Зөвлөх, IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх
Нарангийн Болдмаа	Ахлах судлаач, IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх
Төмөрийн Цогзолмаа	Ахлах судлаач, IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх
Батын Чулуундолгор	Ахлах судлаач, IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх
Ганзоригийн Жаргалмаа	Зохицуулагч, IRIM судалгааны хүрээлэнгийн төслийн менежер
Жаргалсайханы Жавхлан	Туслах судлаач, IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач

## ТАЛАРХАЛ

Тус судалгааг гүйцэтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан АХБ-ны төсөл хэрэгжүүлэх нэгж, ХЗДХЯ-ны дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, орон нутгийн салбар зөвлөлүүд болон Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, ХНХЯ-ны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтэс болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын хамт олонд талархсанаа илэрхийлье.

Мөн өөрийн амьдралын туршлага, үзэл бодлоо нээлттэй хуваалцсан нийт судалгаанд оролцогчдод судалгааны багийн зүгээс гүн талархлаа илэрхийлж байна.

## ХУРААНГУЙ

### **Нэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүний гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй байдал:**

Судалгаанд хамрагдсан нийт хөгжлийн бэрхшээлтэй хүн (ХБХ)-ий 74 хувь нь ямар нэгэн байдлаар гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртсөн байсан. Гэр бүлийн хүчирхийлэл (ГБХ)-ийг нийтлэг тохиолдож буй хэлбэрээс нь эхлэн авч үзвэл сэтгэл санаа болон хянах зан үйлийн хүчирхийлэлд өртсөн байдал хамгийн өндөр. Удаад нь бие махбод, эдийн засгийн болон бэлгийн хүчирхийллүүд орж байгаа хэдий ч дийлэнх нь хавсарсан шинжтэй. Нийт ГБХ-д өртсөн ХБХ-ий 80 хувь нь гурав болон түүнээс дээш хэлбэрийн хүчирхийлэлд хавсарсан байдлаар өртсөн.

Хөгжлийн бэрхшээлийн төрлөөс хамааран аль нэг хүчирхийллийн хэлбэрт илүү өртөмтгий байх шинж ажиглагдсан. Ялангуяа, хөдөлгөөний хязгаарлалттай буюу тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн бүх хэлбэрийн хүчирхийлэлд өртөж буй байдал бусад бэрхшээлтэй иргэдээс илүү өндөр байв. Үр дүнг үзвэл:

- Сэтгэл санааны хүчирхийлэлд бүх төрлийн бэрхшээлтэй хүмүүс
- Хянах зан үйлийн хүчирхийлэлд хараа, сонсгол, тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүс
- Бие махбодын хүчирхийлэлд хараа, сонсгол, тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүс
- Эдийн засгийн хүчирхийлэлд тулгуур эрхтэн, оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүс
- Бэлгийн хүчирхийлэлд хараа, сонсгол болон тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүс илүү өртсөн байна.

Хүчирхийллийн аюулын зэргийг авч үзвэл хүчирхийлэлд өртсөн ХБХ-ий 42 хувь нь аюулын зэргийн хувьд дунд болон өндөр нөхцөлд орж байсан нь эрдлийн түвшин өндөр байгааг харуулж байсан. Бэрхшээлийн төрлөөр авч үзвэл, харааны бэрхшээлтэй хүмүүс илүү эрсдэл өндөр, аюултай байдалд орж байжээ.

### **Хоёр. Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөд нөлөөлж буй хүчин зүйлс:**

ГБХ-д өртөхөд нөлөөлж буй хүчин зүйлийг “Эмзэг байдлын загвар” (Determinants of Vulnerability Model)-ын дагуу хувь хүн, гэр бүл, олон нийт болон тогтолцооны түвшинд тодруулахыг зорьсон. Түвшин тус бүрийг хэмжсэн шалгуур үзүүлэлтийн нөлөөллийг авч үзвэл олон нийт, тогтолцооны түвшний хүчин зүйлс нь илүү ГБХ-д үйлдэгдэхэд суурь шалтгааны шинжтэй нөлөө үзүүлж буй байдал ажиглагдав. Түвшин тус бүрд нөлөөтэй хүчин зүйлсийг авч үзвэл:

#### **Хүснэгт 1. ГБХ-д нөлөөлж буй хүчин зүйлс**

Түвшин	Нөлөөлж буй хүчин зүйлс
Хувь хүний хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> <li>• Хүйс</li> <li>• Гэрлэлтийн байдал</li> <li>• Бэрхшээлийн түүх, төрөл, хүндрэлийн түвшин</li> <li>• Хүчирхийлэлтэй холбоотой өмнөх туршлага</li> <li>• Боловсролын түвшин,</li> <li>• ГБХ-ийн талаар мэдлэг, ойлголт</li> <li>• Хөдөлмөр эрхлэлт, орлого</li> <li>• Нийгмийн харилцаа, холбоо</li> </ul>
Гэр бүлийн хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> <li>• Гэр бүлийн санхүүгийн чадавч (ажил эрхлэлт, орлогын эх үүсвэр),</li> <li>• Гэр бүлийн уур амьсгал,</li> <li>• Гэр бүлийн шийдвэр гаргах байдал</li> <li>• Гэр бүлийн гишүүдийн эрсдэлтэй зан үйл</li> </ul>

Олон нийтийн хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> <li>• Ялгаварлан гадуурхалт,</li> <li>• Нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж, дэд бүтэц,</li> <li>• Хөршийн холбоо</li> </ul>
Тогтолцооны хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> <li>• Гэр бүлийн харилцаа, жендэрийн талаар уламжлалт ойлголт, хандлага (хүчирхийллийг тэвчих байдал)</li> <li>• Боловсролын чанар, хүртээмжийн хангалтгүй байдал</li> <li>• Ядуурал (Үе дамжсан ядуурал, ажилгүйдэл)</li> <li>• ГБХ-тэй тэмцэх тогтолцооны сул байдал</li> <li>• ХБХ-тэй гэр бүлийг дэмжих бодлогын сул байдал</li> </ul>

**Гурав. Хөгжлийн бэрхшээлтэй хүний гэр бүлийн хүчирхийллийн талаар ойлголт мэдлэг, тусламж дэмжлэг эрэлхийлэх зан үйл:**

ХБХ-ий ГБХ-ийн талаарх ойлголт, мэдлэгийг тодруулахдаа хүчирхийллийн 5 төрлийн хэлбэр тус бүрийн илрэх үйлдлүүдийг оролцогчид санал болгож эдгээр үйлдлүүд ГБХ-ийн хэлбэр мөн эсэхийг оролцогчдын өөрсдийнх нь байр сууринаас тодруулсан. Ингэхэд ГБХ-ийн талаар бүрэн дүүрэн тайлбар өгсөн, ойлголттой оролцогч нийт оролцогчдын дөнгөж 12 хувийг эзэлж байв. Харин дурдсан хүчирхийллийн хэлбэрүүдийн талаар огт ойлголтгүй буюу аль ч үйлдлийг ГБХ гэж үзэхгүй байсан нь нийт оролцогчдын 43 хувь байгаа нь ГБХ-ийн талаарх ойлголт мэдлэг маш доогуур байгааг харуулж байсан.

Үлдсэн оролцогчдын хувьд хүчирхийллийн зөвхөн аль нэг хэлбэрийг л таниж байсан ба илүү сэтгэл санаа болон бие махбодын хүчирхийллийн талаар ойлголттой байв. Харин хянах зан үйл, эдийн засгийн болон бэлгийн хүчирхийллийн талаарх ХБХ-ий ойлголт мэдлэг хамгийн бага байна. Нийтлэг тохиолдолд зодож цохиогүй л бол бусад нь хүчирхийлэл биш гэх тайлбар давамгайлж байлаа.

Бэрхшээлийн төрлөөр нь харьцуулж харвал бүх хэлбэрийн хүчирхийллийн талаар харааны бэрхшээлтэй хүмүүс бусад ХБХ-ээс ойлголт мэдлэг сайтай, харин сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн ойлголт мэдлэг хамгийн бага байна.

ГБХ-тэй холбоотой мэдээллийг ямар эх сурвалжаас авсныг тодруулахад дараах гурван хариулт хамгийн нийтлэг дурдагдсан. Үүнд: (1) телевиз, (2) сошиал медиа, (3), ижил бэрхшээлтэй хүмүүс. Цаашид мэдээллийг ямар сувгаар дамжуулж хүргэвэл илүү тохиромжтой байгааг тодруулахад бэрхшээлийн төрлөөс хамааран ялгаатай хариулууд дурдагдаж байсан хэдий ч ихэнх оролцогчдын хувьд энэ талаарх мэдээллийг биечилж уулзаж авах хувилбаруудыг илүүд үзэж байлаа.

**Дөрөв. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоо ба хөгжлийн бэрхшээлтэй хүн:**

ХБХ-ий эсрэг үйлдэгдэж буй ГБХ-тэй тэмцэх тогтолцооны нөхцөл байдлыг 4P-ийн зарчим буюу урьдчилан сэргийлэх, хохирогч хамгаалал, хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаа, хамтын ажиллагаа гэсэн дөрвөн бүлгийн хүрээнд судалсан. Бүлэг тус бүрээрх судалгааны гол үр дүнг нэгтгэн авч үзвэл:

**1. Урьдчилан сэргийлэх чиглэлээр:**

- ❖ **Үр дүн 1:** ГБХ-ээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахдаа ХБХ-ий онцлог, тусгай хэрэгцээг харгалзан, хүртээмжтэй мэдээлэл хүргэх байдал хангалтгүй байна.
- ❖ **Үр дүн 2:** ГБХ-ээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага тулгамдаж байна.

**2. Хохирогч хамгааллын чиглэлээр:**

- ❖ **Үр дүн 1:** ГБХ-ийн хохирогч хамгааллын эрх зүйн орчин сайжирсан хэдий ч хүчирхийлэлд өртсөн ХБХ рүү чиглэсэн хохирогч хамгааллын бодлого хангалтгүй байна.

- ❖ **Үр дүн 2:** ГБХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлж буй байгууллагын бүртгэл мэдээлэл үйлчлүүлэгчийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр нарийвчлагдан задрах боломжгүй байна.
- ❖ **Үр дүн 3:** Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд ХБХ-ийг хүлээн авах орчин бүрдээгүй, тэдгээр төвийн үйл ажиллагаа ХБХ-д хүртээмжгүй байна.
- ❖ **Үр дүн 4:** ГБХ-д өртсөн ХБХ-д нэн шаардлагатай дэмжлэг туслалцаанд сэтгэл зүйн зөвлөгөө, хувийн туслухын системд суурилсан бие даан амьдрах төвийн үйлчилгээ шаардлагатай байна.

### **3.Хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр:**

- ❖ **Үр дүн 1:** ГБХ-ийн гэмт хэрэг, зөрчлийн ойлголтын зөрүүтэй байдал нь хэрэг, зөрчлийг шалгах ажиллагаанд саад учруулж байна.
- ❖ **Үр дүн 2:** Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн, шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн хэчнээн хувьд нь ХБХ хохирогч болсон талаарх мэдээлэл хаалттай байна.
- ❖ **Үр дүн 3:** Хөгжлийн бэрхшээлтэй хохирогч гэмт хэрэг, зөрчлийг шалгаж, шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломж хязгаарлагдмал байна.

### **4.Хамтын ажиллагааны чиглэлээр:**

- ❖ **Үр дүн 1:** ГБХ-тэй тэмцэх чиглэлээр Үндэсний хэмжээнд талуудын хамтын ажиллагаа хэвийн явагдаж байгаа хэдий ч бодлого, төлөвлөлтийн түвшиндээ ажлуудын уялдаа, залгамж холбоо сул байна.
- ❖ **Үр дүн 2:** ГБХ-тэй тэмцэх чиглэлээр орон нутгийн түвшинд талуудын уялдаа холбоог хангахад үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын удирдлага, зохион байгуулалтын уялдаагүй байдал нь хүндрэл учруулж байна.

## ТАНИЛЦУУЛГА

### Судалгааны зорилго, зорилтууд

ХЗДХЯ, АХБ хамтран хэрэгжүүлж буй “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төсөл нь хууль эрх зүй, нийгэм эдийн засаг, соёл болон гэр бүлийн орчинд жендерийн тэгш байдлыг хангах, ингэхдээ ХБХ-ийг ГБХ-ийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилготой. Энэ хүрээнд тус судалгаагаар дараах асуудлуудыг тодруулахыг зорьсон. Үүнд:

1. ХБХ-ий ГБХ-д өртөж буй хэлбэр, түвшин, нөлөөлж буй хүчин зүйл зэргийг тодорхойлох ба ингэхдээ нас, хүйс, хөгжлийн бэрхшээлийн төрөл, газар зүйн байршил, мэдээллийн хүртээмж зэрэг нийгэм, эдийн засгийн онцлогийг харгалзан үзэх.
2. ХБХ-ий хүчирхийлэлд өртөж буй байдлаа ухамсарлан ойлгох, бусдад мэдээлэх, тусламж үйлчилгээ эрэлхийлэх ойлголт, зан үйлийг тодорхойлох
3. ХБХ ГБХ-д өртсөнөө ухамсарлан ойлгох, мэдээлэх, тусламж үйлчилгээ эрэлхийлэх байдлыг сайжруулах талаар цаашид хэрэгжүүлэх санал, зөвлөмж боловсруулах зэрэг зорилтуудын хүрээнд судалгааг гүйцэтгэлээ.

### Судалгааны хүрээ

ХБХ-ий ГБХ-ийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа нь бүхэлдээ чанарын мэдээлэл цуглуулалтын аргад үндэслэж явагдсан. Судалгааны үндсэн нэгж нь ГБХ-д өртөх эрсдэлтэй болон өртсөн 16-аас дээш насны хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй, эмэгтэйчүүд. Тус судалгаа нь сэдвийн хувьд маш эмзэг, судалгаанд оролцогчийн онцлог, тусгай хэрэгцээг харгалзаж судалсан ажил тул гол ойлголт, нэр томъёог авч үзсэн ойлголтын хүрээг дор харуулав:

1. Судалгааг гүйцэтгэхдээ “гэр бүл” гэдэг ойлголтод ГБХ-тэй тэмцэх тухай хуульд заасны дагуу дараах бүлэг хоорондын харилцааг хамааруулан авч үзсэн. Үүнд:
  - Эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүд, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд;
  - Тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү.
  - Гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээдүүдийг мөн хамааруулж авч үзнэ.
2. **Хөгжлийн бэрхшээлтэй хүн (ХБХ)** гэх ойлголтод ХБХ-ий эрхийн тухай хуульд заасан тодорхойлолтын дагуу бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг” авч үзсэн. Хөгжлийн бэрхшээлийн төрөл хэлбэрийг авч үзэхдээ манай улсад мөрдөгдөж буй хууль эрх зүйн баримт бичгүүдэд мөрдөгддөг ерөнхий бие махбодын зургаан төрлийн бэрхшээлтэй (хараа, сонсгол, хэл яриа, сэтгэц, хөдөлгөөн, хавсарсан болон бусад) иргэдийг хамруулав.
3. **Гэр бүлийн хүчирхийлэл (ГБХ)** гэх ойлголтод ГБХ-тэй тэмцэх тухай хуульд заасан хүчирхийллийн хэлбэрүүд болон олон улсын судалгааны ажлуудад нийтлэг авч үзэн судалж буй дараах таван хэлбэрийн хүчирхийллийн хэлбэрийг авч үзсэн болно. Үүнд:

- Бие махбодын хүчирхийлэл
- Сэтгэл зүйн хүчирхийлэл
- Эдийн засгийн хүчирхийлэл
- Бэлгийн хүчирхийлэл
- Хянах зан үйлийн хүчирхийлэл

## Судалгааны арга зүй

Чанарын судалгааны хүрээнд баримт бичгийн судалгаа болон анхдагч мэдээлэл цуглуулах зорилгоор кейс болон хагас бүтэцлэгдсэн ярилцлага (ХБЯ)-ын аргуудыг ашигласан. Кейс ярилцлагын аргаар ГБХ-д өртсөн болон өртөх эрсдэлтэй 16-аас дээш насны ХБХ-тэй ярилцлага хийсэн бол ХБХ-ий асран хамгаалагч, хамтарсан баг, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын төлөөлөөс ХБЯ-ын аргаар мэдээлэл цуглуулав.

Оролцогч талуудын хувьд, ГБХ-д өртөх эрсдэлтэй болон өртсөн ХБХ, тэдгээрийн асран хамгаалагчид болон бусад тогтолцооны оролцогч талууд болох албан хаагчидтай уулзаж мэдээлэл цуглуулсан. Судалгаанд хамруулсан талууд, мэдээлэл цуглуулсан аргын дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгтэд нэгтгэн харууллаа.

### Хүснэгт 2. Мэдээлэл цуглуулсан, боловсруулсан арга

#	Оролцогч тал	Мэдээлэл цуглуулсан арга	Мэдээллийг боловсруулсан арга
1	ГБХ-ийн хохирогч болсон, болох эрсдэлтэй 16-аас дээш насны эрэгтэй эмэгтэй ХБХ	<b>Кейс ярилцлага:</b> Амьдралын түүх судлалын аргад үндэслэн зохион байгуулсан. Энэ нь хүний амьдралын түүхийг цаг хугацааны дарааллын дагуу яриулах явцдаа тохиосон онцгой нөхцөл байдлыг тодруулах, түүнд нөлөөлсөн хүчин зүйлийг нь тодорхойлох, баримтжуулах зорилгоор ашигладаг судалгааны эмпирик, арга юм.	ХБХ-ий кейс ярилцлагын мэдээллийг нэн тэргүүнд бэрхшээлийн төрлөөр ангилж боловсруулсан. Мэдээллийг боловсруулахдаа ярилцлагын гол асуултуудын дагуу тухайн оролцогчдын хариултыг ангилах, бүлэглэж кодлох, матриц үүсгэх, ингэхдээ учир шалтгааныг тодруулах индуктив аргуудыг ашиглав.
2	ХБХ-ий асран хамгаалагч	ХБХ-ий асран хамгаалагч талуудтай хийсэн ярилцлагаар гэр бүлийн түүх, орчин, уур амьсгал, ХБХ-ийг асрахад тулгардаг хүндрэл бэрхшээл, хүндрэлтэй нөхцөлд хэрхэн харилцдаг дадлыг тодруулахыг зорьсон.	Асран хамгаалагчтай хийсэн ярилцлагын хариултуудыг бүлэглэж нэгтгэхээс ярилцлага бүрийн мэдээллийг учир шалтгааныг тайлбарлах мэдээлэл зорилгоор ашиглав.
3	Хохирогчид үйлчилгээ үзүүлэгч талууд	ХБХ-ий ГБХ-тэй тэмцэх эрх зүйн орчны өнөөгийн байдал, тогтолцооны үр дүнтэй байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулах, оролцогч талуудын чадавх, давуу болон сул талыг тогтоох, талуудын хамтын ажиллагааны өнөөгийн байдлыг тодруулах замаар цаашид тогтолцооны хувьд сайжруулах шаардлагатай асуудлуудыг тодруулахыг зорьсон.	Ярилцлагуудыг оролцогч талуудаар нь бүлэглэж хариултуудыг нэгтгэж шинжилсэн.

**Мэдээлэл цуглуулалтын газар зүйн хамрах хүрээ.** Талбарын мэдээлэл цуглуулалтыг төслийн зорилтот байршлууд болох Увс, Сэлэнгэ, Сүхбаатар аймгууд, Улаанбаатар хотын Налайх, Сонгинохайрхан дүүрэгт 2020 оны 09 сарын 10-ны өдрөөс 20-ны хугацаанд зохион байгууллаа. Байршлын хувьд мэдээлэл цуглуулалтад доор дурдсан сум, дүүргүүдээс төвийн болон

алслагдмал хороодын төлөөллийг хамруулсан.

1. Увс аймгийн Улаангом, Тариалан сум
2. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Зүүнбүрэн сум
3. Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Асгат сум
4. Улаанбаатар хотын Налайх дүүрэг
5. Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг

**Түүврийн хүрээ:** Судалгааны зорилго, зорилтот хамаарах мэдээллийг ГБХ-д өртсөн, өртөх эрсдэл бүхий 16-аас дээш насны хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй болон эмэгтэйчүүд, ГБХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын мэргэжилтнүүд болон ХБХ-ий асран хамгаалагч нарын төлөөлөлтэй уулзаж цуглуулсан. Нийт түүврийн дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгтэд харууллаа.

#### Хүснэгт 3. Судалгаанд оролцогчид ба түүврийн хэмжээ

#	Оролцогч талууд	Гүйцэтгэл	Үүнээс эмэгтэй
<b>Кейс ярилцлага</b>			
1	ГБХ-ийн хохирогч болсон, болох эрсдэлтэй 16-аас дээш насны ХБХ	150	64%
<b>Хагас бүтэцлэгдсэн ярилцлага</b>			
2	ХБХ-ий асран хамгаалагч	27	92.3%
3	Аймаг, дүүргийн ГБХЗХ-ийн газар, хэлтсийн гэр бүл, хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж буй мэргэжилтэн	5	77.3%
4	Хүчирхийлэл, ХБХ-ий чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ, түр хамгаалах байрны нийгмийн ажилтан	5	
5	Аймаг, дүүргийн цагдаагийн байгууллагын төлөөлөл	10	
6	Аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын эмч ажилтан	9	
7	Сум, хорооны хөгжлийн нийгмийн ажилтан Сургуулийн нийгмийн ажилтан, халамжийн ажилтан	13	
8	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар (ХБХХЕГ)	1	
<b>Нийт</b>		<b>220</b>	<b>70%</b>

#### Хүснэгт 4. Түүврийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Байршил	Түүвэр, бэрхшээлээр					Түүвэр, хүйсээр	
	Хараа	Сонгол, хэл яриа	Хөдөлгөөн	Оюун, сэтгэц	Бусад	Эмэгтэй	Эрэгтэй
УБ, Налайх дүүрэг	5	6	6	6	6	22	7
УБ, СХД	6	5	6	6	6	18	11
Сэлэнгэ аймаг	5	4	7	10	5	23	8
Сүхбаатар аймаг	6	6	5	6	6	12	18
Увс аймаг	5	4	7	9	7	20	11
<b>Нийт</b>	<b>27</b>	<b>25</b>	<b>31</b>	<b>37</b>	<b>30</b>	<b>95 (64%)</b>	<b>55 (36%)</b>

## Судалгаанд оролцогчдын ерөнхий шинж

Энэ хэсэгт ашигласан арга тус бүрээр судалгаанд хамруулсан талуудын хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн ерөнхий шинж чанаруудыг нэгтгэн харууллаа.

**1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн (ХБХ).** Кейс ярилцлагын аргаар нийт 6 төрлийн бэрхшээлийн 150 ХБХ хамрагдсан. Хүйсийн харьцааны хувьд 64% нь эмэгтэй, 36% эрэгтэй байна.

Насны бүтцийн хувьд харьцангуй жигд төлөөлөлтэй: 25% нь 18-29 насны, 30% нь 30-39 насны, 33% нь 40-49 болон 50 түүнээс дээш насны иргэд 12% байна.

**Хүснэгт 5. Судалгаанд оролцсон ХБХ-ий хүйс, насны харьцаа, бэрхшээлийн төрлөөр, (N=150)**


	Хараа	Оюун, сэтгэц	Тулгуур эрхтэн	Сонгол, хэл яриа	Бусад	Нийт
<b>Хүйсийн харьцаа</b>						
Эрэгтэй	26%	28%	43%	41%	38%	36%
Эмэгтэй	74%	72%	57%	59%	62%	64%
<b>Нас</b>						
18-30	26%	12%	21.2%	40%	26%	25,4%
31-40	18.5%	36%	27.3%	40%	26%	29,6%
41-50	44.4%	32%	39.4%	20%	29.6%	33%
50+	11.1%	20%	12.1%	0%	18.5%	12%
<b>Байршлаар</b>						
Улаанбаатар, Налайх	11.1%	14.7%	11.4%	16%	24.1%	15.3%
Улаанбаатар, СХД	33.3%	14.7%	28.6%	28%	17.2%	24%
Увс	18.5%	23.5%	14.3%	16%	20.7%	18.7%
Сэлэнгэ	18.5%	29.4%	22.9%	16%	17.2%	21.3%
Сүхбаатар	18.5%	17.6%	22.9%	24%	20.7%	20.7%

Хэдийгээр тус судалгаа нь нийт ХБХ-ий нөхцөл байдлыг тархаан тайлбарлах зорилго агуулаагүй хэдий ч судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтийн ерөнхий тархалтыг харахад оролцогчдын дунд 41-50 насны иргэдийн хамрагдалт өндөр байсан. Энэ нь энэ насны хүмүүс ГБХ-д илүү хүлцэнгүй ханддаг, энэ нь хүчирхийлэл улам давтагдан үйлдэгдэх нөхцөл байдлыг бүрдүүлж байгаа байдал ярилцлагуудаас ажиглагдаж байлаа.

Гэр бүлийн нөхцөл байдлын хувьд нийт оролцогчдын 6 хувь нь тухайн судалгаа явагдах хугацаанд ганцаараа амьдардаг, 28 хувь нь 2-3 ам бүл, 41 хувь нь 4-5 ам бүл, 23 хувь нь 6-аас дээш ам бүлтэй өрхөд амьдардаг.

Боловсролын хувьд, судалгаанд хамрагдсан иргэдийн 86% нь бүрэн дунд болон түүнээс бага боловсролтой. Боловсролын түвшин бага (огт боловсролгүй, бага боловсролтой) хүмүүсийн ихэнх хувийг оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэд эзэлж байгаа бол дээд боловсрол эзэмшсэн хүмүүсийн ихэнх нь хараа болон тулгуур эрхтний бэрхшээлтэй байна.

**Дүрс 1. Судалгаанд оролцсон ХБХ-ий боловсролын түвшин, бэрхшээлийн төрлөөр, хувь (n=150)**



**2. Асран хамгаалагч:** Асран хамгаалагч нарыг сонгохдоо 16-аас доош насны хүүхэд болон хүнд хэлбэрийн бэрхшээлтэй хүнийг асардаг иргэдийг хамруулсан. Судалгаанд хамрагдсан нийт асран хамгаалагчдын 33 хувьд нь 16-аас доош насны ХБХ асардаг хүн хамрагджээ. Бэрхшээлийн төрлөөр харвал, тархины саажилт, оюуны бэрхшээл, уналт таталт, нуруу нугасны гэмтэл болон бусад шалтгаанаар тулгуур эрхтний бэрхшээлтэй болсон хүнд хэлбэрийн байнгын асаргаа шаардлагатай ХБХ-ийг асардаг. Нийт 27 төлөөлөл судалгаанд хамрагдсаны 24 нь эмэгтэй байна. Боловсролын хувьд 14 хувь нь дээд, 67 хувь нь бүрэн дунд боловсролтой. Гэр бүлийн хувьд 18 хувь нь 2-3 ам бүлтэй, 48 хувь нь 4-5, 18 хувь нь 6-аас дээш гишүүнтэй өрхөд амьдардаг.

Асран халамжилж буй ХБХ нь гол төлөв төрсөн хүүхэд (17 ХБХ) байх бөгөөд бусад нь нөхөр, ач зээ, эцэг эх болон төрөл садангаа асардаг байв. Мөн судалгаанд оролцогчдын нөхцөл байдлыг авч үзвэл асран хамгаалагчид нь зөвхөн ХБХ-ийг асраад зогсохгүй, ач зээ, өндөр настай эцэг эхээ давхар асардаг байна. ХБХ-ээ асардаг ээжүүдийн хувьд дийлэнх нь өрх толгойлсон байх нийтлэг шинжтэй байлаа.

**3. Оролцогч талууд:** Судалгаанд төрийн болон ТББ нийлсэн түвшин бүрийн төлөөллийн 43 албан хаагчтай ХБЯ зохион байгуулсан. Нийт албан хаагчдын 77 хувь нь эмэгтэй. Тухайн салбартаа ажилласан жилийг үзвэл 31 хувь нь 5 хүртэлх жил, 18 хувь нь 6-10 жил, 50 хувь нь 10-аас дээш жил ажиллаж буй туршлагатай албан хаагчид хамрагдсан байна.

## Судалгааны хязгаарлагдмал тал

Судалгааны дизайн бүхэлдээ чанарын аргад суурилж явагдсан тул үр дүнг тоон утгаар тайлбарлах нь тохиромжгүй хэдий ч уншигчдад ойлгомжтой байх үүднээс судалгаанд хамрагдсан ХБХ-ий зарим үзүүлэлтүүдийг тоон утгаар илэрхийллээ. Иймд дараах бүлгүүдэд дурдсан тоо, хувиуд нь тухайн бэрхшээлтэй нийт иргэдийн нөхцөл байдлыг төлөөлөхгүй болохыг тэмдэглэх хэрэгтэй. Эдгээр хувиуд нь зөвхөн тус судалгаанд оролцсон иргэдийн нөхцөл байдлын тархалтыг илэрхийлсэн үр дүнгүүд болно. Харин чанарын судалгааны үр дүнгээр илэрсэн учир шалтгааныг тайлбарласан нөхцөл байдлууд нь тухайн бэрхшээлтэй ХБХ-ий нөхцөл байдлыг төлөөлөх боломжтой.

Хоёрдугаарт, ХБХ-ээс мэдээлэл цуглуулсан арга нь кейс судалгааны аргаар явагдсан тул тодорхой асуултад цугларсан нийт хариултын тоо жигд биш байж болно. Өөрөөр хэлбэл, тухайн хүн хариулахаас татгалзсан, зарим тохиолдолд мэдээлэл өгөх боломжгүй байх, хариулж мэдэхгүй байх зэрэг олон шалтгаанаар асуулт бүрд цугласан хариултын тоо ялгаатай байна.

## Тайлангийн бүтэц

Тайланг бүтцийн хувьд (1) ХБХ-ий эсрэг үйлдэгдэж буй ГБХ-ийн өнөөгийн нөхцөл байдал (2) ГБХ-д өртөж буй ХБХ-ийг хамгаалах тогтолцооны нөхцөл байдал, эдгээр үр дүнгээс урган гарсан судалгааны дүгнэлт, зөвлөмж гэсэн дарааллын дагуу боловсрууллаа.

ХБХ-ий ГБХ-д өртөж буй байдалтай холбоотой бүлгийн үр дүн нь хөгжлийн бэрхшээлийн төрөл тус бүрээр нарийвчлагдан танилцуулагдсан. Иймд тайланг уншигчдад ойлгомжтой хүргэх үүднээс ХБ-ийн төрөл тус бүрд холбогдох үр дүнг агуулсан бүлгүүдийг дараах өнгөөр илэрхийллээ.

	Харааны бэрхшээлтэй хүн
	Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүн
	Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүн
	Оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүн
	Бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүн

## 1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭСРЭГ ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хөгжлийн бэрхшээлтэй байх нь хүний сэтгэл зүйн болон бие махбодын хамгаалалтыг сулруулах хүчин зүйл болдог ХБХ гэр бүлийн зүгээс болон нийгмийн бусад бүлгийн зүгээс ялгаварлан гадуурхалт, дарамт, хүчирхийллийн хохирогч болох эрсдэл өндөр байдаг.

Иймд тус судалгааг гүйцэтгэснээр ХБХ-ий ГБХ-д өртөж буй байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг өргөн хүрээнд тодруулах, ГБХ-ийн талаар ХБХ-ий ойлголт мэдлэг болон тусламж дэмжлэг эрэлхийлэх зан үйлийг тодруулахыг зорьсон. Эдгээр зорилтын хүрээнд цуглуулсан анхан шатны мэдээлэл цуглуулалтын үр дүнг дараах дэд бүлгүүдэд танилцууллаа.

### 1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ГБХ-д өртөж буй байдал

Бүлгийн гол үр дүн:

- ❖ **Үр дүн 1:** ХБХ сэтгэл санааны болон хянах зан үйлийн хүчирхийлэлд өртсөн байдал хамгийн нийтлэг байна. Үүнд гэр бүлийн орчинд хэл амаар доромжлох, орилж хашхирах, гадуур гарахыг хориглох, хаашаа явж байгаага зайлшгүй мэдэгдэх, зөвшөөрөл авах зэрэг шаардлагуудтай байнга тулгардаг.
- ❖ **Үр дүн 2:** ГБХ-ийн хэлбэрүүдэд тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүс илүү өртсөн бол эрсдэлийн түвшингээр харааны бэрхшээлтэй иргэд илүү хүчирхийллийн ноцтой нөхцөлд орж байсан байна.

Нийт судалгаанд оролцсон ХБХ-ий 74 хувь (n=111) нь ГБХ-ийн аль нэг хэлбэрт өртсөн байсан. Тэдгээр ХБХ-ий хүн ам зүйн мэдээллийг Хүснэгт 6-д харуулав. Үлдсэн хувийг одоогийн байдлаар хүчирхийлэлд өртөөгүй хэдий ч гэр бүлийн нөхцөл байдлыг харгалзвал хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй гэж үзсэн хүмүүс бүрдүүлсэн байна.

ГБХ-д өртсөн байдлыг судалгаанд оролцогчдын нас, хүйс, байршлаар харвал (Хүснэгт 6):

- Хүйсээр харьцуулж үзвэл, ГБХ-д өртсөн хохирогчдын дийлэнх нь (72.1%) эмэгтэйчүүд;
- Насны бүлгээр харьцуулж үзвэл, 31-ээс дээш насныхны өртсөн байдал бусад бүлгээс илүү өндөр;
- Байршлаар харьцуулж үзвэл, ГБХ-д өртсөн байдал Сэлэнгэ аймаг болон Нийслэлийн СХД-ийн оролцогчдоос тооны хувьд олон хамрагдсан байна.


Хүснэгт 6. ГБХ-д өртсөн ХБХ-ий хүйс, насны харьцаа, бэрхшээлийн төрлөөр, (n=111)

	Хараа	Сонгол, хэл яриа	Тулгуур эрхтэн	Оюун, сэтгэц	Бусад	Нийт
<b>Хүйсийн харьцаа</b>						
Эрэгтэй	6.7%	25%	42.4%	27.3%	23.8%	27.9%
Эмэгтэй	93.3%	75%	57.6%	72.7%	76.2%	<b>72.1%</b>
<b>Нас</b>						
18-30	26.7%	15%	19.4%	36.8%	25.0%	23.8%
31-40	20.0%	40%	25.8%	47.4%	30.0%	<b>32.4%</b>
41-50	46.7%	35%	41.9%	15.8%	30.0%	<b>34.3%</b>
50+	6.7%	10.0%	12.9%	0.0%	15.0%	9.5%
<b>Байршлаар</b>						
Улаанбаатар, Налайх	18.8%	15.8%	12.1%	22.7%	33.3%	19.8%
Улаанбаатар, СХД	37.5%	26.3%	30.3%	13.6%	19%	<b>25.2%</b>
Увс аймаг	0	21.1%	9.1%	22.7%	9.5%	12.6%
Сэлэнгэ аймаг	31.3%	21.1%	24.2%	36.4%	19%	<b>26.1%</b>
Сүхбаатар аймаг	12.5%	15.8%	24.2%	4.5%	19%	16.2%

Хүчирхийлэлд өртсөн оролцогчдын хувьд сэтгэл санаа болон хянах зан үйлийн хүчирхийлэлд өртсөн байдал хамгийн өндөр байв (Дүрс 2). Гэвч сэтгэл санааны хүчирхийлэл нь дангаар үйлдэгдэхээс гадна бусад хүчирхийллийн хэлбэрүүдтэй хавсран үйлдэгддэг тул бусад хүчирхийллийн хэлбэрүүдтэй холбон ойлгох шаардлагатай. Харин хянах зан үйлийн хүчирхийллийн хувьд ХБХ-ий бэрхшээлийн онцлог, гэр бүлийн гишүүдээс хамааралтай, тусламж дэмжлэг авдаг байдлаас үүдэн ХБХ-ий бие даасан байдал (шийдвэр гаргах, нийгмийн харилцаанд бие даан оролцох зэрэг) бага байгаатай холбоотойгоор үйлдэгдсэн байдал их байсан.

Нөгөө талд, хянах зан үйлийн хүчирхийлэл үйлдэгдэхээс гадна гэр бүл дотор ХБХ-ийг үл хайхрах байдал маш түгээмэл байсан. Ялангуяа, ХБХ-ийг багаас нь сурч боловсрох боломж олголгүй, хайхралгүй орхих нь нийгмийн харилцаа, хөдөлмөр эрхлэлт дараа дараагийн амьдралын олон боломжийг нь хязгаарласан байв. Ялангуяа, дээрх байдал орон нутагт илүү ажиглагдсан. Гэр бүлийн гишүүдийн зүгээс ХБХ-ийг чадавхгүй, хөгжих боломжгүй гэж үзэж байгаагаас биологийн суурь хэрэгцээг хангах харилцаа л гэр бүлийн орчинд явагдаж байгаа харамсалтай дүр зураг судалгааны явцад олон тааралдаж байлаа.

Дүрс 2. Дор хаяж нэг удаа ГБХ-ийн хэлбэрт өртсөн ХБХ-ий хувь, ХБ-ийн төрлөөр



ГБХ-ийн хэлбэрүүдэд аль нэг төрлийн бэрхшээлтэй иргэд илүү өртөмтгий байх шинж ажиглагдаж байсан хэдий ч нийтлэг дүр зургаар тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн бүх хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн байдал хамгийн өндөр байв.

Хүчирхийллийн хэлбэрүүдийн хавсарсан байдлыг авч үзвэл, хүчирхийллийн зөвхөн 1-2 хэлбэрт өртсөн ХБХ бага байх ба ихэнх нь хүчирхийллийн 3 ба түүнээс дээш хэлбэрүүдэд хавсарсан байдлаар өртсөн. Нийт ГБХ-д өртсөн хүмүүсийн дийлэнх нь буюу 46% нь хүчирхийллийн 5 хэлбэрт бүгдэд нь өртсөн шинжтэй байна (Дүрс 3).

Дүрс 3. ХБХ-ий ГБХ-д өртсөн байдал, хүчирхийллийн давхардлаар



Харин үйлдэгдсэн хүчирхийллийн аюулын түвшнийг авч үзвэл, нийт ГБХ-д өртсөн ХБХ-ий 35 хувь нь маш аюултай буюу тухайн хүний амь насанд ч хүрч болох эрсдэлтэй нөхцөлд орж байсан нь анхаарал хандуулах үр дүн юм. Бэрхшээлийн төрлөөр нь үзвэл харааны бэрхшээлтэй хүмүүс бусад ХБХ-ээс илүү аюултай нөхцөлд ГБХ-д өртсөн байна (Дүрс 4).

Дүрс 4. ХБХ-ий өртсөн ГБХ-ийн аюулын түвшин<sup>1</sup>, %

Үүнээс гадна, шууд ХБХ рүү чиглэсэн хүчирхийлэл үйлдээгүй ч гэр бүл доторх хүчирхийлэлтэй харилцааны **дам хохирогч болох байдал** байна. Ихэнх тохиолдолд, ХБХ асран хамгаалагчаасаа хамааралтай амьдардаг. Гэтэл ХБХ-тэй гэр бүлийн нийгэм эдийн засгийн шинжийг авч үзвэл дийлэнх тохиолдолд орлогын түвшин доогуур, өрх толгойлсон, олон хүүхэдтэй зэрэг зорилтот өрхийн шинжтэй байх ба олон талын шалтгаанаар гэр бүлийн хэрүүл маргаан өдөр тутамдаа үүсдэг байна. Энэ тохиолдолд ГБХ шууд ХБХ рүү чиглээгүй хэдий ч эцэг эх, ах дүү, хүргэн, бэр, хамаатан садан зэрэг бусад гишүүдийн хоорондох хүчирхийлэлтэй харилцааны дам хохирогч нь болсон тохиолдлууд олон байв.

ГБХ-ийн хэлбэр тус бүрээр нийтлэг ажиглагдсан судалгааны үр дүнг дурдвал:

**Сэтгэл санааны хүчирхийллийн хувьд:** ГБХ-ээс хамгийн нийтлэг үйлдэгдэж буй хүчирхийллийн хэлбэр. Хүчирхийлэлд өртсөн нийт оролцогчдын 91 хувь нь буюу бараг бүгд сэтгэл санааны хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртсөн байна. Тус хэлбэр нь дангаар үйлдэгдэхээс гадна бусад хэлбэрийн хүчирхийлэлтэй хавсарч үйлдэгдэх байдал түгээмэл байсан. Бэрхшээлийн хувьд **хараа, тулгуур эрхтний бэрхшээлтэй** хүмүүсийн тус хэлбэрийн хүчирхийлэлд өртөх байдал илүү өндөр байв.

**Хянах зан үйлийн хүчирхийллийн хувьд:** Сэтгэл санааны хүчирхийллийн адил хамгийн нийтлэг үйлдэгдэж буй хүчирхийллийн хэлбэр байв. Нийт ГБХ-д өртсөн ХБХ-ий 83 хувь нь хянах зан үйлийн хүчирхийлэлд өртсөн. Хохирогчид нь нийтлэг **гэр бүлтэй болсон эмэгтэйчүүд** байх ба хардалтын сэдлээр үйлдэгдэж байсан. Өөрөөр хэлбэл, ямар бэрхшээлтэй байхаас үл хамаараад гэр бүлтэй л бол дээрх хүчирхийллийн хэлбэрт өртөж байв.

Илэрч буй хэлбэрийн хувьд бэрхшээлийн төрлөөс үл хамааран ХБХ-ийг гадуур гарахад нь дургүйцэх, найз нөхөдтэйгөө уулзахыг хориглох, хэрэв гадуур гарсан тохиолдолд заавал хаана байгаага мэдэгдэх, зөвшөөрөл авахыг шаардах зэрэг үйлдлүүд түгээмэл тохиолдсон байв. Эдгээр үйлдлүүд нь ХБХ-ий аюулгүй байдалд санаа тавих гэхээс илүүтэй тухайн хүний үйлдлийг хянах, цагдах санаа зорилготой, энэ нь ихэвчлэн ХБХ-ийг сэтгэл зүйн хувьд дарамтад оруулдаг болохыг тус хүчирхийлэлд өртсөн бүх ХБХ дурдсан.

**Бие махбодын хүчирхийллийн хувьд:** Зугтах, эсэргүүцэл үзүүлэх боломж хязгаарлагдмал ХБХ-ий эмзэг байдлыг далимдуулан бие махбодын хүчирхийлэл үйлдсэн тохиолдол нийт хүчирхийлэлд өртсөн

<sup>1</sup> Аюулын түвшний үнэлгээг ХЗДХ-ийн сайдын 2020 оны А/83 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Аюулын зэргийн үнэлгээ хийх журам”-ын дагуу батлагдсан “Хүчирхийллийн аюулын зэргийг тодруулах асуултуудыг ашигласан.

хүмүүсийн 77 хувийг эзэлж байв. Бэрхшээлийн хувьд **хараа, сонсгол, тулгуур эрхтний бэрхшээлтэй** хүмүүсийн тус хэлбэрийн хүчирхийлэлд өртөх байдал илүү өндөр. Илрэх хэлбэрийн хувьд алгадах, юмаар цохихоос авхуулаад хутга, мэсээр айлгах, гэмтээх, хоолой боох зэрэг аюултай үйлдлүүд хүртэл олон хүнд тохиолдсон. Дээрх хэлбэрийн хүчирхийллийг үйлдэхдээ хүчирхийлэгч нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн байх нийтлэг шинжтэй байна.

**Эдийн засгийн хүчирхийллийн хувьд:** Бэрхшээлийн хувьд **тулгуур эрхтэн, оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй** хүмүүсийн тус хэлбэрийн хүчирхийлэлд өртөх байдал илүү өндөр. Хүчирхийлэлд өртсөн ХБХ-ий гэр бүлийн санхүүгийн чадавхыг харвал бүгд орлогын түвшин доогуур эмзэг, зорилтот бүлгийн өрхүүд байсан. Нийтлэг шинжийг дурдвал олон хүүхэдтэй, өрх толгойлсон, өвөө, эмээ, ач зээ, ах дүү хамаатан садан нэг дор амьдрах хэлбэр буюу өргөтгөсөн гэр бүлийн шинжүүд нийтлэг байв. Харамсалтай нь бүл олонтой ч орлогын түвшин доогуур, ихэнх өрхийн санхүү нь (1) ХБХ-ий халамжийн тэтгэвэр<sup>2</sup>, (2) хүүхдийн мөнгөн тэтгэмж<sup>3</sup>, (3) хүнсний талон болон (4) бусад эх сурвалжуудаас бүрдэж байв. ХБХ-ий тэтгэврийн мөнгө ХБХ-ий хэрэгцээнээс илүү тухайн өрхийн гишүүдийн хэрэглээнд зарцуулагдах байдал нийтлэг. Халамжийн тэтгэвэрт хэдэн төгрөг авдаг, хэрхэн зарцуулагддаг талаар огт мэдээлэлгүй, ойлголтоггүй хүмүүс маш олон байсан нь тэдгээр хүмүүс эдийн засгийн хүчирхийлэлд хэр өртөж байгааг харуулж байлаа.

**Бэлгийн хүчирхийллийн хувьд:** Бэрхшээлийн хувьд **тулгуур эрхтэн, хараа, сонсголын бэрхшээлтэй** хүмүүсийн тус хэлбэрийн хүчирхийлэлд өртөх байдал илүү өндөр. Судалгаанд хамрагдсан ГБХ-ийн хохирогч болсон хүмүүсийн дийлэнх нь гэрлэсэн, гэр бүлтэй байсан. Өөрөөр хэлбэл, ГБХ өөрийнх нь зохиосон хоёрдогч гэр бүлд тохиосон байв. Гэвч оролцогчдын дунд бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдол багагүй байсан бөгөөд ялангуяа хүсээгүй үед нь эмэгтэйд хүчээр бэлгийн харилцаанд оруулах явдал хамгийн нийтлэг байв. Уг үйлдэл нь нөхөр, найз залуу, хамтран амьдрагч зэрэг гэр бүлийн хамтрагчийн зүгээс үйлдэгдэж байгаа нь манай улсад гэр бүлийн харилцаа болон жендэрийн талаар хэвшмэл ойлголт хэр бат бөх байгааг харуулж байсан. Энэ нь хүний хувийн орон зайд хүндэтгэлтэй хандах ойлголт байхгүйгээс эмэгтэй хүнийг бэлгийн хэрэгцээгээ хангах хэрэгсэл зорилгоор хандах, хүндэтгэлгүй харьцах, бэлгийн харилцаанд хувь хүний хүсэл сонирхлыг харгалзахгүй байх нөхцөл байдал нийтлэг ажиглагдаж байлаа. Нөгөө талд, эмэгтэйчүүдийн зүгээс ч мөн ижил нөхөртэйгөө хүсээгүй үедээ бэлгийн харилцаанд орж буйгаа хүчирхийлэл болохыг огт хүлээн зөвшөөрөхгүй хандлага ажиглагдаж байсан.

ГБХ-ийн хэлбэр тус бүрээр гарсан гол үр дүнг дээр дурдлаа. Хэдийгээр ХБХ хөдөлмөрийн чадвар алдалттай гэх нэг тодорхойлолтод багтдаг хэдий ч бэрхшээлийн онцлог, хүндрэлийн түвшин зэргээс шалтгаалаад тус бүрд тулгарах хүндрэл бэрхшээл ялгаатай байсан. Иймд, ХБХ-ий өртөж буй хүчирхийллийн хэлбэрийг хөгжлийн бэрхшээлийн төрөл тус бүрээр дараах бүлгүүдэд дэлгэрэнгүй авч үзлээ.

---

2 COVID-19-ээс урьдчилан сэргийлж, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулахад иргэддээ санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээг 2020 оны 5 сарын 1-нээс 12 сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд сар бүр 100,000 төгрөгөөр нэмэгдүүлж, 288,000 төгрөг болгосон.

3 Коронавирусээс урьдчилан сэргийлж, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулахад иргэддээ санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2020 он дуустал 100,000 төгрөг болгож нэмэгдүүлсэн

### 1.1.1 Харааны бэрхшээлтэй хүн

Судалгаанд харааны бэрхшээлтэй 27 хүн хамрагдсан. Хараагаа алдсан шалтгааныг авч үзвэл 60 хувь нь төрөлхийн бол үлдсэн хүмүүс нь нүдний даралт, судасны нарийсал, ахуйн бэртэл гэмтэл, зам тээврийн осол, эм тарианы хордлогоос болж бэрхшээлтэй болсон байна.


Эдгээр хүмүүсийн 55.6 хувь (n=15) нь ГБХ-ийн аль нэг хэлбэрт өртөж байсан. Хүчирхийллийн аюулын зэргээр авч үзвэл эрсдэлийн түвшин дундаас дээш бүлэг нь нийт хүчирхийлэлд өртсөн оролцогчдын 67 хувийг эзэлж байсан нь аюулын түвшний хувьд бусад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс хамгийн өндөр нь байв.

Хүйсийн хувьд хүчирхийлэлд өртсөн бүх хохирогчид нь эмэгтэйчүүд. Хүчирхийлэл үйлдэж буй гол этгээд нь нийтлэг нөхөр, найз залуу (81%), үлдсэн нь ойрын ах дүү, хамаатан садны (эгчийн нөхөр, нагац ах, ах дүү) хүмүүсээ нэрлэсэн байна.

Хүчирхийллийн хэлбэрийн хувьд, сэтгэл санааны (100%), бие махбодын (80%) болон хянах зан үйлийн (73.3%) хүчирхийлэлд өртөх байдал нийтлэг байна (Дүрс 6). Ихэвчлэн гэр бүлийн орчинд болон бусад гаднын хүний дэргэд хэл амаар доромжлох байдал түгээмэл тохиолдохоос гадна хөгжлийн бэрхшээлийнх нь онцлогоос шалтгаалан хаана байгааг нь байнга асуух, хаашаа явж хэнтэй уулзах, ямар ажлаар явж байгаагаа заавал мэдэгдэхийг шаардах зэрэг хэлбэрүүд нийтлэг тохиолддог байна.

Дээрх ГБХ-ийн хэлбэрүүдийн хавсарсан байдлыг авч үзвэл, ГБХ-д өртсөн нийт харааны бэрхшээлтэй хүний 80 хувь нь хүчирхийллийн 3 ба түүнээс дээш хэлбэрүүдэд давхар өртсөн байна (Дүрс 3).

Дүрс 6. ГБХ-ийн 5 төрлийн илрэх хэлбэрүүдээс дор хаяж нэг хэлбэрт өртсөн харааны бэрхшээлтэй хүмүүсийн хувь, (n=27)




Харааны бэрхшээлтэй хүмүүстэй ярилцлага хийх явцад бэрхшээлтэй иргэд дотроо ялгаварлан гадуурхалт их байдаг талаар дурдаж байсан бөгөөд үүний гол суурь нь боловсролын түвшин байна. Харааны бэрхшээлтэй оролцогчдын ярьж буйгаар боловсрол өндөртэй гэх ойлголт нь брайл бичиг үсэгт суралцсан эсэхээр тодорхойлогддог. Гэвч орон нутаг дахь харааны бэрхшээлтэй хүмүүсийн хувьд брайл бичиг үсэгт суралцсан байдал маш бага байгаагаас ажил хөдөлмөр эрхэлж, бие даан амьдрах

боломж хязгаарлагдмал, үүнээс үүдэн ажил хөдөлмөр эрхлэх, нийгмийн харилцаанд оролцох боломж тун хязгаарлагдмал байдаг тухай оролцогчид дурджээ.

Харааны бэрхшээлтэй хүмүүсийн ГБХ-д өртсөн байдлыг хүчирхийллийн хэлбэр тус бүрээр авч үзвэл:

**1. Сэтгэл санааны хүчирхийлэл:** ГБХ-д өртсөн харааны бэрхшээлтэй хүмүүс бүгд аль нэг хэлбэрийн сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн байв. Тус хэлбэрийн хүчирхийллийг таних зорилгоор өгөгдсөн үйлдлүүдээс хамгийн түгээмэл нь гэр бүлийн орчинд болон бусад гаднын хүний дэргэд хэл амаар доромжлох, орилж, ашгичих үйлдлүүд байсан.

### Дүрс 7. ГБХ-д өртсөн харааны бэрхшээлтэй хүмүүсийн сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн байдал, %



#### Шигтгээ 1. Сэлэнгэ аймаг, харааны бэрхшээлтэй, 34 настай, эмэгтэй

Би хоолоо тэмтэрч байгаад хийдэг учраас жаахан удаан хийдэг. Нөхөр орой ирээд хоолоо хурдлаач, сохороо гээд л уурлана. Байнга л сохороо гэнэ, бас ална шүү гэдэг үгийг хэрэглэдэг.

#### Шигтгээ 2. Увс аймаг, харааны бэрхшээлтэй, 42 настай, эмэгтэй

2 хүүхдийнхээ хажууд байнга хэлэх хэлэхгүй үгээр хэлдэг. Энэ бол байнга, өдөр болгон тохиолддог. Утсыг минь аваад хана руу шидээд хаалга үүдээ түгжиж байгаад зоддог. Тэгээд ирлээ гэхээр нь дүүгээ дуудаад хамт хонодог юм. Хэрэв дүү байхгүй бол ээжийндээ очоод хоночихдог. Дүүгийн маань хажууд бариад зодчихгүй ч байнга дарамталж хэл амаар доромжилдог.

**2. Хянах зан үйлийн хүчирхийлэл:** ГБХ-д өртсөн харааны бэрхшээлтэй иргэдийн 73 хувь (n=11) нь хянах зан үйлийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан. Тэдгээр үйлдлүүдээс хөгжлийн бэрхшээлийнх нь онцлогтой холбоотойгоор гадуур гарах, найз нөхөдтэйгөө уулзахыг хориглох, гарахаар бол хаана байгааг нь байнга асуух, хаашаа явж хэнтэй уулзах, ямар ажлаар явж байгаагаа заавал мэдэгдэж, зөвшөөрөл авахыг шаардах зэрэг хэлбэрүүд нийтлэг тохиолддог байна. Эдгээр хэлбэрүүдийг оролцогчид өөрсдийнх нь аюулгүй байдалд санаа тавих гэхээс илүүтэй үйлдлийг хянах, цагдах сэдэлтэй холбож тайлбарлаж байсан (Дүрс 8).

### Дүрс 8. ГБХ-д өртсөн харааны бэрхшээлтэй хүмүүсийн хянах зан үйлийн хүчирхийлэлд өртсөн байдал, %



#### Шигтгээ 3: Сонгинохайрхан дүүрэг, харааны бэрхшээлтэй, 31 настай, эмэгтэй

Манай гэрийнхэн найз нөхөд, эрэгтэй хүнтэй ёстой ойртуулахгүй шүү дээ. Хараагүй хүн, сургууль соёлд ч сураагүй байж гэдэг. Манай эмээгийн ах, дүү нар олуулаа болохоор дахиад нэг хүүхэд гаргаад ирнэ гэдэг. Одоо хүртэл найзгүй л байгаа.


#### Шигтгээ 4: Сэлэнгэ аймаг, харааны бэрхшээлтэй, 42 настай, эмэгтэй

Нөхөр ажил дээрээ байхдаа өдөрт 3-4 удаа залгаж ярьдаг. Тэгээд хүүхэдтэйгээ ярьж байж итгэдэг. Залгах үед нь хүүхэд хичээлдээ явчихсан байна гэвэл худлаа ярилаа гээд бөөн юм болно. Хаана байна, юу хийгээд хаана очоод хэвтээд байгаа юм гээд л шалгаана. Гэр орон орхиод гарсан байвал жинхэнэ ална шүү гэдэг.

Хот явж эмнэлэгт үзүүлэхдээ заавал өөрөөс нь асууж явахгүй бол болохгүй. Заавал өдөртөө ирээрэй гээд явуулдаг.

**3.Бие махбодын хүчирхийлэл.** ГБХ-д өртсөн харааны бэрхшээлтэй хүмүүсийн 80 хувь (n=12) нь бие махбодын хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан. Харааны бэрхшээлтэй хүмүүс аюултай нөхцөлд орсон ч биеэ хамгаалах талаар хурдан арга хэмжээ авах (зугтах, бултах, тусламж дуудах) боломж хязгаарлагдмал байдаг нь хүчирхийлэлд өртөх үед өөрийгөө хамгаалах, тусламж дэмжлэг эрэлхийлэхэд сул тал болдог байна. Тус эмзэг байдлыг хүчирхийлэгч далимдуулан гараараа болон бусад гэмтээж болохуйц эд зүйл шидэх, түлхэх, өшиглөх зэрэг бие махбодын хүчирхийллийн хэлбэрүүдийг нийтлэг үйлддэг байна (Дүрс 9).

Дүрс 9. ГБХ-д өртсөн харааны бэрхшээлтэй хүмүүсийн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байдал, %



**Шигтгээ 5: Сэлэнгэ аймаг, харааны бэрхшээлтэй, 42 настай, эмэгтэй**

Дандаа толгой уруу гараараа цохино. Өнгөрсөн 2 сард бие маань өвдөөд хэвтэрт орчихсон байхад нэг хоолой боож байсан. Азаар бага хүү маань ахыгаа дуудаад салгасан. Тэр үедээ би ухаан алдаад уначихсан байсан. Дандаа түлхэж унагаана, толгой уруу цохино. Хавирга уруу нэг удаа өшиглөсөн. Одоо болтол энд (хавирга уруугаа заав) өвдөөд байдаг юм. Бас 2 сард над уруу хутга бариад дайрсан. Би өөрөө хэвтэрт байсан болохоор манай нэг найз хүүхэн надад хоол хийж өгөх гээд ирчихсэн байж таараад аврагдсан.


**Шигтгээ 6: Сонгинохайрхан дүрэг, харааны бэрхшээлтэй, 29 настай, эмэгтэй**

Нөхөр нууц амрагтай болсныг нь мэдсэнээс хойш манай гэр бүлд хүчирхийлэл улам даамжрах болсон. Хүүхдээ миний хүүхэд биш, намайг шөнө унтаж байхад ухаан алдуулах зэрэг, гэнэт би хаана унтаж байгаа билээ, хүүхдэдээ сүүг нь өгсөн билүү ялаа гээд цочиж сэрдэг. Тэгээд дараа нь толинд харахаар хүзүү маань их улайлттай болчихсон байдаг байсан. Нэг өдөр бөөн хэрүүл зодоон болоод энэ миний хүүхэд биш гээд жоохон 6 сартай охиноо хананд саваад цагдаа дуудах юм бол ална гээд орцоор нэг юм болоод хүн амьтнаар дуудуулаад ямар ч байсан цагдаа дуудсан. Шүүх цагдаа гэж яваад тэр хүн 1.6 жилийн чанга дэглэмтэй хорих ял авсан. Хотод ирээд тайвшраад тэр хүнийг харахгүй болсноос хойш 6 сартай жирэмсэн байснаа мэдсэн. Ингэж амьдарч байхаар үхээд өгье гэсэн бодол надад байсан өөр лүгээ хутга ч дүрж үзсэн.

**4.Эдийн засгийн хүчирхийлэл.** ГБХ-д өртсөн харааны бэрхшээлтэй хүмүүсийн 66 хувь (n=10) нь эдийн засгийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан. Харааны бэрхшээлтэй хүмүүс бэрхшээлийнхээ онцлогоос шалтгаалан санхүүгийн харилцаанд бие даан оролцох боломж хязгаарлагдмал, мөнгөө харж, тоолох боломжгүйгээс асран хамгаалагч эсвэл гэр бүлийн бусад гишүүд ажлын хөлс болон халамжийн тэтгэвэр зэрэг орлогыг нь хариуцан, зарцуулдаг. Ялангуяа энэ байдал орон нутагт илүү ажиглагдаж байв. Ярилцлагын явцад ихэнх оролцогчид хэдэн төгрөг халамжаас авдаг

талаар сайн мэдэхгүй, гэхдээ миний эмчилгээ, эм тан, хувцас гээд хэрэгцээнд зарцуулдаг гэж хариулж байсан хэдий ч эдгээр иргэдэд эдийн засгийн эрх мэдэл бага байгаа нь харагдаж байлаа (Дүрс 10).

**Дүрс 10. ГБХ-д өртсөн харааны бэрхшээлтэй хүмүүсийн эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн байдал, %**



**Шигтгээ 7: Сонгинохайрхан дүүрэг, харааны бэрхшээлтэй, 31 настай, эмэгтэй**

*Би 20 настайгаасаа эхэлж ажил хийж эхэлсэн. Гэхдээ цалингаа авдаггүй эмээгийн том охин л авдаг байсан. Халамж гэж ч мэддэггүй байсан. Манай эмээгийн том охин халамжийг бүгдийг нь авчихна. Ер нь мөнгийг эмээгийн том охин бүгдийг нь барьдаг. Би мөнгө гэдгийг мэдэхгүй, тоо ч мэдэхгүй. Саяхнаас хотод орж ирээд л мөнгөний тоо мэддэг болж, мөнгөө яаж зарцуулахыг мэддэг болж байна. Ер нь бол би хаашаа ч гардаггүй гэрийн л хүн байсан.*

**Шигтгээ 8: Увс аймаг, харааны бэрхшээлтэй, 27 настай, эмэгтэй**

*Бүх тэтгэмж, халамжийн мөнгө хэд байдгийг мэдэхгүй. Ээж аав аваад надаа зарцуулдаг. Эмчилгээнд явуулдаг. Тариа энэ тэр хийж өгөөд, хувцас авч өгдөг.*

**5. Бэлгийн хүчирхийлэл.** ГБХ-д өртсөн харааны бэрхшээлтэй хүмүүсийн 53 хувь (n=8) нь бэлгийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан. Түүний илрэх хэлбэрүүдээс хүсээгүй байхад биеийн эмзэг хэсэгт нь хүрэх тохиолдол нийт ГБХ-д өртсөн хохирогчдын 53.3 хувьд нь тохиолдсон байна. Хамтрагч, нөхөр, найз залуугийн зүгээс хүчээр, хүсээгүй үед нь бэлгийн харилцаанд оруулах явдал олон тохиож байсныг оролцогчид ярилцлагадаа дурджээ. Энэ нь хосын, гэр бүлийн харилцааны талаар иргэдийн дунд уламжлалт ойлголт маш бат бөх байгааг илэрхийлэх бөгөөд эмэгтэй хүнийг бэлгийн сонирхлын үүднээс харах, хувь хүний хувийн орон зайд хүндэтгэлгүй хандах байдал түгээмэл байгааг харуулж байв (Дүрс 11).

**Дүрс 11. ГБХ-д өртсөн харааны бэрхшээлтэй хүмүүсийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдал, %**



**Шигтгээ 9: Увс аймаг, харааны бэрхшээлтэй, 27 настай, эмэгтэй**

*Өмнө үерхэж байсан залуу хүсээгүй байхад хүчээр бэлгийн харилцаанд орох тохиолдол зөндөө байсан. Гэхдээ би надад сайн болохоор л тэгж байна гэж боддог байсан.*

**Шигтгээ 10: Сэлэнгэ аймаг, харааны бэрхшээлтэй, 39 настай, эмэгтэй**

*Манай ээжийн ах нь намайг 10 жилд байхад оролддог байсан. Гэхдээ яг бэлгийн харьцаанд бол орж байгаагүй. Манайх энд шилжиж ирээд байх газаргүй байсан болохоор нагац ахынд байдаг байсан. Тэгээд нагац ах маань намайг дарж аваад өмдөн дотор гараа хийх зэрэг үйлдэл гаргадаг байсан.*

### 1.1.2 Сонголын бэрхшээлтэй хүн

Судалгаанд сонголын бэрхшээлтэй 25 хүн хамрагдсан. Сонголоо алдсан шалтгааныг авч үзвэл 20 хувь нь төрөлхийн бол үлдсэн хүмүүс нь хүүхэд байхдаа хийсэн эмчилгээ, хүчтэй антибиотикийн хордлого, ахуйн осол гэмтэл, гэр бүлийн болон ажлын орчин дахь хүчирхийллийн улмаас сонголоо алдсан байна.

Тэдгээр иргэдийн 80 хувь (n=20) нь ГБХ-ийн аль нэг хэлбэрт өртөж байсан. Хүчирхийллийн эрсдэлийн түвшнийг авч үзвэл нийт ГБХ-д өртсөн оролцогчдын 65 хувь нь эрсдэлийн түвшин бага, 35 хувь нь өндөр байв.

Хүйсийн хувьд хүчирхийлэлд өртсөн хохирогчид нь эрэгтэй, эмэгтэй аль аль хүйсийн төлөөлөл байсан. Хүчирхийлэл үйлдэж буй гол этгээд нь нийтлэг эхнэр, нөхөр (75%) бол үлдсэн хүмүүс нь эцэг эх (18%), ах, эгч дүү (12%) нарыг нэрлэсэн байна.

Чанарын ярилцлагын үр дүнгээс үзэхэд сонголын бэрхшээлтэй хүмүүс ижил бэрхшээлтэй хүнтэй гэр бүл болох байдал нийтлэг ажиглагдаж байсан. Нийгмийн ижилслийн зарчмаар ижил бэрхшээлтэй хүмүүстэй илүү харилцдагаас хоорондоо гэр бүл болох байдал түгээмэл байв. Тухайлбал, судалгаанд хамрагдсан 25 хүний 21 нь гэрлэсэн. Тэдгээрийн 80 хувь нь ижил сонголын бэрхшээлтэй хүнтэй гэр бүл болсон байв.

Гэвч энэ тохиолдолд хүчирхийлэлд өртсөн сонголын бэрхшээлтэй хүмүүсийн хүчирхийлэгч нь ижил төрлийн бэрхшээлтэй нөхөр, хамтран амьдрагч байх нийтлэг дүр зураг харагдаж байсан. Энэ нь ГБХ-д бэрхшээлтэй байх эсэхээс үл хамаараад хүчирхийлэлд өртөгчийн байр сууринд нэг хүйсийн давамгайлал илүү байгаа нь харагдсан. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй байх нь ГБХ-д өртөх сул тал болж байгаа нь тодорхой байсан хэдий ч эмэгтэй байх нь хүчирхийлэлд өртөх, эрэгтэй байх нь илүү хүчирхийлэл үйлдэх хандлага давамгайл байгааг харуулж байв.

Хүчирхийлэл үйлдэгдэж буй хэлбэрийг харвал сэтгэл санааны, хянах зан үйлийн болон бие махбодын хүчирхийлэлд сонголын бэрхшээлтэй хүмүүс илүү өртөмтгий байна (Дүрс 13). Хүчирхийллийн хэлбэрүүдийн хавсарсан байдлыг авч үзвэл, ГБХ-д өртсөн нийт сонголын бэрхшээлтэй хүний 80 хувь нь хүчирхийллийн 3 ба түүнээс дээш хэлбэрүүдэд өртсөн байна (Дүрс 3).

Дүрс 13. ГБХ-ийн 5 төрлийн илрэх хэлбэрүүдээс дор хаяж нэг хэлбэрт өртсөн сонголын бэрхшээлтэй хүмүүсийн хувь, (n=25)



ГБХ-д өртсөн байдлыг хүчирхийллийн хэлбэр тус бүрээр авч үзвэл:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн чанарын судалгаа

**1. Сэтгэл санааны хүчирхийлэл.** ГБХ-д өртсөн сонсголын бэрхшээлтэй иргэдийн 80 хувь (n=16) нь сэтгэл санааны хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан. Түүний илрэх хэлбэрүүдээс гэр бүлийн орчинд хэл амаар байнга доромжлох, юм шидэх, цохиж хагалах зэргээр айлгах үйлдлүүд нийтлэг тохиолдож байна. Эдгээрээс гадна сонирхол татаж буй нэг үр дүн нь сонсголын бэрхшээлтэй хүний сонсож чадахгүй үйлдлийн хязгаарлалтыг нь далимдуулан янз бүрээр хэлдэг, муу муухай үгээр дууддаг, хараадаг, уурлаж, орилж хашхирах үйлдлийг тогтмол гаргадаг тухай оролцогчид ярьж байв. Хэдийгээр бэрхшээлийн онцлогтой холбоотойгоор юу хэлж ярьж байгааг сонсож чадахгүй ч амны хайрцаг болон гэр бүлийн уур амьсгалаас нөхцөл байдлыг бүрэн мэдэрдэг тухай оролцогчид ярилцлагадаа дурджээ.

**Дүрс 14. ГБХ-д өртсөн сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн байдал, %**



**Шигтгээ 11. Сүхбаатар аймаг, сонсголын бэрхшээлтэй, 32 настай, эмэгтэй**

*Урлах, бухимдах, хэл амаар доромжлох асуудал өдөр тутамдаа байдаг. Орилоод л над уруу юм чулуудаад л байдаг. Юу гэж хашхираад байгааг нь сонсож чадахгүй ч ямар ч байсан муухай үгээр л харааж л байдаг байх.*

**Шигтгээ 12. Налайх дүүрэг, сонсголын бэрхшээлтэй, 38 настай, эмэгтэй**

*Сэтгэл санааны хүчирхийлэлд байнга байх их хүнд, бие махбод гайгүй. Хөхрөөд л арилдаг. Явах гэхээр би гэдсээ хүүлчихье шүү гэж сүрдүүлдэг.*

**2. Хянах зан үйлийн хүчирхийлэл.** ГБХ-д өртсөн сонсголын бэрхшээлтэй иргэдийн 85 хувь (n=17) нь хянах зан үйлийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан. Хүчирхийлэлд өртсөн эдгээр оролцогчдыг гэр бүлийн байдлаар нь харвал бүгд гэрлэсэн байсан бөгөөд дийлэнх нь гадуур гарах, найз нөхөдтэйгөө уулзахыг хориглох, хаана байгааг нь байнга асууж шалгаах, хаана байгаагаа өөрт нь заавал мэдэгдэх, зөвшөөрөл авахыг шаардах, өөр эсрэг хүйсийн хүнтэй харилцахад дургүйцэх зэрэг үйлдлүүд нийтлэг тохиолддог талаар дурдсан байна.

**Дүрс 15. ГБХ-д өртсөн сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн хянах зан үйлийн хүчирхийлэлд өртсөн байдал, %**



**Шигтгээ 13. Сэлэнгэ аймаг, сонсголын бэрхшээлтэй, 33 настай, эмэгтэй**

Ажлаа хийгээд цалингаа аваад найзуудтайгаа суух гэхээр манай нөхөр чи яах гэж найзуудтайгаа уулздаг юм, чамд ямар хэрэгтэй юм гээд дургүйцдэг. Энд эрэгтэй хүн байхгүй шүү дээ гэж хэлсэн ч тоохгүй. Би чинь бас хамт олонтой хүн шүү дээ, хааяа бас хамт явмаар л байдаг юм. Тэгээд л би үгэнд нь ороод харьдаг. Үүнийг нь тэвчихээс өөр аргагүй.

**Шигтгээ 14. Сонгинохайрхан дүүрэг, сонсголын бэрхшээлтэй, 35 настай, эмэгтэй**

Намайг гадуур гараад ч хүнтэй харилцаж чадахгүй гээд гэрт хорьдог байсан. Мэдээлэл сайн авч чадахгүй учраас сайн харилцаж чадахгүй байсан. Би өөрөө их даруухан дуугаа хүн. Одоо ч гэсэн жилдээ хэдхэн удаа л гэрээсээ гарч төв ордог.

**3. Бие махбодын хүчирхийлэл.** ГБХ-д өртсөн сонсголын бэрхшээлтэй иргэдийн 80 хувь (n=16) нь бие махбодын хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан. Хүчирхийллийн илрэх хэлбэрийн хувьд алгадах, гараараа цохих зэрэг үйлдлүүдээс гадна хөөх, юм шидэх, түлхэх чирэх зэрэг үйлдлүүд нийтлэг үйлдэгдсэн байна.

**Дүрс 16. ГБХ-д өртсөн сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байдал, %**


**Шигтгээ 15. Налайх дүүрэг, сонсголын бэрхшээлтэй, 38 настай, эмэгтэй**

Манай нөхөр бас сонсголгүй. Гэхдээ гэр бүлээс гадуур харилцаа үүсгэдэг. Манай найз эмэгтэй (хэлгүй) танай нөхөр өөр эмэгтэйтэй чамд 50 мянган төгрөг өгье, хоёулаа унтъя гэж дохисныг надад хэлсэн. Тэгээд нөхрөө ирэхээр нь чи тэгж хэлсэн юм уу гэж асуусан чинь намайг санаанаасаа ямар их юм зохиож ярьдаг юм гээд зодсон.

**Шигтгээ 16. Сэлэнгэ аймаг, сонсголын бэрхшээлтэй, 33 настай, эмэгтэй**

Миний санахад ээж минь намайг их зоддог байсан. Байнга толгой тархи, чих рүү цохидог байсан бөгөөд нэг өдөр чихнээс юм гоождоод нэлээн удсан. Чих их өвдөөд эмнэлэгт хандсан ямар ч эмчилгээ байхгүй гэж хэлсэн. Энэ үеэс л сонсгол хэл ярианы бэрхшээлтэй болсон гэж боддог. Бага наснаас ээж минь чамаас болоод ингэж амьдарч байна гэж үргэлж дарамталж зоддог байсан. Харин хүнтэй суусны дараа нөхөр эдгээр үйлдлийг хийдэг болсон. Архи уухаараа муухай зантай болдог. Архи уусан үедээ байнга хэлээр амаар доромжилно, зодно.

**4. Эдийн засгийн хүчирхийлэл.** ГБХ-д өртсөн сонсголын бэрхшээлтэй иргэдийн 70 хувь (n=14) нь эдийн засгийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан. Бусад ХБХ-тэй харьцуулахад бэрхшээлийн онцлогоос шалтгаалан мөнгө, санхүүгээ өөрөө захиран зарцуулах, удирдахад бэрхшээлээс нь шалтгаалсан хүндрэл бага. Тийм учраас бусад ХБХ-ий эдийн засгийн хүчирхийлэлд өртөж буй байдалтай харьцуулахад энэ талын хүчирхийлэл харьцангуй бага үйлдэгдсэн байсан.

Нийтлэг тохиолдолд сонсголын бэрхшээлтэй эхнэрээ ажил хийхийг, өөрийн гэсэн мөнгөтэй байхыг зөвшөөрөхгүй байх, нөхрүүдийн хувьд өөрөөсөө санхүүгийн хувьд бүрэн хараат байлгах гэсэн сонирхол давамгайлсан байгаа нь ярилцлагын явцад ажиглагдаж байв.

**Дүрс 17. ГБХ-д өртсөн сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн байдал, %**



**Шигтгээ 17. Сүхбаатар аймаг, сонсголын бэрхшээлтэй, 31 настай, эмэгтэй**

*Чи дүлий юм байж гэрийнхээ ажлаа хийгээд хүүхдээ хараад байж бай гэдэг. Манай гэрийнхэн ч ажил хийх гэхээр огт дэмждэггүй.*

**Шигтгээ 18. Сонгинохайрхан, сонсголын бэрхшээлтэй, 32 настай, эмэгтэй**

*Нөхрийн эгч миний утсан дээр аппликейшн суулгаад сүүлийн 2 жилийн хугацаанд нийт 11 аппликейшн дээр 13 саяын зээлийг АРД,Лэнд-ээс миний бичиг баримтыг нь ашиглаад авчихсан. Одоо би 13 сая төгрөгийн өртэй гацчихаад байна. Энэ зээлнээс болоод би цагдаад дуудагдаж байгаа. Би одоо эзжийнхээ ээмэг бөгжийг аваад ломбардад тавиад эхнээсээ өрөө төлж эхэлсэн. Болохгүй бол тэтгэврийн зээл аваад төлнө дөө.*

**5. Бэлгийн хүчирхийлэл.** ГБХ-д өртсөн сонсголын бэрхшээлтэй иргэдийн 50 хувь (n=10) нь бэлгийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан. Тэдгээр хүмүүсийн дийлэнх нь нөхрийнхөө зүгээс өөрийг нь хүсээгүй үед хүчээр бэлгийн харилцаанд оруулж байсан гэж хариулсан байна. Бэлгийн харилцааны хувьд дээрх нөхцөл байдал нь бусад ХБХ-ий хувьд ч мөн адил нийтлэг байгаа нь ажиглагдаж байв.

**Дүрс 18. ГБХ-д өртсөн сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдал, %**



**Шигтгээ 19. Налайх, сонсголын бэрхшээлтэй, 29 настай, эмэгтэй**

*Нөхөр нь хүсээгүй үед хүчээр харилцаанд орох, биеийн эмзэг хэсэгт хүрэх, хийхийг хүсэхгүй зүйл хийхийг байнга шаарддаг. Үгүй гэвэл зодно. Гэхдээ би эхнэр нь учраас үүнийг бол байж болох үйлдэл гэж боддог.*

**Шигтгээ 20. Сэлэнгэ аймаг, сонсголын бэрхшээлтэй, 51 настай, эмэгтэй**

*Би заримдаа бэлгийн харьцаанд орохыг хүсэхгүй байна гэж хэлэхээр уурлана. Хаана хэнтэйгээ унтчихсан юм. Өөр хүнтэй болчихсон юм уу? Гээд л хэрүүл хийнэ. Миний ядарсан байна уу, өвдсөн байна уу хамаагүй. Тэгээд уурлаад байхаар нь за за гээд л унтдаг.*

### 1.1.3 Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүн


Судалгаанд төрөлхийн болон олдмол байдлаар түнхний мултрал, хөлийн тайралт, саажилт, нуруу нугас, хүзүүний гэмтэл, хавдар зэрэг шалтгаанаар хөдөлгөөний бэрхшээлтэй болсон 35 хүн хамрагдсан. Тэдгээр иргэдийн 94 хувь (n=33) нь ГБХ-д өртөж байсан.

Бусад бэрхшээлтэй иргэдээс тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн хүчирхийлэлд өртсөн байдал хүчирхийллийн бүх хэлбэрийн хувьд даруй өндөр дүнтэй байв. Хүчирхийллийн эрсдэлийн зэргийн хувьд 36.6 хувь нь дунд болон түүнээс дээш түвшний эрсдэлтэй нөхцөлд орж байсан.

Хүчирхийлэл үйлдэж буй гол этгээд нь эхнэр, нөхөр (37%) болон төрсөн болон хойд эцэг эх (37%), ах эгч, дүү (18%), төрсөн хүү (8%) нар нь байна.

Хүйсийн хувьд хүчирхийллийн хохирогч нь аль аль хүйсийн хүмүүс байсан. Хүчирхийлэл үйлдэгдэж буй хэлбэрийг харвал сэтгэл санааны, хянах зан үйлийн болон бие махбодын хүчирхийлэлд илүү өртөмтгий. Хүчирхийллийн хэлбэрүүдийн хавсарсан байдлыг авч үзвэл, ГБХ-д өртсөн нийт тулгуур эрхтний бэрхшээлтэй хүний 97 хувь нь хүчирхийллийн 3 ба түүнээс дээш хэлбэрүүдэд өртсөн байна (Дүрс 3).

■ Өндөр ■ Дунд ■ Бага



Дүрс 19. Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн өртсөн ГБХ-ийн эрсдэлийн түвшин


Дүрс 20. ГБХ-ийн 5 төрлийн илрэх хэлбэрүүдээс дор хаяж нэг хэлбэрт өртсөн тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн хувь, (n=35)



ГБХ-д өртсөн байдлыг хүчирхийллийн хэлбэр тус бүрээр авч үзвэл:

**1. Сэтгэл санааны хүчирхийлэл.** ГБХ-д өртсөн тулгуур эрхтний бэрхшээлтэй бүх хүмүүс сэтгэл санааны хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртсөн байсан. Түүний илрэх хэлбэрүүдээс хэл амаар доромжлох байдал нийтлэг илэрдэг нь ихэвчлэн орилж хашхирах байдлаар үйлдэгддэг гэж хариулжээ. Ярилцлагуудаас харахад гэр бүл дотор ХБХ-ийг хөдөлмөрийн чадваргүй гэдэг утгаар нь үл хүндэтгэх, дорд үзэх байдал нийтлэг ажиглагдаж байлаа.

Дүрс 21. ГБХ-д өртсөн тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн байдал, %



**Шигтгээ 21. Сэлэнгэ аймаг, тулгуур эрхтний бэрхшээлтэй, 34 настай, эмэгтэй**


*Бага байхад ээж их харааж, орилж хаширдаг, зоддог байсан. Гичий минь гээд л элдвээр хэлнэ. Одоо бол нэг их тэгж зодож загнаад байхгүй. Гэхдээ л хааяа бас загнуулах цохиулах юм байна. Хоёр хөлийг чинь бүр хугалаад хэвтэрт оруулчихна шүү гэнэ.*

**Шигтгээ 22. Сэлэнгэ аймаг, тулгуур эрхтний бэрхшээлтэй, 45 настай, эрэгтэй**

*Ихэнхдээ мөнгөний асуудлаас болж орилж, хаширч хэрүүл хийдэг. Группын мөнгөө өгөхгүй бол бөөн хэрүүл болно. Хамт гадуур гарах үеэр хүн яарч байхад ямар удаан хиймэл хөлөө өмсдөг юм гээд түлхсэнээс болоод унаад гараа бэртээж байсан. Дүү охин ер нь дандаа л хөлгүй, хөгжлийн бэрхшээлтэй гэж доромжилдог. Дүү охин маань ч гэсэн багаасаа эцгийнхээ хүчирхийлэлд өртсөн болохоор зан авир нь ийм муухай болчихсон.*

**2. Хянах зан үйлийн хүчирхийлэл.** ГБХ-д өртсөн тулгуур эрхтний бэрхшээлтэй бүх хүмүүс хянах зан үйлийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртсөн байсан. Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүний хувьд гадуур явах, зорчиход ихэнх тохиолдолд бусдын туслалцаа, дэмжлэг шаардлагатайгаас гэр бүлийн гишүүд гадуур хамт явахаас төвөгшөөх, гадуур гарахад нь дургүйцэх, хориглох байдал нийтлэг ажиглагдаж байв.

**Дүрс 22. ГБХ-д өртсөн тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн хянах зан үйлийн хүчирхийлэлд өртсөн байдал, %**



**Шигтгээ 23. Сүхбаатар аймаг, тулгуур эрхтний бэрхшээлтэй, 31 настай, эмэгтэй**

*Гадуур гарах гэхээр хөлөө чирээд хаачих гэж байгаа гээд байнга загнана. Гадуур найз нөхөд, хамаатан садантайгаа уулзах ямар ч боломж байдаггүй. Өөр эсрэг хүйсийн хүнтэй таараад мэндлээд таван үг солиод өнгөрөхөд муу янхан гээд эхэлнэ.*

**Шигтгээ 24. Сонгинохайрхан дүүрэг, тулгуур эрхтний бэрхшээлтэй, 40 настай, эмэгтэй**

*Нөхөр маань архины гүн хамааралтай байсан. Нөхрийн дарамтуудаас хамгийн хэцүү нь намайг гадуур гаргахгүй гээд хоёр хөлийн протезыг маань аваад нуучихдаг байсан. Хоёр хүүхэд нялх болохоор өдөржин мөлхөж, хүүхдүүддээ хоол хийж өгч, хашаандаа хүртэл мөлхөж явж бие засдаг байсан.*

**3. Бие махбодын хүчирхийлэл.** ГБХ-д өртсөн тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн 97 хувь нь бие махбодын хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртсөн байсан. Бусад бэрхшээлтэй иргэдтэй харьцуулахад бие махбодын хүчирхийлэлд өртсөн байдал өндөр. Үйлдэгдэж буй хэлбэрийн хувьд гараараа болон эд зүйлээр цохих, гэмтээж болохуйц зүйл шидэх үйлдлүүд нийтлэг тулгарч байна. Хоолой боох, юмаар түлэх, хутга мэс хэрэглэж гэмтээх зэрэг бие махбодын хүчирхийллийн хүнд хэлбэрүүд бусад бэрхшээлтэй иргэдтэй харьцуулахад мөн тулгарсан тохиолдол олон байв.

**Дүрс 23. ГБХ-д өртсөн бие махбодын бэрхшээлтэй хүмүүсийн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байдал, %**



**Шигтгээ 25. Увс аймаг, тулгуур эрхтний бэрхшээлтэй, 45 настай, эмэгтэй**

*Хоолой боох, үсдэх, түлхэх гэх мэт үйлдлүүд байнга болдог байсан. Юмаар түлж байгаагүй. Хутга мэс шиддэг байсан. Миний гуянд хэд хэд хүрсэн. Одоо гуяндаа гурван оёдолтой. Гэхдээ энийг нэг их хүнд гэж бодохгүй байна.*

**Шигтгээ 26. Увс аймаг, тулгуур эрхтний бэрхшээлтэй, 46 настай, эмэгтэй**

*Хүүхдүүдийн аав нь сэтгэцийн өөрчлөлттэй. Архи уучих юм бол энэ тэрүүгээр яваад хүн зодчихсон байдаг. Тийм болохоор согтуу үед нь гадаа амбаарт хийгээд цоожилчихдог. Надаас дөрвөн охин гарсан юм. Нэг охин нь 10 настайд нь аав нь зодоод битүү цус алдалт болоод өнгөрчихсөн. Хамаатан саднууд мэдсэн. Өөрийнхөө хүүхдийг өөрөө тэгсэн юм чинь тэгээд хая хая гээд тэгээд орхисон. Цагдаа шүүх байгууллагад хандаагүй дээ.*

**4. Эдийн засгийн хүчирхийлэл.** ГБХ-д өртсөн тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн 91 хувь нь эдийн засгийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртсөн байсан. Түүний илрэх хэлбэрүүдээс мөнгө, хувцас зэрэг ахуйн хэрэглээний зүйлсээр гачигдуулдаг гэсэн хариулт нийтлэг дурдагдаж байв. Хэдийгээр тулгуур эрхтний бэрхшээлтэй хүн халамжийн тэтгэвэр авч байгаа хэдий ч ихэнх тохиолдолд энэ нь тухайн хүний мэдлээс илүү гэр бүлийн гишүүдийн хэрэгцээнд зарцуулагдаж байна. ХБХ-ийг хөдөлмөрийн чадваргүй, ажилгүй, орлогогүй, гэртээ байнга байдаг гэх шалтгаанаар шаардлагатай хэрэгцээний зүйлсэд халамжийн мөнгийг зарцуулахаас татгалзах, өрхийн бусад гишүүдийн хэрэгцээнд зарцуулах байдал нийтлэг байгаа нь тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүс эдийн засгийн хүчирхийлэлд маш өргөн хүрээтэй өртөж байгааг харуулж байв.

**Дүрс 24. ГБХ-д өртсөн тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн байдал, %**



**Шигтгээ 27. Сэлэнгэ аймаг, тулгуур эрхтний бэрхшээлтэй, 45 настай, эрэгтэй**


*Сар болгоны эхэнд группийн мөнгө буух үеэр охин дүү мөнгө нэхэж ирнэ, мөн байнга хяналт тавина. Та мөнгөөр юу хийдэг юм, яах гэж зээл авсан юм гэх мэтээр. Протезоо солих үеэр их уурласан. Наадах чинь дахиад 3 жил хэрэглэж болно шинийг авч яах гээд байгаа юм гээд.*

**Шигтгээ 28. Сэлэнгэ аймаг, тулгуур эрхтний бэрхшээлтэй, 46 настай, эмэгтэй**

*Би гуравдугаар багийн хэсгийн ахлагч хийдэг байсан. Тухайн үедээ хүнтэй уулзах хэрэг гарна. Нүүрний будаг авъя гэхээр авч өгдөггүй. Хэнтэйгээ ямар юмтайгаа уулзах гээд байгаа юм. Мөнгөний гарлага гаргаад гээд уурладаг. Эх үрсийн баяраар өөртөө нүүрний будаг, подволк авч байгаад загнуулсан. Дандаа өөртөө мөнгө наадаг хар царай нь ч өнгө орох биш гээд.*

**5. Бэлгийн хүчирхийлэл.** ГБХ-д өртсөн тулгуур эрхтний бэрхшээлтэй 88 хувь нь бэлгийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртсөн байсан. Энэ нь бусад бэрхшээлтэй иргэдтэй харьцуулахад мөн л өндөр үзүүлэлт байв. Хүчирхийллийн илрэх хэлбэрүүдээс нийтлэг тохиолдолд хүсээгүй үед нь биеийн эмзэг хэсэгт хүрэх, хүсээгүй үед нь хүчээр бэлгийн харилцаанд оруулах үйлдлүүд нийтлэг илэрдэг. Хүчирхийлэл үйлдэгчийн хувьд хамтран амьдрагч, нөхөр байхаас гадна, зугтааж, эсэргүүцэх чадвар сул хөгжлийн бэрхшээлийн эмзэг байдлыг далимдуулан гаднын хүний хүчирхийлэлд өртсөн тохиолдол байв.

**Дүрс 25. ГБХ-д өртсөн тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдал, %**



**Шигтгээ 29. Увс аймаг, тулгуур эрхтний бэрхшээлтэй, 41 настай, эмэгтэй**

*Хамтран амьдрагч Facebook-ээс элдэв гаж бичлэг үзээд тэрийгээ дуурайхыг шаарддаг байсан. Бэлгийн харьцаанд чинь хүн урд талаараа орно шүү дээ. Бидэнд чинь ганц л сав байгаа. Гэтэл бүр бөгс рүү хийхийг аймар их оролдоно, бэлэг эрхтнээ хөхүүлнэ гэнэ. Миний хувьд энэ бүхэн бол маш балиар үйлдлүүд.*

**Шигтгээ 30. Увс аймаг, тулгуур эрхтний бэрхшээлтэй, 16 настай, эмэгтэй**

*Хоёр удаа бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан. Нэг нь ээжийн найзынх нь ажлын хүн. Нэгийг нь огт танихгүй. Нэг дээр нь манай дүү бүр хажууд байсан. Дүү яаж ч чадаагүй. Энэ хэргээр хот уруу хамгаалах байранд 6 хоног байрласан.*

### 1.1.4 Оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй хүн

Судалгаанд оюуны бэрхшээлтэй 16, сэтгэцийн бэрхшээлтэй 18 хүн хамрагдсан. Бэрхшээлийн шалтгааныг авч үзвэл 20 хувь нь төрөлхийн, үлдсэн хувь нь зам тээврийн болон ахуйн осол, хүнд зодуулах зэрэг бэртэл гэмтэл, олон жилийн амьдралын дарамт, хүнд нөхцөл байдал, хүүхэд төрүүлсний дараа гам алдсан зэрэг шалтгаанаар бэрхшээлтэй болсон. Оношны хувьд эпилепси буюу уналт таталт, F70, F71 ангиллын оюуны бэрхшээл, сэтгэцийн эмгэг, хоёр туйлт сэтгэц хуваагдал зэрэг оноштой хүмүүс судалгаанд хамрагджээ.

Тэдгээрийн 64 хувь (n=22) нь ГБХ-д өртөж байсан. Бусад ХБХ-тэй харьцуулахад хүчирхийлэлд өртсөн байдал оюун, сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд бага гарч ирсэн хэдий ч энэ нь тухайн оролцогчийн мэдээлэл өгөх чадвартай холбоотойгоор бүх асуудлыг бүрэн дүүрэн илэрхийлж чадаагүй байх боломжтой гэж судалгааны баг үзсэн. Судалгаанд оролцогчийн өгсөн мэдээллүүд хоорондоо логикийн зөрүүтэй байх, зарим тохиолдолд зан авирын огцом өөрчлөлтүүд илрэх зэргээр ярилцлагыг гүнзгийрүүлэх боломж хязгаарлагдмал нөхцөлд мэдээллийг цуглуулсан.

Амьдралын нөхцөл, гэр бүлийн харилцаанаас харахад оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүс ГБХ-д өртсөн байх магадлал дээрхээс илүү өндөр байх магадлалтай байв.

Мөн нөгөө талаас оюун болон сэтгэцийн өөрчлөлттэй хүмүүс өөрсдөө гэр бүлийн гишүүдээ хүчирхийлдэг тохиолдлууд байсныг тэмдэглэх хэрэгтэй. Асран хамгаалагч нартай хийсэн ярилцлагаас тухайн хүнийхээ өвчнийг хөдөлгөхгүйн тулд аяыг нь харж амьдардаг тухай хэд хэдэн хүн дурдсан байна.

Ярилцлагад хамрагдсан оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд **бүх хэлбэрийн хүчирхийлэлд өртөх байдал өндөр**. Хүчирхийллийн эрсдэлийн зэргийн хувьд хохирогчдын 45.5 хувь нь дунд болон түүнээс дээш түвшний эрсдэлтэй нөхцөлд орж байсан (Дүрс 26).

Хүчирхийлэл үйлдэж буй гол этгээд нь гэр бүлийн гишүүдээс эхнэр, нөхөр (55%), эцэг эх (16%), ойр болон холын хамаатны хүмүүс (13%) байгаагаас гадна гэр бүлээс гаднын хүний хүчирхийлэлд өртсөн тохиолдол (16%) байна.


Хүйсийн хувьд хүчирхийллийн хохирогч нь аль аль хүйсийн хүмүүс байсан. Хүчирхийлэл үйлдэгдэж буй хэлбэрийг харвал бэлгийн хүчирхийлээс бусад бүх хэлбэрүүдэд эмзэг байна (

Хүчирхийллийн хэлбэрүүдийн хавсарсан байдлыг авч үзвэл, ГБХ-д өртсөн нийт оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүний 72.7 хувь нь хүчирхийллийн 3 ба түүнээс дээш хэлбэрүүдэд өртсөн байна (Дүрс 3).


Дүрс 27). Гэр бүлийн орчинд хэл амаар доромжлох, орилж, хашхирах, өшиглөх зэрэг үйлдэл нийтлэг тохиолддог. Бэрхшээлийн онцлогоос шалтгаалан гадуур гарахыг хориглох, санхүүгийн хувьд эрх мэдэлтэй байхыг хүлээн зөвшөөрөхгүй байх тохиолдлууд нийтлэг байлаа.

Хүчирхийллийн хэлбэрүүдийн хавсарсан байдлыг авч үзвэл, ГБХ-д өртсөн нийт оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүний 72.7 хувь нь хүчирхийллийн 3 ба түүнээс дээш хэлбэрүүдэд өртсөн байна (Дүрс 3).

**Дүрс 27. ГБХ-ийн 5 төрлийн илрэх хэлбэрүүдээс дор хаяж нэг хэлбэрт өртсөн оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн хувь, (n=34)**



**Дүрс 26. Оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн өртсөн ГБХ-ийн эрсдэлийн түвшин**



ГБХ-д өртсөн байдлыг хүчирхийллийн хэлбэр тус бүрээр авч үзвэл:

**1. Сэтгэл санааны хүчирхийлэл.** ГБХ-д өртсөн оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн 86.4 хувь (n=19) нь сэтгэл санааны хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртсөн байсан. Нийтлэг өртөж буй хэлбэрийн хувьд гэр бүлийн орчинд хэл амаар доромжлох болон орилж хашхирах үйлдлүүд нийтлэг тохиолддог гэж хариулжээ. Судалгаанд хамрагдсан оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүс бэрхшээлээсээ шалтгаалан гэр дотроо ад үзэгдэх, үл хүндлэгдэх байдал нийтлэг боловч бусад гэр бүлийн эмзэг ядуу, боловсролын түвшин бага байдал, архидалт зэрэг шалтгаанаас үүдэн байнгын сэтгэл зүйн дарамтад амьдардаг нь оюуны болон сэтгэцийн өвчнийг хүндрэхэд улам нөлөөлж байгаа талаар ярьж байлаа. Эмч нарын зүгээс дээрх бэрхшээлтэй иргэдэд эмээ тогтмол уух, сэтгэл зүйн хувьд тайван байхыг зөвлөдөг хэдий ч гэр бүл доторх хэрүүл, маргаан, зөрчлөөс болоод бэрхшээлийнх нь хүндрэл улам нэмэгдэж байгааг дурдаж байв. Судалгаанд хамрагдсан бүх оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүс өдөр өдрөөр бэрхшээлийнх нь хүндрэл нэмэгдэж, заримдаа өөрийгөө барьж чадахгүй байх, өөрөө ч гэр бүлийнхэндээ хүчирхийлэл үйлддэг гэдгээ хүлээн зөвшөөрч байв.

Дүрс 28. ГБХ-д өртсөн оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн байдал, %



**Шигтгээ 31. Сэлэнгэ аймаг, сэтгэцийн бэрхшээлтэй, 33 настай, эмэгтэй**

Заримдаа уур хүрээд, бачимдаад хэцүү байдаг. Биеэ барьж чадахгүй аймар уур уцаартай болж байгаа. Сэтгэцийн эмч нар болохоороо эмээ уу гэж зөвлөдөг. Гэр орон муухай байгаад ирэхээр л хүүхдээ зодоод, орилж чарлаад эхэлдэг. Нөхрөөсөө 12 сард салсан. Салсан шалтгаан нь архи уугаад, агсан их тавьдаг. Тэрнээсээ болдог юм уу яадаг юм нөхөртэйгөө суухаасаа өмнө ааш зан гайгүй байсан бол одоо аль болох л уурлаад, хүүхдээ зодоод, хүмүүстэй хэрэлдэх нь ихэссэн.

**Шигтгээ 32. Увс аймаг, оюун болон сэтгэцийн хавсарсан бэрхшээлтэй, 43 настай, эмэгтэй**

Хүчирхийлэл гэдэг чинь хамгийн хэцүү. Хүний сэтгэл зүй гэж ямар ч юм байхгүй болчихдог юм байна лээ. Сэтгэл санаагаар ингэж байнга хямарч явсаар өвчний үүр болж байна. Манай охин намайг турж эцсэнийг л

гайхаад байсан. Ямар сайхан махтай шөлтэй байлаа даа. Нөхөр муу банзал авгай, алнаа чамайг л гэдэг. Хэзээ нэг энэний гарт орж үхэх бол гэж бодох юм. Согтуу байгааг нь мэдэх юм бол бие чичрээд байдаг.

**2. Хянах зан үйлийн хүчирхийлэл.** ГБХ-д өртсөн оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн 73 хувь (n=16) нь хянах зан үйлийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан. Эдгээрээс гэр бүлтэй эмэгтэйчүүдийн хувьд нөхөр нь нийтлэг хардалтын сэдлээр гадуур гарах, найз нөхөдтэйгөө уулзахыг хориглодог бол гэр бүл зохиогоогүй эмэгтэйчүүдийн хувьд ээж, ах эгч, дүү нар нь илүү аюулгүй байдлын үүднээс хаашаа явахыг асуудаг гэж хариулж байсан. Гэр бүл зохиогоогүй оролцогчдын хувьд эдгээр үйлдэл байнга тохиолддог хэдий ч миний бэрхшээлтэй холбоотойгоор надад санаа тавьж асуудаг тул хүчирхийлэл гэж үзэхгүй байгаагаа илэрхийлж байсан. Тэгэхээр хянах зан үйлийн хүчирхийлэл үйлдэгдэж буй нийтлэг нөхцөлд нөхрийн зүгээс хардалтын сэдэл давамгайлж тус хэлбэрийн хүчирхийлэл үйлдэгдэж байгаа нь бусад бэрхшээлтэй хүмүүсийн үр дүнгээс мөн адил байна.

**Дүрс 29. ГБХ-д өртсөн оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн хянах зан үйлийн хүчирхийлэлд өртсөн байдал, %**



**Шигтгээ 33. Увс аймаг, оюун болон сэтгэцийн хавсарсан бэрхшээлтэй, 43 настай, эмэгтэй**

Эрх чөлөө гэж байхгүй дээ. Нөхөр найз нөхөд байтугай дэлгүүр ороод ирэх хооронд ямар их уддаг юм гээд загнаад байдаг. Чамд ажиглагдаж байгаа байх (маш их сандарч байв) Хүнтэй нэг их тэгж ярьдаггүй. Гэртээ л гэрийн ажил мал гээд л байж байдаг. Хоёр охин өнчирчихдөг юм болов уу гэж бодоод ингээд тэвчээд олон жил болж байна.

**Шигтгээ 34. Сэлэнгэ аймаг, сэтгэцийн бэрхшээлтэй, 30 настай, эмэгтэй**

Намайг ийшээ тийшээ гарахаар их уурладаг байсан. Тэр байтугай жорлон орох гэхэд хүүхдүүддээ ээжийгээ дагаад яв ээж чинь гараад явчихна гэдэг байсан. Утсаар хүнтэй ярихад маш их уурладаг. Байнга утсыг маань шалгадаг. Тэгээд утсаа нэг л удаа авахгүй бол ирээд зоддог байсан.

**3. Бие махбодын хүчирхийлэл.** ГБХ-д өртсөн оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн 73 хувь (n=16) нь бие махбодын хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан. Дийлэнхдээ гараараа цохидог, өшиглөх, үснээс зулгаах зэрэг үйлдлүүд тохиолддог.

**Дүрс 30. ГБХ-д өртсөн оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байдал, %**



**Шигтгээ 35. Увс аймаг, оюун болон сэтгэцийн хавсарсан бэрхшээлтэй, 43 настай, эмэгтэй**

Манай энэ хавийнхан андахгүй дээ. Хүрз бариад хөөнө, араас хад чулуудаад байдаг. Нэг удаа зугтаж байхад нэг хад энд ирж оноод (толгой уруугаа заав). Тэгэхэд хагалгаанд орчихсон байсан. Азаар хүнд буугаагүй. Толгойн дээр аппрестай байхад ирж онох юм бол зүгээр задарна шүү дээ.


**Шигтгээ 36. Сэлэнгэ аймаг, сэтгэцийн бэрхшээлтэй, 33 настай, эмэгтэй**

Гараараа цохино, барьж байгаа аягаа шидэж байсан. Үснээс зулгааж байсан, чирч байсан, өшиглөж байсан. Согтуудаа ухаан мэдрэлээ алдаад ингээд байна гээд уучлалт гуйдаг.

Нэг удаа манай охин аавтайгаа унтъя гэхээр нь тэг тэг гэсэн чинь орой унтахгүй болохоор нь харсан чинь охиноо оролдоод байхаар нь боль гээд хэлсэн чинь намайг боогоод авсан. Шүүх хурал дээр мөн охиноо оролдсоныг нь хэлсэн чинь өөрөө юу ч санахгүй байна гэж хэлсэн.

**4. Эдийн засгийн хүчирхийлэл.** ГБХ-д өртсөн оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн 73 хувь (n=16) нь эдийн засгийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан. Бусад бэрхшээлтэй хүмүүсээс сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн эдийн засгийн эрх мэдэл хамгийн бага. Бэрхшээлийн онцлогтой холбоотойгоор дээрх төрлийн бэрхшээлтэй хүмүүсийн мөнгөн орлогот гэр бүлийн гишүүд нь бүрэн хяналт тавьдаг, зарцуулалтыг нь хянаж шалгадаг. Тус бэрхшээлтэй хүмүүсийн хувьд санхүүгийн харилцаанд нь асран хамгаалагчийн оролцоо, дэмжлэг байх нь тодорхой хэдий ч бэрхшээлээр нь далимдуулж эдийн засгийн эрх мэдлийг нь боогдуулах тохиолдол цөөнгүй байсан.

**Дүрс 31. ГБХ-д өртсөн оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн байдал, %**



**Шигтгээ 37. Сэлэнгэ аймаг, сэтгэцийн бэрхшээлтэй, 40 настай, эмэгтэй**

Би халамжийн мөнгөө авдаггүй. Ээж маань банкнаас авдаг, надад хэлэхдээ өдөр тутмын амьдралдаа зарцуулж байгаа гэсэн. Гэрээсээ байнга хөөгддөг, өлсдөг, өмсөх олигтой гутал хувцас байхгүй. Саяхан холбооны эгч маань надад өөрийн пүүзээ өгсөн.

**Шигтгээ 38. Налайх дүүрэг, сэтгэцийн бэрхшээлтэй, 36 настай, эмэгтэй**

*Нөхөр ослоор 5 жилийн өмнө өнгөрсөн. Тэр үед манай хадам эмээ, одоо 100 дөхөж байгаа, Казах үндэснийхээ ёсыг их дагадаг уламжлалт сэтгэлгээтэй хүн намайг нөхөр өнгөрсний дараа эрэгтэй дүүтэй нь амьдар, суу гээд амьдарч чадахгүй бол зүгээр зайл гээд, хашаа байшинг маань бүх юмтай нь хурааж аваад хөөчихсэн.*

**5. Бэлгийн хүчирхийлэл.** ГБХ-д өртсөн оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн 41 хувь (n=9) нь бэлгийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан. Гэр бүлтэй хүмүүсийн хувьд гэр бүл дотор хүчирхийлэл байхаас гадна оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй залуу эмэгтэйчүүдийн хувьд гаднын хүний бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдлууд тааралдав. Тус хүчирхийлэл нь үл хайхрах буюу оюуны бэрхшээлтэй хүнийг хараа хяналтгүй орхисонтой холбоотой бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй сул талыг нь далимдуулан бэлгийн хүчирхийлэлд өртүүлсэн байсан. Гэвч хохирогчийг үл таних хүний бэлгийн хүчирхийлэлд өртсөний дараа ч гэр бүлийнхэн нь хайхарч авч хэлэлцэхгүй, зөнд нь орхисон байгаагаас үзэхэд оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийг үл хайхрах байдал түгээмэл байгаа нь харагдаж байв. Ялангуяа энэ нөхцөл байдал орон нутагт илүү ажиглагдсан.

**Дүрс 32. ГБХ-д өртсөн оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдал, %**


**Шигтгээ 39. Увс аймаг, оюуны бэрхшээлтэй, 17 настай, эмэгтэй**

*Охин өөрийгөө хүчирхийлэлд өртсөнийг мэдэж байгаа хэдий ч энэ талаар ярихыг огт хүсээгүй. Сүүлийн үед гэдэс дотор юм хөдлөөд, гэдэс өвдөөд байгаа гэж ярьсан (8 сартай жирэмсэн)*

**Охины кейс дээр ажиллаж буй нийгмийн ажилтны ярианаас:** *Охин төрөлхийн оюуны бэрхшээлтэй. Аав ээж, ах эгч дүү нар нь байдаг хэдий ч охин эмээтэйгээ хоёулхнаа өөр газар амьдардаг. Эмээг нь гараад явсан хойгуур танихгүй хүн орж ирээд хүчирхийлсэн байсан. Одоо охин 8 сартай жирэмсэн. Түр хамгаалах байранд байрлаж байна. Хүчирхийлсэн хүн нь мэдэгдэхгүй. Гэр бүлийнхэн нь огт тоож авч хэлэлцэхгүй байгаа.*

**Шигтгээ 40. Сэлэнгэ аймаг, сэтгэцийн бэрхшээлтэй, 30 настай, эмэгтэй**

*Би 2020 оны 7 сард группээ сунгуулах гээд шинжилгээ өгсөн чинь надаас БЗХӨ илэрсэн. Бага хүүгээ төрсний дараа нөхөртэйгөө нэг л удаа унтсан юм. Манай нөхөр тэгэхэд өөр хүнтэй болчихсон байсан юм билээ. Нөхрийн эгч нь намайг чи л өөрөө эргүүтэж явж байгаад миний дүүд өвчин өглөө гээд зөндөө загнасан. Нөхрөө өөр хүнтэй болсныг 6 сард мэдсэн.*

### 1.1.5 Бусад төрлийн бэрхшээлтэй хүн


Бусад төрлийн бэрхшээлтэй хүмүүст дотор эд эрхтний үйл ажиллагааны алдагдлаас үүдэн хөдөлмөрийн чадвараа алдсан нийт 28 хүн хамрагдсан. Үүнд: харвалт, уналт таталт, түлэгдэлт, саажилт, элэгний цироз, одой зэрэг оноштой хүмүүс багтжээ. Нийт оролцогчдын 67 хувь нь олдмол байдлаар хөдөлмөрийн чадвараа алдсан.

Хүчирхийлэл үйлдэж буй гол этгээд нь эхнэр, нөхөр (35%) болон ах дүү (35%), эцэг эх (18%) болон гэр бүлээс гаднын хүний хүчирхийлэлд өртсөн (12%) тохиолдол байна.

Хүчирхийлэлд өртсөн байдлын хувьд сэтгэл санаа, хянах зан үйлийн хүчирхийлэлд өртөх байдал бусад ХБХ-тэй ижил өндөр. Харин эдийн засгийн, бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн байдал бусад ХБХ-тэй харьцуулахад харьцангуй бага байв (Дүрс 38). Хүчирхийллийн хэлбэрүүдийн хавсарсан байдлыг авч үзвэл, ГБХ-д өртсөн нийт бусад төрлийн бэрхшээлтэй хүний 57 хувь нь хүчирхийллийн 3 ба түүнээс дээш хэлбэрүүдэд өртсөн байна (Дүрс 3).


Хүчирхийллийн аюулын зэргийн хувьд хохирогчдын 33 хувь нь эрсдэлийн түвшин өндөр нөхцөлд орж байсан (Дүрс 33).

■ Өндөр ■ Дунд ■ Бага



Дүрс 33. Бусад хэлбэрийн бэрхшээлтэй иргэдийн өртсөн ГБХ-ийн эрсдэлийн түвшин

Дүрс 34. ГБХ-ийн 5 төрлийн илрэх хэлбэрүүдээс дор хаяж нэг хэлбэрт өртсөн бусад төрлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувь, (n=29)



Хөдөлмөрийн чадваргүй гэх шалтгаанаар гэр бүлийн гишүүдээс гадна хамаатан садны хүмүүс (ах, дүү, хүргэн, бэр хадмын талын ах эгч, дүү нар гэх мэт) зэрэг олон талын хүчирхийлэлд өртдөг байна. ГБХ-д өртсөн байдлыг хүчирхийллийн хэлбэр тус бүрээр авч үзвэл:

**1. Сэтгэл санааны хүчирхийлэл.** ГБХ-д өртсөн бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүсийн 85.7 хувь (n=18) нь сэтгэл санааны хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан. Бусад ХБХ-ий адил гэр бүлийн орчинд хэл амаар доромжлох, орилж хашхирах зэрэг хэрүүл маргааны шинжтэй үйлдлүүд нийтлэг үйлдэгдэж байна. Бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд дотор эд эрхтний өвчлөлөөр хөдөлмөрийн чадвараа алдсан тул харагдах талаасаа илт бие махбодын бэрхшээл бага хэдий ч хүндрэлийн хувьд бусад ХБХ-тэй ижил нөхцөлтэй. Иймд гэртээ зүгээр суудаг, хөдөлмөрийн чадваргүй гэх шалтгаанаар гэр бүл, хамаатан садан, ах дүүгийн хүрээлэл дотроо үл ойшоодог, үл хүндэтгэх, уур бухимдлаа гаргах, сул талыг нь далимдуулж дээрэлхэх зэрэг хандлага нийтлэг ажиглагдаж байв.

**Дүрс 35. ГБХ-д өртсөн бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүсийн сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн байдал, %**



**Шигтгээ 41. Сэлэнгэ аймаг, дотор эрхтний өвчлөлтэй, 28 настай, эмэгтэй**

4 сарын өмнө би ахын урд нь зогсож байсан чинь яараад байхад замд тээглээд байх юм гээд тэрэг рүү өшиглөж байсан.

**Шигтгээ 42. Сэлэнгэ аймаг, дотор эрхтний өвчлөлтэй, 38 настай, эмэгтэй**

Намайг өвдөж чадахгүй, үхэж чадахгүй пизда гээд л хараагаад байдаг. Охидуудынхаа хажууд тоохгүй "муу янхан минь ээ" гээд л хашаагаар нэг орилно. Согтуу ирэхээрээ хэл амаар доромжилж шөнөжин унтуулдаггүй. Заримдаа би 2 охиноо аваад орон доогуураа нуугдана. Аавыгаа унттал чимээгүй байгаарай гээд нуугдана. Өвчнөөсөө болоод миний үс туг тугаараа унаад халцарсан. Тэгсэн нэг өглөө боссон чинь нөхөр согтуудаа охин бид гурвын үсийг жижигхэн болгоод хайчилчихсан байсан. Өмнө нь үс унаад байна хусуулдаг юм билүү гээд ярьж байсныг минь сонссон болохоор тэгсэн байх. Тэгээд тэр чигт нь гурвуулаа үсээ хуссан.

**2. Хянах зан үйлийн хүчирхийлэл.** ГБХ-д өртсөн бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүсийн 71.4 хувь (n=15) нь хянах зан үйлийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан. Эдгээр хүмүүсийн нийтлэг өртөж буй хэлбэр нь хаашаа явж байгаагаа заавал мэдэгдэх, гадуур гарахдаа зөвшөөрөл авахыг шаардах, үйлдлийг нь хянаж, цагддаг гэж хариулсан. Тус хэлбэр нийт бэрхшээлтэй хүмүүсийн дунд хамгийн нийтлэг байгаагаас үзэхэд үүнд бэрхшээлээс хамаарсан ялгаа бага байгаа нь харагдаж байв.

**Дүрс 36. ГБХ-д өртсөн бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүсийн хянах зан үйлийн хүчирхийлэлд өртсөн байдал, %**



**Шигтгээ 43. Сонгинохайрхан дүүрэг, дотор эрхтний өвчлөлтэй, 23 настай, эмэгтэй**

3 сарын өмнө би сүмд явдаг байсан. Ах мэдчихээд тэргэнцэртэй байж сүмд явж яах гээд байгаа юм гээд уурлаад больсон. Гадуур гарах, хянах нь өдөр бүр л тохиолддог. Сая хүртэл ах намайг хаачих гээд байгаа юм гээд асууж байх жишээний. Тэгэхээр нь би хаачих ч үгүй ээ эмнэлэг ороод ирье гээд худлаа ярьчихсан.

**3. Бие махбодын хүчирхийлэл.** ГБХ-д өртсөн бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүсийн 47.6 хувь (n=9) нь бие махбодын хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан. Энэ нь бие махбодын хүчирхийлэлд өртсөн бусад ХБХ-тэй харьцуулахад хамгийн бага дүнтэй нь байв. Өөрөөр хэлбэл хараа, тулгуур эрхтэн зэрэг бэрхшээлтэй хүмүүстэй харьцуулахад бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүсийн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байдал харьцангуй бага байв. Өртсөн хэлбэрүүдийг авч үзвэл гараараа цохих болон хутга мэсээр айлгах, заналхийлэх байдал өндөр байна. Ярилцлагаас үзэхэд хутга, мэсээр айлган сүрдүүлэх үйлдлийг ихэвчлэн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөр нь согтуудаа үйлдсэн байв. ГБХ үйлдэгдсэн олон тохиолдлын түүхийг харахад согтууруулах ундааны хэрэглээ яах аргагүй хүчирхийлэл үйлдэгдэхэд шууд нөлөөтэй байв.

**Дүрс 37. ГБХ-д өртсөн бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүсийн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байдал, %**



**Шигтгээ 44. Сонгинохайрхан дүүрэг, дотор эрхтний өвчлөлтэй, 43 настай, эмэгтэй**

*Дандаа мөлхсөөр байгаад яг цооролт өгөх гээд хоёр өвдөг улаан хүрэн болцон байхад намайг үүдний амбаар руу чирээд гаргаж хаяж байсан тэр л үе миний санаанаас ерөөсөө гардаггүй юм. Хэр баргийн цохилтыг мартдаг ч гэсэн үүн дээр гомдохын дээдээр гомдож байсан. Ягаараад цооролт өгөх гэж байсан шарх чинь цементэн дээгүүр чирээд арьс нь зулгараад би чинь 10 гаран хоног хөдөлж чадахгүй цоорхойгоо эдгээх гэж үйлээ тамтайгаа эдэлж байсан. Ер нь л хэцүү ш дээ цохино би өөдөөс нь мянга сарвалзаад яах вэ дээ.*

**Шигтгээ 45. Сэлэнгэ аймаг, дотор эрхтний өвчлөлтэй, 38 настай, эмэгтэй**

*Архины хамааралтай. Эрүүл өдөр байсныг нь би мэдэхгүй. Өмнө нь өчнөөн зодож янз бүр болдог байсан. Сүүлийн үед хууль чангараад арай дээр болсон ч архиа уусаар л байгаа. Уухаараа шөнө унтуулахгүй, орилно чарлана. Тэрнээс нь болоод миний зүрх савлана.*

*Миний толгой руу архины шилээр цохиод хагалж байсан. Шалтгаан нь найзуудынх нь янз бүрийн яриа. Намайг өмнө нь хүмүүстэй явдаг байсан гэх мэт худлаа юм ярина. Бас миний чихийг сэтэлж байсан. Сандал дээр сууж байхад цохиод би унахдаа чихээ ширээний буланд цохиод сэтэлж байсан.*


**4. Эдийн засгийн хүчирхийлэл.** Бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүсийн эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн байдал харьцангуй бага. ГБХ-д өртсөн бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүсийн 38 хувь (n=8) нь эдийн засгийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан. Үйлдэгдсэн хэлбэрийг авч үзвэл ажил хийхийг зөвшөөрөхгүй байх, зарцуулсан мөнгөнд хяналт тавьдаг гэж хариулсан боловч ярилцлагын мэдээллээс үзэхэд энэ нь хүчирхийллийн түвшний хувьд харьцангуй эрсдэл бага буюу цөөхөн тохиолдсон, тухайн хүний сэтгэл зүйд нөлөөлөх хэмжээний үр дагавар бага байв.

**Дүрс 38. ГБХ-д өртсөн бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүсийн эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн байдал, %**



**5. Бэлгийн хүчирхийлэл.** Мөн ижил бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүсийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдал харьцангуй бага байв. Нийт ГБХ-д өртсөн бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүсийн 38 хувь (n=8) нь бэлгийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан. Илэрсэн хэлбэрийг харвал хойд эцэг болон бусад хамаатан садны зүгээс үг, үйлдлээрээ бэлгийн дур хүслээ илэрхийлэх байдал тохиож байсан. Хүсээгүй үед бэлгийн харилцаанд орох тохиолдол цөөн кейст тулгарч байсан. Хүчирхийлэл үйлдэгчийн хувьд нийтлэг нөхөр эсхүл хамтран амьдрагчийн зүгээс үйлдэгдсэн байна. Энэ тохиолдолд ихэвчлэн биеийн байдал тааруу байх, ядарсан байх зэрэг үед бэлгийн хамтрагчийн зүгээс тухайн хүний хүсэл сонирхол, эрүүл мэндийн байдлыг харгалздаггүй талаар дурдаж байлаа.

**Дүрс 39. ГБХ-д өртсөн бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүсийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдал, %**



**Шигтгээ 46. Налайх дүүрэг, дотор эрхтний өвчлөлтэй, 29 настай, эмэгтэй**

*Хааяа ээжийг байхгүй үед хойд аав оролддог. Өвөл ээж эмнэлэгт хэвтсэн, бас саяхан нэг хоног хөдөө явсан чинь тэр үед нь тэгж байсан. Тэр үед нь хоёр хүүхдийнхээ голоор ороод л унтчихсан. Нэг хэсэг унтаж чадахгүй яачих ч юм билээ гээд. Чимээ чагнаж хэвтээд л. 6 сард тэгсэн. Анх ирчхээд байхад тэгсэн, бас түрүү жил тэгсэн. Ээжийг байхад тэгдэггүй.*

### 1.1.6 ХБХ-ий асран хамгаалагчдын нөхцөл байдал

Судалгаанд нийт 27 асран хамгаалагч хамрагдсан ба тэдний дийлэнх нь (92%) эмэгтэйчүүд. Асран халамжилж буй ХБХ нь гол төлөв өөрийнх нь төрсөн хүүхэд (17 ХБХ) байх бөгөөд бусад нь нөхөр, ач зээ, эцэг эх болон төрөл садангаа асардаг байв. Мөн судалгаанд оролцсон асран хамгаалагчид нь зөвхөн ХБХ-ийг асраад зогсохгүй, ач зээ, өндөр настай эцэг эхээ асрах зэргээр давхар ачаалал үүрч буй байдал түгээмэл байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асардаг эмэгтэйчүүдийн хувьд дийлэнх нь өрх толгойлсон ээжүүд байлаа.

Тус судалгааны хүрээнд асран хамгаалагчдаас ХБХ-ийг асрахтай холбоотой тулгардаг хүндрэл бэрхшээл, тэдгээрийг даван туулж буй туршлага, гэр бүлийн харилцааны нөхцөл байдлыг тодруулахаас гадна ХБХ-тэй гэр бүлд хүчирхийлэл үйлдэгдэхэд нөлөөлж болох хүчин зүйлсийг шууд бус байдлаар тодруулахыг зорьсон. Нөлөөлж буй хүчин зүйлтэй холбогдох үр дүнг ГБХ-д нөлөөлж буй хүчин зүйл бүлгийн "Гэр бүлээс хамаарсан хүчин зүйл" дэд бүлэгт дэлгэрэнгүй танилцууллаа.

Тайлангийн энэ хэсэгт асран хамгаалагч нард тулгарч буй хүндрэл бэрхшээл, хүчирхийлэлтэй холбоотой гэр бүлийн харилцааны туршлагыг авч үзлээ.

Өмнө дурдсанчлан байнгын асаргаа шаардлагатай ХБХ-ий асаргааг ихэвчлэн эмэгтэйчүүд, тэр дундаа ээж нар нь гүйцэтгэдэг. Асран хамгаалагч нарын өгсөн мэдээллээр ХБХ-ий асаргаатай холбоотой тулгарч буй гол хүндрэл бэрхшээлд дараах асуудлууд нийтлэг дурдагджээ:

- Асран хамгаалагчийн хувийн сонирхол, өөрийгөө хөгжүүлэх боломж хязгаарлагдах
- Хөдөлмөр эрхлэх боломжгүй байх, улмаар өрхийн амьжиргаа муудах
- Найз нөхөдгүй болж нийгмийн хүрээлэлгүй болох, нийгмийн идэвх оролцоо багасах
- Асаргаа, өрхийн бусад ажлын ачаалалтай холбоотой ядрах, биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийн хувьд доройтох,
- Гэр бүлийн бусад гишүүдээс асаргаатай холбоотой үүрэг хариуцлагаас хуваалцахгүй байх (Гэр бүлийн гишүүдийн зүгээс хэн нэгэнд асрах үүргийг оногдуулсан бол насан туршдаа уг үүргийг хүлээх)
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төрүүлсэнтэй холбоотой нөхөр, хадам тал болон бусад хамаатан садны зүгээс сэтгэл санааны дарамт үзүүлэх, дорд үзэх, ялгаж харьцах, өрөвдөх
- ХБХ-ий асаргаатай холбоотой үүсэх гэр бүлийн зөрчил маргаан, хүчирхийлэл, салалт

#### Шигтгээ 47. Увс аймаг, асран хамгаалагч, 58 настай, эмэгтэй

*Ам бүл 5 бөгөөд нөхөр, гурван охинтой хамт амьдардаг. Нөхөр, дунд охин, дунд охины охин, бага охин гэсэн 4 ХБХ-ийг асардаг. Нөхрийн хувьд тулгуур эрхтний бэрхшээлтэй, дунд охины хувьд сэтгэц, оюуны бэрхшээлтэй, бага охин хэл ярианы бэрхшээлтэй, дунд охины охин сэтгэц, оюуны бэрхшээлтэй.*

*Халамжийн мөнгөний ихэнх нь эдгээр 4 хүний эм тариа, эмчилгээнд дуусдаг. Бага охин өөрөө өөрийгөө авч явдаг. ХБХ-ийг байнгын асрахаар ядрах, туйлдах, бие өвдөх асуудал их гарна аа. Мөн орлого хүрэлцэхгүйтэй холбоотой уурлах, бухимдах, сэтгэл гутрах үе байдаг. Амьдралаас харахад эрэгтэй хүн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй болохоор салахыг урьтал болгодог юм билээ. 2 охины аав нь тэгээд л хаяад явсан. Миний хувьд 4 өөр өөр бэрхшээлтэй хүнийг асарна гэдэг чанга шүү дээ. Охины бага охин их ууртай, зөрүүд, ойр хавьд байгаа зүйлээ шидэлдэг. Үүнээс нь болж миний уур хүрэх, загнах, цохих үе байна аа.*

Асран хамгаалагч нарын өгсөн мэдээллээс үзэхэд асран хамгаалагч өөрөө ГБХ-ийн хохирогч болсон тохиолдлууд цөөнгүй байсан. Тухайлбал, олон нийтийн дунд хөгжлийн бэрхшээлийг авч үзэх эрүүл мэндийн болон шашны загварт суурилсан хандлага түгээмэл байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд

төрүүлсэн эмэгтэйг нөхөр, хамаатан садан, хадмын тал нь дорд үзэх, ялгаж харьцах, улмаар энэ нь гэр бүлийн зөрчил маргаан нэмэгдэхэд хүргэдэг нь ГБХ үйлдэгдэх гол шалтгаан болдог байна.

Хүчирхийлэл гэр бүлийн бусад гишүүдээс үйлдэгдэх ба үүнд өрхийн хөгжлийн бэрхшээлтэй гишүүн ч орж байв. Тухайлбал, оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй насанд хүрсэн хүмүүс бэрхшээлийнх нь хүндрэлтэй холбоотойгоор зан авир нь огцом өөрчлөгдөх байдал гардаг тул аль болох бухимдуулахгүйн тулд нөхцөл байдалд нь тохируулж харилцах гэж хичээдэг, энэ нь асран хамгаалагчид байнгын түгшүүртэй, сэтгэл зүйн хувьд дарамттай нөхцөл байдлыг үүсгэдэг талаар дурдсан байна.

**Шигтгээ 48. Налайх дүүрэг, оюуны бэрхшээлтэй хүний асран хамгаалагч, 56 настай, эмэгтэй**

*Оюуны бэрхшээлтэй охиноо асардаг. Одоо 34 настай. Энэ маань үе үе гэнэт алга болчихно. Байгаа үед нь яг хүссэнээр нь байлгахгүй бол их ууртай. Уурлахаараа яасан ч үгэнд ордоггүй, юм авч шидээд орилж хашхирна. Ер нь их ууртай, зөрүүд. Аяыг нь харж, эвээр нь л амьдардаг даа. Ер нь надад ч сэтгэл зүйн зөвлөгөө их хэрэгтэй л байна. Хүмүүст ярихаар ойлгодоггүй.*

Асран хамгаалагч нарын ярилцлагын дээрх үр дүн нь ХБХ-ийг асран хамгаалж буй хүн өөрөө ГБХ-д өртдөг, асаргаа болон бусад өрхийн ажлын ачааллаас үүдэн хэр дарамт, ачаалалтай нөхцөлд аж төрж байгааг харуулах ба эдгээр хүчин зүйл нь бүгд гэр бүлийн гишүүдийн харилцаанд нөлөөлөх хүчин зүйлүүд юм. Өөрөөр хэлбэл, судалгааны багийн дүгнэлт нь хөгжлийн бэрхшээлтэй байх нь хувь хүнийг ГБХ-д өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг бол, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй байх нь өрхөд ГБХ үйлдэгдэх эрсдэлийг нэмэгдүүлэхэд мөн нөлөөтэй байна.

Манай улсын халамжийн бодлогоор ХБХ, ялангуяа байнгын асаргаа шаардлагатай, хүнд хэлбэрийн бэрхшээлтэй хүнийг гэр бүлд нь даатган үлдээж, түүнийг зөвхөн мөнгөн тэтгэмж, халамжлан асрах тогтолцоогоор шийдэх оролдлогууд явагдаж байна. Ийм арга хэлбэрийн халамжийн тогтолцоо нь ХБХ-ийг гэр бүлдээ аль болох дарамт үзүүлэхгүйгээр бага зүйл шаардах, анхаарал татахгүй амьдрах гэж хичээх байдалд оруулдаг аж. Энэ нь тэднийг нийгмээс улам холдуулах, сэтгэл зүйн айдас, түгшүүрт оруулж улам нуугдмал амьдрахад хүргэдэг.

Иймд ХБХ-ий ГБХ-д өртөх эрсдэлийг бууруулахын тулд гэр бүл рүү нь чиглэсэн хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна. ХБХ-ийг, ялангуяа хүнд хэлбэрийн бэрхшээлтэй иргэдийг зөвхөн гэр бүлийн гишүүдэд нь даатган орхих нь ХБХ-ий төдийгүй гэр бүлийн гишүүдийн эрх зөрчигдөхөд хүргэж байна.

## 1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ГБХ-д өртөхөд нөлөөлж буй хүчин зүйлс

Бүлгийн гол үр дүн:

- ❖ **Үр дүн 1:** Хөгжлийн бэрхшээлтэй байх нь хүчирхийлэлд өртөхөд нөлөөлж буй хүчин зүйл хэдий ч ГБХ-ийн суурь шалтгаан биш байна. Хувь хүнээс хамаарсан хүчин зүйлээс илүү олон нийт, тогтолцооны түвшний хүчин зүйлс нь ГБХ үйлдэгдэхэд суурь шалтгааны шинжтэй нөлөө үзүүлж байна.
- ❖ **Үр дүн 2:** ГБХ-д өртөхөд хүйсийн ялгаатай байдал шууд нөлөөтэй байна.
- ❖ **Үр дүн 3:** ХБХ-ий гэр бүлийн гишүүдээс хамааралтай байдал нэмэгдэх тусам хүчирхийлэлд өртөх байдал нэмэгдэж байв. Үүнд: хөгжлийн бэрхшээлийн хүндрэлийн түвшин, боловсрол эзэмшсэн байдал голлох нөлөөг үзүүлж байна.

ГБХ-тэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөхийн тулд ГБХ үйлдэгдэхэд нөлөөлж буй суурь хүчин зүйлүүдийг тодруулах нь үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Тайлангийн өмнөх бүлэгт дурдагдсан ХБХ-ий өртөж буй ГБХ-ийн нөхцөл байдлын талаарх мэдээлэлд үндэслэн ГБХ үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тайлангийн тус бүлэгт тодруулахыг зорилоо.

ГБХ үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг Эмзэг байдлыг тодорхойлох загвар<sup>4</sup> -ийн дагуу дараах дөрвөн түвшинд тодруулсан. Энэхүү модель нь хувь хүнийг аливаа төрлийн хүчирхийлэл, гэмт хэрэгт өртөхөд шууд болон шууд бусаар нөлөөлж буй хүчин зүйлсийг цогц түвшинд тодорхойлох, хүчин зүйл хоорондын холбоо хамаарлыг тодруулах боломж олгодгоороо давуу талтай.

Дүрс 40. Эмзэг байдлыг тодорхойлох загвар



Тус судалгааны дизайныг боловсруулах эхлэлтийн шатанд тухайн бэрхшээл бүрийн онцлогоос хамаараад ХБХ-ийг ГБХ-д өртөхөд нөлөөлөх хүчин зүйл ялгаатай байна гэж таамаглаж байсан. Гэвч судалгааны үр дүн хүлээлтээс өөр байв.

<sup>4</sup> Determinants of Vulnerability Model/ The Social-Ecological Model: A Framework for Prevention. National Center for Injury Prevention and Control, Division of Violence Prevention, CDC. 2019

Нэгдүгээрт, зургаан төрлийн бэрхшээлтэй 150 хүний амьдралын түүх, нөхцөл байдлыг нэгтгэн харахад хөгжлийн бэрхшээлтэй байх нь хохирогчийн эмзэг байдлыг нэмэгдүүлж буй хүчин зүйл болох нь илэрхий байсан хэдий ч тухайн өрхөд ГБХ үйлдэгдэхэд нөлөөтэй шийдвэрлэх хүчин зүйл болж харагдсангүй. Бэрхшээл бүрээс хамаараад үйлдлийн хязгаарлалт, тухайн оролцогчид тулгарах хүндрэл бэрхшээл ялгаатай байсан. Гэвч хөгжлийн бэрхшээлээс илүү олон нийт, тогтолцооны түвшний хүчин зүйлс нь ГБХ-д үйлдэгдэхэд суурь шалтгааны шинжтэй нөлөө үзүүлж буй байдал ажиглагдав.

Хоёрдугаарт, судалгаанд хамрагдсан ХБХ-ий нөхцөл байдлаас ГБХ-д өртөхөд хүйсийн ялгаатай байдал шууд нөлөөтэй байгаа нь харагдсан. Ижил төрлийн бэрхшээлтэй хоёр хүн гэр бүл болсон хэдий ч үүнд өрхийн эмэгтэй гишүүн нь хүчирхийлэлд өртсөн тохиолдол олон байлаа. ГБХ-д өртсөн нийт хөгжлийн бэрхшээлтэй хохирогчдын 95 хувь нь эмэгтэйчүүд. Эндээс ГБХ-д эмэгтэйчүүд илүү өртөмтгий байх хандлага ХБХ-ий хувьд ч илэрч байв. Өөрөөр хэлбэл, хөгжлийн бэрхшээлтэй байх нь ГБХ-д өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байгаагаас гадна, хүйсийн хувьд эмэгтэй байх нь энэ эрсдэлийг улам нэмэгдүүлж байна.

Дээр дурдсан хоёр гол үр дүнгээс улбаалан судалгааны баг ГБХ үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулахын тулд жендэрт суурилсан хүчирхийлэл гэх суурь ойлголт, яагаад гэр бүлийн гишүүд бие биеэ хүчирхийлэх үйлдэл гаргадаг, үүнд илүү эмэгтэйчүүд өртөж байгааг зөвхөн ХБХ-ий асуудлаар хязгаарлалгүй илүү өргөн хүрээнд авч үзэх шаардлагатай болсон.

Баримт бичгийн судалгаанаас үзэхэд жендэрт суурилсан хүчирхийлэл үйлдэгдэхэд улс төр, нийгэм, соёл, шашны олон хүчин зүйлс нөлөөлдөг байна. Харилцан хамаарал бүхий олон асуудлуудаас судалгааны баг Монгол Улсад ГБХ үйлдэгдэхэд хамгийн их нөлөөтэй гэж үзэж буй дараах хүчин зүйлсийг онцолж үзсэн. Эдгээр хүчин зүйлсийг тодруулахдаа ГБХ-д өртсөн ХБХ-ий амьдралын түүх, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, мэдлэг, ойлголт, зан үйлд нь нийтлэг ажиглагдсан шинжүүд болон оролцогч талууд, асран хамгаалагч нартай хийсэн ярилцлагын мэдээлэлд үндэслэсэн болно. Үүнд:

#### Хүснэгт 7. ГБХ үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлс, түвшнээр

Түвшин	Нөлөөлж буй хүчин зүйлс
Хувь хүний түвшний хүчин зүйлс	<ol style="list-style-type: none"> <li>1. Хүйс,</li> <li>2. Гэрлэлтийн байдал</li> <li>3. Бэрхшээлийн түүх, төрөл, хүндрэлийн түвшин</li> <li>4. Хүчирхийлэлтэй холбоотой өмнөх туршлага</li> <li>5. Боловсролын түвшин,</li> <li>6. ГБХ-ийн талаар мэдлэг, ойлголт</li> <li>7. Хөдөлмөр эрхлэлт, орлого</li> <li>8. Нийгмийн харилцаа, холбоо</li> </ol>
Гэр бүлийн түвшний хүчин зүйлс	<ol style="list-style-type: none"> <li>1. Гэр бүлийн санхүүгийн чадавх (ажил эрхлэлт, орлогын эх үүсвэр),</li> <li>2. Гэр бүлийн уур амьсгал,</li> <li>3. Гэр бүлийн шийдвэр гаргах байдал</li> <li>4. Гэр бүлийн гишүүдийн эрсдэлтэй зан үйл</li> </ol>
Олон нийтийн түвшний хүчин зүйлс	<ol style="list-style-type: none"> <li>1. Олон нийтийн ялгаварлан гадуурхалт,</li> <li>2. Нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж, дэд бүтэц,</li> <li>3. Хөршийн холбоо</li> </ol>
Тогтолцооны түвшний хүчин зүйлс	<ol style="list-style-type: none"> <li>1. Жендэрийн хэвшмэл ойлголт, хандлага (хүчирхийллийг тэвчих байдал)</li> <li>2. Боловсролын чанар, хүртээмжийн хангалтгүй байдал</li> <li>3. Ядуурал (Үе дамжсан ядуурал, ажилгүйдэл)</li> </ol>

## 4. ГБХ-тэй тэмцэх тогтолцооны сул байдал

## 1.2.1. Хувь хүний хүчин зүйлс

Бүлгийн гол үр дүн:

Хөгжлийн бэрхшээлийн төрлөөс хамааран ГБХ-ийн өртөх хэлбэрүүд ялгаатай байх ба үүнээс гадна хувь хүнээс хамаарсан дараах хүчин зүйлс ХБХ-ийг ГБХ-д өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна:

- Хүйсийн хувьд эмэгтэй байх
- Гэрлэсэн байх
- Амьдралынхаа эрт үед хөгжлийн бэрхшээлтэй болсон байх
- Бэрхшээлийн хүндрэл дунд болон түүнээс дээш байх
- Өмнө нь хүчирхийлэлд өртсөн байх
- Боловсролын хувьд доогуур байх
- Хөдөлмөр эрхэлдэггүй, халамжаас өөр орлогын эх үүсвэргүй байх
- Нийгмийн харилцаа хязгаарлагдмал, найз нөхөдгүй байх

Энэ хэсэгт ХБХ ГБХ-д өртөхөд нөлөөлж буй хувь хүнээс өөрөөс нь хамаарсан хүчин зүйлсийг авч үзлээ:

**1. Нас, хүйс.** ГБХ-д өртсөн нийт ХБХ-ийг хүйсээр харьцуулж үзэхэд хүчирхийллийн хохирогчдын дийлэнх нь эмэгтэйчүүд байсан. Энэ нь бэрхшээлийн төрлөөс үл хамааран ижилхэн үр дүнтэй байгаагаас үзэхэд хүйсийн хувьд эмэгтэй байх нь ГБХ-д өртөхөд нөлөөлж буй нэг хүчин зүйл болж байна.

Хүснэгт 8. ГБХ-д өртсөн ХБХ-ий нас, хүйсийн харьцаа, бэрхшээлийн төрлөөр, (N=111)

	Хараа (N=15)	Сонгол, хэл яриа (N=20)	Тулгуур эрхтэн (N=33)	Оюун, сэтгэц (N=22)	Бусад (N=21)	Нийт
Хүйсээр						
Эрэгтэй	6.7%	25%	42.4%	27.3%	23.8%	27.9%
Эмэгтэй	<b>93.3%</b>	<b>75%</b>	<b>57.6%</b>	<b>72.7%</b>	<b>76.2%</b>	<b>72.1%</b>
Насны бүлэг						
18-30	26.7%	15%	19.4%	<b>36.8%</b>	25.0%	23.8%
31-40	20.0%	40%	25.8%	<b>47.4%</b>	30.0%	32.4%
41-50	<b>46.7%</b>	<b>35%</b>	<b>41.9%</b>	15.8%	<b>30.0%</b>	<b>34.3%</b>
50+	6.7%	10.0%	12.9%	0.0%	15.0%	9.5%

Харин ГБХ-д өртсөн ХБХ-ий насыг харвал ГБХ-д бүх насны хүмүүс өртсөн байна. Насны бүлгээр харьцуулбал, оюун, сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд залуу байх тусмаа хүчирхийлэлд өртсөн байдал нэмэгдэж байсан бол бусад ХБХ-ий хувьд нийтлэг 40-өөс дээш насныхны эзлэх хувь өндөр байна.

Чанарын мэдээллээс үзэхэд 40-өөс дээш насны хүмүүсийн ГБХ-д өртсөн туршлага харьцангуй олон жилийн өмнөөс эхэлсэн бөгөөд энэ насны хүмүүс бусад бүлгээс илүү ГБХ-д хүлцэнгүй байх хандлагатай байгаа нь ажиглагдсан. Тодруулбал, ГБХ-ийн талаар ойлголт мэдлэгийг насны бүлгээр авч үзэхэд, 41-50 хүртэлх насны ХБХ-ийн ойлголт, мэдлэг сайн хэдий ч цагдаагийн байгууллагад хандсан, хүчирхийллийг мэдээллэсэн байдал нь эсрэгээрээ бага байсан. Өөрөөр хэлбэл, энэ насны хүмүүс гэр бүлийн орчинд хүчирхийлэлтэй харилцааг 15 ба түүнээс дээш жилийн турш мэдэрсэн байх ба хүчирхийлэлтэй харилцаанд амьдарч байгаага мэддэг ч, энэ тухай мэдэгдэх зан үйл бага байгаа нь хүчирхийллийг тэвчих хандлагатай болсон байгааг харуулж байлаа.

**Шигтгээ 48. Оюуны бэрхшээлтэй, 43 настай, эмэгтэй**

Одоогийн нөхөртэй суугаад 11 жил болж байна. Нөхөр бас сэтгэцийн өөрчлөлттэй. Маш хартай, дээр нь мэдрэл муутай болохоор тэрнээс нь болж хэрүүл маргаан их гарна. Тэгээд ийм хүнтэй л хамт амьдарч байна даа. Одоо яахав миний л тавьсан тавилан, зурсан зураг. Шоронд нь явуулчихъя гэхээр үр хүүхдүүдийн минь амьдралд бөөн хар толбо үүснэ шүү дээ. Бас хоёр охин өнчирчихдөг юм болов уу гэж бодоод олон жил тэвчээд амьдарч байна.

Үүнээс үзэхэд бүх насны ХБХ ГБХ-д өртөх эрсдэлтэй боловч 40-өөс дээш насны хүмүүс ГБХ-д илүү хүлцэнгүй буюу хүчирхийллийг цааш мэдээлэхгүй байх, тэвчих хандлагатай байна.

**2. Гэрлэлтийн байдал.** Чанарын судалгааны мэдээллээр гэрлэсэн эмэгтэйчүүдийн хувьд нөхөр, хадам аав, ээж, ах, эгч, дүүгийн зүгээс хүчирхийлэл үйлдэгдэх байдал нэмэгдэж буй нийтлэг шинж ажиглагдсан. Тус үр дүнг баталгаажуулах зорилгоор ГБХ-д өртсөн ХБХ-ийг гэрлэлтийн байдлаар нь харьцуулж үзвэл, оюун сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн дунд гэрлээгүй эмэгтэйчүүд илүү хүчирхийлэлд өртсөн бол бусад ХБХ-ий хувьд нийтлэг гэрлэсэн эмэгтэйчүүд ГБХ-д өртсөн байна (Хүснэгт 9). Эндээс үзвэл гэрлэлтийн байдал нь ХБХ-ийг ГБХ-д өртөх эрсдэлийг тодорхой хэмжээнд нэмэгдүүлдэг байна.

**Хүснэгт 9. Нийт ГБХ-д өртсөн ХБХ-ий гэрлэлтийн байдал (n=111)**

Гэрлэлтийн статус	Харааны	Сэтгэц, оюуны	Сонсгол, хэл яриа	Тулгуур эрхтний	Бусад төрлийн
Гэрлэсэн	51.9%	29.4%	84.0%	53.6%	41.4%
Гэрлээгүй	29.6%	55.9%	12.0%	25.0%	41.4%
Салсан	18.5%	14.75	4.0%	21.4%	17.2%

**3. Бэрхшээлийн түүх, төрөл, хүндрэл.** Нэгдүгээрт, нийт ХБХ-ий 62 хувь нь олдмол, 38 хувь нь төрөлхийн бэрхшээлтэй байсан. Бэрхшээлийн түүх нь ГБХ-д өртөх эрсдэлийг нэмэгдүүлэх эсэх нь бэрхшээлийн төрлөөс хамаараад харилцан адилгүй боловч, нийтлэг, амьдралынхаа аль үед хөгжлийн бэрхшээлтэй байх нь тодорхой нөлөөтэй байгаа нь ажиглагдсан. Тухайлбал, төрөлхийн ХБХ-ий хувьд гэр бүлийн гишүүнээс хамааралтай байдал өндөр байгаа бол амьдралынхаа аль нэг үед хөгжлийн бэрхшээлтэй болсон, ялангуяа хожуу үедээ хөгжлийн бэрхшээлтэй болсон бол боловсрол эзэмшсэн байх, ажил хөдөлмөр эрхлэх чадваруудад суралцсан байх, тодорхой нийгмийн хүрээлэлтэй байх зэрэг ГБХ-ийн эрсдэлийг бууруулах хамгаалагч хүчин зүйлс нэмэгдэж байгаа нь ажиглагдсан.

Хоёрдугаарт, бэрхшээлийн төрлөөс шалтгаалан аль нэг хүчирхийллийн хэлбэрт илүү өртөмгөй байдал ажиглагдсан. Тухайлбал, ГБХ-д өртсөн байдлыг бэрхшээлээр авч үзвэл:

- Сэтгэл санааны бэрхшээлд бүх төрлийн бэрхшээлтэй хүмүүс
- Хянах зан үйлийн хүчирхийлэлд хараа, сонсгол, тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүс
- Бие махбодын хүчирхийлэлд тулгуур эрхтэн, хараа, сонсголын бэрхшээлтэй хүмүүс
- Эдийн засгийн хүчирхийлэлд оюун, сэтгэц, тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүс
- Бэлгийн хүчирхийлэлд тулгуур эрхтэн, хараа, сонсголын бэрхшээлтэй хүмүүс илүү өртсөн байна.

Бэрхшээлийн төрлөөс шалтгаалан ГБХ-ийн хэлбэрт өртсөн байдал нь ялгаатай байгааг харгалзвал бэрхшээлийн төрөл нь ГБХ-д өртөхөд тодорхой нөлөөтэй байна.

Гуравдугаарт, ХБХ-ий гэр бүлийн гишүүдээс хамааралтай байдал нэмэгдэх тусам хүчирхийлэлд өртсөн байдал нэмэгдэж байгаа байдал ажиглагдсан. Энэ нь хөгжлийн бэрхшээлийн хүндрэлийн түвшинтэй шууд холбоотой үзүүлэлт. Хэн нэг хүнээс бүрэн хамааралтай байх нь хувийн хүсэл, зорилго,

шийдвэрээс илүү асран хамгаалагчийн шийдвэрээр амьдрах нөхцөлийг бүрдүүлэх ба энэ байдал нь ГБХ-д өртөх эрсдэлийг нэмэгдүүлж, өртсөн ч ямар нэгэн тусламж дэмжлэг авч чадахгүй байхад нөлөөлөх гол хүчин зүйлсийн нэг болж байв.

**4. Өмнө нь хүчирхийлэлд өртсөн байх.** Нийт ГБХ-д өртсөн ХБХ-ий хувьд нийтлэг хүүхэд насны амьдралаа сайнаар дурсаж ярьсан хүн бага байсан. Ихэвчлэн эмзэг, ядуу, зуруу нөхцөлд өссөн, сургуульд байхдаа гадуурхагддаг байсан, хүүхэд насандаа амьдралын хүнд хэцүүг туулсан талаар дурдаж байлаа. Энэ байдал нь бэрхшээлийн түүх буюу төрөлхийн эсвэл олдмол бэрхшээлтэй эсэхээс хамаарч бага зэрэг ялгаатай байв.

Мөн одоогийн хүчирхийлэлтэй харилцаанаас өмнө хүчирхийлэлтэй холбоотой туршлагыг туулж байсан шинж нийтлэг биш ч ажиглагдсан. Хүүхэд байхдаа эцэг эхдээ байнга загнуулж, зодуулдаг байсан гэх хүмүүсийн хувьд одоогийн амьдралдаа ч хэн нэгнээс хүчирхийлэл мэдэрч байгаа туршлага цөөнгүй байв. Мөн ГБХ-ийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдол ч тааралдсан.

Тархалтын хувьд дээрх хүчин зүйл нь нийт оролцогчдын дунд өргөн биш хэдий ч амьдралын түүхийг судалсан чанарын шинжилгээний дүнгээр ГБХ-д өртөхөд нөлөөлсөн хүчин зүйлсийн нэгээр нэрлэгдсэн.

**Шигтгээ 49. Сонгинохайрхан дүүрэг, тулгуур эрхтний бэрхшээлтэй, 40 настай, эмэгтэй**

*Хойд аав маань намайг их гадуурхаж зоддог, архи уудаг, ээжийг ч гэсэн их зоддог байсан. Тийм болохоор гэртээ их очих дургүй, зодуулчхаад их олон удаа амбаартаа хонодог байсан. Ер нь хойд ааваасаа болж хөгжлийн бэрхшээлтэй болсон гэж боддог. Аавдаа зодуулчхаад зугтааж яваад 30 машинд дайруулж хоёр хөлгүй болсон.*

**Шигтгээ 50. Сэлэнгэ аймаг, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй, 48 настай, эмэгтэй**

*Хүүхэд насандаа хөгжлийн бэрхшээлтэй болсон. Миний санахад ээж минь намайг их зоддог байсан. Байнга толгой тархи, чих рүү цохидог байсан бөгөөд нэг өдөр чихнээс юм гоожоод нэлээн удсан. Чих их өвдөөд эмнэлэгт хандсан ямар эмчилгээ байхгүй гэж хэлсэн. Энэ үеэс л сонсгол хэл ярианы бэрхшээлтэй болсон гэж боддог.*

**5. Боловсролын түвшин:** ГБХ-д өртсөн ХБХ-ий 86 хувь нь бүрэн дунд болон түүнээс бага боловсролтой. ХБХ-ий хувьд нийтлэг бэрхшээлийнхээ хүндрэлээс болон олон нийтийн гадуурхал, боловсролын үйлчилгээний хүртээмжгүй байдал, зарим тохиолдолд гэр бүлийнхний үл хайхрах байдлаас үүдэн боловсрол эзэмшээгүй байна. Энэ нь тухайн ХБХ-ий гэр бүлийн гишүүдээс хамааралтай байдлыг нэмэгдүүлж, бие даасан байдлыг бууруулах гол хүчин зүйл болж байв.

Боловсрол эзэмшээгүйн улмаас ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй, ажил хийе гэсэн ч мэдлэг боловсрол, ур чадвар дутагдах, энэ эмзэг байдлыг хөгжлийн бэрхшээл нь улам нэмэгдүүлснээр нийтлэг боловсрол бага, хөдөлмөр эрхлэлт доогуур түүнээс үүдэн амжиргааны түвшин доогуур байх, гэр бүлийн хэн нэг гишүүнээс хамааралтай байх энэ бүх эмзэг байдлын тойрог үүсэж байгаа нь харагдаж байлаа.

**Шигтгээ 51. Налайх дүүрэг, харааны бэрхшээлтэй, 29 настай эмэгтэй**

*Бага насаа Баянхонгор аймагт өнгөрүүлсэн ба орон нутагт хараагүйчүүдийн сургууль гэж байгаагүй, ганцаар нь хот руу явуулаагүй. Харин 15 нас хүрэхэд аймгийн халамжийн дарга аав ээжид минь хүүхдээ ядаж бичиг үсэгтэй болго гэсэн. Тэгээд Улаанбаатар хотын 29 тусгай сургуульд нэг жил суралцсан. Суралцах хугацаанд их зүйл сурсан. Эмээгийн хамаатны авгай дарамталсаар байгаад намайг нутаг буцаалгасан.*

**Шигтгээ 52. Сэлэнгэ аймаг, одой, 43 настай, эмэгтэй**

Манай ээж намайг намхан болохоор сургуульд сургаагүй. Учир нь хүүхдүүд дээрэлхэнэ гээд. Уг нь би сургуульд сурах сонирхолтой байсан.

**Шигтгээ 53. Сүхбаатар аймаг, тулгуур эрхтний бэрхшээлтэй, 45 настай, эмэгтэй**

Баруун-Урт сумын сургуульд 6 анги хүртлээ сурч байсан. Хөл муутай болохоор хүүхдүүд шоолох гээд тэгээд л гарсан.

**6. ГБХ-ийн талаар мэдлэг, ойлголт.** Судалгааны үр дүнгээр, ГБХ-д өртсөн үедээ цагдаагийн байгууллагад хандана гэж хариулсан оролцогчдыг ГБХ-ийн талаарх ойлголт, мэдлэгтэй байдлаар нь харьцуулж үзвэл ойлголттой хүмүүс, ойлголтгүй хүмүүсээс даруй 27%-иар өндөр зан үйлтэй байна (Хүснэгт 15). ГБХ-ийн талаар ойлголттой хүмүүсийн хувьд хууль сахиулах байгууллагад хандаж тусламж авахыг илүүд үзэж байсан бол хангалттай ойлголтгүй хүмүүс ихэвчлэн эцэг эх, гэр бүл, ах дүү хамаатан садан зэрэг ойрын хүрээллийн хүмүүстээ хандахыг илүүд үзжээ. Өөрөөр хэлбэл, ГБХ-ийн талаар мэдлэг, ойлголттой байх нь тусламж, дэмжлэг эрэлхийлэх зан үйлд нөлөөтэй болох нь харагдсан.

Гэтэл тус судалгаанд хамрагдсан нийт ХБХ-ий 87 хувь нь ГБХ-ийн талаар хангалттай мэдлэг, ойлголтгүй байгаагаас үзвэл ХБХ-ий дунд ГБХ, түүний төрөл, илрэх хэлбэрийн талаарх ойлголт маш хангалтгүй байгааг харж болно. Өөрийгөө хүчирхийлэлд өртөж буйгаа мэдэхгүй эсвэл хүлээн зөвшөөрөхгүй байгаа дээрх тооны хүмүүс эрсдэлтэй нөхцөлд орсон үедээ тусламж дэмжлэг эрэлхийлэх, хүчирхийллийг холбогдох байгууллагад мэдээлэх зан үйл сул байна гэсэн үг юм.

Иймд ГБХ-ийн талаар хангалттай ойлголтгүй байх нь ГБХ-д өртөх, өртсөн ч тусламж дэмжлэг авч чадахгүй байх, хүчирхийллийг улам даамжруулахад нөлөөлөх хүчин зүйл байна.

**7. Хөдөлмөр эрхлэлтийн байдал.** ГБХ-д өртсөн ХБХ-ий 57 хувь нь огт ажил хөдөлмөр эрхэлдэггүй. Үлдсэн хүмүүс нь хувиараа, хагас болон бүтэн цагийн ажлууд эрхэлдэг. Өөрөөр хэлбэл, ГБХ-д өртсөн ХБХ-ий хөдөлмөр эрхлэлт маш бага байна. Энэ нь (1) бэрхшээлийн түүх буюу олдмол, төрөлхийн бэрхшээлтэй эсэх, (2) бэрхшээлийн хүндрэл, (3) боловсрол эзэмшсэн байдал, (4) ажил олгогч байгууллагуудын ялгаварлан гадуурхал, ХБХ-ийг ажиллуулах сонирхолгүй байх зэрэг хүчин зүйлстэй холбоотой байсан. Судалгаанд хамрагдсан ХБХ-ий хөдөлмөр эрхлэлтийн байдлыг бэрхшээлийн төрлөөр авч үзвэл:

Оюун, сэтгэц болон тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүс ажил эрхлэхгүй байх нь түгээмэл, гол төлөв гэрийн ажилд туслах замаар өрхийн аж ахуйд дэмжлэг болдог. Бусад ХБХ-ий хувьд дараах ажлын байруудад ажилладаг байна:

- Харааны бэрхшээлтэй 27 хүний 5 нь тогтсон ажилтай, 10 нь хааяа олдсон ажлыг хийдэг гэсэн мэдээллийг өгсөн. Тэдгээр хүмүүс нь хэвлэлийн газарт цаас нугалах, барилга дээр шавар зуурах, ноос самнах, ногооны талбай дээр ажиллах, төмрөөр зуух хийх, бариа засал хийх, тоосгоны үйлдвэрт тоосго цохих, лааз хуванцар сав цуглуулан зарж борлуулах, гэрийн тавилга хийх зэрэг ажил эрхэлдэг.
- Сонсголын бэрхшээлтэй 29 хүний 9 тогтсон ажилтай, 7 цагийн ажил хийдэг. Тэдгээр хүмүүс цэвэрлэгээ хийх, байшин барих, талхны цехэд талх барих, багш, манаач, бараа өрөгч хийх, зам засварлах, цайны газар аяга таваг угаах, айлын үхэр саах, үйлдвэрт оёдолчин хийж амьдрал ахуйгаа залгуулдаг.
- Сэтгэц, оюуны бэрхшээлтэй 34 хүний 4 нь тогтсон ажилтай, 3 нь хааяа олдсон ажлыг хийдэг. Эдгээр хүмүүс нь хадлан авах, гагнуур хийх, гудамжны хог цэвэрлэх, тогооч хийх, айлын мал

маллах, сантехникийн засвар үйлчилгээ, ус түгээгч хийх, баар ресторанд үйлчлэгч хийх, машин засах, үйлдвэрт тавилга хийх зэрэг ажлуудыг хийдэг.

- Тулгуур эрхтний бэрхшээлтэй 35 хүний 3 нь тогтсон ажилтай, 8 нь хааяа олдсон ажлыг хийдэг. Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүс гэрээр оёдол хийх, талбайгаас чацаргана түүх, гутал засах, худаг ажиллуулах, урлан хийх, канон ажилуулах, хүүхэд харах, галч хийх, бичээч хийх, ногоо тарих, борлуулах зэрэг ажлуудыг түлхүү хийж байна.
- Бусад төрлийн бэрхшээлтэй 29 хүний 6 нь ажилтай, 9 нь хааяа олдсон ажлыг хийдэг. Бусад төрлийн бэрхшээлтэй хүмүүс ногоо тарих ба хураах, хүүхэд харах, оёдол хийх, өвс хадах, хувиараа арьс шир, түүхий эд зарж борлуулах, зэрлэг зулгаах, бараа бүтээгдэхүүн зарж борлуулах, лангуун дээр суух, мал саах, хамгаалагч хийх, мал маллах, галч хийх, жолооч хийх, ногоо тариалах, тогооч хийх, мод зарах, зүүмэл даавуун урлалаар цүнх хийх зэрэг ажлыг эрхэлдэг.

ХБХ мэргэжил эзэмшсэн ч хөдөлмөрийн зах зээл дээр тогтмол ажилд авах нь ховор, ААНБ ажлын байранд ажиллуулах хүсэл сонирхолгүй байдаг ба үүний шалтгаан нь хөгжлийн бэрхшээл нь болдог байна. Ийнхүү ХБХ багаасаа боловсрол эзэмших боломж хязгаарлагдмал байдгаас мэргэжил эзэмших боломж багасч, энэ нь цаашдын хөдөлмөр эрхлэх боломжийг бууруулснаар ХБХ нь баялаг бүтээгч бус гэрийнхээ хэн нэгний асаргаанд бүрэн хараат байдлаар амьдрах, энэ нь цаашлаад ГБХ-д өртөх суурь хүчин зүйлсийн нэг болж байна.

Дээрх байдлаас үүдэн ХБХ зөвхөн халамжийн тэтгэврээр санхүүгийн эх үүсвэрээ бүрдүүлж байна. Судалгаанд хамрагдсан ХБХ-ий (n=141<sup>5</sup>) санхүүгийн эх үүсвэрийг авч үзвэл бэрхшээлээс үл хамааран нийтлэг зөвхөн халамжийн тэтгэврээр амжиргаагаа залгуулж байна.

	Төлөв байдал	Харааны	Сонсголын	Тулгуур эрхтний	Сэтгэц, оюуны	Бусад төрлийн
	Халамжийн мөнгө, тэтгэвэр, тогтмол ажил хийн цалин авдаг.	3	3	2	7	1
	Нийгмийн халамжийн мөнгө, хамаатан садны дэмжлэг, хааяа цагийн ажил хийдэг	5	3	4	7	9
	Зөвхөн тэтгэмж, тэтгэвэр, хүнсний талоноор амьдардаг	18	28	22	11	18

Санхүүгийн хувьд хэн нэгнээс хараат байх нь ГБХ-д өртөх суурь хүчин зүйлсийн нэг бөгөөд хүчирхийлэгчээс холдвол, салвал би яаж амьдрах вэ гэсэн асуултыг олон оролцогчид тавьж байсан юм.

**8. Нийгмийн харилцаа, холбоо.** Нийгмийн харилцаатай байх нь хүмүүсийг бие биенээ ойлгох, мэдээлэл солилцох, асуудлыг даван туулахад дэмжлэг болох, өөрийн нөхцөл байдлаа бодитой үнэлэх

<sup>5</sup> Үлдсэн хүмүүс нь тухайн асуудалтай холбоотой мэдээлэл өгөөгүй (хариулахаас татгалзсан, ярилцлагадаа дурдаагүй эсвэл хариулж мэдэхгүй байх зэрэг шалтгаанаар)

боломжийг олгодог. Нийгмийн харилцааныхаа талаар мэдээлэл өгсөн 134<sup>6</sup> ХБХ-ий хувьд ихэвчлэн гэр бүлийн гишүүдтэйгээ харилцдаг бөгөөд найз нөхдийн хүрээлэл бага байх төлөв ажиглагдсан. Тодруулбал, тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн харилцаа хэвийн бол сэтгэц, оюуны бэрхшээлтэй хүмүүс нийгмийн харилцаа хамгийн бага, найз нөхөдгүй байдал ажиглагдлаа.

Төлөв байдал		Харааны	Сонсголын	Тулгуур эрхтний	Сэтгэц, оюуны	Бусад төрлийн
	Найз нөхөд ихтэй	8	9	7	9	5
	Цөөхөн найзтай	7	6	14	6	12
	Найз нөхөдгүй	8	19	5	10	9

Мэдээлэл өгсөн ХБХ-ий 52 хувь нь зөвхөн гэр бүлийн гишүүдтэйгээ харилцдаг гэж хариулсан. ХБХ-ий нийгмийн идэвх, оролцоо хангалтгүй байгаа нь нэг талаас бэрхшээлээс, нөгөө талаас мэдээллийн хүртээмжтэй орчин бүрдээгүйтэй холбон тайлбарлаж байв. Асран хамгаалагчдын өгсөн мэдээллээр хөгжлийн бэрхшээлийн хүндрэлийн түвшин ихсэх тусам нийгмийн харилцаанаас тусгаарлагддаг байна.

### 1.2.2. Гэр бүлийн хүчин зүйлс

*Бүлгийн гол үр дүн:*

*Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийн дараах шинжүүд нь ГБХ үйлдэгдэх эрсдэлийг нэмэгдүүлж байна:*

- Гэр бүлийн орлогын эх үүсвэр цөөн. Дийлэнх тохиолдолд халамжийн тэтгэвэр тэтгэмжээр өрхийн орлого бүрддэг.
- Архины хамааралтай гишүүнтэй байх
- Гэр бүлийн шийдвэр гаргалтад ХБХ-ий санал бодлыг харгалздаггүй байх

Энэ хэсэгт ХБХ-ий ар гэрийн нөхцөл байдлаас шалтгаалан ГБХ-д үйлдэгдэх эрсдэлийг нэмэгдүүлж буй хүчин зүйлсийг авч үзсэн.

**1. Ам бүлийн тоо.** Ярилцлагад хамрагдсан нийт ХБХ-ий хувьд ам бүл олуулаа амьдардаг байх шинж нийтлэг ажиглагдсан.

ҮСХ-ний 2018 онд гүйцэтгэсэн “Ядуурлын дүр төрх” судалгаанд ядуу өрхийн үндсэн шинжүүдийн нэг нь олон хүүхэдтэй байх буюу ам бүлийн тоо олон байгаа талаар дурдсан байна. Өөрөөр хэлбэл, өрх дэхь хүүхдийн тоо нэмэгдэх нь өрхийн ядууралтай хамааралтай болохыг баталсан. Тус үр дүнд

<sup>6</sup> Үлдсэн хүмүүс нь тухайн асуудалтай холбоотой мэдээлэл өгөөгүй (хариулахаас татгалзсан, ярилцлагадаа дурдаагүй эсвэл хариулж мэдэхгүй байх зэрэг шалтгаанаар)

тулгуурлан, ядуу өрх дэхь хүүхдийн тоо нэмэгдэх тусам өрхийн гишүүдийн амьдралын чанар<sup>7</sup> муудаж, үүнээс үүдэн хэн нэгэн нь хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэл нэмэгдэх эрсдэлтэйг ядуурлын тойргийн онолоор<sup>8</sup> тайлбарладаг. Иймд, ам бүлийн тоо олон байх нь ядуурлын үзүүлэлттэй холбоотойгоос гадна ГБХ-д өртөх эрсдэлийг нэмэгдүүлэхэд нөлөөтэй байж болзошгүй гэж судалгааны баг таамагласан.

Уг таамаглалыг шалгах зорилгоор ГБХ-д өртсөн болон өртөөгүй ХБХ-ий өрхийн ам бүлийн тоог харьцуулахад ялгаа бага ажиглагдсан (Хүснэгт 10). Өөрөөр хэлбэл, өрхийн ам бүлийн тоо ГБХ-д өртөх эрсдэлийг нэмэгдүүлэхэд нөлөөлдөг эсэх нь судалгаанд оролцогчдын мэдээллээс батлагдаагүй болно.

#### Хүснэгт 10. Судалгаанд оролцсон ХБХ-ийн насны харьцаа, бэрхшээлийн төрлөөр

Өрхийн ам бүлийн тоо	ГБХ-д өртсөн (N=111)	ГБХ-д өртөөгүй (N=39)
Ганцаараа	2.8%	2.6%
Хоёулаа	7.3%	15.8%
3-4 гишүүнтэй	44%	40%
5-аас дээш гишүүнтэй	45%	42%

**2. Гэр бүлийн орлогын эх үүсвэр.** ХБХ-тэй өрхийн орлогын эх үүсвэрийг авч үзвэл ХБХ-ий хувийн орлогоос эрс ялгаатай байдал харагдсангүй. Энэ нь нэг талаас (1) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөр хоорондоо гэр бүл болох, (2) ХБХ-ий асран хамгаалагч нь хөдөлмөр эрхлэх боломжгүйгээс нийтлэг ХБХ-тэй гэр бүл амьжиргааны түвшин доогуур байгаатай холбоотой байна. Судалгаанд хамрагдсан 141<sup>9</sup> ХБХ-ий өгсөн мэдээллээр гэр бүлийн орлогын эх үүсвэрийг гол төлөв ХБХ-ий халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмж, хүүхдийн мөнгө, хүнсний талон, бусад тохиолдолд ажил хийсэн хөлс бүрдүүлж байна. Хувь хүний орлоготой харьцуулахад өрх, гэр бүлийн орлогод хүүхдийн мөнгө, асаргааны тэтгэмж, ажлын хөлс зэрэг эх үүсвэрүүд нэмэгдэж байсан.

ХБХ-ий өрхийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлж буй эх үүсвэрүүдийг авч үзвэл өрхийн хөдөлмөр эрхэлдэг гишүүний цалингийн орлогоос гадна доорх эх үүсвэрүүдээс<sup>10</sup> бүрдэж байна:

#### Хүснэгт 11. ХБХ-тэй өрхийн гол эх үүсвэрүүд

№	ХБХ-тэй өрхийн орлогын гол эх үүсвэрүүд	Хэмжээ, орц
1	Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарсны тэтгэмж	Сар бүр 60,000 төгрөг
2	Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарсны тэтгэмж	Сар бүр 155,000 төгрөг
3	ХБХ-ий халамжийн тэтгэвэр (Коронавируст халдварын цар тахлын үед хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай иргэдийн нийгмийн	Сар бүр 188,000 төгрөг

<sup>7</sup> Энэ нь амьдралын сэтгэл ханамж буюу бие мах бодийн эрүүл мэнд, боловсрол, ажил эрхлэлт, эд хөрөнгө, аюулгүй байдал, итгэл үнэмшил болон хүрээлэн буй орчин зэрэг хувь хүнийг тав тухтай, сэтгэл хангалуун амьдрахад нөлөөлж буй олон хэмжүүрийг багтаадаг нийгмийн судалгааны ойлголт юм.

<sup>8</sup> ГБХ-д нөлөөлж буй тогтолцооны хүчин зүйлс бүлэгт тус ойлголтыг дэлгэрүүлэн авч үзэв.

<sup>9</sup> Үлдсэн хүмүүс нь тухайн асуудалтай холбоотой мэдээлэл өгөөгүй (хариулахаас татгалзсан, ярилцлагадаа дурдаагүй эсвэл хариулж мэдэхгүй байх зэрэг шалтгаанаар)

<sup>10</sup> Судалгаанд оролцогчдын өгсөн мэдээлэлд үндэслэсэн болно.

	хамгааллыг сайжруулах, орлогыг нэмэгдүүлэх II багц арга хэмжээний хүрээнд тэтгэвэр тэтгэмжийн хэмжээг 2020.04.01-2021.07.01 хүртэл дараах байдлаар нэмсэн болно.	(2020.04.01-2021.07.01 хүртэл хугацаанд дээрх дүнг 100,000 төгрөгөөр нэмсэн)
4	Хүнсний эрхийн бичиг	Сар бүр том хүн -16,000 төгрөг Хүүхэд – 8, 000 төгрөг (2020.04.01-2021.07.01 хүртэл хугацаанд дээрх дүнг 2 дахин нэмсэн)
5	Түлшний хөнгөлөлт (Бүрэн хараагүй, хэлгүй, дүлий одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд орон сууцны төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлши худалдан авах)	Жилд нэг удаа 140,000 төгрөг
6	Олон улсын байгууллагаас тусламж дэмжлэг: - Good Neighbours ОУБ (орон нутаг) - Улаан загалмайн нийгэмлэг (орон нутаг) - Исламын сүм - Дэлхийн зөн ОУБ - Тайваний хүүхэд гэр бүлийг дэмжих сан	Жилд нэг удаа 150,000 төгрөг Жилд нэг удаа будаа, гурил, хуурай цай, ургамлын тос Төмс ногоо, гурил, будаа Сургалт Гурил, будаа, эм авах мөнгө, эсгий гудас

ХБХ-ий асаргаатай холбоотойгоор хөдөлмөрийн чадвартай нэг хүн зайлшгүй гэртээ суухад хүрдэг болохыг бараг бүх асран хамгаалагч нар дурджээ. Ялангуяа, өрх толгойлсон эцэг эхийн хувьд дээрх нөхцөл байдал нь улам хүндрэлтэй нөхцөлд оруулдаг ба зөвхөн ХБХ-ий халамжийн тэтгэвэр болон асаргааны тэтгэмжээр амьжиргаагаа залгуулахаас өөр аргагүй нөхцөлд ордог байна.

Асран хамгаалагч нарын хувьд хөдөлмөр эрхэлж өрхийн орлогоо нэмэгдүүлэх сонирхол өндөр байвч ХБХ-ий асаргаа нь зөвхөн цагийн ажил хийх, зарим тохиолдолд ажил хийх ямар ч боломж олгодоггүй талаар дурджээ. Ажилд орсон ч хөдөлмөрийн гэрээн дээр цагийн уян хатан нөхцөлийг тусгадаггүй, гэр бүлийн хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй холбоотой чөлөө авахад халагдах үндэслэл болдог байна.

ХБХ-тэй өрхийн орлогын гол эх үүсвэр нь халамжийн тэтгэвэр байх нийтлэг шинжтэй ба тус тэтгэвэр нь зөвхөн ХБХ-ий хэрэгцээнээс илүү өрхийн хэрэглээнд зарцуулагдаж байна. Олон эх үүсвэрээс бус зөвхөн халамжаас хэт хараат байх нь өрхийн эмзэг байдлыг нэмэгдүүлэх ба энэ нь гэр бүл дотор зөрчил маргаанийг нэмэгдүүлэх, хүчирхийлэл үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн нэг болж байна.

	Төлөв байдал	Харааны	Сонсголын	Тулгуур эрхтний	Сэтгэц, оюуны	Бусад төрлийн
	Халамжийн мөнгө, тэтгэвэр, тогтмол ажил хийн цалин авдаг.	3	7	2	3	1
	Нийгмийн халамжийн мөнгө, хамаатан садны дэмжлэг, хааяа цагийн ажил хийдэг.	5	7	4	4	9
	Зөвхөн тэтгэмж, тэтгэвэр, хүнсний талон, асаргааны	18	11	22	27	18

мөнгө, хүүхдийн мөнгөөр амьдардаг					
-----------------------------------	--	--	--	--	--

**Шигтгээ 53. Увс аймаг, харааны бэрхшээлтэй, 18 настай, эрэгтэй**

*Манайх ер нь л хүүхдийн мөнгө, миний халамжаар амьдардаг. Хааяа аавын хийдэг ажлын мөнгө нэмэгдэнэ. Сая манай хоёр ихэр дүүгийн нэг нь тархины усжилтай гээд хагалгаанд орсон тэгээд ээж аав байж болох бүх зээлээ авчихсан. Одоо жаахан мөнгө тааруухан л байгаа даа. Миний уналтын эмийг хүртэл авч чадахгүй байгаа. Миний эмүүд одоо дуусчихсан. Нэг эм нь уг нь 700 төгрөгөөр худалдан авдаг.*

**3. Өрхийн эрсдэлтэй зан үйл.** Судалгаанд хамрагдсан нийт ХБХ-ий гэр бүлийн 25 хувь (n=36) нь аль нэг гишүүн (төрсөн аав, ээж, дүү, нөхөр, хадам аав, ээж) архины хамааралтай байсан. Тэдгээр гэр бүлд амьдардаг ХБХ бүгд ГБХ-ийн хохирогч болж байсан өгүүлэмжтэй байгаа нь гэр бүлийн аль нэг гишүүн нь архины хамааралтай байх нь ГБХ үйлдэгдэхэд шууд нөлөөтэй байгааг харуулж байсан.

**Шигтгээ 54. Сэлэнгэ аймаг, хараа, сэтгэц, хэл ярианы хавсарсан бэрхшээлтэй, 45 настай, эрэгтэй**

*Аав минь өдөр бүр архи ууж, агсам тавьдаг. Гэр бүлийн гишүүдийг хараах, зүхэх, доромжлох, эд хогшил эвдэх үйлдлийг байнга гаргадаг.*

**Шигтгээ 55. Сэлэнгэ аймаг, дотор эрхтний өвчлөлтэй, 38 настай, эмэгтэй**

*Нөхөр архины асуудалтай, хэзээ эрүүл байсныг би санахгүй байна. Өмнө нь зодож, цохиж, бэртэл учруулдаг байсан одоо ч архи уухаараа гэрт янз бүрийн хүмүүстэй нийлж уун эдгээр үйлдлийг гаргадаг.*

Мөн өрхийн эрсдэлтэй зан үйлд гэр бүлээс гадуурх харилцаа нь ГБХ үйлдэгдэхэд нөлөөтэй болох нь оролцогчдын өгсөн мэдээллээс харагдаж байв. Гэр бүлээс гадуур харилцаа үүсгэх эс бөгөөс үүнтэй ижил сэдлээр хамтрагчаа хардах зан үйл нь гэр бүл дотор зөрчил маргаанийг нэмэгдүүлэх улмаар ГБХ үйлдэгдэхэд хүргэсэн тохиолдлууд цөөнгүй байв.

**Шигтгээ 56. Сонгинохайрхан дүүрэг, 29 настай, эмэгтэй**

*Нөхөр нууц амрагтай болсныг нь мэдсэнээс хойш манай гэр бүлд хүчирхийлэл улам даамжрах болсон. Хүүхдээ миний хүүхэд биш, намайг шөнө унтаж байхад ухаан алдуулах зэрэг, гэнэт би хаана унтаж байгаа билээ гээд хүүхдэдээ сүүг нь өгсөн билүү яалаа гээд цочиж сэрдэг. Тэгээд дараа нь толинд харахаар хүзүү маань их улайлттай байдаг байсан.*

**4. Гэр бүлийн уур амьсгал.** Судалгаанд хамрагдсан ХБХ-ий 62 хувь нь судалгаа явагдаж байх үеийн гэр бүлийн уур амьсгалаа таатай байдлаар үнэлсэн бол 27.6 хувь нь хэрүүл маргаан, үйл ойлголцолтой гэж үнэлсэн байна. Гэвч нийтлэг ГБХ-д өртсөн ХБХ гэр бүлийн гишүүдийнхээ уур амьсгалын талаар ярих дургүй, өгсөн мэдээлэл нь гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцааг бүрэн дүүрэн гаргахад учир дутагдалтай байв. Ихэнх оролцогчдын дунд мөн гэр бүлийн гишүүдийн зүгээс гаргаж буй зан авир, үйлдэл нь ГБХ мөн эсэх талаар ойлголт мэдлэг хангалтгүй, дутмаг байгаа нь ажиглагдсан.

Асран хамгаалагчдад гэртээ байнга ХБХ-ийг асарснаар уур бухимдал гарах, стресст орох, асаргаатай холбоотой гэр бүлийн гишүүдийн хооронд маргаан гардаг бөгөөд зарим үед уур бухимдлаа барьж чадахгүй асарч буй хүүхдээ цохих, хэл амаар доромжлох, өөр бусад янз бүрийн үйлдэл гаргадгаа нуусангүй. Хүүхдүүд томрох тусам илүү их арчилгаа, хэрэгцээ шаардлагатай болдог. Асаргааг ээжүүд ихэвчлэн үүрдэг тул хүүхдээ даахгүй болох, үүнтэй холбоотой ядрах, туйлдах, эрүүл мэнд нь муудах, нийгмийн харилцаа холбоо багасах зэрэг асуудлуудтай нүүр тулдаг. Зарим гэр бүлийн гишүүдийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй гишүүнээ асрамжийн газар хүргүүлэх асуудлыг хөндөж тавьдаг байна.

**5.Гэр бүлийн шийдвэр гаргалт.** Судалгаанд оролцогчсон ХБХ-ий (n=142<sup>11</sup>) 64.7 хувь нь гэр бүлийн гишүүд аль болох саналыг нь асуун шийдвэр гаргалтад оролцуулахыг хичээдэг гэжээ. Гэр бүлийн орчинд шийдвэр гаргалтад оролцох байдал нь хөгжлийн бэрхшээлийн төрлөөс хамаараад ялгаатай байна. Тухайлбал, сэтгэц, оюуны болон бусад төрлийн бэрхшээлтэй хүмүүс шийдвэр гаргалтын түвшинд оролцуулахгүй, гадуурхах үйлдэл гэр бүлийн орчинд гардаг болох нь ярилцлагын явцад олонтоо дурдагджээ.

	Төлөв байдал	Харааны	Сонголын	Тулгуур эрхтний	Сэтгэц, оюуны	Бусад төрлийн
	Өөрөө шийдвэр гаргадаг.	21	15	23	17	16
	Гэр бүлийн хэн нэгэнд санал бодлоо хэлдэг.	5	8	4	6	5
	Шийдвэр гаргалтад оролцуулдаггүй, өөрөө бие даан шийдвэр гаргадаггүй.	1	2	1	11	7

### 1.2.3. Олон нийтийн хүчин зүйлс

*Бүлгийн гол үр дүн:*

*Тухайн хүний амьдарч буй орон нутгийн онцлогтой холбоотой дараах хүчин зүйлс ХБХ-ийг ГБХ-д өртөхөд шууд бус байдлаар нөлөөлж байна:*

- Олон нийтийн ялгаварлан гадуурхал
- Нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж
- Дэд бүтцийн сул хөгжил
- Олон нийтийн нэгдэл, хөршийн холбоо сул байх

Олон нийттэй холбоотой хүчин зүйлсэд ХБХ-ий амьдарч буй орон нутгийн нөхцөл байдал, хөгжил, орон нутгийн иргэдтэй холбоотой хүчин зүйлс хувь хүнийг ГБХ-д өртөхөд шууд бус байдлаар нөлөө үзүүлж буй эсэхийг авч үзсэн. ХБХ-тэй ярилцлага хийх явцад тухайн орон нутгийн иргэдийн дундах ялгаварлан гадуурхалт, нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж, дэд бүтцийн хөгжил, мөн орон нутгийн иргэдийн бүлийн төлөвшил сул байх зэрэг хүчин зүйлүүд нөлөөтэй байгаа нь оролцогчдын өгсөн мэдээллээс харагдсан.

**1. Ялгаварлан гадуурхалт.** Судалгаанд хамрагдсан 134<sup>12</sup> ХБХ-ий 22.3 хувь нь тухайн амьдарч буй орчиндоо нийгмийн зүгээс ямар нэг ялагаварлан гадуурхлыг мэдэрч байсан гэж хариулсан. Ялангуяа дээрх хариултыг насны хувьд залуу хүмүүс илүү өгсөн байх ба бусад оролцогчдын хувьд сургуульд суралцаж байхад, хүүхэд байхад бэрхшээлээр нь далимдуулж шоглох, шоовдорлох хандлага түгээмэл байснаас сургуулиа орхих болсон, хичээлдээ явах дургүй болсон зэрэг хариултуудыг өгчээ. Эндээс үзэхэд хөгжлийн бэрхшээл нь тэдгээр хүмүүсийн ялгаварлан гадуурхагдах гол шалтгаан болдог ба энэ нь сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх зэрэг нийгмийн харилцаанд идэвхтэй оролцож, амьдралын баталгаагаа хангахад шууд сөргөөр нөлөөлсөн байна. Өөрөөр хэлбэл, олон нийтийн зүгээс ямар нэг

<sup>11</sup> Үлдсэн хүмүүс нь тухайн асуудалтай холбоотой мэдээлэл өгөөгүй (хариулахаас татгалзсан, ярилцлагадаа дурдаагүй эсвэл хариулж мэдэхгүй байх зэрэг шалтгаанаар)

<sup>12</sup> Ibid.

байдлаар ялгаварлан гадуурхалтыг мэдэрсэн нь тухайн ХБХ-ийг сургуулиа орхих, улмаар ажил хөдөлмөр эрхлэх боломжоор хязгаарлах, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцох байдлыг хумигдуулснаар ХБХ гэрээсээ гарах дургүй, нийгмийн харилцаа нь зөвхөн гэр бүлийн хүрээнд хязгаарлагдахад нөлөөлж байна. Нийгмийн харилцаа хязгаарлагдах нь ХБХ-ий эмзэг байдлыг нэмэгдүүлэх, цаашлаад ГБХ-ийн хохирогч болгоход нөлөөтэй байна.

Төлөв байдал		Харааны	Сонсголын	Тулгуур эрхтний	Сэтгэц, оюуны	Бусад төрлийн
	Хаана, хэн ч ялгаатай ханддаггүй.	9	9	22	25	20
	Гэр бүлийн гишүүд, хамаатан садан хүмүүс ялгаварлан гадуурхдаггүй.	7	8	2	5	4
	Хүмүүс доромжилж, илт ялгаварлан гадуурхдаг.	5	7	4	4	3

**Шигтгээ 57. Увс аймаг, тулгуур эрхтний бэрхшээлтэй, 40 настай, эмэгтэй**

Би өөрөө сургуульд явж чадахгүй. Дээр үед хүүхдүүд аймар доромжилдог байсан. Хөл муутай, доголлон гэдэг, байнга буланд аваачиж шахаж зоддог байсан. Хүүхдүүд гадуурхдаг байсан болохоор хөдөө гарч малчин болсон.

**Шигтгээ 58. Сэлэнгэ аймаг, тулгуур эрхтний бэрхшээлтэй, 34 настай, эмэгтэй**

Бага байхад хүүхдүүд их шоолдог байсан. Дээс тоглож чадахгүй, хөл чинь алцайдаггүй гээд дооглоно. Хүүхдүүдийн ялгаварлан гадуурхал 7-р анги хүртэл үргэлжилсэн. Ангийн хөвгүүд маань манай ахын найз байсан. Намайг л өөр ангийн хүүхдүүдээс өмөөрдөг байсан. Хүүхдүүд дээрэлхээд ирэхээр ээждээ их уурлаж гомддог байсан. Сургуулиа төгсөөд ажил байхгүй сургуульдаа үргэлжлүүлээд сурч чадахгүй хэцүү байсан.

Асран хамгаалагч нартай хийсэн ярилцлагад эмнэлэгт сэтгэц, оюуны бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах чадавх, бусад онцлогийг үл харгалзан жирэмслэлтээс хамгаалах тариаг хүчээр хийлгэх, савыг боолгох саналыг ихэвчлэн тавьдаг талаар дурджээ. Өмнө хийгдсэн ижил төстэй судалгаануудад ч энэхүү асуудал хөндөгдөн тавигдсан юм. Ялгаварлан гадуурхалтаас ангид байх, хүний эрх эрх чөлөөг дээдлэн үзэх зарчимд тулгуурлан үйлчилгээг үзүүлэх ёстой эмнэлэгийн салбарын эмч, мэргэжилтнүүд хүний эрхийн талаар ойлголт, мэдлэг хангалтгүй байгааг цаашид анхаарах нь зүйтэй. Мөн өрх толгойлсон эмэгтэйчүүд мэргэжил эзэмшсэн боловч ажлын байрны сонгон шалгаруулалтад нас болон гэртээ асаргаатай хүүхэдтэй гэдгээр ажилд авахгүй байх нь илтэд ялгаварлан гадуурхалтад өртөж байгаа хэрэг юм. Зарим асран хамгаалагчид хөгжлийн бэрхшээлтэй ах, эгч, дүүгээс нь болж гэр бүлийн бусад гишүүд ялгаварлан гадуурхалтад өртөх вий гэдэгт үргэлж санаа зовдогоо илэрхийлж байв.

ХБХ олон нийтийн зүгээс ялгаварлан гадуурхалтад өртөх нь ГБХ-ийг бууруулахад нөлөөтэй хамгаалагч хүчин зүйлсэд (боловсролоо дээшлүүлэх, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцох гэх мэт) сөрөг нөлөөтэй байна.

**2. Нийгмийн үйлчилгээний хүртээмж, дэд бүтэц.** ХБХ-ий боловсрол эзэмшиж чадахгүй байхад нөлөөлж буй нэг хүчин зүйл нь боловсролын үйлчилгээний хүртээмжийн асуудал байсан. ХБХ нь бэрхшээлийнхээ онцлогтой холбоотойгоор тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээ авах нь суурь хэрэгцээ шаардлагын нэг. Тухайлбал, сонсголын бэрхшээлтэй хүнд дохионы хэл, харааны бэрхшээлтэй хүнд брайл бичиг үсгийн боловсрол нь анхдагч суурь хэрэгцээнд тооцогддог. Гэтэл манай улсад улсын хэмжээнд зургаан тусгай сургууль үйл ажиллагаа явуулдаг нь зөвхөн Улаанбаатар хотод төвлөрдөг.

Бусад ерөнхий боловсролын сургуулиудын хувьд тэгш хамруулан сургах орчин дутагдалтайгаас ХБХ боловсролын гадна үлдэхэд хүрч байгаа нь амьдралын чанарыг бууруулахад голлох нөлөө үзүүлж байна.

Мөн ХБХ-ий хамгийн их авдаг үйлчилгээ нь эрүүл мэнд болон халамжийн үйлчилгээ байна. Бусад ХБХ-д чиглэсэн нийгмийн үйлчилгээний хувьд ТББ-ын оролцоо санаачлага илүү өндөр. Тухайлбал, ХБХ-д чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг ТББ-аас спорт, урлагийн арга хэмжээ зохион байгуулах, бие биетэйгээ уулзах, нэг нэгэнтэйгээ зовлон жаргалаа ярилцах, тусламж дэмжлэг шаардлагатай нэгэндээ туслах зэрэг ХБХ-ий нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн олон талт ажлыг зохион байгуулдаг байна. Харин баг/хороодын үйл ажиллагаа сул, төрийн үйлчилгээ иргэдэд тэгш, хүртээмжтэй хүрч чадахгүй байгаа нь асран хамгаалагчдыг бухимдуулж байв. ХБХ-тэй гэр бүл бусад гэр бүлтэй харьцуулахад асуудал их байдаг бөгөөд төрийн байгууллагын зүгээс нөхцөл байдлыг даван туулахад дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагаа цөөн байна.

Мөн дээрх нийгмийн суурь үйлчилгээг авахтай холбоотой дэд бүтцийн хөгжил, ялангуяа орон нутагт сул байгаа нь ХБХ-ийг гэрээсээ гарч, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцоход мэдэгдэхүйц саад учруулж буй хүчин зүйл байв. Ялангуяа, тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүст орчны хүртээмжгүй байдал нь өдөр тутмын амьдралд нь шууд нөлөө үзүүлдэг. Гадуур зорчиход нийтийн тээвэр хүртээмжгүй улмаас таксигаар зорчих шаардлага гарах, налуу шатгүй, шат, довжоо, босго зэрэг орчны саадаас шалтгаалан байнга өргөх, тэврэх зэргээр бусдын туслалцааг ихээр шаарддаг нь тэдгээр ХБХ-ийг гэрээс гарах сонирхолгүй болоход хүргэж байна.

Орон нутагт хүртээмжтэй дэд бүтэц бүхий үйлчилгээний газрууд байснаар ХБХ-ий нийгмийн суурь үйлчилгээг саадгүй авах, хөгжих, сурч боловсрох, санаа бодлоо хуваалцах, харилцан туслах, зөвлөгөө авах, бухимдлаа тайлах, дэмжлэг туслалцаа үзүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд энэ нь ХБХ-ийг ГБХ-д өртөхөд нөлөөлж буй эмзэг байдлыг бууруулахад чухал ач холбогдолтой юм.

Нийгмийн суурь үйлчилгээ ХБХ-д хүртээмжгүй байх нь тэдний эмзэг байдлыг нэмэгдүүлснээр ГБХ-д өртөх эрсдэлд хүргэж байна.

**3. Олон нийтийн нэгдэл, хөршийн холбоо.** Судалгаа явагдсан орон нутгуудад хөршийн холбоо маш сул буюу огт хөгжөөгүй болох нь ГБХ-д өртсөн ХБХ-тэй хийсэн ярилцлагаас харагдаж байв. Тодруулбал, судалгаанд хамрагдсан ХБХ-ээс цаашид ахин ГБХ-д өртвөл нэн тэргүүнд хандах талуудыг тодруулахад “хөршдөө мэдэгдэнэ” гэж хариулсан хүн маш цөөхөн байсан ба үүний шалтгааныг хөршөө сайн танихгүй, гэр бүлийн асуудлаа хөндлөнгийн хүмүүст мэдэгдэхийг хүсэхгүй байгаатай холбон тайлбарласан байна. Хөршүүд нь ХБХ-ийг ГБХ-д өртснийг мэдсэн хэдий ч үл хайхрах нь түгээмэл, санаа тавих, туслахаас цэрвэдэг болох нь ХБХ-ий ярианд дурдагдаж байв.

Асран хамгаалагчдын өгсөн мэдээллээр хөдөө орон нутагт бие биенээ сайн таньдаг уугуул иргэдийн хувьд хөршийн харилцаа байдаг хэдий ч бусдын амьдралд хошуу дүрэхгүй гэсэн хандлага давамгайлдаг. Харин шилжин суурьшсан, эсхүл хотод амьдардаг иргэдийн тухайд хөршийн холбоо сул буюу бараг ажилладаггүй гэж хэлж болохоор дүр зурагтай байна.

**Шигтгээ 59. Сэлэнгэ аймаг, оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй, 40 настай, эмэгтэй**

*Ээж намайг уурандаа харанхуй шөнөөр хөөгөөд гаргачихсан. Гудамжинд хоноход хэн ч надад туслаагүй. Хөрш айлдаа хэлбэл ээж миний мууг үзлээ гэж ахиад аашилж, зодох байх гэж бодоод. Надад хөршүүд маань тусалдаггүй. Уг нь би бага сага танина.*

Дээрх нөхцөл байдал ижил төстэй бусад судалгааны үр дүнгээр мөн баталгаажиг байв. Тухайлбал, IRIM судалгааны хүрээлэнгийн гүйцэтгэдэг “Монголчуудын нийгмийн субъектив сайн сайхан байдлын судалгаа”-аар Монголчуудын нийгмийн итгэлцэл буюу бусадтай хамтарч ажиллах, бүлгийн нэгдэл хамгийн доогуур (10 онооноос 4.7 оноо) үнэлэгдсэн. Ялангуяа, гэр бүл, ойр дотны хүмүүсээс бусад хүмүүст туслах, бусдаас тусламж авах талаар төсөөлөл бага гарсан нь тус судалгааны үр дүнтэй мөн нийцэж байв.

ГБХ-ийн нөхцөлд хүчирхийллийн хохирогч өөрөө шууд тусламж дэмжлэг эрэлхийлэх боломж бага байдгаас хөршүүд, тухайн орон нутгийн иргэд анхан шатны түвшинд холбогдох байгууллагад мэдээлэх зан үйлтэй байх нь ГБХ-ийг бууруулахад олон нийтийн зүгээс шийдвэрлэх нөлөөтэй. Гэвч өнөөдрийн байдлаар олон нийтийн дунд “бусдын хэрэгт хошуу дүрэхгүй”, “миний асуудал биш” гэсэн хандлага түгээмэл байгаа нь манай улсад олон нийтийн нэгдэл, нягтрал тэр хэмжээгээр сул байгааг харуулж байв.

Нөгөө талаас, ГБХ-тэй тэмцэх зан үйлтэй байхын суурь нь ГБХ-ийн талаар мэдлэг, ойлголттой байх явдал юм. Орон нутгийн иргэдийн ГБХ-д хүлцэнгүй байгаа нь ГБХ-ийн талаар иргэдийн мэдлэг ойлголт, хангалтгүй байгааг давхар харуулж байна. Энэ нь бодит байдал дээр хажуу хаалганд нь ГБХ үйлдэгдсэн ч хүчирхийлэл гэж үзэхгүй байх, үл хайхрахад хүргэж буй нь улмаар хүчирхийллийг улам даамжруулахад нөлөөлж байна.

#### 1.2.4. Тогтолцооны хүчин зүйлс

Тогтолцооны түвшний хүчин зүйлс нь системийн түвшний нөлөөлөгч хүчин зүйлсийг илтгэх ба илүү суурь шалтгааны байр сууриас ГБХ үйлдэгдэхэд нөлөөлж буй асуудлуудыг авч үздэг. Иймд тус түвшин нь зөвхөн ХБХ-ийн ГБХ-ийн асуудлаар хязгаарлагдахгүй ба ер нь нийгмийн бүх бүлгийн дунд ГБХ үйлдэгдэхэд нөлөөлж буй бүтцийн шинжтэй хүчин зүйлсийг бүх талын ярилцлагын мэдээлэл болон баримт бичгийн судалгааны үр дүнд үндэслэн тодруулахыг зорилоо.

Харилцан хамаарал бүхий олон асуудлуудаас судалгааны баг Монгол Улсад ГБХ үйлдэгдэхэд хамгийн их нөлөөтэй гэж үзэж буй тогтолцооны түвшний дараах дөрвөн хүчин зүйлийг онцолж байна:

**1. Жендэрийн хэвшмэл ойлголт, хандлага.** Эрэгтэй, эмэгтэй хүний гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх хэвшмэл ойлголт нийгэмд байх нь ГБХ үйлдэгдэх суурь шалтгаан болж байна. Ялангуяа, манай улсад гэр бүл дотор эрэгтэйчүүдийн байр суурь, шийдвэр гаргалт давамгайлах хандлагатай, тус соёлыг олон үе дамжин баримтлан, хүлээн зөвшөөрч, бэхжүүлж ирсэн. Уг соёлын үр нөлөөгөөр нийгэмд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гүйцэтгэх үүрэгт хэвшмэл ойлголтууд тогтсоноор гэр бүлийн гишүүдэд чиг үүргийн талаар тодорхой хүлээлтүүд бий болж, энэ нь эрх мэдэл, харилцаа, хүчний тэнцвэргүй байдал, зөрчлийг бий болгоход хүргэж байна.

Хүчирхийллийг харж өссөн, өөрөө өртсөн хүүхэд зөрчлийг шийдэж болох нэг гарц нь хүчирхийлэл гэсэн ойлголттой өсдөг, эмэгтэй эрэгтэй хүмүүс хоорондын тэнцвэргүй харилцааг мэдэрч өссөн хүүхэд эрэгтэй, эмэгтэй хүмүүс хоорондоо хүчний хувьд ялгаатай, нэг нь сул нөгөө нь илүү гэсэн ойлголттой өсдөг байна.

2017 онд гүйцэтгэсэн ҮСХ-ны Жендэрт суурилсан хүчирхийлэл: Хүчирхийллийн нүцгэн үнэн судалгаагаар хамтрагчтай байсан болон байгаа эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь (55.4 хувь) гэр бүлд нөхөр нь илүү шийдвэр гаргах эрх мэдэлтэй буюу “сайн эхнэр нөхөртэйгөө санал нийлэхгүй байсан ч үгийг нь дагадаг” байх гэсэн бодомжтой санал нийлж байгаагаа илэрхийлжээ. Дээрх хариулыг

хамтрагчийнхаа зүгээс хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүд илүү өгсөн байна.<sup>13</sup> Эдгээр үр дүн бол Монгол Улсад жендэрийн тэгш бус байдал, хэвшмэл ойлголт бат бөх хэвээр байгааг харуулж байна. Ялангуяа дээрх хэвшмэл ойлголт боловсролын түвшин бага, орлогын түвшин доогуур, хөдөө орон нутгийн иргэдийн дунд илүү өндөр байгаа нь ХБХ-тэй хийсэн ярилцлагуудаас ажиглагдаж байлаа.

Судалгаанд хамрагдсан ГБХ-ийн хохирогч ХБХ-ий 72 хувь нь эмэгтэйчүүд, тэдгээрийн 40 хувь нь хамтрагчийн зүгээс буюу нөхөр/эхнэр, хамтран амьдрагч, найз залуугийн зүгээс хүчирхийллийг мэдэрсэн. Харамсалтай нь, судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь хүчирхийлэлд өртөж буй талаараа ойлголт мэдээлэлгүйгээс гадна, нөхрийн зүгээс хийсэн үйлдлийг байж болох зүйл хэмээн зөвтгөж, тухайн үйлдэлд өөрийгөө буруутгаж байгаа нь **жендэрийн хэвшмэл ойлголт эрэгтэй, эмэгтэй аль аль хүйсийн иргэдийн дунд нийтлэг байгааг харуулж байв.**

Ярилцлагуудаас үзэхэд, нийтлэг хүчирхийлэл үйлдэгчийн зүгээс хохирогчийг захирах, удирдах, үгээрээ байлгах гэсэн хүсэл сонирхлоос үүдэн хүчирхийлэл үйлдэгддэг болох нь харагдсан. Сэтгэл зүйн төлөвшлийн хувьд уг сонирхол бүрдэх үндсэн шалтгаан нь гэр бүлийн гишүүдийн харилцааны талаар авсан суурь ойлголт юм. Өөрөөр хэлбэл, гэр бүлийн гишүүд нэгнээ хүчирхийлэхийг байж болох үйлдэл гэж хүлээн зөвшөөрдөг гэр бүл, хамт олон, нийгэмд төлөвшсөн хүнд дээрх **хүчирхийлэгч зан авир** төлөвшдөг. Тэгэхээр ГБХ бол тойрог хэлбэрээр төлөвшдөг нийгмийн үзэгдэл бөгөөд та бидний сайн мэдэх “хүчирхийлэл хүчирхийлэгчийг төрүүлдэг” гэх хэллэг уг санааг бүрэн илэрхийлдэг.

Хүчирхийлэгч зан авир нэгэнт төлөвшсөн бол түүнийг өдөөгч хүчин зүйлс яригддаг. Ярилцлагын явцад архи, согтууруулах ундааны хэрэглээ ГБХ үйлдэгдэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлийн нэг яах аргагүй мөн байсан. Нийт ГБХ-д өртсөн хохирогчдын бараг 80 хувь нь хүчирхийлэгч архидан согтуурсан үедээ дээрх үйлдлийг гаргадаг болохыг дурдсан. “Архи уусан үедээ л тэгдэг, эрүүлдээ бол гайгүй” гэх энэ үг хохирогчдын амны уншлагатай адил тааралдаж байлаа. **Гэвч архи согтууруулах ундаа хэрэглэх нь тухайн хүний хүчирхийлэгч зан авир**ыг өдөөж буй нэг хэрэгсэл боловч ГБХ-ийн суурь шалтгаан биш юм. АНУ-ын эрдэмтэн Абориген ба Торрес Стрэйт Айландер эмэгтэйчүүдийн хүчирхийллийн талаар гаргасан тайланд согтууруулах ундаа нь хүчирхийлэгчийн сөрөг зан авирыг нийгэмд хүлээн зөвшөөрөх, зөвтгөх шалтаг болж байгаа нь хүчирхийллийг өөшүүлж буй явдал болохыг тэмдэглэжээ. Өөрөөр хэлбэл, архи ууснаасаа болж гэр бүлийн хүнээ хүчирхийлдэг бус, архи зөвхөн тухайн хүний хүчирхийлэгч зан авирыг нь ил болгоход нөлөөлж буй хэрэглэгдэхүүн юм.

**2.Боловсролын чанар, хүртээмжийн хангалтгүй байдал.** Жендэрийн хэвшмэл ойлголт боловсролын түвшинтэй тодорхой хамааралтай. ҮСХ-ны Хүчирхийллийн нүцгэн үнэн судалгааны дүнгээр боловсролын түвшин нэмэгдэх тусам “*сайн эхнэр нөхөртэйгөө санал нийлэхгүй байсан ч үгийг нь дагадаг*” байх гэсэн хэвшмэл ойлголттой санал нийлэх нь багасаж байсан. Мөн боловсролын түвшин бага эмэгтэйчүүдийг боловсролын түвшин өндөр эмэгтэйчүүдтэй харьцуулбал бие махбодын хүчирхийллийн тохиолдлыг мэдээлэх нь илүү байна. Эдгээр үр дүн нь боловсролын түвшин нь жендэрийн хэвшмэл ойлголттой тодорхой хамааралтай байгааг харуулж байлаа.

---

<sup>13</sup> Бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байгаагүй дөрвөн эмэгтэй тутмын нэг нь буюу 22.2 хувь нь хэрэв эхнэр нь үнэнч бус байвал нөхөр нь цохиж, зодож болно гэж үзсэн байхад хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдийн 35.5 хувь нь үзэж байна.

Хэдийгээр манай улсын боловсролын түвшний индекс болон бусад ерөнхий үзүүлэлтээрээ<sup>14</sup> бусад ижил төстэй оронтой харьцуулахад эерэг үзүүлэлттэй хэдий ч боловсролын үйлчилгээ дэх тэгш бус байдал, хүртээмжгүй байдал нь олон хүний амьдралын чанарыг доройтуулах, эрсдэлтэй нөхцөлд оруулахад бүтцийн түвшиндээ нөлөөлж байна. Боловсролын тэгш бус байдлын талаар цогц судалгаа хийгдээгүй ч хүүхдүүдийн хэр сайн ерөнхий боловсрол эзэмших нь эцэг эхийн нийгмийн байдлаас хамаарч хүчтэй ялгаралд орж байгааг нийгмийн шинжлэх ухааны эрдэмтэд өөр өөрсдийн бүтээлдээ дурдсан байна<sup>15</sup>.

Хөвгүүд, тэр дундаа хөдөөгийн хөвгүүд гэр бүлийнхэндээ туслахын тулд сургуулиасаа эрт завсардах хандлага давамгайлж, харин охид илүү удаан суралцаж, өндөр боловсрол эзэмших хандлагатай болж байна. Гэвч залуу эмэгтэйчүүдийн (25-29 нас) 70 хувь нь дээд боловсрол эзэмшсэн ч энэ нь тэднийг хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцоход нөлөөлөхгүй байгаа үр дүн гарсан<sup>16</sup>. Өөрөөр хэлбэл, бага боловсролтой байх нь эдийн засгийн хувьд эмзэг байх нөхцөлийг бүрдүүлж байгаа хэдий ч дээд боловсрол эзэмшсэн байх нь эдийн засгийн хувьд сайжрах баталгаа болохгүй байна.

Эдгээр нөхцөл байдал нь манай улсын боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийн өнөөгийн дүр зураг бөгөөд боловсролын үйлчилгээ нь бүх нийтэд тэгш бус байх нь иргэдийн эмзэг байдлыг нэмэгдүүлэх, улмаар гэм хэрэг, хүчирхийллийн гаралтыг нэмэгдүүлэхэд бүтцийн түвшиндээ нөлөө үзүүлж байна.

**3.Ядуурал (ажилгүйдэл).** ГБХ-д өртсөн хүмүүсийн нийтлэг шинжийг харгалзвал амьжиргааны түвшин ГБХ үйлдэгдэхэд нөлөөлж буй нэг хүчин зүйл болж байна. ГБХ-д өртсөн 111 ХБХ бараг бүгд амьжиргааны хувьд доогуур түвшинтэй өрхийн гишүүн байсан.

Ядуурлын төлөв байдлыг илтгэх улсын хэмжээний тоо баримтуудыг авч үзвэл ҮСХ, Дэлхийн Банк хамтран гүйцэтгэсэн Өрхийн нийгэм, эдийн засгийн 2018 оны судалгааны дүнгээр Монгол Улсын хүн амын ядуурлын түвшин 2016 онд 29.6 хувь байсан бол 2018 онд 28.4 хувь болж, 1.2 пунктээр буурсан. Гэсэн хэдий ч энэ нь өндөр үзүүлэлт бөгөөд манай улсын нийт хүн амын 28,4 хувь нь өдөрт 1.9 ам.доллараас бага орлогоор амьдарч байна гэсэн үг. Үүнээс гадна ямар нэг эдийн засгийн цочрол үүсэхэд ядууралд өртөхөд ойрхон, эмзэг байдалтай хүн ам нийт хүн амын 15 хувийг эзэлж байгаа нь мөн өндөр үзүүлэлт юм.

**Хүснэгт 12. Монгол Улсын хүн амын ядуурлын түвшний судалгаа, ядуурлын хүрээ, хувиар**

	2014 он	2016 он	Өсөлт бууралт	2018 он	Өсөлт бууралт
Улсын дундаж	21.6	29.6	+8.0	28.4	-1.2
Хот	18.8	27.1	+8.3	27.2	0.1
Хөдөө	26.4	34.9	+8.5	30.8	-4.1

*Эх сурвалж: Дэлхийн банк, Үндэсний стасистикийн хорооны 2018 онд хийсэн Монгол улсын хүн амын ядуурлын түвшний судалгаа [www.worldbank.org](http://www.worldbank.org)*

14 2020 оны байдлаар манай улсын бичиг үсэг тайлагдалтын түвшин 98,7 хувь<sup>14</sup>, хүн ам боловсролын түвшингээр гурван хүн тутмын хоёр нь бүрэн дундаас дээш боловсролтой (**Error! Reference source not found.**), нэг хүний дунджаар суралцах хугацаа 15 жил

15 МУИС-ийн багш, Социологийн ухааны доктор Г. Түмэннаст, 2020 оны 08 сарын 30-ны өдрийн ikon.mn-д өгсөн ярилцлагаас: <https://ikon.mn/opinion/1z6m>

16 Ядуурлын дүр төрх, ҮСХ, Дэлхийн банк, 2019

Байршлаар харвал орон нутагт 2016-2018 оны хооронд ядуурал 4.1 пунктээр буурсан бол эсрэгээр Улаанбаатар хотод ядуурлын түвшин өөрчлөлтгүй байна. Өөрөөр хэлбэл, **хөдөөгийн ядуурал буурсан ч хотын ядуурал хэвээр байна**. Үүнд, нэг талдаа Улаанбаатар хотод хүн амын төвлөрөл тэр дундаа ядуу хүн амын эзлэх хувь өндөр байгаа нь нөлөөлөх ба нийт ядуу хүмүүсийн 63.5 хувь нь хот суурин газарт, түүний 41.8 хувь (378.2 мянган хүн) нь Улаанбаатар хотод амьдарч байна<sup>17</sup>. Үүнээс гадна хот суурин газарт ядуурал буурах үйл явц саарсан нь хот суурин газрын ядуу хүн амд эдийн засгийн өсөлт тэгш бус, хүртээмжгүй байгаатай хамааралтай байна<sup>18</sup>.

ҮСХ-ны тайланд дурдсанаар ядуурал бага насны хүүхдийн дунд зонхилж байгаа нь анхаарал татаж байв. Монголд ядуу таван хүн тутмын хоёр нь 15-аас доош насны хүүхэд байна. **Ядуурал өрх дэх хүүхдийн тоо, тэжээгчдийн хувьтай нягт хамааралтай байгаа нь үр хүүхдүүдээ тэтгэх хангалттай тооны хөдөлмөрийн насны хүмүүс дутагдалтайн тусгал болж байна**. Тэгвэл ядууралд өссөн хүүхдүүдийн хувьд боловсрол эзэмших боломж бага<sup>19</sup>, үүнийг дагаад хүрэлцээтэй цалин хөлстэй хөдөлмөр эрхлэх боломж буурах, улмаар амьжиргааны түвшин доройтсноос үүдэн гэр бүлийн зөрчил маргаан нэмэгдэх, ГБХ үйлдэгдэх эрсдэлийг нэмэгдүүлэхэд нөлөөлнө.

Энэ нь Америкийн эрдэмтэн Ruby K. Payne-ны тодорхойлсон ядуурлын тойргийн онолоор (cycle of poverty) тайлбарлагдах бөгөөд ядуу гэр бүлд өссөн хүүхэд ядуу амьдралын хэв маяг, нөхцөлд дасан зохицож, ядуу нөхцлөөс гарч чадахгүй гэдэг итгэл үнэмшил, хандлага бат төлөвшснөөр энэ нь үе дамжсан ядуурал буюу ядуурлын соёлыг төлөвшүүлэхэд нөлөөлдөг. Хэдийгээр манай улс зах зээлийн эдийн засагт шилжээд удаагүй, ядуурлын соёл төлөвшиж буй талаар хэлэхэд хугацааны хувьд эрт байж болох хэдий ч ядуурлын соёл нэгэнтээ ажиглагдаж эхэлсэн талаар судлаачид өөрсдийн бүтээлдээ<sup>20</sup> дурдсан байна.

**Дүрс 41. Ядуурлын тойрог, түүний үр дагавар ГБХ-д нөлөөлөх байдал**


---

17 <https://www.worldbank.org/mn/news/press-release/2019/06/21/mongolias-2018-poverty-rate-estimated-at-284-percent>

18 Ядуурлын дүр төрх 2018, ӨНЭЗС-ны дүн, ҮСХ, Дэлхийн банк

19 "Монгол Улсын боловсролын тогтолцоонд тэгш бус байдал газар авч байгааг олон судалгаа дурддаг ба хүүхдүүд хаана, ямар гэр бүлд өсч байгаагаас хамаарч боловсролын үлэмж ялгаатай орчинд суралцаж байна". Боловсролын тэгш бус байдал ардчиллын өөрийнх нь хувь заяатай холбоотой асуудал, МУИС-ийн багш, Социологийн ухааны доктор Г. Түмэннаст, 2020

20 Ibid.



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан зураглал

Дүрс 41-д нэгэнт бий болж буй ядуурлын тойрогт олон нийтийн болон бүтцийн түвшний хүчин зүйлүүд нөлөөлснөөр ядууралд амьдарч буй иргэдэд ядуурлаас гарах боломж улам багасах, улмаар амьдралын чанар олон талаараа (эдийн засаг, оюун санаа, ёс суртахуун...) доройтоход хүргэх нь ГБХ үйлдэгдэхэд хэрхэн нөлөөлөхийг харууллаа.

Ядуу тарчиг амьдралын нөхцөл байдлаас эхийн жирэмсэн үеийн эрүүл мэндийг хангалттай дэмжиж чадахгүй байх, хүүхдийн өсөж торних орчин эрсдэлтэй байх, аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар ойлголт мэдлэг бага байх, эцэг эхийн хараа хяналт сул байх зэргээс шалтгаалан гэр бүлийн гишүүд дунд хэн нэгэн нь төрөлхийн болон олдмол байдлаар хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэл нэмэгддэг. Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхөд хэн нэг гишүүн нь зайлшгүй асаргааны үүргийг гүйцэтгэдгээс өрхийн орлого бага байх, амьжиргааны хувьд улам муудах нөхцөл бүрдэнэ. Мөн олон хүүхэдтэй, ХБХ-тэй, ядуу гэр бүлд өссөн хүүхдүүдийн хувьд сайн, чанартай боловсрол эзэмших боломж хязгаарлагдмал. Чөтгөрийн тойрог гэж нэрлэгддэг энэ бүх асуудлаас нийгмийн ижилслийн зарчмаар ижил түвшний амьжиргаатай, ижил асуудал, бэрхшээлтэй хүнтэй гэр бүл болж уг тойргийг цааш үргэлжлүүлдэг. Эдгээр асуудлууд дээр олон нийтийн болон бусад тогтолцооны түвшний хүчин зүйлүүд нөлөөлснөөр эцсийн дүндээ ГБХ үйлдэгдэх буюу энэ төрлийн гэмт хэргийн эрсдэлийг нэмэгдүүлдэг байна.

**4.ГБХ-тэй тэмцэх тогтолцооны сул байдал.** Манай улсад ГБХ-тэй тэмцэх бүтэц, тогтолцоо нэгэнтээ бүрдсэн хэдий ч тогтолцооны үр дүнтэй байдал эцсийн дүндээ анхан шатны нэгж дээр ирж буй үйлчилгээ, хамгааллын нөхцөл байдлаар дүгнэгдэх учиртай. Гэвч судалгааны дүнгээр ГБХ-д өртсөн ХБХ-ий хувьд хамгааллын үйлчилгээ авсан байдал зөвхөн цагдаагийн байгууллагад дуудлага мэдээлэл өгсөн байдлаар хязгаарлагдаж байв. ГБХ-ээс урьдчилан сэргийлэх тогтолцоонд ХБХ-ий онцлог тусгай хэрэгцээг харгалзсан зохицуулалт тодорхойгүй орхигдсон байгаа нь ХБХ ГБХ-д өртсөн тохиолдолд төрийн зохих хамгаалалтыг авахад хүндрэл учруулж байна. Тухайлбал, сонсголын бэрхшээлтэй хүн ГБХ-д өртсөн тохиолдолд цагдаагийн байгууллагад хэрхэн дуудлага өгөх, дуудлага бүртгэгдсэн тохиолдолд хэргийн байцаалт, хянаж шалгах, шийдвэрлэх, хамгаалах үйл ажиллагаанд ХБХ-ий бэрхшээлийн онцлог, тусгай хэрэгцээг хэрхэн харгалзах талаар заалт, зохицуулалт орхигдсон байгаа нь ГБХ-тэй тэмцэх тогтолцоо хүн бүрд хүрч үйлчилж чадахгүй байгааг харуулж байлаа.

Хууль эрх зүйн хүрээнд ХБХ-ийн онцлог, тусгай хэрэгцээг тусгаагүй нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын ХБХ-ийг хүлээн авах дэд бүтэц, техник хэрэгслээс авахуулан үйлчилгээ үзүүлж буй албан хаагчдын ХБХ-ий онцлог, тусгай хэрэгцээний талаарх мэдлэг, ойлголтгүй байдлаас харагдаж байв. ГБХ-тэй тэмцэх тогтолцооны бүх шатны үйлчилгээнд ХБХ-ий онцлог, тусгай хэрэгцээг харгалзсан зохицуулалт оруулах нь үйлчилгээний хүртээмж болон чанарт шийдвэрлэх нөлөөтэй байна.

ГБХ-тэй тэмцэх тогтолцооны нөхцөл байдлыг тайлангийн 2-р бүлэгт дэлгэрэнгүй авч үзлээ.

### 1.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ГБХ-ийн талаарх ойлголт, тусламж дэмжлэг эрэлхийлэх зан үйл

ГБХ-ийн талаар ойлголт мэдлэгтэй байх нь эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тусламж дэмжлэг эрэлхийлэх зан үйлийн суурь нөхцөл. Нийгмийн эрүүл мэндийн салбарт хүний аливаа зан үйлийг өөрчлөхөд баримталдаг суурь онол нь мэдлэг, хандлага, дадлын загвар юм. Тус загварын үзэл санаагаар, хүн аливаа хүчирхийлэлтэй харилцаанаас өөрийгөө хамгаалах зан үйлтэй байхын суурь нь тухайн асуудлаар мэдлэг, ойлголттой байх явдал гэж үздэг. Иймд тус судалгаанд оролцогчдын ГБХ-д өртсөн үедээ тусламж дэмжлэг эрэлхийлэх зан үйлийг тодорхойлохын тулд эхний ээлжид ХБХ-ий ГБХ-ийн талаар ойлголт мэдлэгийг авч үзлээ.

#### 1.3.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ГБХ-ийн талаарх ойлголт, мэдлэг

- ❖ *Үр дүн 1: Хянах зан үйл, эдийн засгийн болон бэлгийн хүчирхийллийн талаарх ХБХ-ий ойлголт, мэдлэг хамгийн бага байна.*
- ❖ *Үр дүн 2: Бэрхшээлийн төрлөөр харвал, харааны бэрхшээлтэй хүмүүс бусад ХБХ-ээс ойлголт мэдлэг нь өндөр, сонсголын бэрхшээлтэй иргэдийн ойлголт мэдлэг хамгийн бага байна.*
- ❖ *Үр дүн 3: ГБХ-ээс урьдчилан сэргийлэх мэдээллийг ХБХ-д хүргэх арга замууд бэрхшээлийн төрлөөс хамааран ялгаатай байх хэдий ч ихэнх оролцогчдын хувьд энэ талаарх мэдээллийг биечлэн уулзаж авах хувилбаруудыг илүүд үзэж байлаа.*

ХБХ-ий ГБХ-ийн талаарх ойлголт, мэдлэгийг тодруулахдаа хүчирхийллийн 5 төрөл тус бүрийн илрэх үйлдлүүдийг оролцогчид санал болгож эдгээр үйлдлүүд ГБХ-ийн хэлбэр мөн эсэхийг өөрсдийнх нь байр сууринаас тодруулсан. Ингэхэд ГБХ-ийн талаар бүрэн дүүрэн тайлбар өгсөн, ойлголттой оролцогч нийт судалгаанд оролцогчдын дөнгөж 12.7 хувь (n=19)-ийг эзэлж байв. Харин дурдсан хүчирхийллийн хэлбэрүүдийн талаар огт ойлголтгүй буюу аль ч үйлдлийг ГБХ гэж үзэхгүй байсан нь нийт оролцогчдын 43 хувь (n=65) байна. Үлдсэн оролцогчдын хувьд хүчирхийллийн төрлөөс хамаараад ялгаатай хариултыг өгчээ.

ГБХ-ийн талаар ойлголт, мэдлэгтэй байдлыг судалгаанд оролцогчдын нас, хүйс, байршлаар харвал (Хүснэгт 143):

- Хүйсээр харьцуулж үзвэл, ГБХ-ийн талаар огт ойлголтгүй буюу буруу ойлголттой ХБХ-ий дийлэнх нь (73.8%) эмэгтэйчүүд;
- Насны бүлгээр харьцуулж үзвэл, ГБХ-ийн талаар ойлголтгүй хүмүүсийн дунд насны ялгаа бага бол, ойлголт сайтай хүмүүсийн дийлэнх нь 41-50 насны ХБХ;
- Байршлаар харьцуулж үзвэл, ГБХ-ийн талаар ойлголт мэдлэггүй хүмүүсийн хувьд байршлаас хамаарсан ялгаа бага бол, ГБХ-ийн талаар бүрэн ойлголттой оролцогч орон нутгаас, ялангуяа Сэлэнгэ аймгийн ХБХ-ий хувьд илүү мэдээлэл сайтай байна.

**Хүснэгт 13. ХБХ-ий ГБХ-ийн талаар ойлголт, мэдлэг (n=150)**

Үндсэн үзүүлэлтүүд	ГБХ-ийн талаар бүрэн ойлголттой ХБХ	ГБХ-ийн зарим хэлбэрийн талаар ойлголттой ХБХ	ГБХ-ийн талаар огт ойлголтгүй буюу буруу ойлголттой ХБХ	Нийт
ХБХ-ий тоо	19	66	65	150
<b>Хүйсээр</b>				
Эрэгтэй	31.6%	47.0%	26.2%	36.0%
Эмэгтэй	68.4%	53.0%	73.8%	64.0%
<b>Насаар</b>				
18-30	5.3%	25.4%	31.7%	25.4%
31-40	26.3%	27%	33.3%	29.6%
41-50	57.9%	30.2%	28.3%	33.1%
50+	10.5%	17.5%	6.7%	12%
<b>Байршлаар</b>				
Улаанбаатар, Налайх	5.3%	13.6%	20.0%	15.3%
Улаанбаатар, СХД	15.8%	28.8%	21.5%	24.0%
Увс аймаг	15.8%	27.3%	15.4%	20.7%
Сэлэнгэ аймаг	42.1%	19.7%	16.9%	21.3%
Сүхбаатар аймаг	21.1%	10.6%	26.2%	18.7%

Хүчирхийллийн төрлөөр нь ойлголт, мэдээлэлтэй байдлыг авч үзвэл сэтгэл санаа болон бие махбодын хүчирхийллийн талаар ХБХ-ий ойлголт харьцангуй сайн. Харин хянах зан үйл, эдийн засгийн болон бэлгийн хүчирхийллийн талаар ойлголт, мэдлэг хамгийн бага байна. Энэ байдал нийт хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүн тутмын нэгд нь илэрч байсан. Нийтлэг тохиолдолд зодож цохиогүй л бол бусад нь хүчирхийлэл биш гэх тайлбар давамгайлж байлаа.


Мөн ГБХ-ийг архи, согтууруулах ундааны хэрэглээтэй холбож тайлбарлах хүн олон байсан бөгөөд архи уусан үедээ гэр бүлийнхнээ зовоох үйлдэл нь ГБХ мөн бол эрүүл үедээ энэ төрлийн үйлдлийг гаргаж байгаа нь тодорхой шалтгаантай, магадгүй “би өөрөө буруу үйлдэл хийсэн учраас”, “намайг бодсондоо ийм үйлдэл хийдэг байх” гэсэн тайлбарыг ХБХ өгч байсан нь анхаарал татаж байлаа. Хүчирхийллийн төрлөөр нийт оролцогчдын ойлголт мэдлэгтэй байдлыг авч үзвэл:

- 60 хувь нь (n=90) сэтгэл санааны хүчирхийллийн талаар ойлголттой буюу өгөгдсөн хэлбэрүүдийг бүгдийг нь хүчирхийлэл болохыг хүлээн зөвшөөрсөн
- 60 хувь нь (n=90) бие махбодын хүчирхийллийн талаар ойлголттой
- 48 хувь (n=72) нь бэлгийн хүчирхийллийн талаар ойлголттой
- 44 хувь (n=66) нь эдийн засгийн хүчирхийллийн талаар ойлголттой
- 42 хувь (n=63) нь хянах зан үйлийн хүчирхийллийн талаар ойлголттой

Бусад ХБХ-ий хувьд өгөгдсөн ГБХ-ийн хэлбэрүүдийг хүчирхийлэл болохыг хүлээн зөвшөөрөөгүй эсвэл энэ талаар огт мэдээлэлгүй буюу хариулж мэдэхгүй гэдэг хариулт өгсөн байна. Бэрхшээл тус бүрээр ГБХ-ийн төрлүүд, тэдгээрийн илрэх хэлбэрүүдэд өгсөн хариултыг задаргааг Хавсралт 1-ээс үзнэ үү.

ХБХ-ий ГБХ-ийн төрлүүдийн талаар ойлголт, мэдээлэлтэй байдлыг бэрхшээлийн төрлөөр дараах дүрсэд харууллаа.

**Дүрс 42. ГБХ-ийн талаар ойлголт мэдээлэлтэй ХБХ-ий хувь, бэрхшээлийн төрлөөр, %**



Бэрхшээлийн төрлөөр нь харьцуулж харвал бүх хэлбэрийн хүчирхийллийн талаар харааны бэрхшээлтэй хүмүүс бусад ХБХ-ээс ойлголт мэдлэг нь өндөр, сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн ойлголт мэдлэг хамгийн бага байна.

ГБХ-тэй холбоотой мэдээллийг ямар эх сурвалжаас авсныг тодруулахад дараах гурван хариулт хамгийн нийтлэг дурдагдсан. Үүнд: (1) телевиз, (2) сошиал медиа, (3), ижил бэрхшээлтэй хүмүүс. Цаашид мэдээллийг ямар сувгаар дамжуулж хүргэвэл илүү тохиромжтой байгааг тодруулахад бэрхшээлийн төрлөөс хамааран ялгаатай хариулууд дурдаж байсан хэдий ч ихэнх оролцогчдын хувьд энэ талаар мэдээллийг биечлэн уулзаж авах хувилбарыг илүүд үзэж байлаа.

Тус бүлгийн үр дүнг нэгтгэвэл, ХБХ өөрийгөө хүчирхийлэлд өртөж байгаагаа мэдэхгүй байх нь нийтлэг, мэдсэн ч өөрөө ажил хөдөлмөр эрхлээд бие даан амьдрах боломжгүй учраас одоогийн нөхцөлдөө зохицож амьдрахаас өөр сонголтгүй гэсэн хандлагатай байна. Хүчирхийлэлд өртөж, тусламж дэмжлэг авахаас илүү “миний л хувь тавилан” эсвэл “амьдрал ийм л байдаг” гэсэн хүлцэнгүй хандлага маш түгээмэл байлаа.

Хүчирхийлэл гэх ойлголтыг тайлбарлан асуухад би яг хүчирхийлэлд өртөж байгаагүй гэж хариулж байсан хэдий ч хүчирхийллийн илрэх хэлбэрүүдийг нэг бүрчлэн асуух үед хүчирхийллийн шинжтэй үйлдлүүд өөрт нь тохиолдож байсныг ярьж байсан.

Мөн ХБХ-ий нийгмийн харилцааны гол эх сурвалж нь тухайн бэрхшээл бүрээр дагнасан ТББ болон холбоод байна. Эдгээр байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ижил бэрхшээлийн хүмүүстэй танилцах, асуудлаа хуваалцах, мэдээлэл авах зэргээр нийгмийн харилцаанд ордог байна. Иймд ХБХ-д мэдээлэл түгээх, хүргэх үйл ажиллагааны нэг гол эх сурвалж нь тухайн бэрхшээлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбоод, ТББ-аар дамжуулах нь үр дүнтэй болох нь харагдсан. Иймд ижил бэрхшээлтэй хүмүүсийг сургагч багшаар бэлтгэх нь тухайн бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл хүргэх нэг үр дүнтэй арга байж болохоор байна.

Хөгжлийн бэрхшээлийн төрөл хэлбэрээс хамааран мэдээлэл авах боломж харилцан адилгүй тул бэрхшээлийн төрөл хэлбэр тус бүрээр ГБХ-ийн талаар ойлголт мэдээлэлтэй байдлыг дор дэлгэрэнгүй авч үзлээ:

**1.Харааны бэрхшээлтэй хүн.** Судалгаанд хамрагдсан 27 харааны бэрхшээлтэй хүний 30 хувь (n=7) нь ГБХ-ийн талаар огт ойлголтгүй<sup>21</sup>, 22 хувь (n=6) нь бүрэн ойлголттой<sup>22</sup>, үлдсэн хүмүүсийн хувьд ойлголт нь хүчирхийллийн хэлбэрээс хамаараад харилцан адилгүй байв. Хүчирхийллийн хэлбэрээр авч үзвэл, хянах зан үйлийн болон эдийн засгийн хүчирхийллийн хэлбэрүүдийн талаар мэдээлэлгүй эсвэл тэдгээр үйлдлүүдийг ГБХ болохтой санал нийлэхгүй байв. Ялангуяа, хянах зан үйлийн хүчирхийллээс (1) өөр эсрэг хүйсийн хүнтэй харилцахад хамтрагч нь уурлаж, дургүйцэх, (2) эмнэлгийн тусламж үйлчилгээ авахдаа өөрт нь мэдэгдэх, зөвшөөрөл авахыг шаардах зэрэг үйлдлийг ГБХ гэж үзэхгүй, эдгээр үйлдэл бол гэр бүлийн харилцаанд байж болох үйлдэл гэж тайлбарласан байна. Мөн эдийн засгийн хүчирхийллийн талаар ойлголт бага байсан, үүнээс ажил хийхийг зөвшөөрөхгүй байх, өөрийн гэсэн мөнгөтэй байхыг зөвшөөрөхгүй байх үйлдлийг ГБХ гэж үзэхгүй байна.

Дүрс 43. Харааны бэрхшээлтэй хүмүүсийн ГБХ-ийн хэлбэрүүдийн талаар ойлголт, % (n=27)




Харааны бэрхшээлтэй хүмүүсээс ГБХ-ийн талаар мэдээллийг ихэвчлэн ямар эх сурвалжаас авч байгааг тодруулахад зурагт, социал медиа (facebook), орчин тойрны хүмүүсээс, болон сургалтаас гэсэн хариултауд дурдагдсан. Цаашид ГБХ-ээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах талаар мэдээллийг ямар эх сурвалжаар дамжуулж хүргэвэл хамгийн хүртээмжтэй байгааг тодруулахад биечлэн уулзаж мэдээлэл өгөх (55.6%), болон телевизийн сувгаар (40.7%) дамжуулах нь харааны бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл хүргэхэд хамгийн хүртээмжтэй гэж хариулжээ.

**2.Сонсголын бэрхшээлтэй хүн.** Судалгаанд хамрагдсан сонсголын бэрхшээлтэй 25 хүний 60 хувь (n=15) нь ГБХ-ийн талаар огт ойлголт байхгүй, 12 хувь (n=3) нь бүрэн ойлголттой бол үлдсэн хүмүүсийн хувьд бэрхшээлийн хэлбэрээс хамаараад харилцан адилгүй ойлголттой байна. Хүчирхийллийн хэлбэрүүдээс эдийн засгийн болон бэлгийн хүчирхийллийн талаар, ялангуяа эдийн засгийн хүчирхийллийн талаар ойлголт хамгийн бага байна. Илрэх хэлбэрүүдийг авч үзвэл дээрх хоёр хүчирхийллийн хэлбэрийг ГБХ мөн эсэхтэй сонсголын бэрхшээлтэй оролцогчдын 2 хүн тутмын нэг нь санал нийлэхгүй байсан. Энэ нь илэрч болох бүх үйлдэл дээр ижилхэн үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Дүрс 44. Сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн ГБХ-ийн хэлбэрүүдийн талаар ойлголт, % (n=25)

21 Өгөгдсөн хүчирхийллийн 5 хэлбэрийн алийг нь ГБХ гэж үзэхгүй эсвэл мэдэхгүй гэж хариулсан

22 Өгөгдсөн хүчирхийллийн 5 хэлбэрийг бүгдийг нь ГБХ мөн гэж хариулсан



Нийт сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай харилцдаг, мэдээлэл авдаг аргыг тодруулахад 48 хувь нь дохионы хэлээр, 32 хувь нь дохио зангаа, бичиг аль алийг нь ашигладаг бол 20 хувь нь зөвхөн бичгээр (дохионы хэл мэдэхгүй) дамжуулж харилцдаг гэж хариулсан. Дохионы хэлээр харилцдаг оролцогчдын хувьд дохионы хэл нь амьдарч буй байршил, нутаг бүрээс хамаараад ялгаатай байсныг дурдах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, манай улсад дохионы хэлний нэгдсэн стандарт боловсруулагдаагүйгээс нэг үгийг орон нутаг бүр бага зэргийн ялгаатай дохиодог байдал ажиглагдсан (Оролцогчдын хэлж буйгаар гудамжны дохио гэх). Ингэснээр тухайн хүн зөвхөн гэр бүл эсвэл орон нутгийн хэмжээнд л хүмүүстэй харилцаж ойлголцдог байх хязгаарлагдмал талууд үүссэн байв. Дохионы хэлний нэгдсэн стандарт байхгүй, үүнээс гадна дохионы хэлний боловсрол олгох үйл ажиллагаа хүртээмжгүй байгаа нь шууд утгаараа эдгээр иргэдийн мэдээлэл авах эрхэд нөлөөлж байгаа нь харагдаж байлаа.

ГБХ-тэй холбоотой мэдээллийг дийлэнх оролцогчид зурагт, сошиал медиа, сонин сэтгүүл, ижил бэрхшээлтэй хүмүүсээс болон цөөн тохиолдолд сургалтаас авсан гэж хариулсан. Гэвч зурагтаас мэдээлэл авахад дэлгэцийн доор байрлах дохионы хэлмэрчийн дүрс хэт жижиг хэмжээтэйгээс гарын хөдөлгөөнийг харж чадахгүй байх, мөн хэт хурдан явж өнгөрдөг болохыг бүх оролцогчид дурдсан. Мөн зарим сонсголын бэрхшээлтэй хүмүүс текст бичвэрийг уншиж мэдээлэл авдаг хэдий ч зөвхөн том хэмжээтэй, үгийн тоо цөөн байвал илүү уншихад хүртээмжтэй болохыг оролцогчид дурджээ.

**Шигтгээ 60. Налайх дүүрэг, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй, 38 настай, эмэгтэй**

Хөнгөн амархан бичгээр л харилцдаг. Байнга цаас, балтай явдаг.


Сонсголгүй найзууд, орчуулагчаар дамжуулан мэдээлэл авдаг. Телевизүүдээр гардаг жижиг бөөрөнхий хардаг гэхдээ хэлмэрч нь харагддаггүй, маш жижиг. Бусад хүмүүс сонсоод ойлгоно харин сонсголын бэрхшээлтэй хүн заавал нүдээр мэдээлэл авдаг. Мэдээллийн хүртээмж муу байдаг. Covid-19-тэй холбоотой 11 цагийн мэдээний дохионы хэлмэрч яг хажууд нь биеэрээ харуулж байсан нь их ойлгомжтой байсан.

**3.Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүн.** Судалгаанд хамрагдсан тулгуур эрхтний бэрхшээлтэй 35 хүний 51 хувь (n=18) нь ГБХ-ийн талаар огт ойлголтгүй, 11.4 хувь (n=4) бүрэн ойлголттой бол үлдсэн хүмүүс нь хүчирхийллийн хэлбэрээс хамаараад ойлголт нь харилцан адилгүй байв.

Хүчирхийллийн хэлбэрээр авч үзвэл, тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн хувьд хянах зан үйлийн хүчирхийллийн талаар ойлголт хамгийн бага, 2 хүн тутмын нэг нь л эдгээр үйлдэл нь ГБХ болохыг хүлээн зөвшөөрч байсан. Хянах зан үйлийн хүчирхийллийн илрэх хэлбэрүүдээс эмнэлгийн тусламж авахаасаа өмнө мэдэгдэх, зөвшөөрөл авахыг шаардах нь хүчирхийлэл биш гэж 3 хүн тутмын хоёр нь хариулсан байна.

Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн ойлголт бага байгаа хүчирхийллийн хэлбэрийн хоёрдугаарт нь эдийн засгийн хүчирхийлэл орсон. Эдийн засгийн хүчирхийллийн илрэх хэлбэрээс гэр бүлийн гишүүн ажил хийхийг зөвшөөрөхгүй байх, өөрийн гэсэн мөнгөтэй байхыг зөвшөөрөхгүй байх нь хүчирхийлэл биш гэж хариулсан байна. Оролцогчдын тайлбарыг үзвэл зодож, гар хүрээгүй л бол эдгээр үйлдэл нь хүчирхийлэл биш гэж тайлбарлах ба дурдсан дээрх үйлдэл нь намайг бодсондоо хийсэн үйлдэл гэх хүчирхийллийг зөвтгөх хандлагатай ажиглагдаж байв.


Дүрс 45. Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн ГБХ-ийн хэлбэрүүдийн талаар ойлголт, % (n=35)



Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн мэдээлэл авч буй эх сурвалжийг тодруулбал зурагт, социал медиа (facebook), сонин, сэтгүүл болон ойрын хүрээллийн хүмүүсээс болон цөөн тохиолдолд сургалтаас авсан гэж хариулсан. Цаашид тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл хүргэхэд хамгийн хүртээмжтэй аргуудад (1) биечлэн уулзаж мэдээлэл өгөх, (2) социал медиа, (3) телевиз нэрлэгджээ.

**4.Сэтгэц, оюуны бэрхшээлтэй хүн.** Судалгаанд хамрагдсан 34 оролцогчоос 41.2 хувь (n=14) нь ГБХ-ийн талаар огт ойлголтгүй, 11.8 хувь (n=4) нь бүрэн ойлголттой, үлдсэн хүмүүс нь бэрхшээлийн хэлбэрээс хамаараад харилцан адилгүй ойлголттой байв. Хүчирхийллийн хэлбэрээр авч үзвэл, **хянах зан үйл, эдийн засаг, бэлгийн хүчирхийллийн талаар ойлголт хамгийн бага** байна (Дүрс 46). Тэдгээрийн илрэх хэлбэрүүдээр нь авч үзвэл ойлголтынх нь хооронд ялгаа бага ажиглагдсан. Өөрөөр хэлбэл, дээрх хүчирхийллийн хэлбэрүүдийн илэрч болох бүх үйлдлийн талаар оюун, сэтгэцийн бэрхшээлтэй оролцогчид нийтлэг ойлголт бага байна. Ийм оролцогч нийт оюун, сэтгэцийн бэрхшээлтэй оролцогчдын хоёр хүн тутмын нэгийг бүрдүүлж байв.

Дүрс 46. Оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн ГБХ-ийн хэлбэрүүдийн талаар ойлголт, % (n=34)



Дээрх бүлгийн хүмүүс ГБХ-ийн талаарх мэдээллийг зурагтаас, социал медиа (facebook), болон танилууд, найз нөхдөөсөө авдаг гэж хариулсан. Цаашид мэдээллийг ямар эх сурвалжаар дамжуулж хүргэвэл илүү тохиромжтой болохыг тодруулахад (1) биечлэн уулзаж мэдээлэл өгөх арга, (2) зурагтаар дамжуулах нь хамгийн үр дүнтэй гэж хариулжээ.

**5. Бусад төрлийн бэрхшээлтэй хүн.** Судалгаанд бусад төрлийн бэрхшээлтэй 29 хүн хамрагдсаны 38 хувь (n=11) ГБХ-ийн талаар огт ойлголт мэдлэггүй, 7 хувь (n=2) бүрэн ойлголттой бол үлдсэн хүмүүс нь хүчирхийллийн төрөл хэлбэрээс хамаараад ойлголт нь харилцан адилгүй байв. Хүчирхийллийн хэлбэрээр авч үзвэл сэтгэл санаа, бие махбодын хүчирхийллийн талаар оролцогчид тодорхой ойлголттой байгаа бол хянах зан үйл, эдийн засаг болон бэлгийн хүчирхийллийн талаарх ойлголтууд нь харилцан адилгүй, хоёр хүн тутмын нэг нь эдгээр хэлбэрийг ГБХ-д тооцохгүй байна (Дүрс 47).

Хянах зан үйлийн хүчирхийллийн илрэх хэлбэрүүдээс эмнэлгийн тусламж үйлчилгээ авахдаа өөрт нь мэдэгдэхийг шаардах, зөвшөөрөл авахыг шаардах үйлдлийг хамгийн олон хүн ГБХ-д тооцоогүй. Тайлбар нь бусад ХБХ-тэй ижил, ийм шаардлага тавих нь намайг бодсондоо хэлж байгаа зүйл учраас зөв гэж хариулжээ. Эдийн засгийн хүчирхийллийн хувьд гэр бүлийн гишүүний зүгээс миний мөнгөний зарцуулалтад хяналт тавих нь байж болох үйлдэл гэж мөн хоёр хүн тутмын нэг нь хариулсан. Бэлгийн хүчирхийллийн хувьд 35 хувь нь түүний илрэх хэлбэрүүдийг гэр бүлийн хэн нэгэн үйлдэж байгаа бол хүчирхийлэл гэж үзэхгүй байв.

Дүрс 47. Бусад төрлийн бэрхшээлтэй хүмүүсийн ГБХ-ийн хэлбэрүүдийн талаар ойлголт, % (n=29)



### 1.3.2. ГБХ-д өртсөн ХБХ-ий тусламж, дэмжлэг эрэлхийлэх зан үйл

- ❖ **Үр дүн 1:** Судалгаанд оролцогчдын 70 хувь нь ГБХ-д өртвөл холбогдох төрийн байгууллагад хандахаа илэрхийлсэн хэдий ч тэдгээрийн ойролцоогоор 40 хувь нь тусламж дэмжлэг эрэлхийлэх тодорхой зан үйлтэй байна. Төрийн байгууллагад хандах зан үйл илэрч буй дээрх оролцогчдыг ГБХ-ийн талаар тодорхой мэдлэг, ойлголттой хүмүүс бүрдүүлж байгаагаас үзвэл ГБХ-ийн талаар мэдлэг, ойлголттой байх нь тусламж дэмжлэг эрэлхийлэх зан үйлд нөлөөлж байна.
- ❖ **Үр дүн 2:** Бэрхшээлийн төрлөөр авч үзвэл, хараа, сонсгол, тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүс ГБХ-д өртсөн тохиолдолд холбогдох байгууллагад мэдэгдэж тусламж дэмжлэг авахыг чухалчилж байгаа бол оюун, сэтгэц, бусад төрлийн бэрхшээлтэй хүмүүсийн тусламж дэмжлэг эрэлхийлэх зан үйл хамгийн сул байна.

ГБХ-д өртсөн нийт ХБХ-ий холбогдох төрийн байгууллагад хандаж тусламж дэмжлэг авч байсан эсэх, энэ чиглэлээр тодорхой үйлдэл хийсэн байдлыг авч үзвэл нийт ГБХ-д өртсөн ХБХ-ий 40% (n=45) нь харьяа орон нутгийн цагдаагийн байгууллагад хандаж, дуудлага мэдээлэл өгсөн байна. Тэдгээр хүмүүсийн 85% нь мэдээллийн дагуу хариу арга хэмжээ авсан гэж хариулсан бол үлдсэн хүмүүсийн хувьд ямар нэгэн тусламж дэмжлэг авч чадаагүй. Тусламж авч чадаагүй шалтгааныг тодруулбал, олон дахин хандсаар цагдаа авч хэлэлцэхээ больсон, эсвэл хүчирхийлэгч нь орон нутгийн цагдаа нарыг таньдаг тул онцгойлон хариу арга хэмжээ аваагүй талаар дурджээ.

ГБХ-д өртсөн үедээ цагдаагийн байгууллагад хандаж тусламж дэмжлэг авч байсан нийт ХБХ-ий мэдээллийг нас, хүйс, байршлаар задалж үзвэл (Хүснэгт 14):

- Бэрхшээлийн төрлөөр харьцуулбал, сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн цагдаагийн байгууллагад хандсан байдал бусад ХБХ-тэй харьцуулахад хамгийн бага.
- Хүйсээр харьцуулж үзвэл, цагдаагийн байгууллагад хандсан ХБХ-ий 93.3% нь эмэгтэйчүүд
- Насны бүлгээр харьцуулж үзвэл, 31-40 насныхны тусламж дэмжлэг эрэлхийлэх зан үйл бусад насны хүмүүсээс хамгийн өндөр.
- Байршлаар харьцуулж үзвэл, хот, хөдөөгөөс хамаарсан ялгаа бага байна. Мэдээлэл цуглуулалт явагдсан орон нутгуудаас Сэлэнгэ аймаг болон Нийслэлийн СХД-ийн оролцогчдын хувьд цагдаагийн байгууллагад хандсан байдал бусад орон нутгаас өндөр байна.


Хүснэгт 14. ГБХ-д өртсөн ХБХ-ий цагдаагийн дуудлага мэдээлэл өгсөн байдал

Үндсэн үзүүлэлтүүд	Хараа	Сонсгол, хэл яриа	Тулгуур эрхтэн	Оюун, сэтгэц	Бусад (N=21)	Нийт
ГБХ-д өртсөн ХБХ-ий тоо	15	20	33	22	21	111
Цагдаад хандсан ХБХ-ий хувь	9%	5%	8%	9%	9%	40%
<b>Цагдаагийн байгууллагад хандаад тусламж авсан байдал (n=45)</b>						
Тийм	17.7%	13.3%	17.7%	22.2%	17.7%	84.5%
Үгүй	4.4%	-	2.2%	-	4.4%	15.5%
<b>Хүйс (n=45)</b>						
Эрэгтэй	2.2%	-	-	2.2%	2.2%	6.7%
Эмэгтэй	20%	13.3%	20%	20%	20%	93.3%
<b>Нас (n=45)</b>						
18-30	11.1%	-	4.4%	3%	4.4%	27.2%
31-40	6.6%	6.6%	11.1%	11.1%	6.6%	42%
41-50	4.4%	4.4%	4.4%	4.4%	8.8%	26.4%
50+	-	2.2%	-	-	2.2%	4.4%
<b>Байршил (n=45)</b>						
Улаанбаатар, Налайх	20%	16.7%	11.1%		20%	13.3%
Улаанбаатар, СХД	30%	33.3%	44.5%	10%	20%	26.7%

Увс аймаг		16.7%	22.2%	20%	10%	13.3%
Сэлэнгэ аймаг	40%	33.3%	22.2%	70%	40%	42.2%
Сүхбаатар аймаг	10%				10%	4.5%

Оролцогчдын цаашдын зан үйлийг тандах зорилгоор хэрвээ ГБХ-д өртвөл/ ахин өртвөл хэн нэгэн, эсвэл ямар нэгэн байгууллагаас тусламж дэмжлэг хүсэж хандах эсэх, хандах бол хамгийн түрүүнд хэнд итгэж хандахыг тодруулахад нийт оролцогчдын 91 хувь (n=137) нь хэрвээ ГБХ-д өртвөл хэн нэгэнд мэдэгдэнэ гэж хариулсан. Итгэж хандах талуудыг тодруулбал, давхардсан тоогоор<sup>23</sup>, нийт ХБХ-ий 71 хувь нь холбогдох төрийн байгууллагыг (цагдаа, орон нутгийн захиргаа, эмнэлэг, түр хамгаалах байр зэрэг) сонгосон бол 62% нь эцэг эх, ойрын хамаатан садны хүмүүс, найз нөхдөө, 3.3% нь үйлчилгээ үзүүлэгч ТББ-ыг сонгосон байна. Эдгээрээс хамгийн олон хүн буюу 46.7% нь цагдаагийн байгууллагад хандана гэж хариулжээ (Дүрс 48).

Дүрс 48. ГБХ-д өртвөл хамгийн эхэнд хандах тал, (n=150)



ХБХ-ий дунд хамгаалах байр болон НЦҮТ-ийн талаар ойлголт мэдээлэл маш бага байсан. Талбарын мэдээлэл цуглуулалтын үеэр судалгааны баг давхар улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг хамгаалах байр, НЦҮТ-ийн үйлчилгээ болон тэдгээрийн холбоо барих мэдээллийг оролцогчдод өгсөн бөгөөд бараг бүх оролцогчид (n=147) эдгээр төвүүдийн талаар мэдээлэлгүйгээ илэрхийлж байсан. Судалгаанд оролцогчдын хариултыг харвал, оролцогчдын зөвхөн 5 хувь нь (n=3) л ГБХ-д өртвөл хамгаалах байранд хандана гэж хариулжээ.

ХБХ-ий ГБХ-ийн талаарх ойлголт мэдээлэлтэй байдлаас тусламж, дэмжлэг эрэлхийлэх зан үйл хамаарч буй эсэхийг шалгах зорилгоор ГБХ-ийн талаар огт ойлголтгүй<sup>24</sup> болон бүрэн ойлголттой<sup>25</sup> ХБХ-ийг харьцуулж үзэхэд мэдээлэлтэй байх нь тусламж дэмжлэг эрэлхийлэх зан үйлд нөлөөтэй байгаа нь харагдсан. Өөрөөр хэлбэл, ГБХ ба түүний илрэх хэлбэрүүдийн талаар ойлголт мэдээлэлтэй хүмүүсийн хувьд хууль сахиулах байгууллагад хандаж тусламж авахыг илүүд үзэж байгаа бол эсрэгээр хангалттай ойлголтгүй хүмүүс ихэвчлэн эцэг эх, гэр бүл, ах дүү хамаатан садан зэрэг ойрын хүрээллийн хүмүүстээ хандахыг илүүд үзэж байна (Хүснэгт 15).

Хүснэгт 15. ГБХ-д өртсөн үедээ хандах талууд, ГБХ-ийн талаар ойлголттой эсэхээр (n=150)

<sup>23</sup> Нэг хүн олон хариултыг сонгосон гэсэн үг.

<sup>24</sup> 5 төрлийн ГБХ-ийн алийг нь ч хүчирхийлэл гэж үзэхгүй байгаа эсвэл мэдэхгүй гэж хариулсан бүлэг

<sup>25</sup> 5 төрлийн ГБХ-ийн хэлбэрүүдийг бүгдийг нь хүчирхийлэл мөн гэж хариулсан бүлэг

Хандах талууд	ГБХ-ийн талаар огт ойлголтгүй ХБХ	ГБХ-ийн талаар бүрэн ойлголттой ХБХ
Найз нөхөд	9.2%	0
Төрсөн ах, эгч, дүү	21.5%	10.5%
Өөрийн эцэг эх	18.5%	15.8%
Хамаатан садан	7.7%	10.5%
Эмнэлэг	7.7%	5.3%
<b>Цагдаа</b>	<b>41.5%</b>	<b>68.4%</b>
Сум, хорооны захиргаа	9.2%	15.8%
ТББ	3.1%	5.3%
Хамгаалах байр	6.2%	5.3%
НЦҮТ	0	0


ХБХ-ий тусламж дэмжлэг эрэлхийлэх байдлыг бэрхшээлийн төрөл хэлбэр тус бүрээр дор дэлгэрүүлэн авч үзлээ:

**1.Харааны бэрхшээлтэй хүн.** ГБХ-д өртсөн нийт харааны бэрхшээлтэй хүний 66 хувь (n=10) нь цагдаагийн байгууллагад өмнө хандаж байсан ба бүгд эмэгтэйчүүд байна. Цаашид ахин ГБХ-д өртвөл хандах талыг тодруулахад 60 орчим хувь нь цагдаагийн байгууллагад хандахаа илэрхийлсэн (Дүрс 49). Бусад ХБХ-тэй харьцуулахад цагдаагийн байгууллагад хандана гэж хариулсан оролцогчдын хувь харааны бэрхшээлтэй хүмүүсийн дунд хамгийн өндөр байсан.

Тусламж дэмжлэг хүсэж хандах талуудыг төрлөөр нь харвал, харааны бэрхшээлтэй хүмүүсийн 63% нь Дүрс 50-д харуулсан холбогдох төрийн байгууллагуудад, 33 хувь нь гэр бүл, ойр дотны хүмүүстээ, 7.4 хувь нь ТББ-д хандана гэж хариулсан байна.

Хэнд ч хандахгүй гэж нийт харааны бэрхшээлтэй хүмүүсийн 4 хувь хариулсан байх ба шалтгаан нь энэ нь гэр бүлийн дотоод асуудал учраас бусдад мэдэгдэх шаардлагагүй, өөрсдөө л учраа олох ёстой, эсвэл хандсан ч ямар ч нэмэргүй гэсэн цөхөрсөн хариултаудыг өгчээ.

Дүрс 49. ГБХ-д өртвөл хамгийн эхэнд хандах тал, харааны бэрхшээлтэй хүн, давхардсан тоогоор (n=27)



Дээр дурдсан талуудад мэдээлэхдээ харааны бэрхшээлтэй хүмүүсийн 81 хувь нь утсаар холбогдож мэдээлэл хүргэнэ гэж хариулсан. Иймд 101, 102, 103, 107, 108 зэрэг тусламжийн утасны операторуудыг дуудлага хүлээн авахдаа хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг лавладаг, цааш дараагийн шатны байгууллага уруу мэдээллийг дамжуулахдаа бэрхшээлийн онцлог, тусгай хэрэгцээний талаарх мэдээллийг давхар дамжуулдаг болох нь чухал юм.

Дүрс 50. ГБХ-ийн талаар мэдээлэхдээ харааны бэрхшээлтэй хүмүүсийн ашиглах боломжтой харилцааны хэрэгсэл, хувь




**2. Сонголын бэрхшээлтэй хүн.** Нийт ГБХ-д өртсөн сонголын бэрхшээлтэй хүний 30 хувь (n=6) нь л өмнө нь цагдаагийн байгууллагад хандаж байсан нь бусад ХБХ-тэй харьцуулахад тусламж дэмжлэг авсан байдлын хувьд хамгийн бага үзүүлэлтийн нэг байв. Үүний шалтгааныг ихэнх нь бэрхшээлийн онцлогтой холбоотойгоор мэдээлэл өгөх, дамжуулах боломж хязгаарлагдмал байдалтай холбож тайлбарласан.

Тусламж дэмжлэг хүсэж хандах талуудыг төрлөөр нь харвал, сонголын бэрхшээлтэй хүмүүсийн 68% нь Дүрс 52-д харуулсан холбогдох төрийн байгууллагуудад, 36 хувь нь гэр бүл, ойр дотно хүмүүстэй хандана гэж хариулсан байна.

Төрийн байгууллагаас хамгийн олон хүн цагдаагийн байгууллагад хандахыг илүүд үзэж байгаа хэдий ч хэрхэн яаж цагдаад хандах эсэхийг тодруулахад оролцогчдын хувьд тодорхой хариулт өгч мэдэхгүй байлаа. Хэдийгээр 2020 оноос эхлэн сонгогч, хэл ярианы бэрхшээлтэй иргэд яаралтай тусламжийн утсанд мессэжээр дуудлага өгөх боломж бүрдсэн ч энэ одоогийн байдлаар зөвхөн Нийслэлд нэвтрүүлж эхэлж байгаа ба иргэдийн дунд мэдээлэл хараахан сайн түгээгүй байна.

Мөн таньдаг дохионы хэлмэрчдээ эсвэл дохионы хэл мэддэг хэн нэгэнд хандана гэсэн оролцогч олон байсан. Гэвч хөдөө орон нутагт дохионы хэлмэрч маш дутагдалтай болох нь мэдээлэл цуглуулалтын явцад ажиглагдаж байсан бөгөөд энэ нь сонголын бэрхшээлтэй хүмүүс аливаа эрсдэлээс өөрсдийгөө хамгаалах, урьдчилан сэргийлэх, төрийн хамгааллын үйлчилгээг авахад тулгардаг гол хүндрэлийн нэг болж байв.

Дүрс 51. ГБХ-д өртвөл хамгийн эхэнд хандах тал, сонголын бэрхшээлтэй хүмүүс, хувь (n=25)



Дээр дурдсан талуудад мэдээлэхдээ сонголын бэрхшээлтэй хүмүүсийн таван хүн тутмын нэг нь (1) “мессеж” бичнэ, (2) “утсаар дуудлага хийнэ” гэж хариулсан. Сонголын бэрхшээлтэй хүмүүсийн хувьд сошиал платформыг ашиглан цахим дүрс дуудлага (video call) хийж хоорондоо харилцах байдал өргөн ашиглагддаг байна. Иймд өмнө дурдсан оролцогч талуудтай холбогдохдоо дуудлага хийнэ гэсэн хүн нийт оролцогчдын 5/1-ийг эзэлж байсан.

**Шигтгээ 61. Сэлэнгэ аймаг, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй, 38 настай, эмэгтэй**

Сонсголын бэрхшээлтэй иргэд өөрт ямар нэгэн бэрхшээл тулгарахад цахим орчинд (гол төлөв facebook) шууд холбогдоод мэдээллээ солилцох боломжтой.

**Дүрс 52. ГБХ-ийн талаар мэдээлэхдээ сонголын бэрхшээлтэй хүмүүсийн ашиглах боломжтой харилцааны хэрэгсэл, хувь**



Гуравдугаарт, дохионы хэл мэддэг хэн нэгэнд “биечилж хандана” гэж хариулсан. Гэвч дээр дурдсан харилцааны хэрэгслийн аль аль нь төрийн захиргааны ГБХ-ийн дуудлага хүлээн авах анхан шатны нэгжид хүртээмжгүй аргууд байгааг харгалзаж сонсголын бэрхшээлтэй хүмүүсээс анхан шатны түвшинд мэдээлэл хүлээн авах хувилбарт аргуудыг нэвтрүүлэх, мэдээллээ сайн түгээхэд анхаарах шаардлагатай байна.

**Шигтгээ 62. Сүхбаатар аймаг, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй, 34 настай, эмэгтэй**


Цаашид ахин ийм зүйл болбол цагдаад л хандах байх. Гэхдээ бас яаж хандахаа сайн мэдэхгүй байна. Төрийн байгууллагаас үйлчилгээ авахыг хүссэн ч хэлмэрч байхгүй учраас харилцаж чаддаггүй.

**3.Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүн.** Нийт ГБХ-д өртсөн тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн зөвхөн 27 хувь (n=9) нь л зөвхөн цагдаагийн байгууллагад хандаж тусламж, дэмжлэг авч байсан нь бусад ХБХ-тэй харьцуулахад тусламж дэмжлэг авах зан үйлийн хувьд хамгийн бага үзүүлэлтийн нэг байв.

Цаашид шаардлагатай нөхцөлд хандах талыг тодруулахад, сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн 57% нь Дүрс 54-д харуулсан холбогдох төрийн байгууллагуудад, 48.6 хувь нь гэр бүл, ойр дотно хүмүүстэй хандана гэж хариулсан бол 20 хувь нь хэнд ч хандахгүй гэж хариулсан.


Бусад ХБХ-ий өгсөн хариулттай харьцуулж үзвэл, тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн цагдаагийн байгууллагад хандах хувь хамгийн бага, түүнээс илүү ойр дотно хэн нэгэндээ мэдээлэх эс бөгөөс огт мэдэгдэхгүй гэх хариулт өндөр байсан нь анхаарал татаж байв.

**Дүрс 53. ГБХ-д өртвөл хамгийн эхэнд хандах тал, сонсголын бэрхшээлтэй иргэд, хувь (n=25)**



ГБХ-ийн талаар мэдэгдэхдээ (1) утсаар дуудлага хийж мэдээлэл өгөх болон (2) гар утасны мессежээр холбогдох хувилбаруудыг илүү боломжтой гэж үзсэн. Бэрхшээлийн онцлогоос шалтгаалан биечлэн очиж мэдээлэл өгөх боломж бага тул аль болох зайнаас холбогдох хувилбаруудыг тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүс илүү сонгожээ.

**Дүрс 54. ГБХ-ийн талаар мэдээлэхдээ тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн ашиглах боломжтой харилцааны хэрэгсэл, хувь**




**4.Оюун, сэтгэцийн бэрхшээлтэй хүн.** ГБХ-д өртсөн нийт оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүний 45 хувь нь (n=10) өмнө нь тусламж дэмжлэг эрэлхийлж цагдаагийн байгууллагад хандаж байсан.

Цаашид шаардлагатай нөхцөлд хандах талыг тодруулахад, оюун, сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн 44% нь Дүрс 56-д харуулсан холбогдох төрийн байгууллагуудад, 41 хувь нь гэр бүл, ойр дотно хүмүүстээ хандана гэж хариулсан. Ярилцлагын мэдээллээс үзэхэд төрийн байгууллагад хандсан ч төдийлөн авч хэлэлцдэггүй, хамгаалахгүй гэсэн сөрөг хандлагууд оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн дунд ажиглагдсан. Тэдгээр иргэдийг бэрхшээлийнх нь онцлогтой холбон хууль эрх зүйн чадамжгүй гэж харах, өгсөн мэдүүлэг, мэдээллийн үнэн бодитой байдалд эргэлзэх нийтлэг хандлага нь дээрх иргэдийг ГБХ-д өртсөн тохиолдолд зохих хамгаалалтыг авах боломжийг бууруулдаг байна. Мөн найз нөхдийн хүрээлэл бага тул дээрх байдлаар хариулсан байлаа.

**Шигтгээ 63. Сонгинохайрхан дүүрэг, оюун сэтгэцийн бэрхшээлтэй, 43 настай, эмэгтэй**  
 2000 оноос эхлэн байнгын шар хадны эмнэлгийн хяналтад байдаг болсон. Байнгын эм уудаг. Надад найз нөхөд бараг байдаггүй ийм өвчин болохоор ээжтэйгээ л хамт амьдардаг.

Оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй оролцогчдын хувьд хамгийн ойрын дийлэнх нь төрсөн гэр бүлийнхэндээ хэлэхийг илүү чухалчилж байсан. Тус хариулт нь бусад ХБХ-ээс харьцангуй өндөр.

**Дүрс 55. ГБХ-д өртвөл хамгийн эхэнд хандах тал, оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүн, хувь (n=34)**



**Шигтгээ 64. Сонгинохайрхан дүүрэг, сэтгэцийн бэрхшээлтэй, 38 настай, эрэгтэй**

Миний хувьд гэр бүлийн гишүүний зүгээс хүчирхийлэлд өртдөг бөгөөд дарамтлаад байхаар нь цагдаа дуудсан. Гэтэл хүргэн ах цагдаад хэлэхдээ дүүгээ юу боллоо гэж хөөдөг юм, эсрэгээр намайг шар хаданд хэвтэн эмчлүүлдэг, сэтгэцийн өвчтэй гээд хэлсэн чинь цагдаа нь намайг буруутгасан. Дахин цагдаа руу хандах хүсэл алга.

**Дүрс 56. ГБХ-ийн талаар мэдээлэхдээ тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн ашиглах боломжтой харилцааны хэрэгсэл, хувь**




Оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд ГБХ-ийн талаар мэдээлэхдээ “утсаар дуудлага хийх” болон “мессеж” бичих байдлаар мэдэгдэх боломжтой гэж хариулжээ.

**5.Бусад төрлийн бэрхшээлтэй хүн.** Нийт ГБХ-д өртсөн бусад төрлийн ХБХ-ий 46 хувь (n=10) нь өмнө цагдаагийн байгууллагад хандаж байсан. Цаашид ахин ГБХ-д өртвөл 38% нь цагдаагийн байгууллагад хандана гэж хариулсан бол, төрсөн ах, эгч дүү нар болон эцэг эх, найз нөхдөдөө мэдэгдэнэ гэж хариулсан хувь өндөр.

Цаашид шаардлагатай нөхцөлд хандах талыг тодруулахад, бусад төрлийн бэрхшээлтэй хүмүүсийн 48% нь Дүрс 58-д харуулсан холбогдох төрийн байгууллагуудад, 45 хувь нь гэр бүл, ойр дотно хүмүүстэй хандана гэж хариулсан.

**Дүрс 57. ГБХ-д өртвөл хамгийн эхэнд хандах тал, бусад төрлийн бэрхшээлтэй хүн, хувь (n=29)**



Бусад төрлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд (1) утсаар дуудлага хийх (64.7%) болон (2) мессежээр (23.5%) ГБХ-ийн талаар дуудлага мэдээлэл өгөх боломжтой байна.

**Дүрс 58. ГБХ-ийн талаар мэдээлэхдээ тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн ашиглах боломжтой харилцааны хэрэгсэл, хувь**



## 2. МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТОГТОЛЦОО БА ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХ

Бүлгийн гол үр дүн:

- ❖ **Үр дүн 1:** ГБХ-тэй тэмцэх тогтолцоо тодорхой хэмжээнд бүрдсэн ч ХБХ-ий асуудал эрхэлсэн байгууллагын үүрэг оролцоо тодорхойгүй байна.
- ❖ **Үр дүн 2:** Хамтарсан багийн үйл ажиллагаа явуулах төсөв хүрэлцээгүй байна.
- ❖ **Үр дүн 3:** ХБХ-ий эсрэг үйлдэгдэж буй ГБХ-тэй тэмцэх, үйлчилгээ үзүүлэх байгууллагын албан хаагч, мэргэжилтнүүдэд чиглэсэн сургалт хангалтгүй байна.

**Үр дүн 1: ГБХ-тэй тэмцэх тогтолцоо тодорхой хэмжээнд бүрдсэн ч ХБХ-ий асуудал эрхэлсэн байгууллагын үүрэг оролцоо тодорхойгүй байна.**

Монгол Улс ГБХ-тэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг шинэ түвшинд гаргах зорилгоор анх удаа 2004 онд ГБХ-тэй тэмцэх тухай хуулийг баталсан бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор ГБХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр, Улсын дээд шүүхээс тус хуулийн зарим зүйл заалтыг нэг мөр ойлгож, хэрэглэх тухай тайлбар, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон заавар, журмуудыг батлан хэрэгжүүлсэн. Мөн төрөөс хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг хамгаалан байрлуулах, гэр бүлд утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээг мэргэшсэн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх, НЦҮТ-ийг байгуулан үйлчилгээ үзүүлж эхэлсэн зэрэг бодлого болон үйл ажиллагааны хүрээнд нааштай алхмууд хийгдсэн. Гэвч хүчирхийллийн гаралт буурахгүй, харин ч хүний амь нас хохирох, гэмтэх, хүүхэд өртөх зэргээр илүү ноцтой хэлбэрт шилжих болсон тул Монгол Улсын Их Хурлаас 2016 онд ГБХ-тэй тэмцэх тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг баталсан<sup>26</sup>.

Мөн Эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэлийн явцад Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийг тодорхойлон зааж, оногдуулах шийтгэлийг тодорхой болгосон нь олон улсын гэрээ, конвенц, Үндсэн хууль, бусад хууль тогтоомжоор хамгаалсан хүний халдашгүй байх эрх, амьд явах эрхийг баталгаатай хангахад чиглэгдсэн зохицуулалт болжээ.

26 ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга нь өмнөх хуулиас дараах өөрчлөлтийг авчирснаараа онцлогтой. Үүнд:

- ГБХ-ийн хохирогчдын олонх нь хуулийн хамгаалалтын гадна үлддэг байдал үгүй болсон.
- Бүх шатны боловсролын байгууллагын багш, ажилтан, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан ажилтан, баг, хороо, сум, дүүргийн холбогдох албан тушаалтан, төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж буй төрийн бус байгууллагын ажилтан ГБХ үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдлын талаар цагдаагийн байгууллагад, цагдаагийн алба хаагчийн эзгүйд сум, багийн засаг даргад мэдээлэх үүрэг хүлээх болсон.
- ГБХ-ийн талаарх мэдээллийг хүлээн авах, байгууллага, албан тушаалтныг тодорхой заасан.
- ГБХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчлийн талаар цагдаагийн байгууллагаас хүлээх үүргийг тодорхой заасан.
- Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг тусгай хамгаалалтаар хангахаар зохицуулсан.
- Хохирогчдод үзүүлэх үйлчилгээг төрөлжүүлэн хуульчилсан.
- Хохирогчийг хамгаалах үйлчилгээг нэг дороос үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн.
- Зөрчил болон гэмт хэргийг заагласан.
- Шаталсан, ялгамжтай хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан.
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүчирхийлэл үйлдэгдэж тодорхой эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэж болохоор хуульчилсан зэрэг болно.

ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор эрх бүхий байгууллагаас 30 гаруй журам баталсан нь өдгөө хүчин төгөлдөр үйлчилж байна. Эдгээр баримт бичгүүдийг харгалзан үзвэл манай улс ГБХ-тэй тэмцэх чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхааран, нэгдэн орсон олон улсын гэрээний агуулгад үндэсний хууль тогтоомжоо нийцүүлэх талаар гаргасан хүчин чармайлтын үр дүнд ГБХ-тэй тэмцэх эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн байна.

Гэвч ГБХ-тэй тэмцэх хууль эрх зүйн баримт бичиг, түүнд холбогдох журамд ХБХ-ий онцлог, тусгай хэрэгцээнд нийцүүлэн урьдчилан сэргийлэх болон хамгааллын үйлчилгээг хэрхэн хүргэх талаар тусгайлан авч үзсэн зохицуулалт байхгүй байна. Тухайлбал: Оюуны бэрхшээлтэй, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүн хүчирхийлэлд өртсөн тухай цагдаагийн байгууллагат хандвал хэрхэн тэдгээр иргэдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн ажиллах тухай заавар зааварчилгаа, чадавхыг бүрдүүлэх талаар зохицуулалт байхгүй юм. Энэ нөхцөл байдлаас үүдэн ХБХ ГБХ-ийн хохирогч болсон тухайгаа холбогдох байгууллагад мэдээлэх, бий болсон нөхцөл байдлаа бүрэн ойлгуулах, шаардлагатай тусламж үйлчилгээг авч чадахгүй байх нөхцөл үүсэх боломжтой байна. ХБХ-ий төлөөлөлтэй хийсэн ярилцлагуудын явцад ч энэ байдал ажиглагдаж байлаа.

#### Шигтгээ 65.

*Манай эмнэлгийн эмч нар өөрсдийн мэргэжлийн арга зүй, мэдлэг туршлагаараа л үйлчлүүлж буй ХБХ-тэй харилцах арга барилаа тодорхойлдог. Бидэнд стандартчиллагдсан заавар зааварчилгаа гэж байдаггүй, энэ талаарх сургалт зөвлөгөөнд хамрагдаж байгаагүй.*

#### Шигтгээ 66.


*ГБХ-тэй тэмцэх чиглэлээр гарсан хууль тогтоомжууд харьцангуй сайжирсан. Аймаг, орон нутгийн хэмжээнд хуулийг хэрэгжүүлэхийг зорьж байгаа хүмүүс байна. Харин яг ХБХ-ийг ингэж хамгаална, ингэж харьцана гэсэн нарийвчилсан зүйл байхгүй. Ер нь хууль, журам хийхдээ практикт ажиллаж байгаа, ялангуяа хөдөө ажиллаж байгаа хүмүүсийнхээ санаа бодлыг сонсдог байвал их сайн. Тэгвэл энэ асуудлыг гаргаад л ирэх байсан.*

**Хамтарсан багийн гишүүдийн ярилцлагаас**

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14-р зүйлийн 14.1 дэх хэсэгт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр, аймаг, нийслэл, сум, дүүрэгт түүний иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн даргаар удирдуулсан орон тооны бус зөвлөл зохицуулах тухай заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ахлуулсан 34 гишүүнтэй зохицуулах зөвлөл байгуулж, түүний ажиллах журмыг Засгийн газрын 2020 оны 107-р тогтоолоор баталжээ.

Уг хуулийн 15 дугаар зүйлд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй, Улсын хэмжээнд тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг дагнан зохицуулах үүрэг бүхий дэд зөвлөлийг зохицуулах зөвлөлийн дэргэд ажиллуулж болно гэж зааснаас үзвэл ГБХ-тэй тэмцэх тогтолцооны гол цөм нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, түүний дэргэд үйл ажиллагааг явуулж буй ГБХ, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөл болж байна.

#### Дүрс 59. ГБХ-тэй тэмцэж буй одоогийн тогтолцоо



Дэд зөвлөлд нийт 13 гишүүнтэй бөгөөд төрийн байгууллагын 8 газрын дарга, захирал, 4 төрийн бус байгууллагын тэргүүн, нэг олон улсын байгууллагын төлөөллөөс бүрдэж буй ч ХБХ-ий төлөөлөлгүй байна.

Улсын Их Хурлаас 2016 онд баталсан ХБХ-ий эрхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд ХБХ-ий асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь **ХБХ-ий тэгш эрх болон нийгмийн хамгааллын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих, ХБХ-ий эрхийг хангах, хамгаалах, хөгжлийн бодлого боловсруулах, холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, эрх бүхий байгууллагад уламжлах, төрийн болон ТББ-ыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ** гэж зааснаас ХБХ-ийг аливаа гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар заагаагүй байна.

Иймд дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх замаар тэгш оролцоог хангаж, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ХБХ-ий асуудал эрхэлсэн байгууллагыг татан оролцуулах нь чухал байна. Энэ нь цаашид ГБХ-д өртсөн ХБХ-д үзүүлэх хариу үйлдэл тодорхой байхын зэрэгцээ цаашид анхаарах асуудлыг бодлогын түвшинд авч хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

## Үр дүн 2: Хамтарсан багийн үйл ажиллагаа явуулах төсөв хүрэлцээгүй байна.

ГБХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцооны анхан шатны нэгж нь **хамтарсан баг** юм. ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлд зааснаар “Хамтарсан баг нь өрхийн эмч, сум, хороо, сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг ТББ-ын төлөөллөөс бүрдэх бөгөөд хамтарсан багийг тухайн сум, хорооны Засаг дарга ахална” гэжээ.

Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журмыг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/173, А/259, А/3801 тоот хамтарсан тушаалаар баталсан. Уг журмын 5 дугаар зүйлд хамтарсан багийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөв, хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх тухай дурджээ. Хамтарсан багийн үйлчилгээний зардлын төсвийг сум, дүүрэг, аймаг, нийслэлийн засаг дарга нар жил бүр ГБХ-тэй тэмцэх үйл ажиллагааны зардалд тусгайлан төсөвлөж, иргэдийн төлөөлөгчийн хурлаар батлуулахаар зохицуулсан байна.

Гэвч бодит байдалд ажиллаж буй хамтарсан багийн гишүүдтэй хийсэн ярилцлагын үр дүнд хамтарсан багийн төсөв хүрэлцээгүй, зарим тохиолдолд байгууллага бүр үйл ажиллагааныхаа дотоод төсвөөс гарган ажиллах байдлаар зохицуулж байна.

Шигтгээ 67.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах гэж 600,000 төгрөг байдаг. Энэ нь хаанаа ч хүрдэггүй. Иргэдэд зориулсан арга хэмжээ зохион байгуулах гэхээр төсөв байхгүй, тэгээд нэгэнт иргэдийг цуглуулж байгаа болохоор өөрсдөөсөө мөнгөө гаргаад цай унд бэлддэг.

#### Шигтгээ 68.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөв бага хэмжээгээр аймаг, сумдын төсөвт орж байгаа боловч тэр нь ХБХ-ийг хамгаалах, харилцан ойлголцох, тулгамдсан саад бэрхшээлийг зохицуулах зэрэг зориулалтгүй, хүргэх ч боломжгүй байна.

#### Шигтгээ 69.

Хамтарсан багийн гишүүд үйлчилгээ үзүүлэхэд тулгарч буй өөр нэг асуудал нь унаа тэрэг, бензин, тосны асуудал. Төрийн байгууллага тэр бүр зардлыг нь гаргаж өгдөггүй. Тэгэхээр нөгөө албан хаагчид чинь байнга явган, эсвэл хувиасаа тэр зардлаа гаргаж явахаас мэдээж түүртэнэ. Анхан шатны хүмүүстээ хүрч үйлчлэх наад захын зардал нь л хүрэлцээгүй болохоор хүн бүрд хүрч үйлчлэхэд хэцүү шүү дээ.

#### **Хамтарсан багийн гишүүдийн ярилцлагаас**

Иймээс анхан шатны нэгжид ГБХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж буй төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог хангаж, үйл ажиллагаагаа тасралтгүй, шуурхай, түргэн хүргэхэд шаардлагатай зардлыг улсын болон орон нутгийн төсөвт суулгах, нэгэнт суусан төсөв зориулалтын дагуу зарцуулагдаж буй эсэхэд хяналт тавих нь зүйтэй байна. Мөн улсын болон орон нутгийн жилийн төсвийг төлөвлөхдөө өмнөх жилд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоон судалгаа, мэдээлэлд үндэслэн тооцоонд суурилсан төсөвлөлт хийхэд анхаарах шаардлагатай байна.

#### **Үр дүн 3: ХБХ-ий эсрэг үйлдэгдэж буй ГБХ-тэй тэмцэх, үйлчилгээ үзүүлэх байгууллагын албан хаагч, мэргэжилтнүүдэд чиглэсэн сургалт хангалтгүй байна.**

ГБХ-тэй тэмцэх тухай, ХБХ-ий эрхийн тухай бие даасан хууль баталж, ХБХ-ий эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа хэдий ч ХБХ-ий эсрэг үйлдэж буй ГБХ-тэй тэмцэх, түүнийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, түүнчлэн энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг шалгаж, шийдвэрлэх үүрэг бүхий албан хаагч нь ХБХ-ий онцлог хэрэгцээг ойлгох, үйлчилгээг хэрхэн хүртээмжтэй хүргэх талаар ойлголттой байх шаардлагатай.

Баримт бичгийн судалгаанаас үзэхэд, төрийн байгууллагууд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж алба хаагчдынхаа ХБХ-ий эрх, онцлог хэрэгцээг ойлгох, үзүүлж буй үйлчилгээгээ хүртээмжтэй хүргэх талаар анхааран ажилласан санаачилгууд цөөнгүй байна. Тухайлбал, Цагдаагийн байгууллагаас ХБХХЕГ-тай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах хөтөч цагдаа бэлтгэх нь” сэдэвт сургалтыг сүүлийн нэг жилийн хугацаанд зохион байгуулж, ХБХ-д цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, тэднээс ирүүлж буй дуудлага мэдээлэл, өргөдөл, гомдлыг цаг алдалгүй хүлээн авч шийдвэрлэх, эрхийг нь хангах боломжийг бүрдүүлэх чиглэлээр ажиллажээ<sup>27</sup>.

Мөн ХБХХЕГ нийт алба хаагчдынхаа 60 орчим хувийг дохионы хэлний сургалтад хамруулж, сонсгол болон хэл ярианы бэрхшээлтэй хүмүүстэй харилцах ур чадварт суралцуулах ажлыг хэрэгжүүлсэн байна. Энэ мэтчилэн төрийн ажил үйлчилгээг ХБХ-д хүртээмжтэй хүргэх, ХБХ-ийн онцлог, тусгай хэрэгцээг харгалздаг болоход чиглэсэн цөөнгүй санаачилгууд ажил хэрэг болсон байгаа хэдий ч

27 <http://police.gov.mn/a/5376>

явуулж буй сургалтууд нь зөвхөн нэг удаагийн, төрийн байгууллага, албан хаагчдыг бүрэн хамарч чадахгүй байх, нөгөө талаас төрийн алба хаагчдын тогтвор суурьшилтай холбоотой асуудлууд нь ХБХ-д төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэхэд саад учруулж байгаа нь тус судалгааны үр дүнгээс ажиглагдлаа.

**Шигтгээ 70.**

*Бид үндсэн чиглэлээ бариад ГБХ-ийн талаарх сургалтад л хамрагддаг. Яг ХБХ-тэй холбоотой сургалтад сууж байгаагүй юм байна.*

**Шигтгээ 71.**

*ГБХ-ийн талаарх сургалтад хангалттай их суусан. Гэхдээ ХБХ-ийг хэрхэн хамгаалах, тэдэнтэй яаж харилцах ч байдаг юм уу эсвэл тэдний хэрэгцээ шаардлагыг ойлгох гэсэн сургалтад бол сууж байгаагүй. Ер нь тийм тусгайлсан сургалт байдаг юм уу? Манай цагдаагийн газрын нэг алба хаагч л дохионы хэлний сургалтад сууж байсан. Үр дүн нь хэр байсныг бол сайн мэдэхгүй.*

**Цагдаагийн албан хаагч нарын ярилцлагаас**

Тус судалгаанд оролцсон төрийн болон ТББ-ын албан хаагчдын 75% (n=32) нь ГБХ-ийн талаарх сургалтад хамрагдаж байсан өндөр үзүүлэлттэй гарч байгаа боловч 90 хувь нь ХБХ-тэй холбоотой мэдлэг, ойлголт эзэмшүүлэх сургалтад хамрагдаж байгаагүй байна.

Иймээс цаашид төрийн байгууллагуудын нийт ажилтан, албан хаагчдад ХБХ-ий эрхийн ойлголт, тэдний онцлог хэрэгцээг таньж мэдэх, түүнд нийцсэн үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар сургалтад хамруулах нь зүйтэй байна.

Судалгааны баг ГБХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцооны нөхцөл байдлыг системтэй судлах зорилгоор олон улсад нийтлэг ашиглагддаг 4P-ийн парадигмыг баримталсан. 4P-ийн парадигм нь урьдчилан сэргийлэх (prevention), хохирогчийг хамгаалах (protection), хэрэг хянан шийдвэрлэх (prosecution) болон хамтын ажиллагаа (partnership) гэсэн үндсэн 4 асуудлын дагуу аливаа гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо, үйл ажиллагааг авч үзэхэд ашиглагддаг олон улсын суурь арга зүй юм. Тус арга зүйн дагуу авч үзсэн судалгааны үр дүнг дараагийн дэд бүлгүүдэд танилцууллаа.

## 2.1 GBX-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

Бүлгийн гол үр дүн:

- ❖ **Үр дүн 1:** GBX-ээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага тулгамдаж байна.
- ❖ **Үр дүн 2:** GBX-ээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахдаа ХБХ-ий онцлог, тусгай хэрэгцээг харгалзан, хүртээмжтэй мэдээлэл хүргэх байдал хангалтгүй байна.

### Үр дүн 1: GBX-ээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага тулгамдаж байна.

Манай улсад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 20 гаруй хууль<sup>28</sup> мөрдөгдөж байгаагаас GBX-тэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх хохирогчийг хамгаалах талаар гол хууль нь GBX-тэй тэмцэх тухай хууль юм. Уг хууль нь GBX-ийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход чиглэгдсэн. Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 30 гаруй журам батлагдаж хүчин төгөлдөр мөрдөгдөж буй талаар өмнөх бүлэгт дурдсан билээ.

Үүнээс гадна гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйлчилж буй 20 гаруй хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, нэгдсэн бодлого, зарчимд суурилж, олон талын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох зорилгоор Монгол Улсын Их Хурлаас Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг 2019 онд баталж, 2020.01.01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Уг хуульд болон GBX-тэй тэмцэх тухай хуульд заасны дагуу GBX-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх Дэд зөвлөл нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах, нэгдсэн бодлогоор уялдуулан зохицуулах үүрэг хүлээж байна.

GBX-тэй тэмцэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь хэсэгт “төрөөс GBX-тэй тэмцэх талаар баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгах арга хэмжээ авах” Засгийн газрын чиг үүргийг зааж өгсөн боловч хууль батлагдсанаас хойших 4 жилийн хугацаанд Үндэсний хөтөлбөр батлагдаагүй нь энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нэгдсэн бодлого төлөвлөлт, зохион байгуулалтгүй, үр дүнгүй явагдах үндсэн шалтгаан болж байна гэж судалгааны баг үзэж байна.

Өнөөдрийг хүртэл явж ирсэн энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлсэн ажлыг хангалтгүй гэж хэлэх үндэсгүй ч GBX-ээс урьдчилан сэргийлэх, түүнд нөлөөлөх

28 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авлигын эсрэг, Садар самуун явдалтай тэмцэх тухай, Мансууруулах эм, сэтгэгдэл нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай, GBX-тэй тэмцэх тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Эрүүгийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай, Гэрч хохирогчийг хамгаалах тухай, Гамшгаас хамгаалах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Цагдаагийн албаны тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиуд

шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэгдээгүй, илүү тухайн нөхцөл байдлыг таслан зогсоох, түр зуурын, богино хугацааны ажлууд түлхүү хэрэгжиж байна.

Тухайлбал, ГБХ-ийн хор уршгийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, гэр бүлийн харилцааны сөрөг хандлагыг өөрчлөх, эерэг мэдээлэл түгээж, хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх, нуугдмал гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр төрийн болон ТББ, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Цагдаагийн байгууллага, бусад төрийн байгууллага, ТББ, ОУБ-тай хамтран зохион байгуулсан “Ойлгоё Хүндэлье” аян 23 хоногийн, “Хайр өвтгөдөггүй” аян 22 хоногийн хугацаанд хэрэгжсэн байна. Мөн Цагдаагийн байгууллага ГБХЗХГ, Дэлхийн зөн Монгол ОУБ, JCI Монгол ОУБ-аас хамтран хүүхдийг гэмт хэрэг зөрчил, бэлгийн хүчирхийлэл, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахад эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулсан “Сүүдэр бүү тусга” аян нэг сарын хугацаанд үргэлжилсэн байна.

Аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын эцсийн үр дүн нь “тухайн гэмт хэргийн гаралт буурах” явдал бөгөөд ийм үр дүнд хүрсэн эсэхийг тогтоох нь ихээхэн ач холбогдолтой бөгөөд дараагийн үйл ажиллагааг төлөвлөх шаардлагатай юм. Гэтэл “тодорхой үр дүн” гарах эсэх нь тодорхойгүй богино хугацаатай, тухайн үеийнхээ нөхцөл байдалтай холбогдуулан нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ авч хэрэгжүүлж буй нь нэгдсэн бодлого үгүйлэгдэж буйг илтгэж байна.

**Үр дүн 2: ГБХ-ээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахдаа ХБХ-ий онцлог, тусгай хэрэгцээг харгалзан, хүртээмжтэй мэдээлэл хүргэх талаар холбогдох хууль эрх зүйн баримт бичигт тодорхой заалт, зохицуулалт хийгдээгүй байна.**

ХБХ-ий эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлд “Түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин нөхцөл, үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлээгүй байх, бүрдүүлэхээс татгалзах, нийгмийн үйлчилгээг бусдын адил тэгш хүртэх боломжийг хязгаарлах, ХБХ мэдээлэл авах, бусадтай харилцахад шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлээгүй байх” нь ХБХ-ийг ялгаварлан гадуурхаж буй үйлдэл тухай заасан. Өөрөөр хэлбэл, олон нийтэд зориулсан мэдээ мэдээллийн үйл ажиллагаа, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулгын мэдээллүүд нь ХБХ-ий онцлог, тусгай хэрэгцээг харгалзаагүй байх, энэ чиглэлээр тодорхой үйлдэл хийгээгүй байх нь ХБХ-ийг ялгаварлан гадуурхаж буй явдал юм.

Гэтэл ГБХ-тэй тэмцэх тухай хуульд ГБХ-ийн талаар мэдээлэх, ГБХ-ээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зэрэг урьдчилан сэргийлэх чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ХБХ-ий өвөрмөц хэрэгцээнд нийцүүлэх, бүх нийтэд хүртээмжтэй хүргэх талаар тодорхой заалт, зохицуулалт тусаагүй байна. Хууль эрх зүйн баримт бичигт тодорхой зохицуулалт ороогүй нь ГБХ-ээс урьдчилан сэргийлэх ажилд ХБХ-ий онцлог, тусгай хэрэгцээг хангах тодорхой үйлдэл хийхгүй байх суурь нөхцөл болно.

Бодит байдалд, ГБХ, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ХБХ хэр ойлголт мэдлэгтэй байгааг авч үзэхэд судалгаанд хамрагдсан нийт ХБХ-ий дөнгөж 12 хувь нь ГБХ-ийн талаар зохих мэдлэгтэй байсан. Ихэнх оролцогчид зөвхөн зодож, цохиж бие махбодын хохирол учруулсан бол хүчирхийлэл гэх хязгаарлагдмал ойлголттой байх бөгөөд ГБХ-ийн бусад хэлбэрүүд болох хянах зан үйл, эдийн засаг болон бэлгийн хүчирхийллийн үйлдэгдэж болох хэлбэрүүдийн талаар мэдлэг, ойлголт маш сул байв.

ГБХ-д өртсөн тохиолдолд хаана хандахыг тодруулахад ихэнх оролцогчид цагдаад мэдэгдэнэ гэж хариулж байсан боловч бусад туслалцаа дэмжлэг авч болох НЦҮТ, түр хамгаалах байр, бусад ТББ-ын талаар мэдлэг ойлголт маш хангалтгүй байснаас үзэхэд тус гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл түгээх ажил ХБХ-д огт хүртээмжгүй байгааг харуулж байна.

Бэрхшээлийн төрлөөр нь авч үзвэл, ГБХ-ийн талаар сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн мэдлэг, ойлголт бусад ХБХ-тэй харьцуулахад хамгийн бага байгаа нь тэдгээр иргэдийн бэрхшээлийн онцлог, тусгай хэрэгцээг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөхдөө нэн тэргүүнд анхааран авч үзэх шаардлагатайг харуулж байв.

**Шигтгээ 72. Увс аймаг, Сонсголын бэрхшээлтэй, 26 настай, эмэгтэй**

*ГБХ гэхээр гэрийнхээ хэн нэгнийг цохисон, зодсон ч юм уу тийм үйлдлийг хэлэх байх. Гэхдээ энэ яг хүчирхийлэл мөн үү. Би огт сонсохгүй, стандарт дохио сайн мэдэхгүй, сургуульд сурч байгаагүй. Зурагтаар гардаг дохио байгаа хүмүүсийн дохиог бас ойлгодоггүй. Тийм болохоор мэдээ мэдээллээс хол байдаг.*

Сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн мэдээллийн хүртээмжийг сайжруулах зорилгоор ХБХ-ий эрх, оролцоо хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрт “МҮОНРТ болон бусад арилжааны телевизийн мэдээллийн болон танин мэдэхүйн хөтөлбөрийг дохионы орчуулгатай, уран сайхны киног хадмал орчуулгатай болгох”<sup>29</sup> ажил тусгагдсан. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд холбогдох мэдээллийн сувгуудад дохионы хэлний орчуулгын талбар хуваарилагдсан. Гэвч сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаар дэлгэцийн доор байрлах дохионы хэлмэрчийн талбар нь хэт жижиг хэмжээтэйгээс гарын хөдөлгөөнийг сайн харж чаддаггүй гэх хариулт олон давтагдаж байлаа.

Тус үр дүн нь хэдийгээр ХБХ-ий мэдээллийн хүртээмжийг сайжруулах тодорхой ажлууд хийгдэж байгаа боловч, яг ХБХ-ийн хэрэгцээнд нийцсэн байдал, хүртээмжтэй байдлын хувьд сайжруулах асуудлууд байсаар байгааг харуулж байлаа.

Иймд цаашид ХБХ-ий ГБХ-ийн талаар мэдлэг ойлголтыг дээшлүүлэх ажлыг бэрхшээл бүрийн онцлог, тусгай хэрэгцээг харгалзаж, хэрэгцээнд суурилсан байдлаар зохион байгуулж энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай. Өөрөөр хэлбэл ГБХ, түүнд өртөж хохирсон тохиолдолд хаана хандах, ямар тусламж үйлчилгээ авах талаарх мэдээллийг тэдний хөгжлийн бэрхшээлийн онцлог байдалд тохируулан түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах хэрэгтэй байна.

## 2.2 ГБХ-ийн хохирогч хамгааллын асуудал, шаардлагатай дэмжлэг туслалцаа

Бүлгийн гол үр дүн:

- ❖ **Үр дүн 1:** ГБХ-ийн хохирогч хамгааллын эрх зүйн орчин сайжирсан хэдий ч хүчирхийлэлд өртсөн ХБХ рүү чиглэсэн хохирогч хамгааллын бодлого хангалтгүй байна.
- ❖ **Үр дүн 2:** ГБХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлж буй байгууллагын бүртгэл мэдээлэл үйлчлүүлэгчийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр нарийвчлагдан задрах боломжгүй байна.
- ❖ **Үр дүн 3:** Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд ХБХ-ийг хүлээн авах орчин бүрдээгүй, тэдгээр төвийн үйл ажиллагаа ХБХ-д хүртээмжгүй байна.
- ❖ **Үр дүн 4:** ГБХ-д өртсөн ХБХ-д нэн шаардлагатай дэмжлэг туслалцаанд сэтгэл зүйн зөвлөгөө, хувийн туслахын системд суурилсан бие даан амьдрах төвийн үйлчилгээ шаардлагатай байна.

<sup>29</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр, УБ., 2017 он

## Үр дүн 1: ГБХ-ийн хохирогч хамгааллын эрх зүйн орчин сайжирсан хэдий ч хүчирхийлэлд өртсөн ХБХ рүү чиглэсэн хохирогч хамгааллын бодлого хангалтгүй байна.

ГБХ-тэй тэмцэх тухай хуульд заасан ГБХ-ийн хохирогч хамгааллын харилцааг зохицуулж буй заалтуудыг даган нийгмийн ажил үйлчилгээнд шууд хамааралтай 11 журам<sup>30</sup>, нэг стандарт (Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, MNS:6040-2019) үйлчилж байна.

ГБХ-п өртсөн хохирогчийг хамгаалах чиглэлд үйлчилж буй зүйн баримт бичгүүдийн өнөөгийн нөхцөл байдлыг авч үзвэл **дараах ололттой талууд байна**. Үүнд;

1. **Хамтарсан багийн зохион байгуулалтыг бий болгосон.** Анхан шатны нэгж дээр ГБХ-ийн асуудлыг хариуцсан, үйлчилгээ үзүүлэх нэгжийг бий болгосон. Тус багийг тухайн сум, хорооны Засаг даргаар ахлуулан өрхийн эмч, сум, хороо, сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.
2. **ГБХ-ийн талаарх мэдээллийг хүлээн авах, байгууллага, албан тушаалтныг тодорхой заасан.** Тухайлбал, Цагдаагийн байгууллагын үүрэг оролцоог маш тодорхой заасан ба цагдаа хохирогчийн аюулын зэргийн үнэлгээг хийснээр эрсдэл өндөртэй хүнд хамгаалалтын арга хэмжээг авах эрхтэй болсон.
3. **Хохирогчид үзүүлэх үйлчилгээг төрөлжүүлэн хуульчилсан ба үйлчилгээ тус бүр нь холбогдох чиг үүргийн байгууллагын хүрээнд журамласан.** Энэ хүрээнд ГБХ-тэй тэмцэх тухай хуулийг даган гарах нийт 35 журмаас 33<sup>31</sup> нь батлагдан хэрэгжиж байна. Үүнд, хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам, хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам гэх зэрэг юм.
4. **Хохирогчийг хамгаалах үйлчилгээг нэг дороос үзүүлэх боломж бүрдсэн.** Хохирогчийг хамгаалах үйлчилгээг нэг дороос шууд үзүүлэх хамгийн чухал үйлчилгээ болох НЦҮТ, Түр

30 ХНХ-ын сайдын 2017 оны А/116 дугаар тушаалаар батлагдсан Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам,

ХЗД-ийн сайд, ЭМ-ийн сайд, ХНХ-ын сайдын 2017 оны А/80, А/132, А/60 дугаар хамтарсан тушаалаар баталсан Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам,

ХЗДХ-ийн сайдын 2017 оны А/39 дугаар тушаалаар баталсан ГБХ-ийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам,

ХНХ-ын сайдын 2017 оны А/33 дугаар тушаалаар баталсан ГБХ-д өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам,

ХНХ-ын сайдын 2017 оны А/73 дугаар тушаалаар баталсан Холбон зуучлах үйлчилгээний журам,

ХЗД-ийн сайд, ЭМ-ийн сайд, ХНХ-ын сайдын 2017 оны А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаалаар баталсан Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам,

ХЗД-ийн сайд, ЭМ-ийн сайд, ХНХ-ын сайдын 2017 оны А/84, А/59, А/130 дугаар хамтарсан тушаалаар баталсан Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам,

ХНХ-ын сайдын 2020 оны А/150 дугаар тушаалаар баталсан Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журам,

НХХ-ын сайдын 2012 оны А/91 дугаар тушаалаар баталсан Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх журмыг тус тус мөрдөж байна

31 ГХУСА33АА-ын мэдээлэл

хамгаалах байр юм. Өнөөдрийн байдлаар нийт 18 түр хамгаалах байр, 12 НЦҮТ байгуулагдаад байна<sup>32</sup>.

5. **ГБХ-ийн талаарх мэдээллийг хүн бүр мэдээлэх үүрэгтэй болсон.** Үүгээрээ ГБХ-тэй холбоотой дуудлага, мэдээллийг цагдаагийн байгууллага нэн тэргүүнд түргэн шуурхай хүлээн авч хохирогчийг хамгаалах үүргийг хуульчилсан.

ГБХ-тэй тэмцэх тухай хууль нь **хохирогч төвтэй хандлагад суурилсан, төрийн байгууллагуудын чиг үүрэг болоод салбар дундын хамтын ажиллагаа, зохион байгуулалтыг тодорхой болгосны зэрэгцээ, хохирогчдод үзүүлэх үйлчилгээг төрөөс үнэ төлбөргүй үзүүлэх** болсон зэргийг харгалзвал ГБХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчинд тодорхой эерэг ахиц дэвшлүүд багагүй гарсан байна.

Гэвч тус хуульд ХБХ-тэй холбоотой асуудлыг хэрхэн тусгасныг авч үзэхэд зөвхөн тусгай хэрэгцээт хүмүүст үйлчилгээг үзүүлэхдээ онцлог хэрэгцээг харгалзан үзүүлэх тухай ерөнхийлөн заасан байгаа нь ХБХ-ийн онцлог, тусгай хэрэгцээг хохирогч хамгааллын үйлчилгээнд хэрхэн хангах талаар зохицуулалт хангалтгүй гэж үзэх үндэслэл болж байна. Тухайлбал, хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэгт **Хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн эмгэгтэй хүн** ГБХ-д өртсөн тохиолдолд хэрэгцээ шаардлагыг харгалзан шууд үзүүлэх, мөн хуулийн 33.7 дахь хэсэгт бичиг мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хохирогчид үйлчилгээ үзүүлэхдээ орчуулагч, хэлмэрчийн тусламж авах эрхээр хангах талаар зохицуулалтыг тусгасан боловч хуулийн энэ заалтыг хэн, хэрхэн, хангах талаар нарийвчлан зохицуулсан заалт холбогдох журмуудад тусаагүйн улмаас хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Иймд ГБХ-тэй тэмцэх хуульд ХБХ-ийн онцлог, тусгай хэрэгцээг харгалзан үйлчилгээ үзүүлэх талаар зохицуулалт одоогоор хангалтгүй байгаа нь цаашид ХБХ-ийг ГБХ-ийн хохирогч болохоос хамгаалах, тэдэнд үзүүлэх үйлчилгээг тэгш хүртээмжтэй болгох, хэрэгжилтийг хангахад онцгойлон анхаарах шаардлагатайг харуулж байна.

*Хохирогчдод үйлчилгээ үзүүлэх чиглэлээр батлагдан гарсан журмуудад ХБХ-тэй холбоотой зохицуулалт хэрхэн тусгагдсаныг Хавсралт 2-т харууллаа.*

**Үр дүн 2. ГБХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлж буй байгууллагын бүртгэл мэдээлэл үйлчлүүлэгчийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр нарийвчлагдан задрах боломжгүй байна.**

**Үр дүн 3. Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд ХБХ-ийг хүлээн авах орчин бүрдээгүй, тэдгээр төвийн үйл ажиллагаа ХБХ-д хүртээмжгүй байна.**

ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлд хохирогчид үзүүлэх долоон төрлийн үйлчилгээг хуульчилсан. Үүнд:

Үйлчилгээний төрөл	Хэн, ямар үйлчилгээ үзүүлэх
Аюулгүй байдлын хамгаалалт <sup>33</sup>	Цагдаагийн байгууллага, холбогдох газар хэлтсүүдэд ажиллаж буй алба хаагч Хамтарсан багийн гишүүд, Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч, прокурор нь ГБХ-ийн шинжтэй гомдол, мэдээлэл шалгах, хэрэг бүртгэл, мөрдөн

32 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны мэдээлэл

33 Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн авуулгүй байдлыг хангах журам

	байцаалт, болон зөрчлийн хэрэг бүртгэлийн явцад хохирогчийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.
<b>Эмнэлгийн тусламж үйлчилгээ<sup>34</sup></b>	Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх эрх бүхий өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд үйлчилгээ үзүүлнэ. Яаралтай тусламжаас бусад үйлчилгээг хохирогчийн оршин сууж байгаа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллага, стандарт, зааврын дагуу үзүүлнэ.
<b>Сэтгэл зүйн үйлчилгээ<sup>35</sup></b>	Нийгмийн ажилтан сэтгэл зүйн анхан шатны тайвшруулах зөвлөгөө өгнө. Сэтгэлзүйн зөвлөгөө, үйлчилгээг цаашид мэргэжлийн сэтгэл зүйч үзүүлнэ. Эрүүл мэндийн ажилтан сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлнэ.
<b>Нийгмийн халамжийн үйлчилгээ</b>	Хохирогчид нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх нь журмаар хэрэгжинэ.
<b>Хүүхэд хамгааллын үйлчилгээ<sup>36</sup></b>	Хүүхэд хамгааллын анхан шатны болон хоёрдогч шатны урьдчилан сэргийлэх, хамгаалах, холбон зуучлах үйлчилгээг Хамтарсан баг үзүүлнэ. Тусгай хамгаалалтаар хангах, дэмжих, холбон зуучлах үйлчилгээг асуудал эрхэлсэн төрийн байгууллага, магадлан итгэмжлэгдсэн байгууллага, хүн үзүүлж, хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдал сайжирсан эсэхэд үйлчилгээний үнэлгээ хийж, эргэх холбоотой ажиллана. ГБХ-д өртсөн хүүхэд 7 түүнээс дээш настай бол хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ хүүхдийн саналыг харгалзана.
<b>Эрх зүйн туслалцаа</b>	Эрх зүйн зөвлөгөөг ГБХ-тэй тэмцэх чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн ТББ, мөн хамтарсан ба биечлэн болон утсаар цахим хэлбэрээр үзүүлнэ. Бүх шатны засаг дарга хохирогч хүүхдэд эрх зүйн зөвлөгөөг цахим хэлбэрээр үзүүлэх боломжийг бүрдүүлнэ. ГБХ-д өртсөн хүүхдэд 107, 108 дугаарын утсаар эрх зүйн зөвлөгөөг үнэ төлбөргүй өгнө. Хохирогч хүүхэд 7-с дээш настай бол өөрийн саналыг харгалзан үзнэ.
<b>Холбон зуучлах үйлчилгээ<sup>37</sup></b>	Хохирогчид эхэлж холбоо тогтоосон байгууллага, ажилтан нь холбон зуучлах үйлчилгээг төлөвлөх, байгууллага, мэргэжилтэнд шилжүүлэх, үйлчилгээний үр дүнд хяналт тавих, үнэлэх зэргээр кейс хаах хүртэл зохицуулалтыг бүрэн хийнэ.

Хуульд заасан эдгээр үйлчилгээг НЦҮТ болон түр хамгаалах байраар дамжуулан хүргэж байна. ИНБ-ын нөлөөллийн ажлын үр дүнд<sup>38</sup> түр хамгаалах байр, НЦҮТ байгуулах ажлыг Монгол Улсын Засгийн газраас бодлогоор дэмжиж Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2009 оны 308/189/129 дугаартай хамтарсан тушаалаар НЦҮТ байгуулах тухай шийдвэрийг гаргаж байсан.

Тэгвэл өнөөдрийн байдлаар эрүүл мэндийн байгууллага, цагдаа, ГБХЗХГ болон ТББ-ыг түшиглэсэн 23 түр хамгаалах байр, 18 НЦҮТ үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж байна.

**Хүснэгт 16. Үндэсний хэмжээд үйл ажиллагаа явуулж буй түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн тоо, 2020 оны 10 сарын байдлаар**

Байгууллагын төрөл	Түр хамгаалах байр	НЦҮТ
Эрүүл мэндийн байгууллагад түшиглэсэн	0	3
Цагдаагийн байгууллагад түшиглэсэн	4	2

34 Хохирогчдоод эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам

35 Хохирогчид сэтгэлзүйн зөвлөгөө үзүүлэх журам

36 ГБХд өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх журам

37 Холбон зуучлах үйлчилгээний журам

38ХЭҮТ нь хамгийн анхны хамгаалах байрыг байгуулан ажиллаж байсан. Тэдний нөлөөллийн ажлын үр дүнд төр анх удаа Нэг цэгийн үйлчилгээний төвийг байгуулах ажлыг эхлүүлсэн учир ийм дүгнэлтийг хийсэн.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт түшиглэсэн	17	13
Төрийн бус байгууллагад түшиглэсэн	2	0
<b>Нийт</b>	<b>23</b>	<b>18</b>

Дээрх түр хамгаалах байр, НЦҮТ-ийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас үзэхэд **ойролцоогоор нийт үйлчлүүлэгчдийн 5 орчим хувийг ХБХ эзэлдэг байна.**

Тус тоон мэдээллийг нарийвчлалтай авч ГБХ-д өртөн хамгааллын үйлчилгээ авсан ХБХ-ийн тоон мэдээлэлд шинжилгээ хийх зорилгоор эдгээр төвүүдээр үйлчлүүлсэн ХБХ-ий тоон мэдээллийг цуглуулахаар судалгааны багаас албан хүсэлт илгээсэн. Гэвч холбогдох байгууллагуудаас ирсэн хариунаас үзэхэд **үйлчлүүлэгчийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр тоон мэдээлэл задарч гарах боломжгүй, тус ангиллаар үйлчлүүлэгчийн мэдээллийг харгалзаж албан ёсоор бүртгэдэггүй байдал ажиглагдлаа.** Жилд цөөн тооны хүнд үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хувьд үйлчлүүлэгчийн мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр гаргаж өгсөн бол олон хүнд хүрч үйлчилдэг байгууллагуудын бүртгэлийн системээс тус ангиллаар мэдээлэл гарах боломжгүй байв.

Хохирогчдын мэдээлэл нарийн, задаргаатай гарах боломжтой байх, ялангуяа үйлчлүүлэгчийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр анхан шатны бүртгэл үүсгэх нь тэдгээр иргэдийн онцлог, тусгай хэрэгцээг хохирогч хамгааллын үйлчилгээнд харгалздаг болох, хохирогч хамгааллын бодлого төлөвлөлт, цаашлаад түүнд шаардагдах төсвийг төлөвлөх суурь нөхцөл юм. Иймд цаашид ГБХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, ялангуяа түр хамгаалах байр, НЦҮТ-үүд үйлчлүүлэгчдийн мэдээллийг “хөгжлийн бэрхшээлтэй эсэх”, түүний төрөл хэлбэрээр нарийвчлан бүртгэдэг болох шаардлагатай байна. Тухайлбал, наад зах нь хохирогчийн нөхцөл байдлыг тодорхойлох “Аюулын зэргийн үнэлгээ хийх асуумж”-д хохирогчийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тодруулсан асуултыг нэмэх нь зүйтэй юм.

ГБХ-ийн хохирогчид хамгааллын үйлчилгээг үзүүлж буй түр хамгаалах байр, НЦҮТ-ийн мэдээллийг харьяа байгууллагаар нь авч үзвэл:

### **1.Эрүүл мэндийн байгууллагад түшиглэсэн НЦҮТ-ийн тухайд:**

2010 онд ХЗДХЯ-ны харьяа Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, ЭМЯ-ны харьяа Гэмтэл согог судлалын үндэсний төв, НЗДТГ-ын Эрүүл мэндийн газрын харьяа Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төвийг тус тус түшиглэн НЦҮТ-ийг байгуулжээ. Эдгээр төвүүдээр үйлчлүүлсэн иргэдийн тоон мэдээллийг авч дор дурдсан хэдий ч үйлчлүүлэгчдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр тоон мэдээллийг нарийвчлан гаргах боломжгүй байна.

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн дэргэдэх НЦҮТ-өөр 2010-2018 оны байдлаар ГБХ-д өртсөн хохирогч нийт 5031 хүн үйлчлүүлсэн ба үйлчлүүлэгчдийн дийлэнх нь бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн хохирогчид байна<sup>39</sup>. Дээрх үйлчлүүлэгч нарт эрүүл мэндийн үйлчилгээ, сэтгэл зүйн болон хууль зүйн туслалцаа, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах үйлчилгээ

39 ЭМЯ, НЭМХ шинэчлэл хүрээлэн, ХЭҮТ, НҮБХАС нарын бүтээл “ГБХд өртөгсдөд тусламж үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн “нэг цэгийн үйлчилгээний төв”-тэй холбоотой бодлогын баримт бигчийн нөхцөл байдлын үнэлгээ” тайлан, 2019 он, Улаанбаатар хот, хуудас 9

үзүүлдэг байна. Тус төв нь нэг албаны дарга, нэг ахлах нийгмийн ажилтан, 3 ээлжийн нийгмийн ажилтны бүрэлдэхүүнтэйгээр 24 цагаар ажиллаж байна.<sup>40</sup>

Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн дэргэдэх НЦҮТ нь 2010-2018 оны байдлаар ГБХ-ийн улмаас хохирсон нийт 968 хүн үйлчилсэн байна. Тус төв нь СБД-ийн хороодын хамтарсан багаас илгээсэн гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн улмаас эрүүл мэндээрээ хохирсон иргэдийг хүлээн авч эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсний дараа шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн эмчийн оношилгоо, эмчилгээнд хамруулж өндөр эрсдэлтэй бол 24-72 цагийн түр хамгаалах байранд байрлуулж эрүүл мэндийн болон нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлж байна.<sup>41</sup>

### **2.Цагдаагийн байгууллагад түшиглэсэн түр хамгаалах байр, НЦҮТ-ийн тухайд:**

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 4 түр хамгаалах байр, 2 нэг цэгийн үйлчилгээний төв үйл ажиллагаа явуулж байгаагаас Нийслэлд нэг, Дорноговь аймагт хоёр, Төв аймагт нэг түр хамгаалах байр ажиллаж байна. НЦҮТ-ийн тухайд Завхан аймагт нэг, Баянзүрх дүүрэгт нэг төв тус тус ажилладаг. Эдгээр төвүүд нь үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах, сэтгэл зүйн болон хууль зүйн туслалцаа, холбон зуучлах үйлчилгээг үзүүлж байна.

Дээрх байруудад 2017-2020/09 сарын байдлаар нийт 365 хүн байрласны 5 хувьд нь ХБХ үйлчлүүлжээ.

**Хүснэгт 17. Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн тоон мэдээллээс хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчдийн тоон мэдээлэл**

	<b>Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгч</b>	<b>2017 он</b>	<b>2018 он</b>	<b>2019 он</b>	<b>2020 он</b>
1	Насанд хүрсэн эрэгтэй хүн	6	2	-	-
2	Насанд хүрсэн эмэгтэй хүн	-	-	2	3
3	Эрэгтэй хүүхэд	-	3	-	-
4	Эмэгтэй хүүхэд	2	1	1	-
	<b>Нийт</b>	<b>8</b>	<b>6</b>	<b>3</b>	<b>3</b>

ЦЕГ-ын ГБХ-тэй тэмцэх хэлтсийн мэдээллээр Төв, Дорноговь, Завхан аймагт байрлах түр хамгаалах байр, НЦҮТ-өөр ХБХ үйлчлүүлээгүй байгаа нь энэ төрлийн үйлчилгээ орон нутаг дахь ХБХ-д илүү хүртээмжгүй байгааг харуулж байна.

### **3.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын түшиглэсэн түр хамгаалах байр, НЦҮТ-ийн тухайд:**

ГБХЗХ-ийн газар, хэлтсийг түшиглэн 17 түр хамгаалах байр, 13 нэг цэгийн үйлчилгээний төв ажиллаж байна. Нийт үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 81 хувийг насанд хүрээгүй хүн эзэлдэг.

**Дүрс 60. Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны тоон мэдээлэл**

**Дүрс 61. Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн үйлчлүүлэгчийн тоо болон байрласан хоног**

<sup>40</sup> Мөн тэнд, хуудас 13

<sup>41</sup> Мөн тэнд, хуудас 19



Эдгээр төвөөр үйлчлүүлсэн хүний мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр нь задаргаатай авах хүсэлт тавьсан боловч үйлчлүүлэгчдийн нэгдсэн тоон мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр задалж гаргах боломжгүй тухай хариу өгсөн. Энэ нь ГБХ-ийн дуудлага, хохирогчид үзүүлж буй анхан шатны үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын нэгдсэн бүртгэлд тус ангиллаар үйлчлүүлэгчийн мэдээллийг бүртгэж авдаггүй болохыг харуулж байв.

#### 4.Төрийн бус байгууллагад түшиглэн байгуулагдсан түр хамгаалах байрны тухайд:

ГБХ-ийн хүчирхийллийн хохирогчийг байрлуулан хамгаалах үйлчилгээ үзүүлж буй дараах хоёр гол ТББ үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүснэгт 18. ГБХ-ийн хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг ТББ-ын мэдээлэл

	Үйлчилгээний төрөл	ХБХ үйлчлүүлсэн байдал
Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	<ul style="list-style-type: none"> <li>Аюулгүй байдлын хамгаалалт</li> <li>Эмнэлгийн тусламж, үйлчилгээ</li> <li>Сэтгэл зүйн үйлчилгээ</li> <li>Нийгмийн халамжийн үйлчилгээ</li> <li>Хүүхдэд хамгааллын үйлчилгээ</li> <li>Эрх зүйн тусалцаа</li> <li>Холбон зуучлах үйлчилгээ зэргийг үзүүлдэг.</li> </ul>	ТББ-аас ГБХ-ийн хохирогчид тусалцаа үзүүлэх чиглэлээр хамгийн туршлагатай нь Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ба 2017-2020 оны 10-р сарын байдлаар нийт 5073 хүнд үйлчилгээ үзүүлсний 2 хувь (n=120) нь ХБХ байна <sup>42</sup> .
Лантуун дохио ТББ Ид шидийн орон төсөл	<ul style="list-style-type: none"> <li>Аюулгүй байдлын хамгаалалт</li> <li>Эмнэлгийн тусламж, үйлчилгээ</li> <li>Сэтгэл зүйн үйлчилгээ</li> <li>Нийгмийн халамжийн үйлчилгээ</li> <li>Хүүхдэд хамгааллын үйлчилгээ</li> <li>Эрх зүйн тусалцаа</li> <li>Холбон зуучлах үйлчилгээ зэргийг үзүүлдэг</li> </ul>	Лантуун дохио төв нь “Ид шидийн орон-1” төслийнхөө хүрээнд ГБХ-д өртсөн хүүхдэд хамгаалах байраар үйлчилдэг. Жилд ойролцоогоор 50-70 хүүхдийг байрлуулан үйлчилгээ үзүүлдэг бөгөөд өнөөдрийг хүртэлх үйлчилгээ авсан хүмүүсийн дунд ХБХ бүртгэгдээгүй байна.

Дээрх төвүүдийн мэдээллээс үзэхэд үйлчлүүлсэн ХБХ-ий тоо нийт үйлчлүүлэгчдийн тоонд харьцангуй бага хувийг эзэлж байна. Тайлангийн өмнөх бүлэгт дурдсанчлан хөгжлийн бэрхшээлтэй байх нь ГБХ-д өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байгааг харгалзан үзвэл үйлчилгээ авсан хүн бага байгаа нь ХБХ зохих шатны хамгааллын үйлчилгээг авч чадахгүй байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна.

42 ХЭҮТ-өөс ирүүлсэн тоон мэдээлэл

Судалгааны явцад эдгээр түр хамгаалах байр, НЦҮТ нь материаллаг орчны хувьд ХБХ-ийг хүлээн авах, үйлчилгээ үзүүлэх дэд бүтцийн хувьд хүртээмжгүй байх нийтлэг шинж ажиглагдаж байсан. Тухайлбал, Түр хамгаалах байр, НЦҮТ-дэд тэргэнцэртэй, харааны бэрхшээлтэй хүн орох боломжгүй, хуулийн болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай дохионы хэлмэрч, хөтөч байхгүй байна<sup>43</sup>. Үүнд, эдгээр төвүүдийн санхүүжилтийн хязгаарлагдмал байдал гол нөлөөг үзүүлж байгаа бөгөөд түр хамгаалах байр, НЦҮТ нь **санхүүжилтийн эх үүсвэргүйн улмаас тогтвортой үйл ажиллагаа явуулж чадахгүй** байна<sup>44</sup>.

Эдгээр үр дүнгээс үзэхэд манай улсын ГБХ-тэй тэмцэх тогтолцоо нь хамгааллын үйлчилгээ авсан ХБХ-ийн тоон мэдээллийг нарийвчлан гаргаж, холбогдох бодлого төлөвлөлтөд ашиглах боломж хязгаарлагдмал байхын зэрэгцээ хамгааллын үйлчилгээ үзүүлж буй төвүүдэд ХБХ-ийг хүлээн авах дэд бүтэц, орчин бүрдээгүй нь ГБХ-д өртсөн ХБХ-ийн зохих хамгааллын үйлчилгээг авахад саад учруулж байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэж түр хамгаалах байр, НЦҮТ-н үйл ажиллагааг тогтмолжуулах, чадавхжуулах, хүртээмжтэй болгоход шаардлагатай үйл ажиллагааны зардлыг **улсын, орон нутгийн төсөвт суулгах шаардлагатай** байна.

#### **Үр дүн 4. ГБХ-д өртсөн ХБХ-д сэтгэл зүйн зөвлөгөө, болон бие даан амьдрах төвийн үйлчилгээг хүргэх хэрэгцээ шаардлага байна.**

ГБХ-д өртсөн ХБХ болон хохирогчид үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөллийн ярилцлагаас үзэхэд ХБХ болон тэдгээрийн асран хамгаалагч нарт нэн тэргүүнд сэтгэл зүйн туслалцаа, зөвлөгөө, нөхөн сэргээх эмчилгээ хэрэгцээтэй байгааг онцолж байв.

ГБХ-ийн хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/74 тоот тушаалаар батлагдсан “Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх журам”-аар зохицуулагдаж байгаа ба нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүйгээр хохирогчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шуурхай, чанартай, хүртээмжтэй, үнэ төлбөргүй хүргэхээр заажээ.

Гэвч судалгаанд хамрагдсан орон нутагт ГБХ-тэй тэмцэх чиг үүрэгтэй оролцогч талуудын төлөөлөл болох 41 алба хаагчтай хийсэн ярилцлагаас үзэхэд, дийлэнх хамгаалах байр, НЦҮТ-д мэргэжлийн сэтгэл зүйч, болон нийгмийн ажилтан ажилладаггүй тул хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх үйлчилгээг үзүүлж чаддаггүй талаар дурдсан байна.

Энэ чиглэлээр ажиллах хүний нөөц орон нутаг дутагдалтайн зэрэгцээ, ажиллаж буй мэргэжилтнүүдийн хувьд ХБХ-ийн онцлог, тусгай хэрэгцээг харгалзаж ажиллах мэдлэг, ойлголт, туршлага дутмаг зэрэг нь хэдийгээр сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг авах хэрэгцээ иргэдийн зүгээс өндөр байвч тэр хэрэгцээ хангагдахгүй байхад голлох нөлөөг үзүүлж байна.

#### **Шигтгээ 73. Сүхбаатар аймаг, харааны бэрхшээлтэй, эмэгтэй**

*Сэтгэл зүйн дэмжлэг, зөвлөгөө их хэрэгтэй байдаг. Цагдаад хандсан үед ойлгодоггүй бараг л буруутгах хандлагатай, эсвэл өрөвдсөн байдалтай байдаг. Сэтгэл зүйчээс зөвлөгөө авах, ярилцах нь уг нь их чухал санагддаг.*

Хоёрдугаарт, ярилцлагын үр дүнгээс үзэхэд ГБХ-д өртсөн ХБХ хүчирхийллийн тохиолдлыг мэдээлдэггүй, шаардлагатай дэмжлэг туслалцаа авах үйлдэл хийхгүй байхад нөлөөлж буй гол хүчин

43 Монголын эмэгтэйчүүдийн сан, “Монгол Улс дах эмэгтэйчүүдийн эрхийн нөхцөл байдал: 2015-2019 он” судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2020 он, хуудас18

44 [http://forum.mn/res\\_mat/2019/SubmissiononDV\\_Sep%2023\\_2019.pdf](http://forum.mn/res_mat/2019/SubmissiononDV_Sep%2023_2019.pdf)

зүйлийн нэг нь хүчирхийлэгчээс эдийн засаг, асаргаа, амьжиргааны нөхцөл байдлын хувьд хараат байх нөхцөл байдал байсан. Нэг хүнээс хараат байх нөхцөл нь эрх мэдлийн тэнцвэргүй харилцааг гэр бүл дотор үүсгэх бөгөөд улмаар ГБХ-ийн эрсдэлийг нэмэгдүүлж байдаг.

Иймд ХБХ-ий нийгмийн оролцоог дээшлүүлэх, асран хамгаалагчаас хараат байх нөхцөлийг бууруулахын тулд түр хамгаалах байр, НЦҮТ-өөс гадна, хувийн туслахын үйлчилгээнд суурилсан бие даан амьдрах төвийн үйлчилгээг эрчимжүүлэх шаардлагатай байна.

2016 онд батлагдсан ХБХ-ий эрхийн тухай хуулийн 32 дугаар зүйлд ХБХ өөртэй нь холбоотой аливаа асуудлаар бие даан шийдвэр гаргах, сонголт хийх, оролцох боломжийг нэмэгдүүлэх зорилгоор ХБХ-ий бие даан амьдрах эрхийг баталгаажуулсан. Тус заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор 2017 онд ХБХ-ийг бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам батлагдсан. Журамд ХБХ-ийг бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэхийн тулд (1) хувийн туслахын үйлчилгээ, (2) харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээ, (3) түр байрлуулан сургалтад хамруулах үйлчилгээг үзүүлэх талаар тусгажээ. Гэвч өнөөдрийн байдлаар тус үйлчилгээг үзүүлэх эрх бүхий бие даан амьдрах төв улсын хэмжээнд тав байгаа бөгөөд үйл ажиллагааны цар хүрээний хувьд хязгаарлагдмал хэвээр байна.

Бие даан амьдрах төвийн үйлчилгээ нь нэгдүгээрт, ХБХ-ийг чадавхжуулах, эрх мэдэлжүүлэх замаар нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, хоёрдугаарт, ХБХ-ий гэр бүлд ирэх ачааллыг бууруулах, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтойгоороо ГБХ-д өртсөн болон өртөх эрсдэлтэй ХБХ-д нэн тэргүүнд шаардлагатай тусламж дэмжлэгийн нэг болж байгаа тул цаашид тус үйлчилгээг өргөн нэвтрүүлэх, холбогдох журмын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

## 2.3 ГБХ-ийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа

*Бүлгийн гол үр дүн:*

- ❖ **Үр дүн 1:** *ГБХ-ийн гэмт хэрэг, зөрчлийн ойлголтын зөрүүтэй байдал нь хэрэг, зөрчлийг шалгах ажиллагаанд саад учруулж байна.*
- ❖ **Үр дүн 2:** *Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн, шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн хэчнээн хувьд нь ХБХ хохирогч болсон талаарх мэдээлэл хаалттай байна.*
- ❖ **Үр дүн 3:** *Хөгжлийн бэрхшээлтэй хохирогч гэмт хэрэг, зөрчлийг шалгаж, шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломж харьцангуй хязгаарлагдмал байна.*

**Үр дүн 1: ГБХ-ийн гэмт хэрэг, зөрчлийн талаар ойлголтын зөрүүтэй байдал нь хэрэг, зөрчлийг шалгах ажиллагаанд саад учруулж байна.**

Ижил төстэй гэмт хэрэг, зөрчлийг ялган зүйлчлэх асуудал манай хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал хэвээр байсаар байна. Энэ нь аливаа гэмт хэрэг, зөрчлийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан шийдвэрлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдэд шударгаар ял оногдуулах, хүний зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэхэд хамгийн их саад төвөг учруулдаг билээ.

Практикт хууль хэрэглээний тулгамдсан асуудал өнөөдрийг хүртэл байсаар байгаа нь манай судалгааны үр дүнд ажиглагдсан. Тухайлбал, ГБХ-ийн зөрчил болон гэмт хэргийн зүйлчлэлийн ялгааг авч үзсэн Улсын дээд шүүхийн тогтоолыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад буруугаар ойлгох явдал байсаар байна.

Тодруулбал, Шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэхь хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын нэмэлт орохоос өмнө<sup>45</sup> Улсын дээд шүүх нь “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргах эрхтэй хэмээн заасан. Энэ хүрээнд ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийг зөв зүйлчлэх талаар хэд хэдэн хэрэг шийдвэрлэсэн тогтоолоороо тайлбарласан байдаг. Тухайлбал<sup>46</sup>:

Хууль тогтоогч Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан ГБХ үйлдэх гэмт хэргийн нэг онцлог шинж нь тухайн зүйлд заасан үйлдлийг гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний эсрэг байнга үйлдсэн тохиолдолд хамаарахаар хуульчилсан болно. Эрүүгийн эрх зүйн онол болон практикт тодорхой үйлдэл, эс үйлдэхүйн давтамжийн шинжийг тодорхойлоход давтан, байнга гэсэн ойлголт хэрэглэдэг бөгөөд байнга гэдэг нь тоон илэрхийллийн хувьд гурав болон түүнээс дээш удаа үйлдэгдсэн байхыг авч үздэг хууль хэрэглээний ойлголт юм.

Иймээс ГБХ үйлдэх гэмт хэргийн бие даасан шинж болох гэр бүлийн хамаарал бүхий хүнийг зодсон гэх үйлдэл нь байнга буюу гурав ба түүнээс дээш давтамжтай үйлдэгдсэн байхыг шаардах ба Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэгт заасан өөр гэмт хэргийн шинжийг агуулаагүй, хохирол, хор уршиг учраагүй, эсхүл өөр салбар эрх зүйд тодорхойлсон хэм хэмжээгээр хариуцлага хүлээгээгүй байхыг багтаан ойлгоно.

Эрүүгийн хуулиар хамгаалагдсан нэг харилцаа буюу хүний эрүүл мэндийн халдашгүй байдалд хохирол учруулсан нэг үйлдлийг тухайн харилцааны доторх өөр зүйл, хэсгээр давхар зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд заасан нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна гэсэн шударга ёсны зарчимд нийцэхгүй тул ГБХ үйлдэж бусдын биед гэмтэл учруулсан нэг үйлдлийг ГБХ үйлдсэн гэмт хэрэг гэж салгаж зүйлчлэх боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, хохирогчийн эрүүл мэндэд хөнгөн, хүндэвтэр болон хүнд хохирол учруулсан шинжээр Эрүүгийн хуулийн холбогдох зүйл, хэсгээр тусдаа зүйлчлэгдээгүй, түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтад заасны дагуу хариуцлага хүлээгээгүй байна, гэр бүлийн хамааралтай байдлыг нь далимдуулан зодсон гурав ба түүнээс дээш удаагийн бие даасан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд заасан шинжийг хангана гэж тайлбарлажээ.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс хийсэн ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн судалгааны тайланд Эрүүгийн хуулийн /2015/ тусгай ангийн 11.7 ГБХ үйлдэх зүйл ангид “Байнга” ГБХ үйлдэхийг гэмт хэрэгт тооцох тухай заасан. Гэвч “байнга” гэх үйлдлийг нотлоход бэрхшээлтэйгээс ял завших явдал гарч байна хэмээн дүгнэсэн байна.

#### Шигтгээ 74.

*...манай аймагт яг одоо эрүүгийн хуулийн 11.7-оор хоёрхон эрүүгийн хэрэг шалгагдсан байхад бусад аймагт болохоор арван хэд хорин хэд гараад явчихсан байдаг. Тэгээд танайхан яаж үзээд байна гэхээр хуулийн ойлголтгүй байдлаас болж байгаа гэдэг. Өөрөөр хэлбэл тухайн орон нутагт шүүх ГБХ-ийг яаж авч үздэгээс шууд хамаараад байна гэдэг дүгнэлтэд хүрсэн. Нэг иймэрхүү зүйл амьдралд харагдаад байна.*

**Цагдаагийн албан хаагчтай хийсэн ярилцлагаас**

45 Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргах... гэснийг Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 07 дугаар тогтоолоор хүчингүй болгосон боловч Монгол Улсын Их Хурал 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан.


46 Улсын дээд шүүхийн 2019 оны 506 дугаартай тогтоол

Энэ нь ч цагдаагийн байгууллагад бүртгэгдэж байгаа ГБХ-ийн гэмт хэрэг, зөрчлийн тоон мэдээллээс харагдаж байна. Тодруулбал, 2019 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн ГБХ-ийн зөрчлийн тоон мэдээ нь бүртгэгдсэн гэмт хэргийн тооноос даруй 43 дахин их үзүүлэлттэй байна.

Эндээс үзвэл ГБХ-ийн чиглэлээр хийгдэж буй сургалт, мэдээлэл харьцангуй их байгаа ч ГБХ үйлдэх гэмт хэргийн нөхцөлд заасан “байнга” үйлдсэн шинжийг практикт ойлгож хэрэглэх явдал ялгаатай байгаа нь гэмт хэрэг, зөрчлийг зүйлчлэх талаар онолын хувьд маргаантай асуудлууд байгааг илтгэж байна.

**Үр дүн 2: Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн, шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн хэчнээн хувьд нь ХБХ хохирогч болсон талаар мэдээлэл хаалттай байна.**

2017 оноос хойш цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн судалгаа болон шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн судалгааг харьцуулан авч үзвэл:



Дээрх тоон мэдээллээс харвал 2018, 2019 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн болон шүүхээр шийдвэрлэгдсэн зөрчлийн хэргийг харьцуулж үзвэл хэргийн шийдвэрлэлт 74.8 хувьтай байна. Мөн дээрх онуудад бүртгэгдсэн болон шүүхээр шийдвэрлэгдсэн ГБХ үйлдэх гэмт хэргийн харьцааг авч үзвэл 77.9 хувьтай байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх процессын хувьд эерэг үр дүнг харуулж байна.

Хэдийгээр ГБХ-ийн зөрчил, гэмт хэргийн шийдвэрлэлт өндөр байгаа боловч шүүхийн практикт шүүхээр шийдвэрлэгдэж буй хэрэг, зөрчилд нийт хэчнээн ХБХ хохирогч болсон тоон мэдээлэл байхгүй байна.

Харин цагдаагийн байгууллагад ГБХ-ийн гэмт хэрэг, зөрчилд 2017 онд 8, 2018 онд 9, 2019 онд 11, 2020 оны эхний 7 сарын байдлаар 8 ХБХ хохирогч болж бүртгэгджээ<sup>47</sup>. Гэвч хохирогч гэж бүртгэгдсэн эдгээр хүмүүс нь гэмт хэрэг эсхүл зөрчлийн алинд өртөж хохирсон нь тодорхойгүй байна.

Иймд цагдаа, шүүхийн практикт аливаа гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг нэгтгэн боловсруулахдаа аль болох дэлгэрэнгүй, хохирогч, холбогдогчийн нийгмийн байдлыг тодорхой оруулах нь зүйтэй байна. ГБХ-д өртсөн хохирогч болон холбогдогчийн хүн ам зүйн мэдээлэл олон үзүүлэлтээр задардаг байх, тоо статистик нарийвчлалтай байх нь тус гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх бодлого хөтөлбөрийг нотолгоод суурилсан байдлаар төлөвлөх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үр дүнтэй явуулахад шинэ арга туршлага нэвтрүүлэхэд ашиглагдах олон давуу талтайг анхаарах нь зүйтэй.

### **Үр дүн 3: Хөгжлийн бэрхшээлтэй хохирогч гэмт хэрэг, зөрчлийг шалгаж, шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломж хязгаарлагдмал байна.**

ХБХ-ий эрхийн тухай хуульд ХБХ-ийг нийгмийн амьдралд эрх тэгш оролцоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг үл тэвчих зарчмыг баримтлах бөгөөд шүүх, прокурор, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаа нь ХБХ-д хүртээмжтэй байна гэж зохицуулсан. Энэ нь шүүх, прокурор болон хууль сахиулах бусад байгууллагын үйл ажиллагаа ямар ч төрлийн ХБХ-д хүртээмжтэй байхаас гадна тэднээс ирүүлэх гомдол, мэдээллийг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байхыг шаардаж байна.

#### ***Нэг. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл гаргах тухайд:***



Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу аливаа гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг гаргах учиртай. Эдгээр хуулиудад гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг амаар, бичгээр эсхүл бусад харилцаа холбооны хэрэгслээр авч болохоор заажээ.

Сүүлийн жилүүдэд шууд тусламжийн үйлчилгээг ХБХ-д хүртээмжтэй болгох, дуудлага мэдээлэл авах мэдээллийн сувгуудыг ХБХ-ий онцлог, тусгай хэрэгцээнд нийцүүлэн хүртээмжтэй хүргэх чиглэлээр тодорхой санаачилгууд хэрэгжсэн байна. Тухайлбал, 2020 оноос ХБХХЕГ, ЦЕГ-ын мэдээлэл шуурхай удирдлагын төв болон үүрэн холбооны операторуудтай хамтран хэл яриа, сонсголын бэрхшээлтэй иргэдэд шуурхай тусламжийн 101, 102, 103, 105 утасны дугаарт мессежээр (SMS) дуудлага өгөх, мэдээлэл авах үйлчилгээг нэвтрүүлээд байна. Тус арга хэмжээ нь одоогийн байдлаар зөвхөн Нийслэлийн 9 дүүргийн иргэдэд үйлчилж байгаа ба тухайн хүний утасны дугаар нь заавал бүртгэлтэй байх шаардлага тавигдаж байна. Өөрөөр хэлбэл, эдгээр шууд тусламжийн дугаарт зөвхөн сонсголын бэрхшээлтэй хүн өөрийн нэр дээр бүртгэлтэй дугаараас хандах боломжтой буюу дурын үүрэн телефоны дугаараас мессеж илгээн гомдол гаргах, дуудлага өгөх боломж хязгаарлагдмал байна.

ГБХ-ийн дуудлага мэдээлэл хүлээн авах 107 утасны хувьд зөвхөн дуудлагаар мэдээлэл авах боломжтой бол, хүүхдийн тусламжийн 108 утсанд сонсголын бэрхшээлтэй хүн гомдол, мэдээлэл гаргахад фейсбүүкийн чатбокс үйлчилгээг ашиглах боломж бүрдсэн байгаа ч энэ нь заавал интернэт, ухаалаг утас, таблет, компьютертой байхыг шаардаж байна.

---

47 ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны 2020.08.19-ны 86/2530 дугаартай албан бичиг



Тус судалгаанд оролцсон ГБХ-тэй тэмцэх чиглэлээр ажиллаж буй төрийн албан хаагчдын ярилцлагын үр дүнд ч мөн тухайн байгууллагад ХБХ, ялангуяа сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй хүнтэй харилцах хэмжээнд бэлтгэгдсэн албан хаагчгүй, ХБХ-ий онцлогт тохирсон мэдээлэл хүргэх орчин, нөхцөл бүрдээгүй байгаа нь ажиглагдаж байлаа.

#### Шигтгээ 75.

*Сонсголын бэрхшээлтэй, хэл ярианы бэрхшээлтэй хүнээс дуудлага мэдээлэл авахад дохио мэддэг хэлмэрч хүний оролцоо зайлшгүй хэрэгтэй. Манайд ийм тохиолдол гарч байсан. Нэг сонсголын бэрхшээлтэй хүн ирээд өөрийгөө хүнд зодуулсан талаар гомдол гаргатай ойлголцдог хүн байгаагүй. Аймгийнхаа нийгмийн бодлогын хэлтэстэй холбогдоод тусалцаа хүстэл бас тийм байхгүй гэсэн. Тэгээд гэр бүлийнх нь хүнийг дуудаж байж ойлголцож байсан.*

#### **Цагдаагийн албан хаагчтай хийсэн ярилцлагаас**

Дээрх үр дүнгээс үзэхэд ГБХ-д өртсөн ХБХ-ээс гомдол мэдээлэл хүлээн авах сувгийг нэмэгдүүлэх санаачилгууд тодорхой хэмжээнд ажил хэрэг болж байгаа нь сайшаалтай байна. Цаашид ХБХ-ий эрх оролцоог дэмжих үндэсний хөтөлбөрийн 3.5.2.4-р зүйлд тусгагдсан “Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүнээс яаралтай тусламжийн дуудлагыг хүртээмжтэй хэлбэрээр хүлээн авах зайн дүрс, ярианы үйлчилгээг нэвтрүүлэх” үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаж, цагдаа, прокурор, шүүхийн байгууллагад ХБХ-ий бэрхшээлийн хэлбэрт тохирсон арга хэлбэрээр хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авах нөхцөлийг хангахад анхаарах шаардлагатай байна.

#### **Хоёр. Гэмт хэрэг, зөрчлийг шалгах ажиллагаанд хэлмэрч оролцуулах тухайд:**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.3 дугаар зүйлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг монгол хэлээр явуулж, төрийн албан ёсны хэл, бичгээр хөтөлж, баримтжуулна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч нь монгол хэл мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлэх чадвар хязгаарлагдмал бол өөрийн эх хэл, эсхүл сайн мэдэх хэл, бичиг, дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан орчуулагч, хэлмэрчийн тусламж авах эрхээр хангагдана гэжээ.

Мөн ХБХ-ий эрхийн тухай хуульд зааснаар шүүх, прокурор, хууль хяналтын байгууллага ХБХ эрх ашгаа хамгаалахад хүртээмжтэй орчныг бүрдүүлэх үүрэгтэй бөгөөд тэдгээрийг текст уншигч, бичигч, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчаар үнэ төлбөргүй хангах ба үйлчилгээний зардлыг улсын төсөвт тусгах тухай заажээ.

Дээр дурдсанчлан гэмт хэрэг, зөрчлийг шалгаж, шийдвэрлэх ажиллагаанд оролцогч этгээд орчуулагч хэлмэрчийн тусламж авах эрхээр хангагдаж буй нь ХБХ-ий эрхийг хангасан зохицуулалт байна. Гэвч

гэмт хэрэг, зөрчлийг шалгаж, шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй ХБХ-ий эрх үүрэг болон холбогдох мэдээллийг тэдний бэрхшээлийн онцлогт нь нийцүүлэн ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр тайлбарлах, хууль ёсны эрх ашгаа хамгаалахад хүртээмжтэй орчныг бүрдүүлэх үүрэгтэй бөгөөд текст уншигч, бичигч, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчаар үнэ төлбөргүй хангах тухай заасан ч хэрэгжилт хангалтгүй байгаа нь тулгамдсан асуудал болоод байна<sup>48</sup>.

Мөн эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах хэлмэрчийн хүрэлцээ хангалтгүй, орон нутагт огт хэлмэрч байдаггүй, хэлмэрч байсан ч дохионы хэлний нэгдсэн стандарт боловсруулагдаагүйгээс орон нутаг бүрд дохионы хэлний хэрэглээнд ялгаа байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байв.

#### Шигтгээ 76.

*Манай аймгийн аль ч байгууллага, сургуульд дохионы хэлмэрч, сэтгэл зүйч байхгүй. Бид олон жилийн ажлын туршлагаараа үүссэн асуудлын шийдэхийг хичээдэг.*

**Цагдаагийн албан хаагчтай хийсэн ярилцлагаас**

Иймд ХБХ, нэн ялангуяа сонсголын бэрхшээлтэй хүмүүс шүүх болон цагдаад хандах, боломж тодорхой хэмжээнд бүрдсэн ч, дохионы хэлмэрчийн хүрэлцээгүй байдлаас үүдэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үр дүнтэй оролцож чадахгүй байна. Улмаар дээрх нөхцөл нь ХБХ-ийг хэргийг орхиж явах, шийдвэр гарахаас өмнө хэргийг хэрэгсэхгүй болгоход хүргэж байна<sup>49</sup>. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу сонсголын бэрхшээлтэй хүмүүс эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагаанд дохионы хэлний хэлмэрчийн тусламжийг авах боломжтой хэдий ч хэлмэрчийн зардлыг улсын төсөвт тусгадаггүй нь дээрх нөхцөл байдлыг үүсгэж байна.

Иймд нэгдэн орсон олон улсын конвенцоор хүлээсэн үүргээ шударгаар биелүүлж, үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ХБХ-ийг дохио зангааг хэлмэрчилж, гэмт хэрэг, зөрчлийг шалгаж шийдвэрлэх ажиллагааг үр дүнтэй явуулахын тулд хэлмэрчид төлөх зардлын төсвийг шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна.

#### **Гурав. Хөгжлийн бэрхшээлтэй хохирогчид өмгөөлөл, хууль зүйн туслалцаа үзүүлэх тухайд:**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлд хохирогч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй хэмээсэн ч төрөөс ХБХ-д шаардлагатай хууль зүйн зөвлөгөө, тусламж үйлчилгээгээр үнэ төлбөргүй хангагдах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай хуулийн заалтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Хэдийгээр 2019 онд баталсан Өмгөөллийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд “нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хэлбэр, журмыг Өмгөөлөгчдийн Холбооны Удирдах зөвлөл батлах, төлбөрийн чадваргүй хүнд хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг Өмгөөлөгчдийн Холбоо эрх

<sup>48</sup> Зөрчлийн тухай хууль болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхсан заалт буй эсэхэд үнэлгээ хийх, бусад орны хууль тогтоомжийн талаар харьцуулсан судалгаа, Хууль зүйн үндэсний хүрээлэн, УБ.,2018

<sup>49</sup> МХҮХ, МТИҮХ, МХБИҮХ-ноос НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн хороонд хүргүүлсэн тайлан

бүхий байгууллагатай хамтран зохион байгуулах тухай заасан. Гэвч хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх харилцааг зохицуулсан тус журам өнөөдрийн байдлаар батлагдан гараагүйгээс үзэхэд төлбөрийн чадваргүй хохирогч хууль зүйн туслалцаа авах эрх зүйн үндэс бүрдээгүй байна<sup>50</sup>.

Өөрөөр хэлбэл, төлбөрийн чадваргүй хохирогчид хууль эрх зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэхийг өмгөөлөгчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд шийдвэрлэхээр хуульд заасан хэдий ч түүнийг зохицуулах журам батлагдан гараагүй нь хөгжлийн бэрхшээлтэй хохирогч хуулиар олгогдсон эрхээ эдлэх баталгааг эрх зүйн түвшиндээ бүрдээгүйг харуулж байна.

Төр ийнхүү төлбөрийн чадваргүй хохирогчийн өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаажуулаагүйгээс бодит байдал дээр ХБХ-ий эрх, ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг энэ чиглэлээр ажиллаж буй төрийн болон ТББ-ууд өөрсдийн хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийнхөө зардлаас шийдвэрлэж ажиллаж буй туршлагауд цөөнгүй байна.

#### Шигтгээ 77.

*2018-2020 онуудад хөгжлийн бэрхшээлтэй 3 хүүхдийн бэлгийн эрх чөлөөнд халдсан, хүчирхийлсэн хэрэгт манай байгууллага үйлчилгээ үзүүлж ажилласан байгаа. Хэрэг шийдвэрлэх үйл ажиллагаа нь амжилттай явж байна. Үүнд манай байгууллага гэрээт өмгөөлөгчөөрөө дамжуулан өмгөөллийн үйлчилгээг үзүүлсэн ба өмгөөлөгчийн хөлсийг дотоод нөөц бололцоогоороо шийдсэн.*

**Цагдаагийн албан хаагчтай хийсэн ярилцлагаас**

Иймд аливаа гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирсон, төлбөрийн чадваргүй хохирогчдод өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаатай хангах үүднээс “Өмгөөлөгчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх журам”-ыг яаралтай батлах, үүнд хохирогчийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс хамааран ХБХ-ий онцлог, тусгай хэрэгцээг хангаж ажиллах чадвартай, туршлагатай өмгөөлөгчийн туслалцааг авахтай холбоотой харилцааг тусгахад анхаарах шаардлагатай.

## 2.4 ГБХ-тэй тэмцэх чиглэлээр талуудын хамтын ажиллагаа

Бүлгийн гол үр дүн:

- ❖ **Үр дүн 1:** ГБХ-тэй тэмцэх чиглэлээр Үндэсний хэмжээнд талуудын хамтын ажиллагаа хэвийн явагдаж байгаа хэдий ч бодлого, төлөвлөлтийн түвшиндээ ажлуудын уялдаа, залгамж холбоо сул байна.
- ❖ **Үр дүн 2:** ГБХ-тэй тэмцэх чиглэлээр орон нутгийн түвшинд талуудын уялдаа холбоог хангахад үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын удирдлага, зохион байгуулалтын төвөгтэй байдал нь хүндрэл учруулж байна.

ГБХ-тэй тэмцэх чиглэлээрх талуудын хамтын ажиллагааг үндэсний хэмжээнд болон орон нутгийн түвшинд авч үзлээ:

### Нэг. Үндэсний хэмжээний хамтын ажиллагаа:

ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтад “ГБХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг нэгдсэн удирдлагаар

<sup>50</sup> Эрүүгийн болон зөрчлийн хэрэг шалгах, шийдвэрлэх ажиллагаанд хуульч бус шүүхэд төлөөлөх эрхтэй өмгөөлөгч оролцдог тул Монголын Хуульчдын холбоо энэ үйл ажиллагаанд хамааралгүй болно.

хангах” гэж заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/27 дугаар тушаалаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд ГБХ, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх дэд зөвлөл байгуулагдан тус гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, оролцогч талуудын мэргэжлийн удирдлагаар хангах, талууд хоорондын үйл ажиллагааг уялдуулах, нэгдсэн удирдлагаар хангах үүргийн хүрээнд ажиллаж буй талаар өмнөх бүлгүүдэд дурдсан.

Дэд зөвлөл үндэсний хэмжээнд ГБХ-тэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагааг удирдан, зохион байгуулахдаа төр, төрийн бус, олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж байна. Тухайлбал, ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах төсөл хөтөлбөрийн хүрээнд ОУБ-тай хамтран ажиллаж байна:

- НҮБ-ын Хүн амын сангийн “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”,
- Азийн хөгжлийн банкны “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг ГБХ-тэй тэмцэх төсөл”,
- Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO) олон улсын байгууллагын “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”,
- Хүүхдийг ивээх сангийн “Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төсөл тус тус хэрэгжиж байна.

Дээрх төслүүдийн удирдах зөвлөлд ГХУСАЗЗАА, ХНХЯ, ЦЕГ, ГБХЗХГ зэрэг төрийн байгууллагууд, ХЭҮТ, ХТЭТ зэрэг байгууллагуудын төлөөлөл орж ажиллаж байгаагаас үзэхэд ГБХ-тэй тэмцэх чиглэлээр төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагааны түвшинд үндэсний хэмжээний хамтын ажиллагаа хангагдаж байна гэж үзэж болохоор байна.

Гэвч, талуудын хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд давхардал гарах, уялдаа, залгамж холбооны асуудал сул хэвээр байгаа нөхцөл ажиглагдсан нь ГБХ-тэй тэмцэх чиглэлээр нэгдсэн бодлого, бодлогын түвшний хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатайг харуулж байлаа. Өөрөөр хэлбэл, ГБХ-тэй тэмцэх чиглэлээр төсөл хөтөлбөр, үйл ажиллагаа нь бодлогын түвшиндээ нэгдсэн удирдлагагүй, тал бүрд байгууллагынхаа үйл ажиллагааны үндсэн чиглэл, байршил, цар хүрээ, санхүүгийн нөөцдөө тулгуурлан харилцан уялдаа, залгамж холбоогүй явагдаж байгаа шинжтэй байна. Төсөл хөтөлбөрүүд тодорхой хугацаанд төлөвлөсөн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжээд дуусах хэдий ч дараагийн төсөл хөтөлбөрүүд өмнөх ажлуудын хүрсэн амжилтыг үргэлжлүүлэх ажлыг төлөвлөгөөндөө харгалзах, тогтвортой байдлыг нь дэмжих, үйл ажиллагаатайгаа уялдуулах зэрэг төлөвлөлтийн түвшний уялдаа холбоо, хамтын ажиллагаа дутагдаж байна.

#### Шигтгээ 78.

*Би ГБХ-ийн чиглэлээр маш олон судалгаанд оролцсон. Асуудал ерөөсөө сайжирдаггүй, өөрчлөлт гардаггүй, түүнээс гадна энэ олон явж буй судалгаа, сургалт, нөлөөллийн ажлууд хоорондоо ямар ч уялдаагүй байдаг юм шиг. Нэг байгууллагаас ирээд нэг сургалт гэнэ, судалгаа гэнэ, ахиад өөр байгууллагаас ирээд ахиад л ижилхэн юм ярина, асууна.*

**Хамтарсан багийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас**

Иймд ГБХ-тэй тэмцэх чиглэлээр талуудын хамтын ажиллагааг үндэсний хэмжээнд сайжруулахын тулд ГБХ-ийн чиглэлээр төрийн баримталж буй бодлого, хууль тогтоомж, хэрэгжиж буй журам, тэдгээрийн хэрэгжилттэй холбоотой төсөл хөтөлбөрүүдийн мэдээлэл, уялдаа холбоог агуулсан, жил тутмын салбарын мэдээллийн эмхэтгэл гаргах замаар оролцогч талуудыг мэдээллээр хангаж, цаашдын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулахыг судалгааны багийн зүгээс санал болгож байна.

**Хоёр. Орон нутгийн хэмжээний хамтын ажиллагаа:**

Орон нутгийн түвшинд ГБХ-ээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, түүнд хамаарах талуудын уялдаа холбоог хангах үүргийг ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймаг, нийслэл, сум, дүүргийн салбар зөвлөл хүлээж байна. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилсан сэргийлэх тухай хуульд зааснаар Аймаг, нийслэл, дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь орон тооны нарийн бичгийн даргатай байх бөгөөд орон тооны ажлын алба байна гэж заажээ.

Үндэсний хэмжээнд 21 аймаг, 9 дүүрэгт салбар зөвлөлүүд байгуулагдан ажиллаж байгаагаас Баянхонгор, Дорнод, Завхан аймаг болон Баянзүрх, Хан-Уул дүүргийн ГХУСАЗ салбар зөвлөлийн дэргэд ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилготой дэд зөвлөлүүд<sup>51</sup> ажиллаж байна.

ГБХ-ийн хохирогч хамгааллын асуудлыг хууль зүй, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаас нь бүхэлд нь хууль, журмаар зохицуулсан боловч тэдгээрийн хэрэгжилтийг хангахад орон нутгийн түвшний холбогдох байгууллагуудын зохион байгуулалттай холбоотой хэд хэдэн хүндрэл бэрхшээл тулгарч байна.

Тухайлбал, ГБХ-ийн хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлдэг дийлэнх нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр орон нутгийн ГБХЗХХ-ийн дэргэд үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр төв, байрны үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсвөөс, хохирогч хамгааллын зардлыг улсын хүүхэд хамгааллын зардлаас санхүүжүүлдэг<sup>52</sup>. Гэтэл, нөгөө талаас Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд (8.3.5) заасны дагуу ГБХЗХХ-ийн удирдлага, зохион байгуулалт нь босоо тогтолцоогоор хэрэгжиж байна. Өөрөөр хэлбэл, түр хамгаалах байр, НЦҮТ-өөр дамжуулж хохирогчид үйлчилгээ үзүүлж буй гол байгууллагын удирдлага зохион байгуулалт нь босоо хэдий ч санхүүжилтийн эх үүсвэр нь орон нутаг болон бусад эх үүсвэрээс бүрдэж байна. Тухайлбал, зарим орон нутагт орон нутгийн төсвөөс түр хамгаалах байр, НЦҮТ-ийн үйл ажиллагааны зардал болон төв, байранд ажиллах ажилчдын бүтэц, орон тоо, цалингийн санг шийдээгүйгээс шинээр байгуулагдсан түр хамгаалах байр, НЦҮТ нь ашиглалтад орохгүй хүлээгдэж буй тохиолдол байна. Улмаар энэ нь орон нутаг дахь талуудын хамтын ажиллагаанд үл ойлголцол үүсгэх, шаардлагатай хохирогчид хамгааллын үйлчилгээ хүрч чадахгүй байхад нөлөөлөх эрсдэлийг дагуулж болохоор байна.

---

51 ГХУСАЗЗ-ийн ажлын албаны мэдээлэл

52 Төрийн албан хаагчтай хийсэн ярилцагаас

### 3 ДҮГНЭЛТ

#### НЭГ. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ГБХ-Д ӨРТӨЖ БУЙ БАЙДАЛ:

Судалгаанд хамрагдсан нийт ХБХ-ий 74 хувь нь ямар нэгэн байдлаар гэр бүлийн хүрээнд хүчирхийлэлд өртөж байсан. ГБХ-ийн нийтлэг тохиолдож буй хэлбэр нь сэтгэл санаа болон хянах зан үйлийн хүчирхийлэл байх ба удаад нь бие махбод, эдийн засаг, бэлгийн хүчирхийлэл орж байгаа хэдий ч дийлэнх нь хавсарсан шинжтэй. Нийт ГБХ-д өртсөн ХБХ-ий 80 хувь нь гурав болон түүнээс дээш хэлбэрийн хүчирхийлэлд хавсарсан байдлаар өртсөн.

ХБХ бэрхшээлийн төрлөөс хамааран хүчирхийллийн аль нэг хэлбэрт илүү өртөмтгий байх шинж ажиглагдсан. Тэр дундаа хөдөлгөөний хязгаарлалттай буюу тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн бүх хэлбэрийн хүчирхийлэлд өртөж буй байдал бусад ХБХ-ээс илүү өндөр байв. Үр дүнг үзвэл:

- Сэтгэл санааны хүчирхийлэлд бүх төрлийн бэрхшээлтэй хүмүүс
- Хянах зан үйлийн хүчирхийлэлд хараа, сонсгол, тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүс
- Бие махбодын хүчирхийлэлд хараа, сонсгол, тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүс
- Эдийн засгийн хүчирхийлэлд тулгуур эрхтэн, оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүс
- Бэлгийн хүчирхийлэлд хараа, сонсгол болон тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүс илүү өртсөн байна.

Хүчирхийллийн аюулын зэргийг авч үзвэл хүчирхийлэлд өртсөн нийт ХБХ-ий 42 хувь нь аюулын дунд болон өндөр зэрэгт орж байсан нь эрсдлийн түвшин өндөр байгааг харуулж байсан. Бэрхшээлийн төрлөөр авч үзвэл харааны бэрхшээлтэй хүмүүс аюулын өндөр эрсдэлтэй байдалд орж байжээ.

Эдгээр үр дүн нь ГБХ-ээс урьдчилан сэргийлэх ажлуудыг төлөвлөхдөө хүчирхийллийн хэлбэр тус бүрд илүү өртөмтгий, эрсдэл өндөр бүлгүүдийн онцлог хэрэгцээг харгалзан үзэх хэрэгтэйг харуулж байна. Ялангуяа өөрийн амь насанд аюултай нөхцөлд орсон тохиолдолд хаана хэрхэн хандах, анхан шатны ямар дэмжлэг туслалцаа авах, аюулгүй байдлаа хамгаалуулах талаарх мэдээллийг харааны бэрхшээлтэй хүмүүсийн онцлог, тусгай хэрэгцээнд нийцүүлэн хүргэхийг нэн тэргүүнд анхаарах нь чухал байна.

#### ХОЁР. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ГБХ-Д ӨРТӨХӨД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС:

ГБХ үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлийг “Эмзэг байдлын загвар” (Determinants of Vulnerability Model)-ын дагуу хувь хүн, гэр бүл, олон нийт болон тогтолцооны түвшинд тодруулахыг зорьсон. Түвшин тус бүрийг хэмжсэн шалгуур үзүүлэлтийн нөлөөллийг авч үзвэл олон нийт болон тогтолцооны хүчин зүйлс нь ГБХ үйлдэгдэхэд илүү суурь шалтгааны шинжтэй нөлөө үзүүлж буй байдал ажиглагдав. Түвшин тус бүрд нөлөөтэй хүчин зүйлсийг авч үзвэл:

##### 1.Хувь хүний түвшний хүчин зүйлс:

- (1) **Хүйсийн хувьд эмэгтэй байх:** ГБХ-д өртсөн нийт ХБХ-ий 72 хувь нь эмэгтэй байсан. Аль аль хүйсийн ХБХ-тэй хийсэн ярилцлагын үр дүнд хүйсийн хувьд эмэгтэй байх нь хүчирхийлэлд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж буй хүчин зүйл болохыг тодорхой харуулж байв.
- (2) **Гэрлэсэн байх:** ГБХ-д өртсөн эмэгтэйчүүдийн дийлэнхэд нь хүчирхийлэл өөрийнх нь зохиосон хоёрдогч гэр бүлд үйлдэгдсэн байв. Гэрлэсэн эмэгтэйчүүдийн хувьд хянах зан үйлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөж буй байдал гэрлээгүй хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдээс илүү өндөр байгаа нь гэрлэлтийн байдал нь ГБХ-д нөлөөлж буй нэг хүчин зүйл болохыг харуулж байв.
- (3) **Амьдралынхаа эрт үед хөгжлийн бэрхшээлтэй болсон байх:** Бэрхшээлийн түүх нь ГБХ-д өртөх эрсдэлийг нэмэгдүүлж буй эсэх нь бэрхшээлийн төрлөөс хамаараад харилцан адилгүй байсан

боловч, нийтлэг, амьдралынхаа аль үед хөгжлийн бэрхшээлтэй болсон эсэх нь тодорхой нөлөөтэй байгаа нь ажиглагдсан. Төрөлхийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд гэр бүлийн гишүүдээс хамааралтай байдал нь олдмол байдлаар бэрхшээлтэй болсон хүмүүсээс илүү өндөр байсан. Үүнээс олдмол байдлаар, ялангуяа амьдралынхаа хожуу үед бэрхшээлтэй болсон байх тусам ГБХ-д өртөх эрсдэлийг бууруулах хамгаалагч хүчин зүйлс (боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа зэрэг) нэмэгдэх байдал ажиглагдсан.

- (4) **Бэрхшээлийн хүндрэл нэмэгдэх:** ХБХ-ий гэр бүлийн гишүүдээс хамааралтай байдал нэмэгдэх тусам хүчирхийлэлд өртөх нь нэмэгдэж буй зүй тогтол ажиглагдсан. Хамааралтай байдлыг нэмэгдүүлж буй гол хүчин зүйлсийн нэг нь бэрхшээлийн хүндрэлийн түвшин байх ба хүндрэлийн түвшин нэмэгдэх тусам хувь хүний үнэт зүйл, сонголтоос илүү асран хамгаалагчийн сонголт, үг, үйлдлийг дагаж, хувь хүний эрх мэдэл буурч буй байдал нийт хүчирхийлэлд өртсөн ХБХ-ий дунд нийтлэг байв.
- (5) **Өмнө хүчирхийлэлд өртсөн байх:** ГБХ-д өртсөн ХБХ-ий амьдралын түүхээс үзэхэд одоогийн хүчирхийлэлтэй харилцаанаас өмнө өөрийн төрсөн эцэг эх (мөн хойд эцэг эх), ах дүү, хамаатан садан, өмнөх хамтрагч эс бөгөөс олон нийтийн зүгээс ямар нэгэн байдлаар ялгаварлан гадуурхал, хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан. Эдгээр хүмүүс бусад оролцогчидтой харьцуулахад илүү хүчирхийллийг тэвчих, хүлцэх хандлагатай бөгөөд үүнийг "Хүчирхийллийн тойргийн" онолоор тайлбарлавал ГБХ-д өртөхөд нөлөөлж буй хүчин зүйл болж байна.
- (6) **Боловсролын түвшин доогуур байх:** ГБХ-д өртсөн ХБХ-ий 86 хувь нь бүрэн дунд болон түүнээс доош боловсролтой. Боловсролын түвшин доогуур байх нь (1) бэрхшээлийн түүх буюу төрөлхийн эсвэл олдмол байдлаар бэрхшээлтэй болсон эсэх, (2) гэр бүлийн үл хайхрах байдал болон (3) бусад олон нийт, бүтцийн түвшний хүчин зүйлтэй холбоотой байв. Боловсрол эзэмшээгүй байх нь хөдөлмөр эрхлэх боломжийг бууруулах, улмаар асран хамгаалагчаас хамааралтай байдлыг нэмэгдүүлж, хувь хүний эрх мэдлийг бууруулахад хүргэж байгааг харгалзвал ГБХ-д өртөх эрсдэлийг нэмэгдүүлж буй хүчин зүйлийн нэг болж байна.
- (7) **ГБХ-ийн талаар мэдлэг, ойлголтгүй байдал.** Судалгааны үр дүнгээр ГБХ-ийн талаар мэдээлэлтэй байх нь тусламж, дэмжлэг эрэлхийлэх зан үйлд нөлөөтэй болох нь харагдсан. Гэтэл тус судалгаанд хамрагдсан нийт ХБХ-ий 87 хувь нь ГБХ-ийн талаар хангалттай мэдлэг, ойлголтгүй байв. Өөрөөр хэлбэл, өөрийгөө хүчирхийлэлд өртөж буйгаа мэдэхгүй эсвэл хүлээн зөвшөөрөхгүй байгаа дээрх тооны хүмүүс эрсдэлтэй нөхцөлд орсон үедээ тусламж дэмжлэг эрэлхийлэх, хүчирхийллийг холбогдох байгууллагад мэдээлэх зан үйл сул байна. Иймд ГБХ-ийн талаар хангалттай ойлголтгүй байх нь ГБХ-д өртөх, өртсөн ч тусламж дэмжлэг авч чадахгүй байх, хүчирхийллийг улам даамжруулахад нөлөөлөх хүчин зүйл болж байна.
- (8) **Хөдөлмөр эрхэлдэггүй байх:** ГБХ-д өртсөн 111 оролцогчийн 50 орчим хувь нь хөдөлмөр эрхэлдэггүй. Хөдөлмөр эрхэлдэг ХБХ-ий дунд ч байнгын ажилтай, тогтвортой орлоготой хүн цөөн (11.3 хувь), илүү албан бус секторт, цагаар, өдрөөр хөдөлмөр эрхлэх байдал нийтлэг байв. Хөдөлмөр эрхлэлтийн байдал нь (1) хөгжлийн бэрхшээлийн түүх буюу олдмол, төрөлхийн бэрхшээлтэй эсэх, (2) хөгжлийн бэрхшээлийн хүндрэл, (3) боловсрол эзэмшсэн байдлаас шууд хамааралтай байна. ХБХ-ий хөдөлмөр эрхлэлт бага, тодорхой санхүүгийн эх үүсвэргүй ба оролцогчдын 68.8 хувь нь зөвхөн халамжийн тэтгэврээр амьжиргаагаа залгуулдаг. Энэ нь ХБХ-ийг хүчирхийлэл үйлдэгчээс санхүүгийн хувьд хараат байдалд оруулж, түүний зүгээс үйлдэж буй ГБХ-ийг мэдээлэхгүй байхад нөлөөлж буй хүчин зүйлийн нэг болж байна.

## 2. Гэр бүлийн түвшний хүчин зүйлс:

- (1) **Гэр бүлийн/Өрхийн орлого бага байх:** ХБХ-тэй өрхийн орлогын эх үүсвэрийг тодруулахад ХБХ-ий халамжийн тэтгэвэр болон бусад тэтгэмжийн орлогууд (асаргааны тэтгэмж, хүүхдийн мөнгө, хүнсний талон зэрэг) голлох байр суурийг эзэлж, хөдөлмөр эрхлэлтийн орлогын эзлэх хувь бага байв. Өөрөөр хэлбэл, ГБХ-д өртсөн ХБХ-ий өрхийн амьжиргаа, орлогын түвшин доогуур байгаа нийтлэг дүр зураг ажиглагдаж байна. Энэ нь ХБХ-ийг асран хамгаалж буй хүн нь хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдмал байх, хүүхэд болон ахмад настай хүн олон, хөдөлмөр эрхэлдэг гишүүн цөөн байгаатай холбоотой байв. Өрхийн эмзэг байдал нь гэр бүл доторх зөрчил маргааныг нэмэгдүүлэх, ГБХ үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн нэг болж байв.
- (2) **Өрхийн эрсдэлтэй зан үйл:** ГБХ-д өртсөн гурван хүн тутмын нэг нь архины хамааралтай гишүүнтэй гэр бүлд амьдардаг. Архины хамааралтай гишүүний зүгээс ГБХ үйлдэх байдал тэдгээр бүх оролцогчдод тохиосон байгаагаас үзвэл тус шинж нь ГБХ-д өртөх эрсдэлийг нэмэгдүүлж буй хүчин зүйл болж байна.  
 Үүнээс гадна, гэр бүлийн хэн нэгэн гишүүн гэр бүлээс гадуур харилцаа үүсгэх, эс бөгөөс түүнтэй ижил сэдлээр хардах зан авир тогтмол илрэх нь хүчирхийлэл үйлдэгдэх эрсдэлийг шууд нэмэгдүүлж байв.
- (3) **Гэр бүлийн гишүүдийн эрх мэдлийн тэнцвэргүй байдал:** Хөгжлийн бэрхшээлээс хамаарсан эмзэг байдал нь тухайн хүний гэр бүл доторх эрх мэдлийг бууруулж буй байдал ажиглагдсан. Энэ нь гэр бүлийн шийдвэр гаргалтад тухайн ХБХ-ийг оролцуулахгүй байх, саналыг нь харгалзахгүй байх шинжээр илэрч байв. Ялангуяа, оюун, сэтгэц болон бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүст дээрх байдал илүү ажиглагдсан. Мөн хөгжлийн бэрхшээлийн хүндрэлийн түвшнээс хамааралтай байдал ажиглагдсан ба эрх мэдлийн тэнцвэргүй байдал нь хүчирхийлэл үйлдэгдэх гол хүчин зүйлсийн нэг юм.

### 3.Олон нийтийн түвшний хүчин зүйлс:

- (1) **Олон нийтийн ялгаварлан гадуурхал:** ХБХ-ий олон нийтийн дунд ялгаварлан гадуурхагдах гол шалтгаан нь тэдгээрийн бэрхшээл байх ба энэ нь сургууль завсардах, олон нийтийн үйл ажиллагаанд оролцохоос татгалзах, найз нөхөд, хүрээлэлгүй болоход хүргэхэд нөлөөлсөн гол хүчин зүйл байв. ХБХ-ий ялгаварлан гадуурхал нь гэр бүлийн бусад гишүүдэд ч сөргөөр нөлөөлсөн байх ба ХБХ-д хүндэтгэлгүй хандах, хүчирхийлэл үйлдэх, эрх мэдлийн тэнцвэргүй байдал үүсгэхэд нөлөөлсөн байна. Өөрөөр хэлбэл, олон нийтийн зүгээс ирэх ялгаварлан гадуурхал нь ХБХ-ийг ГБХ-д өртөхөөс хамгаалах хүчин зүйлс (боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх, найз нөхөд, хамт олонтой байх зэрэг)-д сөргөөр нөлөөлж байна.
- (2) **Нийгмийн суурь үйлчилгээ, дэд бүтцийн хүртээмж сул байх:** Хотын захын хороолол, хөдөө орон нутагт тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээ хүртээмжгүй байх, тэгш хамруулах боловсролын хөгжил сул байгаа нь олон талаар ХБХ-ийг боловсрол эзэмших суурь эрхээ эдлэхэд сөргөөр нөлөөлж байна. Мөн ХБХ-ий хувьд нийтлэг авдаг үйлчилгээ нь эрүүл мэнд болон халамжийн үйлчилгээнүүд байх ба тэдгээр үйлчилгээг авахад тухайн байгууллагын болон орон нутгийн дэд бүтцийн хөгжил сул байгаа нь ХБХ-ийг гэрээсээ гарч, бие даан нийгмийн харилцаанд оролцоход саад болж байгаа нь ХБХ-ий гэр бүлийн гишүүдээс хамааралтай байдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлж байв.
- (3) **Олон нийтийн нэгдэл, хөршийн холбоо сул байх:** Цаашид ГБХ-д ахин өртвөл нэн тэргүүнд тусламж эрэх талуудыг тодруулахад хөршөө/хажуу айлаа сонгосон хүн маш бага байв. Судалгаанд оролцогчдын өгсөн мэдээллээс үзэхэд хөдөө орон нутгийн хувьд иргэд хөршүүдээ таних хэдий ч “бусдын амьдралд хошуу дүрэхгүй” гэх хандлага түгээмэл байдгийг дурдаж байсан бол Улаанбаатар хотоос хамрагдсан оролцогчдын хувьд хөршүүдээ “сайн танихгүй”

гэж дийлэнх нь хариулж байгаагаас үзэхэд ГБХ-тэй тэмцэх чиглэлээр олон нийтийн ойлголт мэдлэг, зан үйл сул, тэр хэрээр олон нийтийн нэгдэл, нягтрал бага байгааг харуулж байв.

#### 4.Тогтолцооны түвшний хүчин зүйлс:

- (1) **Жендэрийн талаарх хэвшмэл ойлголт, хандлага:** ГБХ нь эрх мэдлийн тэнцвэргүй байдлаас улбаатай бөгөөд үүнд олон жил уламжлагдаж ирсэн жендэрийн талаарх хэвшмэл ойлголт суурь шалтгааны нөлөө үзүүлж байна. Судалгаанд хамрагдсан ГБХ-ийн хохирогч ХБХ-ий 72 хувь нь эмэгтэйчүүд, тэдгээрийн 40 хувь нь хамтрагчийн зүгээс буюу нөхөр, хамтран амьдрагч, найз залуугийн зүгээс хүчирхийлэлд өртсөн. Харамсалтай нь, судалгаанд оролцогчдын дийлэнх нь хүчирхийллийн талаар мэдлэг ойлголт бага, хамтрагчийн зүгээс хийсэн хүчирхийллийн үйлдлийг байж болох зүйл хэмээн бодохын зэрэгцээ тухайн үйлдэлд өөрийгөө буруутгах байдал ажиглагдсан. Энэ нь жендэрийн хэвшмэл ойлголт эрэгтэй, эмэгтэй аль аль хүйсийн хүмүүсийн дунд нийтлэг байгааг харуулах ба улмаар гэр бүлд хүчирхийлэл үйлдэгдэх, үйлдэгдсэн ч мэдээлэхгүй байх суурь шалтгааны нэг болж байна.
- (2) **Боловсролын чанар, хүртээмжийн хангалтгүй байдал:** Боловсролын түвшин нэмэгдэх тусам ГБХ-ийг мэдээлэх, тусламж дэмжлэг эрэлхийлэх зан үйл нэмэгдэж буй нь судалгааны үр дүнгээс харагдсан. Мөн боловсролын түвшин нэмэгдэх тусам жендэрийн хэвшмэл ойлголтыг хүлээн зөвшөөрөх байдал буурч байгаа нь бусад судалгааны үр дүнд дурдагдсан байна. Эдгээр нь ГБХ-тэй тэмцэхэд олон нийтийн ойлголт мэдлэг, боловсролын түвшин тодорхой эерэг нөлөөтэй болохыг харуулна. Гэвч судалгаа явагдсан орон нутгийн нөхцөл байдлаас үзэхэд боловсролын үйлчилгээний тэгш бус, хүртээмжгүй байдал нь иргэдийн эмзэг байдлыг нэмэгдүүлэх, улмаар гэмт хэрэг, хүчирхийллийн гаралтыг нэмэгдүүлэхэд бүтцийн түвшиндээ нөлөө үзүүлж байгаа нь ажиглагдав. Боловсролын тэгш бус байдлын талаар цогц судалгаа хийгдээгүй ч хүүхдүүдийн ерөнхий боловсрол хэр сайн эзэмших нь эцэг эхийн нийгмийн байдлаас хамаарч хүчтэй ялгаралд орж байна.
- (3) **Ядуурал (ажилгүйдэл):** Судалгаанд хамрагдсан ГБХ-д өртсөн ХБХ бараг бүгд амьжиргааны хувьд доогуур түвшинтэй өрхийн гишүүн байсан нь ГБХ үйлдэгдэж буй өрхийн нийтлэг шинж байв.  
 2018 оны байдлаар манай улсын нийт хүн амын 28.4 хувь нь ядуурлын шугамаас доогуур амьдарч байгаа ба тэдгээр иргэдийн таван хүн тутмын хоёр нь 15-аас доош насны хүүхэд байгаа нь ядуурал өрх дэх хүүхдийн тоо, тэжээгчдийн хувьтай нягт хамааралтай болохыг харуулж байна. Улмаар амьжиргааны түвшин бага, ядуу гэр бүлд өсөх нь хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэлийг нэмэгдүүлэх, зохих түвшний боловсрол эзэмшихгүй байх, үүнийг дагаад хүрэлцээтэй цалин хөлстэй хөдөлмөр эрхлэх боломж буурах, улмаар эдгээр бүх хүчин зүйл нь эцсийн дүндээ гэр бүлийн зөрчил маргаан нэмэгдэх, ГБХ үйлдэгдэх эрсдэлийг нэмэгдүүлэхэд нөлөөтэй.  
 Манай Улсад ядуурлын соёл төлөвших хандлага нэгэнтээ ажиглагдаж эхэлж буйг зайлшгүй анхааралдаа авах нь чухал ба үе дамжсан ядуурал нь сэтгэлгээний ядууралд хөтлөх буюу улмаар түүнтэй тэмцэх, ядуурлаас гарах итгэл үнэмшлийг сулруулдаг нь ядуурлаас үүдэлтэй нийгмийн олон асуудлыг шийдвэрлэхэд хүндрэл учруулах, хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийн үр дүнг сулруулахад нөлөө үзүүлнэ.
- (4) **ГБХ-тэй тэмцэх тогтолцоо ХБХ-д хүртээмжгүй байх:** ГБХ-д өртсөн ХБХ-ий хамгааллын үйлчилгээ авсан байдал нь зөвхөн цагдаагийн байгууллагад дуудлага өгсөн байдлаар хязгаарлагдаж байв. Гэвч энэ нь анхан шатны түвшиндээ эрсдэлийг таслан зогсоож буй нэг удаагийн арга хэмжээ боловч түүнээс цааших, хүчирхийлэгчийн зан үйлд нөлөөлөх, ГБХ давтан үйлдэгдэхгүй байхад чиглэсэн үйл ажиллагааны үр шимийг хүртсэн ХБХ бараг байсангүй.

Үүнээс гадна хөгжлийн бэрхшээлийнхээ онцлог, хязгаарлагдмал байдлаас шалтгаалан ГБХ-ийг мэдээлж, тусламж дэмжлэг авч чадахгүй байх нөхцөл байдал ХБХ-ий дунд түгээмэл байна. Нөгөө талд, ГБХ-ээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах тогтолцоонд ХБХ-ий онцлог, тусгай хэрэгцээг харгалзсан зохицуулалтууд тодорхойгүй орхигдсон нь ГБХ-тэй тэмцэх тогтолцооны оролцогч талуудад хөгжлийн бэрхшээлтэй хохирогч хандсан тохиолдолд хэрхэн бэрхшээлийн онцлог, тусгай хэрэгцээг харгалзан үйлчилгээ үзүүлэх талаар тодорхойгүй байдлуудыг үүсгэж байна.

## **ГУРАВ. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ГБХ-ИЙН ТАЛААР ОЙЛГОЛТ МЭДЛЭГ, ТУСЛАМЖ ДЭМЖЛЭГ ЭРЭЛХИЙЛЭХ ЗАН ҮЙЛ:**

ХБХ-ий ГБХ-ийн талаарх ойлголт, мэдлэгийг тодруулахдаа хүчирхийллийн 5 төрлийн хэлбэр тус бүрийн илрэх үйлдлүүдийг оролцогчид санал болгож эдгээр үйлдлүүд ГБХ-ийн хэлбэр мөн эсэхийг оролцогчдын өөрсдийнх нь байр сууринаас тодруулсан. Ингэхэд ГБХ-ийн талаар бүрэн дүүрэн тайлбар өгсөн, ойлголттой оролцогч нийт оролцогчдын дөнгөж 12 хувийг эзэлж байв. Харин дурдсан хүчирхийллийн хэлбэрүүдийн талаар огт ойлголтгүй буюу аль ч үйлдлийг ГБХ гэж үзэхгүй байсан нь нийт оролцогчдын 43 хувь байгаа нь ХБХ-ий ойлголт мэдлэг маш доогуур байгааг харуулж байсан.

Үлдсэн оролцогчдын хувьд хүчирхийллийн зөвхөн аль нэг хэлбэрийг л таньж байсан ба илүү сэтгэл санаа болон бие махбодын хүчирхийллийн талаар ойлголттой байв. Харин хянах зан үйл, эдийн засгийн болон бэлгийн хүчирхийллийн талаарх ХБХ-ий ойлголт мэдлэг хамгийн бага байна. Нийтлэг тохиолдолд зодож цохиогүй л бол бусад нь хүчирхийлэл биш гэх тайлбар давамгайлж байлаа.

Бэрхшээлийн төрлөөр нь харьцуулж харвал бүх хэлбэрийн хүчирхийллийн талаар харааны бэрхшээлтэй хүмүүс бусад ХБХ-ээс ойлголт мэдлэг сайтай, харин сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн ойлголт мэдлэг хамгийн бага байна.

ГБХ-тэй холбоотой мэдээллийг ямар эх сурвалжаас авсныг тодруулахад (1) телевиз, (2) сошиал медиа, (3) ижил бэрхшээлтэй хүмүүсээс гэсэн хариултыг хамгийн их сонгосон байна. Цаашид мэдээллийг ямар сувгаар дамжуулж хүргэвэл илүү тохиромжтой байгааг тодруулахад бэрхшээлийн төрлөөс хамааран ялгаатай хариултууд дурдагдаж байсан хэдий ч ихэнх оролцогчдын хувьд энэ талаарх мэдээллийг биечилж уулзаж авах хувилбарыг илүүд үзэж байлаа.

Эдгээр үр дүнгээс үзвэл ХБХ-д ГБХ-ийн хүчирхийллийн хянах зан үйл, эдийн засаг болон бэлгийн хүчирхийллийн хэлбэрүүдийг таниулах, эдгээр нь гэр бүл, асран хамгаалагч, ойр дотны хүмүүсийн зүгээс хэрхэн ямар байдлаар илэрч, үйлдэгдэж болох, түүнээс үүдэх эрсдэлийг таниулахад анхаарах нь чухал байна.

Мэдээллийн хүртээмжийн хувьд сонсголын бэрхшээлтэй хүмүүст бэрхшээлийн онцлог, тусгай хэрэгцээг харгалзсан байдлаар мэдээлэл хүргэх хувилбарт аргуудыг нэвтрүүлэх шаардлага байна. Судалгааны үр дүнгээр сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн мэдээлэл, харилцааны сувгийг зөвхөн дохионы хэлээр хязгаарлах нь учир дутагдалтай болох нь харагдсан. Иймд, телевизийн сургийн дохионы хэлмэрчийн дүрс тайлбарын хэмжээг томруулахаас гадна, цөөн энгийн үг хэллэг, текст ашигласан видео контент бэлтгэх, мөн ижил бэрхшээлтэй хүмүүсийн дунд сургагч багш нарыг бэлтгэх зэрэг олон нийтэд түшиглэсэн аргууд илүү үр дүнтэй байхаар харагдаж байна.

## **ДӨРӨВ. МОНГОЛ УЛС ДАХЬ ГБХ-ТЭЙ ТОГТОЛЦОО БА ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХ:**

Манай Улсад ГБХ-тэй тэмцэх тогтолцоо тодорхой хэмжээнд бүрдсэн хэдий ч уг тогтолцоонд ХБХ-ий эрх ашгийг төлөөлөх асуудал хариуцсан байгууллагын үүрэг оролцоо тодорхойгүй, ГБХ-тэй тэмцэх,

урьдчилан сэргийлэх чиглэлээрх бодлогыг тодорхойлох үүрэг бүхий “Гэр бүл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”-д ХБХ-ий төлөөлөл багтаагүй зэргээс үзэхэд ХБХ-ий эрх ашгийг хамгаалах төлөөлөл бодлогын түвшиндээ орхигдсон гэж үзэж болохоор байна. Иймд бодлогын түвшинд талуудын тэгш оролцоог хангах үүднээс ХБХХЕГ болон бусад ХБХ-ийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн төлөөллийг Дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд оролцуулах нь зүйтэй байна.

Тогтолцооны үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдлыг авч үзэхэд ГБХ-тэй тэмцэх анхан шатны нэгж болох хамтарсан багийн үйл ажиллагааны төсөв хэдийгээр улсын болон орон нутгийн төсөвт тусгагддаг боловч өнөөдрийн байдлаар хүрэлцээгүй байна. Иймээс ГБХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж буй төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог хангаж, үйл ажиллагаагаа тасралтгүй, шуурхай, түргэн хүргэхэд шаардлагатай төсвийг улсын болон орон нутгийн төсөвт одоо байгаагаас нь нэмж суулгах, нэгэнт суусан төсөв зориулалтын дагуу зарцуулагдаж буй эсэхэд хяналт тавих хэрэгтэй байна.

Судалгаанд хамрагдсан ХБХ-д үйлчилгээ үзүүлж буй төрийн болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагын алба хаагч мэргэжилтнүүдийн 90 хувь нь ХБХ-ий эрх, тэдний онцлог хэрэгцээг танин мэдэж, үйлчилгээ үзүүлэх талаар ямар нэгэн сургалтад хамрагдаж байгаагүй гэжээ. Энэ нь зөвхөн судалгаанд хамрагдсан төлөөллийн нөхцөл байдлыг илтгэх боловч нийтлэг ижил дүр зурагтай байгаа нь ажиглагдаж байв. Иймээс ХБХ-ий эрх, хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах, тэдэнд тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагын алба хаагчдад чиглэсэн энэ төрлийн сургалтыг тасралтгүй зохион байгуулах шаардлагатай байна.

Тогтолцооны нөхцөл байдлыг системтэй судлах зорилгоор 4Р-ийн зарчим буюу урьдчилан сэргийлэх, хохирогч хамгаалал, хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаа, хамтын ажиллагаа гэсэн 4 асуудлын хүрээнд нөхцөл байдлыг судалсан. Бүлэг тус бүрээрх судалгааны үр дүнг дүгнэн авч үзвэл:

### **1. Урьдчилан сэргийлэх чиглэлээр:**

- (1) Монгол Улсад ГБХ-тэй тэмцэх эрх зүйн орчин, тогтолцоог бүрдэж, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явагдаж байгаа нь сайшаалтай. Өнөөдрийг хүртэл явж ирсэн энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнг хангалтгүй гэж хэлэх үндэсгүй ч хэт богино хугацаатай, тодорхой үүссэн нөхцөл байдалд нийцүүлэн зохион байгуулж буй шинж ажиглагдаж байна. Аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын эцсийн үр дүнд нь “тухайн гэмт хэргийн гаралт буурах” явдал бөгөөд ийм үр дүнд хүрсэн эсэхийг тогтоох нь ихээхэн ач холбогдолтой юм. Гэтэл “тодорхой үр дүнд” гарах эсэх нь тодорхойгүй богино хугацаатай, тухайн үеийнхээ нөхцөл байдалтай холбогдуулан нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ авсаар байгаа нь нэгдсэн бодлого үгүйлэгдэж буйг илтгэж байна.
- (2) Олон Улсын гэрээ конвенц, ХБХ-ий эрхийн тухай хуульд зааснаар ХБХ ялгаварлан гадуурхагдахаас хамгаалагдаж, аливаа мэдээллийг өөрийн онцлог хэрэгцээндээ нийцсэн байдлаар хүртэх эрхтэй тухай заасан. Гэтэл судалгаанд хамрагдсан ХБХ-ий дийлэнх нь ГБХ-ийн талаар ойлголт, мэдлэггүй, ГБХ-тэй тэмцэх тухай хууль болон энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон тохиолдолд хаана хандахаа мэдэхгүй байх нөхцөл байдал тогтоогдож байгаа нь батлагдсан хууль тогтоомж ХБХ-д хүртээмжгүй байгааг харуулж байна.

### **2. Хохирогч хамгааллын чиглэлээр:**

- (1) ГБХ-тэй тэмцэх тухай хууль нь хохирогч төвтэй хандлагад суурилсан, төрийн байгууллагуудын чиг үүрэг болоод салбар дундын хамтын ажиллагаа, зохион байгуулалтыг тодорхой болгосны зэрэгцээ, хохирогчдод үзүүлэх үйлчилгээг төрөөс үнэ төлбөргүй үзүүлэх болсон зэргийг харгалзвал ГБХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчинд тодорхой эерэг ахиц дэвшлүүд гарсан байна. Гэвч тус хуульд ХБХ-ий эрх ашгийг хамгаалах, хохирогч хамгааллын үйлчилгээнд онцлог, тусгай хэрэгцээг харгалзах талаар тодорхой заалт тусгагдаагүйгээс үзэхэд хүчирхийлэлд өртсөн ХБХ рүү чиглэсэн хохирогч хамгааллын зохицуулалт хангалтгүй байна.
- (2) Эрх зүйн орчинд ХБХ-ий онцлог, тусгай хэрэгцээг хангасан зохицуулалт дутагдалтай байгаагийн үр дүн нь бодит байдалд хамгааллын үйлчилгээ авсан ХБХ-ий тоо маш бага байгаа тоон мэдээллээр баталгаажиг байна. Хэдий хөгжлийн бэрхшээлтэй байх нь ГБХ-д өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байгаа хэдий ч үйлчилгээ авсан хүн бага байгаа нь ХБХ зохих шатны хамгааллын үйлчилгээг авч чадахгүй байгааг харуулж байлаа. Тухайлбал, түр хамгаалах байр, НЦҮТ нь материаллаг орчны хувьд ХБХ-ийг хүлээн авах, үйлчилгээ үзүүлэх дэд бүтцийн хувьд хүртээмжгүй байна. Түр хамгаалах байр, НЦҮТ-дэд тэргэнцэртэй, харааны бэрхшээлтэй хүн орох боломжгүй, хуулийн болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай дохионы хэлмэрч, хөтөч байхгүй байна.
- (3) ГБХ-тэй тэмцэх тухай хуульд заасан хохирогч хамгааллын 7 төрлийн үйлчилгээг үзүүлэхээр эрүүл мэнд, цагдаа, ГБХЗХГ болон ТББ-ыг түшиглэсэн 23 түр хамгаалах байр, 18 НЦҮТ үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж байна. Гэвч эдгээр байгууллагуудаас үйлчлүүлэгчийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр тоон мэдээлэл задарч гарах боломжгүй, тус ангиллаар үйлчлүүлэгчийн мэдээллийг албан ёсоор бүртгэдэггүй байдал ажиглагдлаа. Хохирогчдын мэдээлэл нарийн, задаргаатай гарах боломжгүй, ялангуяа үйлчлүүлэгчийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр анхан шатны бүртгэл үүсэхгүй байх нь ХБХ-ий онцлог, тусгай хэрэгцээг хамгааллын үйлчилгээнд харгалзах, хохирогч хамгааллын бодлого төлөвлөлт, цаашлаад түүнд шаардагдах төсвийн төлөвлөлтөд ашиглах суурь тоон мэдээлэл гарах боломжгүй байгааг харуулж байна.

### **3.Хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр:**

- (1) Улсын дээд шүүхээс 2019 оны 506, 633 дугаар тогтоолоороо ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийг хэрхэн ялган зүйлчлэх талаар тайлбарласан боловч түүнийг практик үйл ажиллагаанд ашиглахгүй байх, буруу ойлгож хэрэглэх явдал өнөөдрийг хүртэл байсаар байна.
- (2) Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болон холбогдон шалгагдаж буй хүмүүсийн хэдэн хувь, шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг, зөрчлийн хохирогч, холбогдогчийн хэдэн хувь нь ХБХ болох нь тодорхойгүй байна.
- (3) Эрүүгийн болон зөрчлийн хэрэг шалгаж, шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй ХБХ тухайн ажиллагаанд оролцох боломж хязгаарлагдмал байдаг нь мэргэжлийн дохионы хэлмэрч орчуулагчийн дутагдал, төлбөрийн чадваргүй байдал, төрөөс төлбөрийг нь төлөх зохицуулалттай ч төсөв нь шийдвэрлэгдээгүй байдал, хууль тогтоомжид заасан эрх, үүрэгтэйгээ өөрийн бэрхшээлийн онцлогт тохирсон байдлаар танилцах боломжгүй байдагтай холбоотой байна.
- (4) Судалгааны үр дүнгээр ХБХ нь амьжиргааны баталгаажих түвшин доогуур, төлбөрийн чадваргүй байгаа харагдаж байна. Гэтэл манай улсын эрх зүйн зохицуулалтаар төлбөрийн чадваргүй хохирогч өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авах боломж бүрдээгүй байна. Өөрөөр хэлбэл УИХ-аас 2013 онд баталсан Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх

хууль зүйн туслалцааны тухай хууль нь зөвхөн гэмт хэрэг үйлдэж, яллагдагчаар татагдсан этгээдэд хамаарах зохицуулалт юм. Хэдийгээр 2019 онд баталсан Өмгөөллийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд “нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хэлбэр, журмыг Өмгөөлөгчдийн Холбооны Удирдах зөвлөл батлах тухай, төлбөрийн чадваргүй хүнд хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг Өмгөөлөгчдийн Холбоо эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулна” гэж заасан ч энэ журам өнөөдрийг хүртэл батлагдаагүй байгаа нь төлбөрийн чадваргүй хохирогч хууль зүйн туслалцаа авах эрх зүйн үндэс бүрдээгүй байгааг харуулж байна.

#### **4.Хамтын ажиллагааны чиглэлээр:**

- 1) ГБХ-тэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагааны түвшинд талуудын хамтын ажиллагаа хэвийн байгаа боловч энэ чиглэлээр хэрэгжүүлж буй ажлууд нь бодлогын түвшиндээ нэгдсэн удирдлагагүй, тал бүрд байгууллагынхаа үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилтот байршил, цар хүрээ, санхүүгийн нөөцдөө тулгуурлан харилцан уялдаа, залгамж холбоогүй явагдаж байгаа шинжтэй байна. Иймд ГБХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлуудыг төлөвлөхдөө өмнө хийгдсэн ажлуудын хүрсэн амжилтыг үргэлжлүүлэх, тогтвортой байдлыг нь дэмжих, үйл ажиллагаатайгаа уялдуулах зэрэг төлөвлөлтийн түвшний уялдаа холбоо, хамтын ажиллагаа дутагдаж байна.
- 2) ГБХ-тэй тэмцэх чиглэлээр орон нутгийн түвшинд талуудын уялдаа холбоог хангахад үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын удирдлага, зохион байгуулалтын төвөгтэй байдал нь хүндрэл учруулж байна. Тухайлбал, түр хамгаалах байр, НЦҮТ-өөр дамжуулж хохирогчид үйлчилгээ үзүүлж буй гол байгууллагын удирдлага зохион байгуулалт нь босоо хэдий ч санхүүжилтийн эх үүсвэр нь орон нутгийн захиргаа болон бусад эх үүсвэрээс бүрдэж байгаа нь хохирогч хамгааллын үйлчилгээг үр дүнтэй, тогтмол, чанартай хүргэхэд хүндрэл учруулж байна.

## 4 САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Дээрх гол дүгнэлтүүдэд үндэслэн судалгааны багийн зүгээс дараах санал, зөвлөмжийг холбогдох талуудад хүргүүлж байна:

### 1. ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

1. ГБХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх гол үүргийг гүйцэтгэж буй анхан шатны нэгж болох хамтарсан багийн үйл ажиллагааг тасралтгүй, түргэн шуурхай явагдах нөхцөлийг бүрдүүлэх, техник, хэрэгслээр хангахад шаардлагатай төсвийг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусган батлах;
2. ХБХ-ий хохирсон, холбогдсон гэмт хэрэг, зөрчлийг шалгаж, шийдвэрлэх ажиллагаанд оролцох дохионы хэлмэрчид төлөх зардлыг улсын төсөвт жил бүр тусган батлах;
3. Төлбөрийн чадваргүй хохирогчид хууль зүйн үнэ төлбөргүй тусалцаа үзүүлэхтэй холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлэх;
4. Хууль тогтоомжийн төслийг батлахдаа ХБХ-ий онцлог, тусгай хэрэгцээг харгалзаж, мэдээллийг олон нийтэд хүргэхээс гадна ГБХ-ээс урьдчилан сэргийлэх, хохирогч хамгааллын үйлчилгээг хүртээмжтэй авах боломжийг бүрдүүлэх асуудлыг анхааран үзэх;

### 2. ГҮЙЦЭТГЭХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

#### Монгол Улсын Засгийн газарт:

1. ГБХ-тэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой тусгасан Үндэсний хөтөлбөрийг нэн яаралтай батлан, хэрэгжүүлэх;
2. Батлагдсан хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичгүүдийн талаарх мэдээллийг ХБХ-д хүртээмжтэй байдлаар хүргэх ажлыг зохион байгуулах замаар ХБХ-ий хууль тогтоомжийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх;
3. ГБХ-ээс урьдчилан сэргийлэх, хохирогчдод тусалцаа үзүүлэхэд шаардлагатай төсвийг улсын болон орон нутгийн төсөвт жил бүр суулгах;
4. ГБХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтарсан баг болон бусад шатны төрийн албан хаагч зориулсан сургалтын агуулгад ХБХ-ий онцлог, тусгай хэрэгцээний талаар агуулгыг тусгах, сургалтаар өгөгдөж буй мэдээлэл нь хууль тогтоомжийн агуулгыг бүрэн, үнэн зөв илэрхийлж буй эсэхэд хяналт тавих замаар цаашид энэ чиглэлээр явагдаж буй бүхий л сургалтыг нэгдсэн арга зүйн удирдлагаар хангах;
5. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байруудыг ХБХ-ийн онцлог, тусгай хэрэгцээг харгалзаж, түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин нөхцөл, үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлэх;
6. Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд ажиллах боловсон хүчний асуудлыг орон нутгийн удирдлагатай зөвшилцөн томилох, чөлөөлөх асуудлыг журамлах;
7. Нийгмийн ажилтан, сэтгэл судлаач нарыг бэлтгэж буй их, дээд сургуулийн хичээлийн хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварт суурилсан ойлголт, ХБХ-ий онцлог, тусгай хэрэгцээг мэргэжлийн үйлчилгээндээ хэрхэн харгалзаж ажиллах талаар агуулгыг тусгах, төгсөгчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх замаар орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

#### Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэдэх ГБХ, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд ХБХХЕГ-ын болон бусад ХБХ-ий эрхийг хамгаалах чиглэлээр ажиллаж буй иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оруулах;
2. ГБХ-тэй тэмцэх тухай хуулийг даган гарсан журмуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх замаар ХБХ-ий онцлог, тусгай хэрэгцээг хэрхэн харгалзах, түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин, үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлэх талаар холбогдох зохицуулалтыг тусгах, нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж батлуулахад анхаарах;
3. ГБХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр төр болон төрийн бус, олон улсын байгууллагын хэрэгжүүлж буй үйл ажиллагааны давхардлыг арилгах, уялдуулах, нэгдсэн удирдлагаар хангах байдлаар үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэхэд анхаарах;
4. ГБХ-ийн гэмт хэрэг, зөрчлийн талаарх нөхцөл байдлыг тогтоох, урьдчилан сэргийлэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг нэгтгэсэн тайланг жил бүр оролцогч талуудын оролцоотой бэлтгэн боловсруулж, нийтэд нээлттэй байршуулах;
5. Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв болон, түүгээр үйлчлүүлэгчдийн тоон мэдээллийг нэгтгэх чиглэлээр холбогдох газруудыг нэгдсэн удирдлагаар хангах. Үйлчлүүлэгчийн мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй эсэх, түүний төрлөөр нарийвчлалтай бүртгэдэг болох, тоон мэдээллийг нийтэд нээлттэй байршуулах асуудлыг шийдвэрлэх;
6. ГБХ-ийн төрөл хэлбэр, түүнээс урьдчилан сэргийлэх, ГБХ үйлдэгдсэн тохиолдолд эрх бүхий байгууллагад хэрхэн мэдээлж тусламж дэмжлэг авах талаар олон нийтэд зориулсан мэдээллийг хөгжлийн бэрхшээлийн төрөл тус бүрд тохирох хэлбэрээр зохион байгуулах; Тухайлбал: ГБХ-ийн талаар ойлголт мэдлэг хамгийн багатай сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулж телевизийн дэлгэцийн дохионы хэлмэрчийн дүрс тайлбарын хэмжээг томруулах, цөөн энгийн үг хэллэг, текст ашигласан видео контент бэлтгэх, мөн ижил бэрхшээлтэй хүмүүсийн дунд сургагч багш нарыг бэлтгэх зэрэг олон нийтэд түшиглэсэн аргууд илүү үр дүнтэй байна.

### **Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт:**

1. ХБХХЕГ нь ГБХ, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх Дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд гишүүнээр оролцох хүсэлтээ уламжлах;
2. ГБХ-тэй тэмцэх чиглэлээр гаргасан хууль тогтоомж, эрх зүйн бусад баримт бичиг нь ХБХ-ий онцлог, хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, сайжруулах санал боловсруулж хууль тогтоох, хэрэгжүүлэгч байгууллагад хүргүүлэх;
3. ХБХХЕГ-аас төрийн байгууллага, албан тушаалтнууд, ялангуяа хэрэг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран ХБХ-д өгч болохуйц мэдээллийг бэрхшээлийн хэлбэр, онцлог хэрэгцээнд нийцүүлэн, түгээмэл загвараар бэлтгэх талаар санаачилгатай ажиллах;
4. Гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирсон хохирогчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалан ажиллах өмгөөлөгчдийг мэргэшүүлэн сургахад Монголын Өмгөөлөгчдийн холбоотой хамтран ажиллах;
5. ГБХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж буй төрийн болон иргэний нийгмийн байгууллагын мэргэжилтнүүдэд хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварт суурилсан ойлголтыг өгөх, ХБХ-ий онцлог, тэдэнтэй харилцах, ажиллах арга барил эзэмшүүлэх, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтыг тогтмол зохион байгуулах;
6. ГБХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад үйлчлүүлэгчдийн мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр задаргаатай гаргах, бүртгэлийн санд тус ангиллыг нэмж оруулах талаар хүсэлт тавих; ГБХ-д өртсөн болон холбогдох үйлчилгээ авсан ХБХ-ийн мэдээллийг

- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа” жил тутмын мэдээллийн лавлах номын агуулгад тусгах;
7. ХБХХЕГ-аас хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ дагуу ХБХ-д тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын алба хаагчдад (нийгмийн ажилтан, сэтгэл судлаач, цагдаа, эрүүл мэндийн ажилтан зэрэг хамтарсан багийн гишүүд) нэн тэргүүний ээлжид хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварт суурилсан ойлголтыг танилцуулах, ХБХ-ий онцлог, тусгай хэрэгцээг хэрхэн мэргэжлийн үйлчилгээндээ харгалзаж ажиллах талаар сургалтыг тодорхой хөтөлбөртэйгөөр, тогтмол давтамжтай зохион байгуулах, үр дүнг тооцох;
  8. ХБХ-д үзүүлэх сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг хөгжүүлэх, ялангуяа орон нутагт энэ төрлийн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх төв байгуулах боломж нөхцөлийг судалж, шийдвэрлүүлэх талаар боломжит бүхий л арга хэмжээг авах;
  9. ГБХ-ээс урьдчилан сэргийлэх, өртсөн тохиолдолд хаана, хэнд хандаж зөвлөгөө, тусламж авах, үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ авах эрх зүйн боломжийн талаар бэрхшээлийн хэлбэр, онцлог, тусгай хэрэгцээг харгалзан тохирох хэлбэрээр хүргэх;
  10. ХБХ-ий бие даан амьдрах эрхийг таниулах, хувийн туслахын системд суурилсан бие даан амьдрах үйлчилгээг нэвтрүүлэх, ХБХ-ийг бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журмын хэрэгжилтэд анхаарч ажиллах;
  11. ГБХ-ийн талаар ХБХ-ийн мэдлэг ойлголт хангалтгүйн зэрэгцээ, боловсролын түвшин, бэрхшээлийн хүндрэлтэй холбоотойгоор нийгмийн харилцаанд бие даан оролцох байдал хязгаарлагдмал, улмаар өөрийн нөхцөл байдлыг бүрэн дүүрэн илэрхийлж бусдаас дэмжлэг туслалцаа авах зан үйл сул байгаа тул ХБХ-д зориулсан эрх мэдэлжүүлэлтийн сургалтыг холбогдох төр, ТББ, холбоодор дамжуулан зохион байгуулах (*хөгжлийн бэрхшээлийн тухай, өөрийнхөө асуудлыг оновчтойгоор илэрхийлэх, өөртөө итгэх итгэлтэй болох, асуудлыг танин мэддэг болох зэрэг мэдлэг ойлголттой болгох*);
  12. ХБХ-ий асран хамгаалагчдын нөхцөл байдлыг судлах, тэдэнд рүү чиглэсэн хөгжлийн бодлогыг тодорхойлох

### 3. ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БОЛОН ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

1. Хөгжлийн бэрхшээл болон бусад тусгай хэрэгцээнээс үл шалтгаалан бүх хүн үйлчлүүлэх боломжтой түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын орчин, үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлэх /ингэхдээ Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 256 дугаар тушаалаар баталсан Барилгын норм ба дүрмийг баримтлах/;
2. Шүүх, прокурор, мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллагууд ХБХ өртөж, хохирсон эсхүл холбогдсон эрүүгийн болон зөрчлийн хэргийг шалгаж, шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй алба хаагчдынхаа ХБХ-ий онцлог хэрэгцээг танин мэдэж, түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүнийг хангаж ажиллах талаар сургалтад үе шаттайгаар хамруулах, энэ чиглэлээр ХБХХЕГ-тай хамтран ажиллах
3. Шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагууд иргэдэд чиглэсэн аливаа мэдээ, мэдээллээ ХБХ-ий онцлог хэрэгцээнд нийцүүлэн түгээх;
4. Улсын дээд шүүх 2020 оны 1 сараас хууль тайлбарлах эрхтэй болсонтой холбоотойгоор ГБХ үйлдэх гэмт хэрэг, ГБХ-тэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчлийг хэрхэн ялган зүйлчлэх талаар нэн яаралтай тайлбар гаргах /тухайлбал, сэтгэл санааны хүчирхийлэл, эдийн засгийн хүчирхийлэл, хүчирхийллийг байнга үйлдэх, хүчирхийллийг хүсэл зоригийн эсрэг үйлдэх гэх мэт агуулгыг тайлбарлах/;

5. Аливаа төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого тодорхойлох, шалтгаан, нөхцөлийг тогтооход ашиглах зорилгоор хэрэг, зөрчлийн хамаарах бүх мэдээллээр мэдээллийн сан бүрдүүлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах
6. Шүүх хуралдаанд оролцож буй ХБХ-ий онцлог, тусгай хэрэгцээнд нийцүүлэн дохионы хэлмэрчийг ажиллуулах зааварчилгаа гаргах,
7. Шүүх, прокурор, цагдаагийн байгууллагад хандсан ХБХ-д үйлчилгээ үзүүлэх талаар зааварчилгаа гаргах

#### 4. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

##### Үйлчилгээ үзүүлэгч ТББ-д:

1. ХБХ-ий эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр ажиллаж буй иргэний нийгмийн байгууллагууд нь төрийн болон нутгийн захиргааны байгууллагатай ХБХ-ий эсрэг үйлдэгдэж буй ГБХ-ийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах чиглэлд хамтарч ажиллах;
2. Хамтарсан баг болон бусад шатны үйлчилгээ үзүүлэгч байгууллагын албан хаагч нарт зориулсан ХБХ-тэй харилцах, ажиллах, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой арга зүйн гарын авлагын мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулах;
3. ГБХ-тэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, явуулах сонирхолтой ТББ-ын мэргэжилтнүүдийг сургах сургалтыг үе шаттай зохион байгуулахад холбогдох төрийн байгууллагатай хамтран ажиллах;
4. Хөгжлийн бэрхшээлийн төрөл тус бүрээр дагнасан холбоо, ТББ-ууд нь ГБХ-ээс урьдчилан сэргийлэх, авч болох тусламж дэмжлэгийн талаар мэдээлэл өгөх ажлыг ХБХ-ий онцлог, тусгай хэрэгцээнд нийцүүлэн зохион байгуулах, зохион байгуулахад төрийн байгууллагад дэмжлэг үзүүлэх;

##### Монголын Өмгөөлөгчдийн холбоонд:

5. Хөгжлийн бэрхшээлтэй төлбөрийн чадваргүй хохирогчид үнэ төлбөргүй хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор “Өмгөөлөгчийн нийтэд тустай хөдөлмөр эрхлэх журам”-ыг яаралтай батлах;

#### 5. ТӨСЛИЙН НЭГЖИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

1. ХБХ-ий онцлог, тусгай хэрэгцээнд нийцүүлэн ГБХ-ээс урьдчилан сэргийлэх мэдээллийг түгээх олон талт, дэвшилтэт техник, технологи, программ хангамж, үйлчилгээг судлах, нэвтрүүлэхэд техникийн дэмжлэг үзүүлэх, бусад улс орны сайн туршлагад суурилсан урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг ХБХ-д хүртээмжтэй байдлаар хэрэгжүүлэх талаар арга зүйн дэмжлэг үзүүлэх;
2. Хохирогчид үйлчилгээ үзүүлж буй түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвүүдийг дотоод орчин, тохижилт, тохирох хэрэглэгдэхүүний хувьд бүх төрлийн ХБХ үйлчлүүлэх боломжтой болгон тохижуулж, хүртээмжийн хувьд түгээмэл загварыг баримталсан түр хамгаалах байр байгуулах;
3. ГБХ-тэй тэмцэх тогтолцооны оролцогч талууд, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хүний нөөцийг ХБХ-ий онцлог, тусгай хэрэгцээг үйлчилгээндээ хэрхэн харгалзаж, анхаарч ажиллах талаар мэргэжлийн байгууллагын албан хаагч нард зориулсан гарын авлагыг боловсруулж, албан хаагчдыг сургах;

4. Хамтарсан багийн гишүүдийг сургахдаа, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нараар дамжуулан ХБХ-д ГБХ-ийн төрөл, түүний илрэх хэлбэрүүдийг таниулах, тэр дундаа зан үйл, эдийн засгийн болон бэлгийн хүчирхийллийн хэлбэрүүдийг хэрхэн танин мэдэх, илрүүлэхэд анхаарал хандуулах талаарх арга зүйн чиглэл өгч ажиллах;
5. ГБХ-д өртсөн үедээ хэрхэн тусламж дэмжлэг авах талаар мэдээллийг нэн тэргүүнд ХБХ-д чиглүүлэхээс гадна ХБХ-ийн ойрын хүрээллийн хүмүүс болон хөрш, тухай орон нутаг дахь олон нийтийн зан үйлийг сайжруулахад анхаарах саналыг оролцогч талуудад зөвлөх;
6. Мэдлэг, ойлголт олгох үйл ажиллагаандаа хөгжлийн бэрхшээлийн төрөл, нас, хүйс, байршлын ялгаатай байдлыг харгалзан нэн тэргүүний зорилтот бүлгийг тодорхойлж, тэдгээр бүлэгт хүртээмжтэй арга хэлбэрүүдийг сонгож ашиглах. Тухайлбал:

<b>Хүйсийн хувьд:</b>	<ul style="list-style-type: none"> <li>• ГБХ-д илүү эмэгтэйчүүд өртөх, эрэгтэйчүүд илүү хүчирхийлэл үйлдэх хандлагатай байгаа тул ойлголт, мэдлэг өгөх үйл ажиллагааны агуулгыг хүлээн авагчдын хүйсийн ялгаатай байдалд тохируулж хүргэхэд анхаарах</li> </ul>
<b>Хөгжлийн бэрхшээлийн хувьд:</b>	<ul style="list-style-type: none"> <li>• ГБХ-ийн талаар мэдлэг, ойлголт хамгийн бага сонголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй арга хэлбэрийг сонгоход анхаарах, ингэхдээ сонголын бэрхшээлтэй иргэдийн харилцааны олон талт арга ашигладаг байдлыг харгалзах</li> <li>• ГБХ-ийн төрлүүдэд хамгийн их өртөж буй тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүст ГБХ-ийн хэлбэрүүдийг таниулахад анхаарах</li> <li>• ГБХ-ийн илүү аюул, эрсдэлтэй нөхцөлд өртөж буй харааны бэрхшээлтэй хүмүүст яаралтай нөхцөлд хэрхэн туслалцаа дэмжлэг авч болох талаар мэдээлэл өгөхөд анхаарах</li> </ul>
<b>Насны хувьд:</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Насны бүлгээр 41-50 насны ХБХ ГБХ-д илүү хүлцэнгүй байх хандлагатай байгааг харгалзан дээрх насны бүлгийн ХБХ-д мэдээлэл хүргэхдээ насны бусад бүлгийн иргэдээс илүү зорилтот, зан үйлд нөлөөлөхүйц оролцоонд суурилсан идэвхтэй аргуудыг ашиглах;</li> </ul>
<b>Мэдээлэл хүргэх аргын хувьд:</b>	<ul style="list-style-type: none"> <li>• ХБХ-ийг сургагч багшаар бэлтгэж, орон нутаг дахь ижил бэрхшээлтэй хүмүүст дамжуулан мэдээлэл хүргэх аргыг турших</li> <li>• Ингэхдээ бэрхшээлийн төрөл бүрээр дагнасан орон нутгийн ТББ-тай хамтран ажиллах</li> <li>• ГБХ-ийн талаар мэдээллийг ХБХ-д хүртээмжтэй байдлаар түгээхдээ өргөн нэвтрүүлгийн суваг болон социал платформуудыг ашиглах</li> </ul>

## Хавсралт 1. ХБХ-ий ГБХ-ийн талаар ойлголт, үйлдэл тус бүрээр

Сэтгэл санааны хүчирхийллийн илрэх хэлбэрүүд		Бэрхшээлийн төрөл					Нийт судалгаанд оролцогчдын хувь
		Харааны бэрхшээл	Оюуны бэрхшээл	Тулгуур эрхтний бэрхшээл	Сонсголын бэрхшээл	Бусад төрлийн бэрхшээл	
<b>Нийт</b>		<b>27</b>	<b>34</b>	<b>35</b>	<b>25</b>	<b>29</b>	<b>150</b>
Гэр бүлийн орчинд хэл амаар доромжлох нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	14.8%	23.5%	3.4%	32.0%	20.7%	18.8%
	Үгүй	3.7%	17.6%	20.7%	12.0%	6.9%	12.5%
	Тийм	81.5%	58.8%	75.9%	56.0%	72.4%	68.8%
Бусдын дэргэд дорд үзэх, гутаан доромжлох нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	14.8%	20.6%	3.7%	36.0%	17.2%	18.3%
	Үгүй	18.5%	29.4%	33.3%	20.0%	13.8%	23.2%
	Тийм	66.7%	50.0%	63.0%	44.0%	69.0%	58.5%
Орилох, ашгичих нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	18.5%	17.6%	7.1%	36.0%	27.6%	21.0%
	Үгүй	11.1%	20.6%	21.4%	16.0%	17.2%	17.5%
	Тийм	70.4%	61.8%	71.4%	48.0%	55.2%	61.5%
Юм цохиж хагалах, шидэх зэргээр айлган сүрдүүлэх нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	14.8%	23.5%	3.7%	36.0%	20.7%	19.7%
	Үгүй	11.1%	29.4%	25.9%	24.0%	17.2%	21.8%
	Тийм	74.1%	47.1%	70.4%	40.0%	62.1%	58.5%
Тухайн хүнийг эсвэл бусад түүнийг асарч халамжилдаг хэн нэгнийг хохирооно гэж айлгах нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	18.5%	29.4%	7.7%	40.0%	27.6%	24.8%
	Үгүй	14.8%	29.4%	26.9%	24.0%	20.7%	23.4%
	Тийм	66.7%	41.2%	65.4%	36.0%	51.7%	51.8%



		Бэрхшээлийн төрөл					Нийт судалгаанд оролцогчдын хувь
		Харааны бэрхшээл	Оюуны бэрхшээл	Тулгуур эрхтний бэрхшээл	Сонсголын бэрхшээл	Бусад төрлийн бэрхшээл	
Нийт		27	34	35	25	29	150
Найзуудтайгаа уулзах, гадуур гарахыг хориглох нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	22.2%	23.5%	3.8%	32.0%	17.2%	19.9%
	Үгүй	18.5%	29.4%	46.2%	28.0%	41.4%	32.6%
	Тийм	59.3%	47.1%	50.0%	40.0%	41.4%	47.5%
Төрсөн ар, гэр, хамаатнуудтайгаа холбогдох, харилцах боломжийг хаах нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	18.5%	29.4%	15.4%	32.0%	27.6%	24.8%
	Үгүй	22.2%	32.4%	42.3%	32.0%	27.6%	31.2%
	Тийм	59.3%	38.2%	42.3%	36.0%	44.8%	44.0%
Хаана байгааг нь байнга асууж мэдэх гэж оролдох, хаашаа явж байгаагаа заавал мэдэгдэж байхыг шаардах нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	18.5%	23.5%	7.7%	32.0%	34.5%	23.4%
	Үгүй	7.4%	38.2%	50.0%	20.0%	24.1%	28.4%
	Тийм	74.1%	38.2%	42.3%	48.0%	41.4%	48.2%
Өөр эсрэг хүйсийн хүнтэй ярилцахад уурлах нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	22.2%	32.4%	11.5%	36.0%	31.0%	27.0%
	Үгүй	25.9%	26.5%	46.2%	32.0%	27.6%	31.2%
	Тийм	51.9%	41.2%	42.3%	32.0%	41.4%	41.8%
Эмнэлгийн тусламж авахаасаа өмнө өөрөөс нь зөвшөөрөл авахыг шаардах нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	25.9%	29.4%	15.4%	36.0%	27.6%	27.0%
	Үгүй	29.6%	38.2%	57.7%	36.0%	37.9%	39.7%
	Тийм	44.4%	32.4%	26.9%	28.0%	34.5%	33.3%

		Бэрхшээлийн төрөл					Нийт судалгаанд оролцогчдын хувь
		Харааны бэрхшээл	Оюуны бэрхшээл	Тулгуур эрхтний бэрхшээл	Сонсголын бэрхшээл	Бусад төрлийн бэрхшээл	
Нийт		27	34	35	25	29	150
Алгадаг, гараараа цохих нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	7.4%	17.6%	7.7%	28.0%	10.3%	14.0%
	Үгүй	7.4%	14.7%	21.4%	28.0%	10.3%	16.1%
	Тийм	85.2%	67.6%	71.4%	44.0%	79.3%	69.9%



Эд зүйлээр цохих (Сур, суран бүсээр ороолгох, уургаар ороолгох гэх мэтээр) нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	7.4%	23.5%	8.0%	28.0%	13.8%	16.4%
	Үгүй	11.1%	32.4%	32.0%	28.0%	20.7%	25.0%
	Тийм	81.5%	44.1%	60.0%	44.0%	65.5%	58.6%
Гэмтээж болохуйц зүйл шидэх нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	7.4%	20.6%	11.1%	36.0%	13.0%	17.6%
	Үгүй	7.4%	26.5%	29.6%	24.0%	17.2%	21.1%
	Тийм	85.2%	52.9%	59.3%	40.0%	69.0%	61.3%
Түлхэх, чирэх нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	14.8%	20.6%	3.7%	32.0%	17.2%	17.6%
	Үгүй	11.1%	20.6%	29.6%	28.0%	20.7%	21.8%
	Тийм	74.1%	58.8%	66.7%	40.0%	62.1%	60.6%
Үснээс зулгаах нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	18.5%	20.6%	4.0%	32.0%	17.2%	18.6%
	Үгүй	11.1%	17.6%	28.0%	24.0%	17.2%	19.3%
	Тийм	70.4%	61.8%	68.0%	44.0%	65.5%	62.1%
Өшиглөх нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	11.1%	20.6%	7.7%	32.0%	13.8%	17.0%
	Үгүй	7.4%	14.7%	23.1%	24.0%	17.2%	17.0%
	Тийм	81.5%	64.7%	69.2%	44.0%	69.0%	66.0%
Хоолой боох нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	18.5%	26.5%	7.7%	32.0%	13.8%	19.9%
	Үгүй	14.8%	29.4%	23.1%	32.0%	24.1%	24.8%
	Тийм	66.7%	44.1%	69.2%	36.0%	62.1%	55.3%
Юмаар түлэх нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	7.4%	26.5%	7.7%	32.0%	17.2%	18.4%
	Үгүй	11.1%	26.5%	26.9%	32.0%	20.7%	23.4%
	Тийм	81.5%	47.1%	65.4%	36.0%	62.1%	58.2%
Хутга, мэс эсвэл бусад зэвсэг хэрэглэх эсвэл хэрэглэхээр заналхийлэх нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	14.8%	26.5%	14.3%	36.0%	13.8%	21.0%
	Үгүй	22.2%	26.5%	21.4%	28.0%	20.7%	23.8%
	Тийм	63.0%	47.1%	64.3%	36.0%	65.5%	55.2%
Хөөх (морь, машин, мотоциклоор гэх мэт) нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	18.5%	23.5%	11.5%	44.0%	13.8%	22.0%
	Үгүй	14.8%	26.5%	19.2%	24.0%	17.2%	20.6%
	Тийм	66.7%	50.0%	69.2%	32.0%	69.0%	57.4%

		Бэрхшээлийн төрөл					Нийт судалгаанд оролцогчдын хувь
		Харааны бэрхшээл	Оюуны бэрхшээл	Тулгуур эрхтний бэрхшээл	Сонголын бэрхшээл	Бусад төрлийн бэрхшээл	
<b>Нийт</b>		<b>27</b>	<b>34</b>	<b>35</b>	<b>25</b>	<b>29</b>	<b>150</b>
Хохирогчийн мөнгөн орлогод хяналт тавих, Зарцуулсан мөнгийг нь нэг бүрчлэн тооцох нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	18.5%	26.5%	7.4%	44.0%	27.6%	24.6%
	Үгүй	14.8%	20.6%	37.0%	32.0%	34.5%	27.5%
	Тийм	66.7%	52.9%	55.6%	24.0%	37.9%	47.9%
Ажил хийхийг зөвшөөрөхгүй байх, өөрийн гэсэн мөнгөтэй байхыг үл зөвшөөрөх нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	22.2%	29.4%	15.4%	48.0%	31.0%	29.1%
	Үгүй	25.9%	23.5%	38.5%	24.0%	27.6%	27.7%
	Тийм	51.9%	47.1%	46.2%	28.0%	41.4%	43.3%
Мөнгө, хувцас болон ахуйн хэрэглээний зүйлсээр гачигдуулах бүхий л үйлдэл нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	22.2%	35.3%	17.2%	40.0%	24.1%	27.8%
	Үгүй	22.2%	26.5%	31.0%	32.0%	34.5%	29.2%
	Тийм	55.6%	38.2%	51.7%	28.0%	41.4%	43.1%

		Бэрхшээлийн төрөл					Нийт судалгаанд оролцогчдын хувь
		Харааны бэрхшээл	Оюуны бэрхшээл	Тулгуур эрхтний бэрхшээл	Сонголын бэрхшээл	Бусад төрлийн бэрхшээл	
<b>Нийт</b>		<b>27</b>	<b>34</b>	<b>35</b>	<b>25</b>	<b>29</b>	<b>150</b>
Хүсээгүй байхад биеийн эмзэг хэсэгт хүрэх нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	14.8%	29.4%	12.0%	40.0%	27.6%	25.0%
	Үгүй	11.1%	29.4%	28.0%	32.0%	24.1%	25.0%
	Тийм	74.1%	41.2%	60.0%	28.0%	48.3%	50.0%
Үг, үйлдлээрээ бэлгийн дур хүслээ илэрхийлэх, бэлгийн харилцаанд орохыг шахах нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	14.8%	29.4%	16.0%	36.0%	27.6%	25.0%
	Үгүй	14.8%	29.4%	32.0%	32.0%	24.1%	26.4%
	Тийм	70.4%	41.2%	52.0%	32.0%	48.3%	48.6%
Хүсээгүй байхад хүчээр бэлгийн харилцаанд оруулах нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	14.8%	29.4%	11.5%	32.0%	27.6%	23.4%
	Үгүй	14.8%	29.4%	30.8%	32.0%	27.6%	27.0%
	Тийм	70.4%	41.2%	57.7%	36.0%	44.8%	49.6%
Бэлгийн харилцаанд орж байх үедээ хийхийг хүсэхгүй үйлдлийг хүчээр хийлгэх нь хүчирхийллийн хэлбэр мөн эсэх	Мэдэхгүй	11.1%	29.4%	11.5%	32.0%	41.4%	25.5%
	Үгүй	14.8%	29.4%	30.8%	36.0%	27.6%	27.7%
	Тийм	74.1%	41.2%	57.7%	32.0%	31.0%	46.8%

## Хавсралт 2. ГБХ-тэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдох журмуудад орсон ХБХ-тэй холбоотой зохицуулалт тусгагдсан байдал

Журам	ХБХ-тэй холбоотой зохицуулалт тусгагдсан байдал
Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдын 2017 оны А/116 дугаар тушаалаар батлагдсан Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам,	2.5. Түр хамгаалах байрыг хүүхэд, ХБХ, ахмад настан, эрэгтэй, эмэгтэй хохирогчдын хэрэгцээ, шаардлагыг харгалзан төрөлжүүлэн байгуулж болно. 2.6. Төрөлжсөн түр хамгаалах байр байхгүй тохиолдолд хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан, эрэгтэй, эмэгтэй хохирогчийн онцлог хэрэгцээ, шаардлагыг харгалзан үзүүлнэ.
Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/80, А/132, А/60 дугаар хамтарсан тушаалаар баталсан Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам,	ХБХ-ийг хүлээн авах зохицуулалт байхгүй.
Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/39 дугаар тушаалаар баталсан Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн түр хамгаалах журам,	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх үйлчилгээний зохицуулалт тусгагдаагүй.
Улсын Ерөнхий Прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/22, А/31 дугаар хамтарсан тушаалаар баталсан Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам,	ХБХ-тэй холбоотой зохицуулалт байхгүй
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/33 дугаар тушаалаар баталсан ГБХ-д өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам	ХБХ-тэй холбоотой зохицуулалт байхгүй
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/73 дугаар тушаалаар баталсан Холбон зуучлах үйлчилгээний журам	ГБХ-д өртсөн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хэрхэн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад шилжүүлэх талаарх зохицуулалт байхгүй.
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаалаар баталсан Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам,	ХБХ-тэй холбоотой зохицуулалт байхгүй.
Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/84, А/59, А/130 дугаар хамтарсан тушаалаар баталсан Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг магадлан итгэмжлэхэд тавих тусгай шаардлага үзүүлэлт байхгүй.
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/120, А/178 дугаар тушаалаар баталсан нөхцөл байдлын үнэлгээ хийх журам	2.12. Үйлчлүүлэгч ХБХ, үндэсний цөөнх, гадаадын иргэн бол дохионы хэлний хэлмэрч, орчуулагчаар дамжуулан нөхцөл байдлын үнэлгээ хийж энэ тухай тэмдэглэл хэсэгт дурдана. 2.13. Нөхцөл байдлыг үнэлгээг үйлчлүүлэгчид танилцуулж гарын үсэг зуруулна. Хэрэв үйлчлүүлэгч бичиг үсэгт тайлагдаагүй, хөгжлийн бэрхшээлтэй (сонсгол, хараа, хэл яриа гэх мэт), үндэсний цөөнх, гадаадын иргэн бол тэмдэглэлд дурдана.
Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны А/91 дугаар тушаалаар баталсан Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх журам	Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд иргэнд үзүүлэх үйлчилгээг халамжаар дамжуулан Түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулсан, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулсан тохиолдолд тэтгэмж авах зохицуулалтыг тусгасан байна. Дээрх хоёр төрлийн үйлчилгээг иргэн, өрх үзүүлсэн тохиолдолд халамжаас тэтгэж авах эрх үүснэ.
ХЗДХ-ийн сайдын 2020 оны А/83 тушаалаар батлагдсан "Аюулын зэргийн үнэлгээ хийх журам	3.12. Хохирогч монгол хэл, бичиг мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлэх чадвар хязгаарлагдмал бол орчуулагч, хэлмэрчийн тусламжтайгаар аюулын зэргийн үнэлгээг хийж, гарын үсгийг зуруулна.